2024
№ 04(51)

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠴᠡᠷᠢᠭ ᠤᠨ ᠡᠷᠬᠡ ᠵᠠᠰᠠᠭ ᠤᠨ ᠭᠠᠵᠠᠷ



ШҮҮХИЙН ШИЙДВЭР

ГҮЙЦЭТГЭЛ СУДЛАЛ

ОНОЛ-АРГА ЗҮЙН УЛИРАЛ ТУТМЫН СЭТГҮҮЛ

Улаанбаатар хот

UNIYERSITY OF INTERNAL AFFAIRS
SCHOOL FOR COURT DECISION EXECTION SERYICE

COURT DECISION EXECUTION STUDY

THEORETICAL AND METHODOLOGICAL QUARTERLY JOURNAL

2024
№04

Ulaanbaatar

Дугаарыг эрхлэн гаргаж эмхэтгэсэн: Хошууч Д.Буяннэмэх

Сургалт, судалгааны 403 дугаар анги-Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн Аюулгүй байдлын тэнхим

Эх бэлтгэсэн: Б.Тулга
Хэвлэл, редакцын хэлтсийн
эх бэлтгэгч-дизайнер, дэд ахлагч

Хэвлэлийн хуудас: 12
Хэвлэлийн тоо: 10

ISBN: 978-99978-770-2-4

“ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭЛ СУДЛАЛ” сэтгүүл

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг,
Цагдаагийн академийн өргөн чөлөө,
Хилчний гудамж,
Дотоод хэргийн их сургууль
И-мэйл: setguul.cd@gmail.com
Веб: uia.gov.mn

СЭТГҮҮЛИЙН РЕДАКЦЫН ЗӨВЛӨЛ	JOURNAL EDITOR BOARD
Сэтгүүлийн эрхлэгч **Дамдинцэрэн Д.** Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн захирал, доктор, бригадын генерал	**Editor of the journal** **Damdintseren D.** Director, School For Court Decision Execution Service, Ph.D, Brigadier general
Нарийн бичгийн дарга **Галбадрах Б.** Нийгмийн ажил, сэтгэл зүйн тэнхимийн профессор, доктор, дэд профессор, дэд хурандаа	**Editor of the journal** **Galbadrakh B.** Professor of Social work and psychology department, Ph.D, Associate professor, Lieutenant colonel
Гишүүд **Алтангэрэл Б.** Доктор, профессор, хурандаа	**Members** **Altangerel B.** Ph.D, Professor, Colonel
Очгэрэл Ц. Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлалын профессорын судалгааны багийн тэргүүлэх профессорын орлогч, доктор, дэд профессор, хурандаа	**Ochgerel Ts.** Deputy professor of Professor research team ofCourt Decision Execution, Ph.D, associated Professor, Colonel
Баттулга Г. Аюулгүй байдлын тэнхимийн профессор, хурандаа	**Battulga G.** Professor, the Department of Security, Colonel
Батгэрэл Я. Иргэний шийдвэр гүйцэтгэлийн тэнхимийн профессор, дэд хурандаа	**Batgerel Ya.** Professor of Civil Court Decision Execution Department, Lieutenant colonel
Батбаяр Э. Ял эдлүүлэх эрх зүйн тэнхимийн профессор, доктор, дэд профессор, хурандаа	**Batbayar E.** Professor of Department of Penal Law, Ph.D, Associate professor, Colonel
Мягмарсүрэн Д. Ахлагчийн мэргэжил, сургалт, үйлдвэрлэлийн төвийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны тэнхимийн эрхлэгч, доктор, дэд хурандаа	**Myamarsuren D.** Head of Department of the Court Decision Execution Service of the Sergeant Profession, Training and Production Center, Ph.D, Lieutenant colonel

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭЛ СУДЛАЛ

Онол-арга зүйн сэтгүүл

ДУГААРЫН ТОВЧООН	
ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ӨГҮҮЛЭЛ	
Э.Батбаяр Торгох ялын ойлголт, онцлог	1
Г.Хосбаяр Шүүхээс гэмт хэрэг үйлдсэн этгээдэд оногдуулсан албадлагын арга хэмжээний хэрэгжилт, анхаарах асуудал	8
Д.Энх-Амар Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүгчийн захирамж, шүүгчийн тогтоолыг хянах асуудал	25
Д.Алтантуяа Уламжлалт шинжилгээний арга зүйд хиймэл оюун ухаан ашиглах боломж	34
Х.Түвшин-Эрдэнэ, Ч.Цогтбаяр Хиймэл оюун ухаанд суурилсан царай таних технологи	44
Ц.Өнөболд Багшийн ёс зүйн асуудал боловсролын системд нөлөөлөх нь	52
И.Санчиргарав Америкийн нэгдсэн улсын эрүүгийн хуулийг монгол улсын эрүүгийн хуультай харьцуулсан судалгаа	63
Ч.Батболд Хоригдлыг гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх ажлын эрх зүйн зохицуулалтад хийсэн шинжилгээ	71
Э.Өнөболд Хууль сахиулагчийн хүний эрхэд суурилсан шийдвэр гаргалт	78
Х.Уянга, Д.Энх-Амар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын эмэгтэй ахлагч бүрэлдэхүүний ажлын гүйцэтгэлийг үнэлж, дүгнэх асуудал	89
С.Бямба-Эрдэнэ Арбитрын шийдвэрийн гүйцэтгэх ажиллагааг Сайжруулахад анхаарах асуудлууд	100
Судлаач сонсогч, оюутан, суралцагч	
Н.Удвалцэцэг Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэй хүмүүжигч нарт тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга зам	107
Б.Өсөхбаяр Хоригдлын шашин шүтэх, эс шүтэх эрхийн хэрэгжилт, анхаарах асуудал	112
ЦАГ УЕ, ҮЙЛ ЯВДАЛ	
Дотоод хэргийн их сургуулийн баг тамирчид гардан тулааны Ази тивийн аварга шалгаруулах тэмцээнд амжилттай оролцлоо	124

Докторын диплом гардууллаа	125
Багш, албан хаагчдад хугацааны цол олголоо	125
Дотоод хэргийн их сургуулийн түүхт 90 жилийн ойн баярын хурал болж байна	126
Дотоод хэргийн их сургуулийн 90 дэх хичээлийн шинэ жилийн нээлт боллоо	127
Тэргүүний багш нарт ДХИС-ийн тэргүүн дээд “эрдэм” шагнал гардууллаа	128
Докторын зэрэг амжилттай хамгааллаа	129
Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа хорих анги, салбар нэгжийн удирдах албан тушаалтны мэргэшүүлэх сургалтыг зохион байгууллаа	130
Шилдэг илтгэл, уран илтгэгч” шалгаруулах тэмцээн зохион байгууллаа	132
Сургалт, судалгааны 403 дугаар анги-шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн аварга шалгаруулах 3 төрөлт спортын тэмцээн зохион байгууллаа	133
Тэргүүний судлаачдад их сургуулийн тэргүүн дээд “эрдэм” шагнал гардууллаа	134
Докторын зэргийн диплом гардууллаа	136
Дотоод хэргийн их сургуулийн “ЭМЕРИТ ПРОФЕССОР”, монгол улсын гавьяат хуульч, хууль зүйн доктор, профессор а.лхагваа агсны нэрэмжит “оюуны индэр-2024” эрдэм шинжилгээний хурал зохион байгуулагдлаа	137
Дээд боловсролтой иргэдэд зориулсан хоёр жилийн мэргэшүүлэх бакалаврын сургалтын хөтөлбөрүүдийг сурталчлах өдөрлөгийг ШУТИС-д зохион байгууллаа	139
Дэд түрүүч Б.Өсөхбаяр: хоригдлуудаас авсан бодит судалгаа маань илтгэлийг илүү үр дүнтэй, ач холбогдолтой болголоо	139
Хүний эрхийг дээдэлье” сэдэвт парламентын мэтгэлцээнийг зохион байгууллаа	140
Дотоод хэргийн их сургуулийн сонсогч, суралцагчдын дунд "спортын дөрвөн төрөл"-т тэмцээний аваргууд шалгарлаа	141

ЭРХЛЭГЧИЙН ЗУРВАС



Хүндэт уншигч Танд энэ өдрийн мэнд хүргэе.

Сургалт, судалгааны 403 дугаар анги-Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулиас улирал тутам эрхлэн гаргадаг “Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлал” онол-арга зүйн сэтгүүлийн 2024 оны №4 дугаарыг тус сургуулийн Аюулгүй байдлын тэнхим эрхлэн гаргаж уншигч та бүхэнд хүргэж байна.

Тус сэтгүүл нь 2012 онд анхны дугаараа нийтийн хүртээл болгосноос хойш 50 дугаарыг тасралтгүй хэвлэн нийтлүүлсэн байна. Ингэхдээ шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлалын судалгааны голлох эх сурвалж болон шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлалын салбарын үе үеийн эрдэмтэн профессорууд болон судлаачдын судалгаа, эрдэм шинжилгээ өгүүлэл, ял эдлүүлэх ажиллагаа, иргэн, захиргаа, зөрчлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хийсэн дүн шинжилгээ зэргийг хэвлэн нийтэлдэг манай салбарын шинжлэх ухаан практикт өөрийн өнгө аяс бүхий хүлээн зөвшөөрөгдсөн сэтгүүл болон хөгжиж ирсэн билээ.

Тус сэтгүүлийг орчин үеийн технологийн хөгжил, дэвшилд нийцүүлэн цахим хэлбэрт шилжүүлэн олны хүртээл болгохоор ажиллаж байна.

Уншигч, судлаач та бүхэн Монгол улс болон олон улсын түвшинд дүйцэхүйц шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлалын сэтгүүлийг буй болгох үйлсэд бидэнтэй хамтран ажиллаж, хувь нэмрээ оруулна гэдэгт итгэлтэй байна.

Уншигч Таны эрдэм шинжилгээ, судалгааны ажилд тань өндөр амжилт хүсье.

Хүндэтгэсэн:

АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТЭНХИМИЙН ДЭД ПРОФЕССОР,
ДОКТОР (Ph.D), ХОШУУЧ Д.БУЯННЭМЭХ

ТОРГОХ ЯЛЫН ОЙЛГОЛТ, ОНЦЛОГ

CONCEPT AND CHARACTERISTICS OF CRIMINAL PUNISHMENT

Э.Батбаяр

Дотоод хэргийн их сургуулийн шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн ял эдлүүлэх эрх зүйн тэнхимийн профессор, хууль зүйн доктор /Ph.D/, дэд профессор, хурандаа;

Торгох ял түүний ойлголт, онцлогийн талаар авч үзэх нь торгох ялын тухай үндсэн мэдлэг олгох, торгох ялын мөн чанар, агуулга, зорилго зэрэг эрүүгийн эрх зүй дэх ялын сургаалтай бүрэн танилцах эхлэл болох юм.

Хэл зүйн хувьд авч үзвэл “торгууль” гэх үгийн эхний утга нь “ял болгож авах мөнгө, торгуулийн мөнгө, тавин төгрөгийн торгууль ногдов” гэсэн утгатай,[1] хууль зүйн толь бичигт англи хэлнээ торгууль гэдгийг “fine” гэж тэмдэглэсэн байна[2].

Эртний ял шийтгэлийн цусан өшөө авах үзэл сэтгэлгээнд суурилж бий болсон талионы зарчим нь аажимдаа композицийн систем рүү шилжиж, хатуу харгис ялын оронд нөхөн төлөөс төлөх, хохирол төлбөрийг гаргуулах, үүнд торгууль оногдуулах явдал багтаж байсан зэргээс үзэхэд ийм ойлголтоос торгох ялын гарал зүй эхлэл авсан байх үндэслэлтэй.

Жишээ нь: “**золио авах**” гэж Манжийн үеийн цааз бичигт хэрэглэж байсан ялтай холбоотой ойлголт бөгөөд алах ялыг өөр хөнгөн ялаар /торгууль, пүнлүү хасах гэх мэт/ солих, алах ялыг малаар сольж амь хэлтрүүлэхийг хэлдэг байжээ[3].

Монгол Улсын Эрүүгийн хуулийн Ерөнхий ангийн **5.3** дугаар зүйлд зааснаар, **Торгох ялын** эрх зүйн зохицуулалт нь дор дурдсанаар хуульчлан тогтоогджээ. Үүнд:

1. Гэмт хэрэг үйлдсэн хүнд энэ хуулийн тусгай ангид заасан торгуулийн нэгж /цаашид "нэгж" гэх/-тэй тэнцүү хэмжээгээр мөнгөн төлбөр оногдуулахыг **торгох ял** гэнэ.

2. Торгох ялын хэмжээ нь дөрвөн зуун тавин нэгжээс дөчин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг байна.

3. Энэ хуульд заасан нэг нэгж нь нэг мянган төгрөгтэй тэнцүү байна.

[1] Я.Цэвэл. Монгол хэлний товч тайлбар толь. УБ., 1966., 544 дэх тал.
[2] С.Нарангэрэл. МУ-ын Хууль зүйн нэвтэрхий толь бичиг. УБ., 2021., 396 дахь тал.
[3] Б.Баярсайхан. Хууль зүйн тайлбар толь. УБ., 2003., 256 дахь тал.

4. Шүүх ялтны хөрөнгө, цалин хөлс, бусад орлого олох боломжийг харгалзан торгох ялыг гурван жил хүртэл хугацаанд хэсэгчлэн төлөхөөр тогтоож болно.

5. Ялтан торгох ялыг шүүхээс тогтоосон хугацаанд биелүүлээгүй бол шүүх биелэгдээгүй торгох ялын арван таван нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгийг нэг хоногоор тооцож хорих ялаар солино.

6. Нийтэд тустай ажил хийлгэх, зорчих эрхийг хязгаарлах, хорих ялыг торгох ялаар солихгүй.

Эрүүгийн хуульд зааснаар авч үзвэл, дан ганц торгох ялтай гэмт хэрэг Эрүүгийн хуулийн тусгай ангид байхгүй байна /өмнөх 2002 оны Эрүүгийн хуульд байсан юм, жишээ нь: жагсаал цуглаан хийх эрх чөлөөг зөрчих /үз. 132 дугаар зүйл/.

Гагцхүү торгох ялыг хорих ба, зорчих эрхийг хязгаарлах, нийтэд тустай ажил хийлгэх зэрэг ялуудтай хамт буюу сонгох санкцын хэлбэрээр тогтоожээ. **Жишээ нь:** Хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол санаатай учруулсан бол 450-1350 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл ... нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл .... зорчих эрхийг хязгаарлах /үз. 11.6/ ял шийтгэнэ.

Торгох ялын хэмжээг хуульчилж ирсэн байдал:

№	Хууль	Ялын нэр	Хэмжээ	Итгэлцүүр
1	1926 оны Шүүх цаазын бичиг /11 дүгээр зүйл/	Мөнгөн ял торгох	10 төгрөг /доод/	Төгрөг ба Мөнгө
2	1929 оны Шүүх цаазын бичиг /11 дүгээр зүйл/	Мөнгө торгох	100 төгрөг /дээд/	Төгрөг
3	1934 оны Шүүх цаазын бичиг /28 дугаар зүйл/	Мөнгөөр торгох	2 сарын хөлс /дээд/	Мөнгө
4	1942 оны Эрүүгийн хууль /41 дүгээр зүйл/	Мөнгөн торгууль	2 сарын цалин /дээд/	Мөнгө
5	1961 оны Эрүүгийн хууль /23 дугаар зүйл/	Торгох	доод хэмжээг заагаагүй	Мөнгө
Тайлбар: Тус хуульд анх “торгох” гэсэн нэрийг хэрэглэжээ. Мөн нэмэгдэл ялаар хэрэглэж болохыг заасан байна. /үз. 17 дугаар зүйл. 1966.11.02/.				
6	1986 оны Эрүүгийн хууль /29 дүгээр зүйл/	Торгох /үндсэн, нэмэгдэл/	250-1500, 5000 төгрөг	2.000-250.000, 500.000, үндсэн ял /1993 онд/
7	2002 оны Эрүүгийн хууль /47 дугаар зүйл/	Торгох /үндсэн ял/	5-500 дахин	Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ

8	2015 оны Эрүүгийн хууль /5.3 дугаар зүйл/	Торгох ял /үндсэн/	100-40.000 нэгжтэй тэнцүү	Нэгж, 1 нэгж 2000 төгрөг
9	Нэмэлт, өөрчлөлт	Торгох ял	451-40.000	1 нэгж 1000 төгрөг

Торгох нь одоогийн хүчин төгөлдөр үйлчилж байгаа Монгол Улсын Эрүүгийн хуульд тусгалаа олсон ялын төрлүүдийн нэг бөгөөд эрүүгийн эрх зүй дэх ялын тогтолцоонд зонхилох байр суурийг эзэлдэг ял юм.

Орчин цагт ял нь "Хорих болон хорихоос өөр төрлийн ял" гэж зааглагдаж буй хандлага түгээмэл болсон учир торгох ялыг хорихоос өөр төрлийн буюу нийгмээс гэмт хэрэг үйлдсэн этгээдийг тусгаарлахгүй шинжтэй ялын тогтолцооны хүрээнд, "альтернатив" шинжийг нь харгалзаж, ялын бодлогын хувьд "хүний эрх, энэрэнгүй ёсны зарчимд тулгуурласан, хорих ялаас хөнгөн шинж чанартай" байдалд нь үндэслэж, сонгох санкц болж буй нөхцөлд өргөн хэрэглэх болсон байна.

Ингэснээрээ гэмт хэрэг үйлдсэн этгээдийн гэм бурууг шүүхээр тогтоосны дараа нийгмээс тусгаарлаж, хугацаа тогтоож хорихгүйгээр торгууль ногдуулах замаар уг этгээдийн өмчлөх эрхэд тодорхой хязгаарлалт тогтоох хэлбэрээр хэрэгжиж, торгох ялыг эс биелүүлэх буюу зайлсхийсэн тохиолдолд хорих ялаар солих хууль зүйн үр дагавар үүсэхийг нь заавал анхааруулж шийтгэх тогтоолд шүүгч дурдах юм.

Торгох ял нь уг ялаар шийтгүүлж байгаа хүн, хуулийн этгээдийн үйлдсэн гэмт хэрэгтэй хууль зүйн хувьд шалтгаан ба үр дагаврын холбоог үүсгэж, улмаар энэ ялыг оногдуулах нь зохимжтой агаад эрүүгийн хариуцлагын нийтлэг "цээрлүүлэх, нийгэмшүүлэх, эрх сэргээх, хохирлыг нөхөн төлүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх" зэрэг /ялын/ зорилгыг хангахад чиглэсэн, эрүүгийн эрх зүйн "шударга, энэрэнгүй, тэгш, хууль ёсны, ял гарцаагүй байх" зарчмуудад үндэслэсэн байна.

Гэмт хэрэг үйлдсэн хувь хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан тохиолдолд, шүүхээс, торгуулийн тогтоосон нэгжийн хэмжээгээр, мөнгөн төгрөг төлөх хэлбэрээр торгууль оногдуулахыг **торгох** ял гэнэ. Үүнд:[1]

- зөвхөн гэмт хэрэг үйлдсэн, гэм бурууtай хувь хүн болон хуулийн этгээдэд ял болгож оногдуулна;

[1] Торгох ялын үндэс нь торгууль юм. Энэ торгууль нь /бусад торгуулийг бодвол/ эрүүгийн хуульд заагдсан ял болохын хувьдаа Монгол Улсын мөнгөн тэмдэгт болох төгрөгөөр тооцогдож байгаа болно. Иргэний эрх зүйн харилцаанд үүргийн гүйцэтгэлийг хангах нэг арга болох анзын нэг хэлбэр торгууль, нөгөөх нь алданги байдаг. Үз. Иргэний хуулийн 232 дугаар зүйлийн 232.4 ба 232.5 дахь хэсэг.

- тухайн гэмт хэрэг үйлдсэн, гэм буруутай хүн болон хуулийн этгээдэд торгох ял оногдуулахаар Эрүүгийн хуулийн тусгай ангид /зүйлчлэн/ заасан бол торгох ялыг оногдуулж болно;

- торгох ялыг гагцхүү шүүх, шүүх хуралдаан явуулж, шийтгэх тогтоол гаргах арга замаар /хэмжээ, хугацаа зэргийг тусгаж/ оногдуулна;

- торгуулийн тогтоосон нэгжийн хэмжээ буюу торгох ялын итгэлцүүрийг ашиглах байдлаар ялын тооцоолол гаргаж оногдуулна;

- биелэлт нь төрд мөнгөн төлөөс төлөх байдлаар хангагдах учир торгуулийн мөнгийг Монгол Улсын мөнгөн тэмдэгт болох төгрөгөөр тогтоож гаргуулж, зохих дансанд хийлгэх байдлаар хэрэгжинэ.

Манай улсын эрүүгийн эрх зүйгээр эрүүгийн ялыг түүний үйлчлэлийн мөн чанар, эдлүүлэх арга хэлбэрийн онцлогийг харгалзан "үндсэн ял, үндсэн болон нэмэгдэл ял, зөвхөн нэмэгдэл ял" гэж тус тус ангилдаг[1].

Ийнхүү "ялыг тодорхой тогтолцоонд ангилах нь шүүх гэмт хэрэг үйлдсэн, гэм буруутай нь нотлогдсон шүүгдэгчийн үйлдсэн хэргийн хор аюул, түүний хувийн байдал, ял хөнгөрүүлэх болон хүндрүүлэх нөхцөл байдлуудыг харгалзан ялыг оновчтой сонгон оногдуулахад чухал ач холбогдолтой" юм[2].

Одоогийн дагаж мөрдөж буй Эрүүгийн хуулийн зохицуулалтаас үзвэл торгох нь "үндсэн ялд" хамаарч байна. **Үндсэн ял** гэдэг нь гэмт хэрэг үйлдсэн, гэм буруутай этгээдэд уг ялыг дангаар нь оногдуулна гэсэн үг. Мөн уг ял дээр нэмэгдэл ял /эрх хасах/ хэрэглэж болохыг ойлгоно[3].

Торгох нь манай түүхэн уламжлалт ял бөгөөд дэлхийн улс орнуудын жишигт ч байдаг. Цээрлүүлэх гол агуулга нь өмчлөх эрхийг нь хязгаарласан материаллаг шинжтэй төрийн албадлага юм. Торгох ял нь нийгмээс тусгаарладаггүйгээрээ ялын тогтолцооны хөнгөн төрөлд багтдаг[4].

Торгох ялын үндсэн зорилго нь нэг талаас гэмт хэрэг үйлдсэн этгээдэд хорих мэтийн хүнд ялыг хэрэглэхгүйгээр эрүүгийн хариуцлагын гарцаагүй байх зарчмыг хэрэгжүүлэх, нөгөө талаас гэмт этгээдэд материалын хохирол учруулж цээрлүүлэн хашраахад орших[5] буюу ... гэмт замаар алдагдалтай амьдрах уу, аль эсхүл хууль

[1] Г.Совд. Эрүүгийн хуулийн тайлбар. УБ., 2002., 62 дахь тал.
[2] С.Жанцан. Дурдсан бүтээл. Боть-II., УБ., 2014., 142 дахь тал.
[3] 1986 оны Эрүүгийн хуулиар торгох ялыг үндсэн ялаас гадна нэмэгдэл ялаар хэрэглэж байсан юм. 1993 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлтөөр дан ганц үндсэн ял болгожээ. Үз. 20 дугаар зүйлийн 2. Ардын эрх /сонин/. 1993.06.26., МУ-ын Эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал /1911-2009/. УБ., 2011., 634-635 дахь тал.
[4] С.Жанцан. Эрүүгийн хариуцлага. УБ., 2006., 10 дахь тал.
[5] Г.Совд. Монгол Улсын Эрүүгийн цааз /хууль/-ыг өөрчлөх үзэл баримтлал. Монголын төр, эрх зүй. УБ., 1995., №1., 9 дэх тал.

ёсны замаар аж төрөх үү гэдгийг эргэцүүлэн бодоход энэ ял гэм буруутай этгээдэд тодорхой нөлөө үзүүлнэ[1].

Торгох ялын ойлголт, хүснэгтээр:

Төрөл	**Хэлбэр**	**Хэмжээ**	**Дэглэм**	**Тогтолцоо**
Торгох ял	Биечлэн бус	*- нэгж, 1 нэгж - 1000 төгрөг *- 451-40000 нэгж	Төрд тушаах	Үндсэн ял
Торгох нь торгуулийн мөнгөн нэгжээр хэмжигдэх эдийн засгийн арга хэрэглүүр ашиглаж байгаа эрх зүйн хориглолт учир материаллаг шинжтэй ял бөгөөд ялтны эд хөрөнгийн эрх ашгийг хөндөхөөс өөр хуулийн хязгаарлалт тогтоохгүй.				
Дүйцүүлэх итгэлцүүр нь хуульд заасан торгуулийн нэгж. Торгох ялыг хэсэгчлэн төлүүлэхээр шүүх тогтоож болно. Хэрэв тогтоосон хугацаанд торгох ялыг төлөөгүй тохиолдолд хорих ялаар солих хууль зүйн үр дагавар үүснэ.				
Тайлбар, санал: Гэмт хэрэг үйлдсэн “хүнд” гэж хууль тогтоогч субъектийг заасан атал Эрүүгийн хуулийн 9.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэгт “хуулийн этгээдэд” уг ялыг оногдуулахаар мөн заажээ. Иймд хууль нь эрх зүйн ном зохиол биш учраас түүнийг хэт хатуугаар муйхарлан эс ойлгож хууль хэрэглээний нэгдмэл ойлголтын зөрүү үүсгэхгүй байх, эсхүл “хуулийн этгээд” гэж нэмэх нь зүйтэй.				

Бусад ялын төрлөөс нийгмээс тусгаарлахгүй шинжээрээ торгох нь хөнгөн ялд тооцогддог, зөвхөн нэг удаагийн үйлчлэлтэй, эдийн засгийн буюу эд материалын эрх, ашиг сонирхолд халдахаас бус ялтны бусад эрхийг хязгаарлахгүй, хөрөнгө чинээ зэргээр хүнийг ялгаварлал тогтоох хандлага үүсгэх эрсдэлтэй, улсын төсөв бүрдүүлэх чиг үүргийг давхар тээж явдаг, зайлшгүйгээр дүйцүүлэх итгэлцүүрийн хөшүүрэг ашиглаж хэмжээг нь тогтоодог зэрэг онцлогтой.

Торгох ялыг эд хөрөнгө хураах ял буюу албадлагын арга хэмжээнээс ялган авч үзэх нь чухал юм. Торгох ба эд хөрөнгө хураахын аль аль нь материаллаг буюу эд хөрөнгийн шинжтэй боловч харилцан адилгүй агуулгатай.

Үүнд: тухайлбал, торгох ялыг дан ганц нэгж буюу төгрөг /мөнгө/ -өөр тооцдог бол эд хөрөнгө хураах үед шүүгдэгчээс мөнгө, ба бусад эд хөрөнгийг албадан гаргуулж авдаг. Торгох нь үндсэн ялын төрөлд хамаарч байхад эд хөрөнгө хураах явдлыг албадлагын арга хэмжээнд тооцдог. Торгуулийн хэмжээг нэгжээр тооцож хуульд шууд тогтоон заасан бол эд хөрөнгө хураахын хувьд бүгдийг буюу эсхүл заримыг нь гэсэн сонголт байдаг. Торгуулиас зайсхийх буюу төлөөгүй тохиолдолд хорих ялаар солих журамтай бол эд хөрөнгө хураахад хохирол нөхөн төлүүлэх гэх зэрэг зорилгоор хийгдэх ажиллагаанд хамаарна.

[1] С.Нарангэрэл. Дурдсан бүтээл. УБ., 1999., 277 дахь тал.

Шүүхийн практик. “Т” нь нэгэн сүлжээ дэлгүүрт менежерээр ажиллаж байхдаа 16 нэр төрлийн 7.891.000 төгрөгийн бараа завшсан гэмт хэрэгт 11.000 төгрөгөөр торгох ялаар шийтгэгдсэн ба шүүх уг торгох ялыг 3 жилийн хугацаанд сар тутамд хувь тэнцүүлж хэсэгчлэн төлөх хугацааг тогтоож өгчээ[1].

“Т” нь шүүхээс тогтоосон 3 жилийн хугацаанд 11.000.000 төгрөгийн торгох ялаас 2.000.000 төгрөгийн ялыг төлж, 9.000.000 төгрөгийн торгох ялыг хугацаандаа төлж дуусаагүй учир прокурор “Торгох ялыг хорих ялаар солих тухай” дүгнэлт бичиж шүүхэд шилжүүлжээ.

Шүүх Эрүүгийн хуулийн 5.3 дугаар зүйлд заасан “... Ялтан торгох ялыг шүүхээс тогтоосон хугацаанд биелүүлээгүй бол шүүх биелэгдээгүй торгох ялын 15 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгийг 1 хоногоор тооцож хорих ялаар солино” гэсэн заалтыг үндэслэн ялтан “Т”-гийн төлөөгүй 9.000.000 төгрөгийн торгох ялын 15 нэгжийг хорих ялын 1 хоногоор тооцож 600 хоногийн хорих ялаар сольж, нээлттэй хорих байгууллагад эдлүүлж шийдвэрлэжээ.

“Т” нь “... Ковид-19 цар тахлын нөлөөлөл, хил гаалийн хаалттай байдал, хөл хорионы улмаас ажил төрөл хийх, орлого олох боломжгүй нөхцөл байдалд орсон учир торгуулийн ялыг биелүүлж чадаагүй. Торгох ялаа нэн даруй төлнө. Хорих ялыг бүцаан торгох ялаар сольж өгнө үү” гэсэн агуулга бүхий давж заалдах гомдол гаргаснаар ... давж заалдах шатны шүүх хэргийг хэлэлцээд:

- торгох ял нь Эрүүгийн хуульд заасан үндсэн төрлийн ял бөгөөд хуульд заасан үндэслэл, журмаас өөр нөхцөлөөр уг ялыг хойшлуулах болон Эрүүгийн хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд шийдвэр гүйцэтгэх ажиллагааг түдгэлзүүлэх, биелүүлэхгүй байх талаар заагаагүйгээс гадна;

- шүүхийн шийдвэр гүйцэтгэгчээс торгох ялаа биелүүлэх талаар шаардахад “... ажилтай болоод очиж чадахгүй байна, төлнө” гэсэн тайлбарыг “Т” нь өгч байсан зэргийг үндэслэн торгох ялыг хорих ялаар сольсон анхан шатны шүүхийн шийдвэр үндэслэлтэй гэж үзэж, хэвээр үлдээж, түүний гаргасан гомдлыг хэрэгсэхгүй болгон шийдвэрлэжээ.

Шигтгээ. Торгох ялын цээрлэл нь ялтны эд хөрөнгийн эрхийг хязгаарлаж, түүнд таагүй үр дагавар буюу эргэж төлөгдөх нөхцөлгүйгээр төрийн өмчлөлд мөнгөн төлбөр хийж байгаагаар илэрнэ[2].

Ихэнх орны Эрүүгийн хуульд хэрэглэж байгаа шинж байдлын хувьдаа нийтлэг буюу түгээмэл хандлагатай, зах зээлийн харилцааны нийгэм, эдийн засгийн хэв шинжид тулгуурлагдсан тул голчлон мөнгөн хэлбэртэй, эдийн засгийн

[1] https://citycourt.mn/site/index.php?newsid=446. Үз. Торгох ялыг хорих ялаар сольсон нь хуульд нийцсэн гэж үзсэн байна.
[2] Эрүүгийн хариуцлага /хамтын бүтээл/. УБ., 2006., 32 дахь тал.

хөшүүргийн үүднээс хүний орлого буюу халаас руу төрийн гар шургалж түрийвчтэй ярьдаг гэх мэтийн өнгөц ойлгож болох үндсэн шинжүүдтэй ял нь торгох юм.

Гэмт хэрэг үйлдсэн этгээдэд шүүхээс төгрөгөөр /мөнгөн/ ял оногдуулахыг торгох ял гэж ойлгож болно. Харин одоогийн хуульд заасан шиг энэ нь "төлбөр" биш ээ. Торгох ялыг хэрвээ "төлбөр" гэж үзэх юм бол төрөөс үйлчилгээ авч байгаа утга болох бөгөөд энэ нь гэмт хэрэг үйлдсэнийхээ төлөөс болгож хураамж өгч буйтай ижил. Цаашид мөнгөн хэлбэр нь мал, эд зүйл зэрэг бус, төгрөгөөрөө байх нь илүү зохимжтой байна.

Зарим эрдэмтэд " ... торгуулийн ялыг "мөнгөн төлбөр" гэж заасан нь үүргийн гүйцэтгэлтэй холбоотой төлбөр мэтээр ойлгогдох утгыг буй болгож байгаа тул зөв томьёологдоогүй" гэж үзжээ[1].

[1] С.Нарангэрэл, Ж.Эрдэнэбулган. Монгол Улсын Эрүүгийн эрх зүй: үзэл баримтлал, уламжлал, сургамж /нэгэн сэдэвт бүтээл/.УБ., 2019., 254 дэх тал.

ШҮҮХЭЭС ГЭМТ ХЭРЭГ ҮЙЛДСЭН ЭТГЭЭДЭД ОНОГДУУЛСАН АЛБАДЛАГЫН АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ, АНХААРАХ АСУУДАЛ

"THE APPLICATION OF COURT-ORDERED COMPULSIONS IN CRIMINAL JUSTICE: CHALLENGES AND CONSIDERATIONS

Г.Хосбаяр

Дотоод хэргийн их сургуулийн Удирдлагын академийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн удирдлага, стратегийн тэнхимийн дэд профессор, докторант, хошууч;

Хураангуй: Өгүүлэлд албадлагын арга хэмжээ, эрх зүйн бодлогын орчин, цаашдын чиг хандлага мөн анхаарах асуудлын талаар судлаачийн үзэл бодлыг илэрхийлсэн.

Түлхүүр үг: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, эрүүгийн ялын бодлого, албадлага, албадлагын арга хэмжээ.

Удиртгал

Эрүүгийн хариуцлагын албадлагын арга хэмжээ нь хууль тогтоомжийг дагаж мөрдөхийг албадах эсвэл эрүүгийн гэмт хэргийг мөрдөн шалгах, яллах, түүнийг хэрэгжүүлэхэд туслах зорилгоор эрх зүйн тогтолцооны янз бүрийн аргуудыг хамааруулан авч үздэг. Эдгээр арга хэмжээ нь ихэвчлэн хувь хүний эрх чөлөө, эрхийг хязгаарлахтай холбоотой төрийн албадлагын арга хэмжээгээр илрэн гардаг бөгөөд тэдгээрийн хэрэглээ нь пропорциональ, зайлшгүй байхын тулд хууль, эрх зүйн хатуу хамгаалалтад хамрагддаг.

Гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай этгээдэд эрүүгийн хариуцлагын алтернатив сонголт бүхий хорихоос өөр төрлийн ял эдлүүлж, хорих ялыг оногдуулахгүй тэднийг нийгэмших, хүмүүжих боломжийг олгох нь зүйтэй гэсэн чиг хандлага XVIII зууны сүүлч XIX дүгээр зууны эхэн үеэс эрх зүйн тогтолцоонд дэлгэрч, өнөө үед олон улсын түвшинд хүчтэй байр суурийг эзлэх болжээ.

Эрүүгийн хариуцлагын албадлагын арга хэмжээг хэрэглэх нь нэг талаас хувь хүний эрх, чөлөө, нөгөө талаас олон нийтийн аюулгүй байдлыг хамгаалах хэрэгцээ хоёрын хоорондын тэнцвэрт байдлын талаарх ёс зүйн болон хууль, эрх зүйн чухал сорилтуудыг бий болгодог. Эдгээр арга хэмжээ нь хууль сахиулах үйл ажиллагаанд зайлшгүй шаардлагатай арга хэрэгсэл боловч төр болон шүүх эрх мэдлийн байгууллагаас хариуцлагатай, хуулийн дагуу хэрэглэх нь нэн чухал юм.

Эрүүгийн эрх зүйн хүний эрх, эрх чөлөө, нийгэм, төрийн ашиг сонирхлыг гэмт халдлагаас хамгаалах зорилтоос үүдэн эрүүгийн хариуцлага нь ихэвчлэн гэмт хэрэг үйлдсэн этгээдэд хэрэглэх албадлагын арга хэмжээ байдлаар илрэн гардаг.

Албадлагын арга хэмжээ нь эрүүгийн ялын зорилгыг хангах, ялын үр нөлөөг дээшлүүлэхийн тулд шүүхийн шийтгэх тогтоолоор эрүүгийн хуулийн тусгай ангийн санкцид заасан ял оногдуулахгүйгээр тэнсэж, эсвэл оногдуулсан ял дээр нэмж ялтанд тусгай үүрэг хүлээлгэж, эрхийн хязгаарлалт тогтоож буй эрүүгийн ял бус хариуцлагын төрөл юм.

Үндсэн хэсэг

Эрүүгийн хариуцлага болох ял, албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэх эрх зүйн зохицуулалт болох Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль 2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш багагүй хугацаа өнгөрчээ.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, түүнд нийцүүлэн гаргасан эрхийн актуудын хэрэгжилтийг онолын болон практикийн түвшинд судлах, тулгамдаж буй асуудлыг нээн илрүүлж, шийдвэрлэх арга замыг судалгааны үндсэн дээр гаргах, төрийн ял шийтгэлийн буюу эрүүгийн бодлогыг шинэчлэх шаардлага зүй ёсоор урган гарч байна.

Төрийн эрүүгийн бодлого гэдэг нь хүн, төр, нийгмийн байгууллага, аж ахуйн нэгжийн хууль ёсны эрх ашиг, сонирхлыг гэмт халдлагаас хамгаалах зорилгоор нийгэмд аюултай үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцох, тэдгээрт оногдуулах эрүүгийн хариуцлагын төрөл, хэмжээ, тэдгээрийг хэрэглэх, эсхүл тэдгээрээс чөлөөлөх үндэслэл, журмыг тогтоох, түүнчлэн гэмт явдлын шалтгаан, нөхцөлийг судалж тогтоох, энэ үндсэн дээр урьдчилан сэргийлэх, таслан зогсоох үр өгөөжтэй арга хэмжээг боловсруулах, хэрэгжүүлэх, шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагуудын гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагааг төгөлдөржүүлэх талаар төрөөс баримталж буй чиглэл, удирдамж юм[1].

Ял бол төрийн албадлагын тусгай хэлбэр тул түүнийг төрийн нэрийн өмнөөс гагцхүү шүүх оногдуулж, шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх гол хэрэгсэл нь албадлагаар хэрэгждэг.

Албадлагын арга хэмжээг эрүүгийн эрх зүйн онолын үүднээс авч үзвэл, шүүгдэгчийн эрх, эрх чөлөөг хасах эсхүл хязгаарлахад албадлагын мөн чанар оршдог.

Эрүүгийн хариуцлагын албадлагын арга хэмжээний онол нь МЭӨ-ны 2100 оны үеийн Шүмэрийн Ур Намму хааны хуулиас эхлэн хожмын Арван лүндэн, Солоны хуулиуд, Ромын эрх зүйн Арван хоёр хүснэгт болон Жастинианы

[1] С.Жанцан. Монгол Улсын Эрүүгийн эрх зүй.Ерөнхий анги.2002.24 дэх тал

төрөлжсөн хуулиудаар дамжин И.Кант[1], Ж.Бентам[2] нарын философийн үзэл санаа, онолд тулгуурлан хөгжиж өнөө цагт хүрсэн билээ.

Энэ нь олон зуун жилийн турш хөгжиж ирсэн, янз бүрийн эрх зүйн философи, нийгмийн өөрчлөлтийн нөлөөнд автсан хууль зүйн судлагдахуун юм.

Олон улсын хүний эрхийн хууль тогтоомж нь хүний угаас заяасан нэр төрийг эрхэмлэх, эрүүдэн шүүх, хэрцгий, хүнлэг бус, нэр төрийг гутаан доромжлохыг хориглохыг чухалчилснаар албадлагын арга хэмжээ олон нийтэд зөвшөөрөгдөх (legalis agnitio[3]), хамрах хүрээг ихээхэн тодорхойлсон юм.

Эрх зүйн хүрээнд (De Jure[4]) ялын хэрэгжилтийг ял шийтгэл гүйцэтгэх болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх гэсэн хоёр хэлбэрээр хангагдах бөгөөд зарчмын хувьд эдгээр нь өөр өөр ойлголтууд юм.

“Шүүхийн шийдвэр гүйцэтгэх[5]” гэдэг нь ялын гүйцэтгэлээс илүү өргөн утгатай ойлголт бөгөөд үүнд шүүх болон бусад эрх бүхий байгууллагын зүгээс шүүхийн тогтоолыг хангахад чиглэсэн эрх зүйн хүрээнд явуулж буй бүх хэлбэрийн үйл ажиллагааг... хамааруулдаг бол “Эрүүгийн ял шийтгэл гүйцэтгэх ажиллагаа” гэдэгт шүүхээс ял оноосон этгээдэд албадлагын арга хэмжээ авах замаар эрүүгийн ялын бодлогыг хангахын тулд эрүүгийн ял шийтгэл гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн хэмжээний хүрээнд хэрэгжүүлж буй төрийн байгууллагын үйл ажиллагааг ойлгоно[6].

Эрүүгийн ял шийтгэл гүйцэтгэх болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны нийлбэрт тулгуурлан эрүүгийн ял шийтгэл гүйцэтгэх ажиллагааны бодлого тодорхойлогдох бөгөөд эрүүгийн ялын бодлогыг түшиглэн төрийн эрүүгийн бодлого бүрдэнэ.

Эрүүгийн бодлого нь төрийн бодлогод эзлэх байр суурь, гүйцэтгэх үүрэг, нийгмийн үйл явцад нөлөөлөх аргаараа бусад салбарын бодлогоос өвөрмөц онцлогтой, өөртөө эрүүгийн эрх зүйн, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх эрх зүйн, эрүүгийн ял эдлүүлэх эрх зүй, криминологи зэрэг хэд хэдэн чиглэлийн тусгай бодлогыг багтааж байдаг. Үүнтэй уялдан эрүүгийн ба эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх,

[1] И.Кантын хувь хүний үүрэг хариуцлага, ёс суртахууны дэг журмыг сахин хамгаалахын тулд шийтгэх хэрэгцээ чухал үүрэг гүйцэтгэсэн.
[2] Ж.Бентамын хувь хүний болон нийгмийн сайн сайхныг дээд зэргээр нэмэгдүүлэх, зовлон зүдгүүрийг багасгахад чиглэсэн философийн үзэл санаа нь илүү хүмүүнлэг, албадлагын бага хэлбэрийг хөгжүүлэхэд нөлөөлсөн.
[3] Энэ нэр томьёо нь "хууль ёсны" гэсэн утгатай "legalis" ба "agnitio" нь "хүлээн зөвшөөрөх" эсвэл "хүлээн зөвшөөрөх" гэсэн үгнээс гаралтай.
[4] De jure гэдэг нь шууд утгаараа "хуулийн" эсвэл "хуулийн дагуу" гэсэн утгатай.
[5] Ромын эрх зүйд шүүхийн шийдвэрийг биелүүлэхийг ихэвчлэн "adiudicatio" гэж нэрлэдэг.
[6] Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаа: харьцуулсан судлал. Уб., 2018. 21 дэх тал.

зөрчлийн зэрэг салбар хуулиудад төрийн эрүүгийн бодлогын агуулга хуульчлагдан хэрэгжиж байдаг[1].

2015 оны Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулга, 2017 оны Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн онцлог нь хорих ял биечлэн эдлүүлэх явдлыг багасгах, хохирол нөхөн төлүүлэх чиглэлд анхаарч, зорчих эрхийг хязгаарлах ял, хорих ялыг тэнсэж үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээ хэрэглэх, гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн хүнд оногдуулах ялыг хөнгөрүүлэх, чөлөөлөх, албадлагын арга хэмжээ хэрэглэх, өсвөр насны хүнд болон хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх институтийг тусгасан.

Эрх зүйн шинэтгэлийн хүрээнд батлагдсан "Эрүүгийн хууль" нь 2002 оны хуулиас 40 орчим хувиар өөрчлөгдсөн. Тухайлбал, хорих ял биечлэн эдлэх явдлыг багасгах чиглэлд анхаарч гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдэд оногдуулах ялын төрлийг торгох, нийтэд тустай ажил хийлгэх, зорчих эрхийг хязгаарлах, хорих, эрх хасах ял болгон өөрчилж нийт 211 гэмт үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцон хуульчилснаас сонгох санкцтайг 130 гэмт хэрэгт торгох ял, 56 гэмт хэрэгт нийтэд тустай ажил хийлгэх ял, 135 гэмт хэрэгт зорчих эрх хасах ял, 195 гэмт хэрэгт хорих ял, 37 гэмт хэрэгт эрх хасах ял шийтгэхээр, үүнээс торгох болон хорих ял оногдуулах санкцтай 8, хорих болон нийтэд тустай ажил хийлгэх ялын санкцтай байхгүй, хорих болон зорчих эрх хязгаарлах ялын санкцтай 9, хорих болон эрх хасах нэмэгдэл ялын санкцтай байхгүй, торгох, нийтэд тустай ажил хийлгэх, зорчих эрх хасах, хорих ялын санкцтай 40, бүх төрлийн ялаас сонгох санкцтай 8, хорихоос өөр төрлийн ялаас сонгох санкцтай 16, сонгох санкцгүйгээр хорих ял оногдуулахаар 61, гэмт хэргийг тус тус хуульчилсан бөгөөд Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 6.7 дугаар зүйлд зааснаар "Гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн хүнд оногдуулах хорих ялыг хөнгөрүүлэх, хорих ялаас чөлөөлөх, албадлагын арга хэмжээ хэрэглэх" хууль зүйн орчин бүрдсэн.

Эрүүгийн хуулийн 5.1 дүгээр зүйлд "Эрүүгийн хариуцлагын зорилго нь гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг цээрлүүлэх, гэмт хэргийн улмаас зөрчигдсөн эрхийг сэргээх, хохирлыг нөхөн төлүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг үйлдсэн хүнийг нийгэмшүүлэхэд оршино", мөн "Эрүүгийн хариуцлага нь энэ хуульд заасан ял, албадлагын арга хэмжээнээс бүрдэнэ" гэж тус тус тодорхойлсон[2].

Мөн Эрүүгийн хуулийн 7.2 дугаар зүйлд шүүх ялын зорилгыг хангахад шаардлагатай гэж үзвэл гэмт үйлдсэн хүнд ял оногдуулахгүйгээр тэнсэж, эсхүл оногдуулсан ял дээр нэмж албадлагын арга хэмжээг хэрэглэхээр заасан.

---

[1] Албадлагын арга хэмжээнд тавих хяналтын тогтолцоо: хэрэгжилт, чиг хандлага. Уб., 2018. 11 дэх тал.

[2] Эрүүгийн хууль. Төрийн мэдээлэл эмхэтгэл. 2016. № 7.

Гэмт хэрэг үйлдсэн хүнд хорих ял оногдуулахгүйгээр тэнсэж, албадлагын арга хэмжээ хэрэглэх журам нь хорих ял биечлэн эдлэх явдлыг багасгах, гэмт хэрэг үйлдсэн хүний гэм бурууг өөрөөр нь ухамсарлуулах, хохирол нөхөн төлүүлэхэд чиглэсэн төрийн албадлагын арга хэмжээ юм.

2015 оны Эрүүгийн хуульд гэмт хэрэг үйлдсэн хүн, өсвөр насны хүн, хуулийн этгээдэд хэрэглэх албадлагын арга хэмжээний төрлийг хуульчилж өгсөн. Үүнд:

1. Хүнд:
-үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээ;
-эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ;
-хөрөнгө, орлогыг хураах албадлагын арга хэмжээ;
2. Өсвөр насны хүнд:
-хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ;
3. Хуулийн этгээдэд:
-эрх хасах албадлагын арга хэмжээ;
-татан буулгах албадлагын арга хэмжээ;
-хуулийн этгээдийн хөрөнгө орлогыг хураах албадлагын арга хэмжээг хэрэглэхээр тус тус заасан.

Эдгээрт заасан үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах, хөрөнгө, орлогыг хураах болон хуулийн этгээдэд хэрэглэх албадлагын арга хэмжээ нь шинэ төрлийн албадлагын арга хэмжээ юм.

Нийслэл, орон нутаг дахь шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтсийн хяналтад байгаа үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээ авсан шүүхийн шийдвэрийг төрлөөр харуулбал:

Албадлагын арга хэмжээний хэрэгжилтийн тоон үзүүлэлт

Төрөл	**Тайлбар**	**2020 он**	**2021он**	**2022 он**	**2023 он**	**2024 он**
Хорих ял оногдуулахгүйгээр тэнссэн	Нийт	**4422**	**4147**	**2126**	**2899**	**3194**
	Шийдвэрийг хүчингүй болгож, ял оногдуулсан	63	20	7	20	14
	Дахин гэмт хэрэг үйлдэж, ял шийтгүүлсэн	55	29	9	22	23
Хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолыг биелүүлэхийг хойшлуулсан	Нийт	**433**	**269**	**157**	**181**	**176**
	Шийдвэрийг хүчингүй болгож, ял оногдуулсан	1	1	1	-	2
	Дахин гэмт хэрэг үйлдэж, ял шийтгүүлсэн	11	15	3	5	5
	Нийт	**2512**	**2743**	**1956**	**2157**	**2263**

Хорих ялаас хугацаанаас өмнө суллаж, хяналт тогтоосон	Шийдвэрийг хүчингүй болгож, ял оногдуулсан	9	2	8	12	8
	Дахин гэмт хэрэг үйлдэж, ял шийтгүүлсэн	37	34	39	25	19
Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан	Нийт	**368**	**318**	**249**	**409**	**452**
	Шийдвэрийг хүчингүй болгож, ял оногдуулсан	-	1	-	1	1
	Дахин гэмт хэрэг үйлдэж, ял шийтгүүлсэн	6	5	3	6	8
Хөрөнгө, орлогыг хураах албадлагын арга хэмжээ авагдсан	Гүйцэтгэвэл зохих	**961**	**1316**	**1640**	**1951**	**2418**
	Гүйцэтгэсэн	641	808	1161	1067	1367
	Одоо хяналтад байгаа	320	508	479	884	1051
Хуулийн этгээдэд эрх хасах, татан буулгах албадлагын арга хэмжээ авсан	Оны эхэнд	1	2	2	7	5
	Нэмэгдсэн	2	2	6	4	10
	Хасагдсан	1	2	1	6	6
Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан	Оны эхэнд	44	37	36	44	38
	Нэмэгдсэн	27	16	29	19	18
	Хасагдсан	34	17	21	25	18

Албадлагын арга хэмжээг төрлөөр нь сүүлийн 8 жилийн байдлаар авч үзвэл[1]:

Албадлагын арга хэмжээний төрөл	2017 он	2018 он	2019 он	2020 он	2021 он	2022 он	2023 он	2024 он
Хорих ял оногдуулахгүйгээр тэнссэн	344	2053	3890	4422	4147	2126	2899	3194
Хорих ял эдлүүлэхийг хойшлуулсан	25	155	420	433	269	157	181	176
Хорих ялаас хугацаанаас өмнө суллаж хяналт тогтоогдсон	189	1186	2267	2512	2743	1956	2157	2263

[1] Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны тайлан. 2024 он

Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан	42	230	363	368	318	249	409	452
Хөрөнгө орлогыг хураах албадлагын арга хэмжээ авагдсан	2	188	523	961	1320	1677	2000	2471
Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан	0	0	62	71	53	65	63	56
Эрх хасах албадлагын арга хэмжээ авагдсан	0	0	1	3	4	10	11	15
Албадлагын арга хэмжээ авагдсан этгээдийн нийт тоо	602	3812	7526	8770	8854	6240	7720	8627

Дээрх судалгаанаас харахад жил ирэх тусам шүүхээс албадлагын арга хэмжээ оногдуулсан этгээдийн тоон үзүүлэлт нэмэгдэх өсөх хандлага ажиглагдаж байгаа бөгөөд энэ нь Хууль зүй, дотоод хэргийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2017 оны А/247,А/167, 303 дугаар “Жишиг норматив шинэчлэн батлах тухай” тушаалаар батлагдсан “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн ажлын ачааллын жишиг норматив”-т заасан шалгуур үзүүлэлтээс хэд дахин давсан үзүүлэлт гарах бөгөөд алба хаагчдын ажлын ачаалалд сөргөөр нөлөөлөх хүчин зүйлсийн нэг болж байна.

Нийслэлийн 6 дүүргийн харьяалалтай хорих ялаас хугацааны өмнө суллаж, хяналт тогтоосон этгээд, тэнсэх, албадлагын арга хэмжээ авагдсан этгээдүүдийг Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх хэлтсийн дүүрэг хариуцсан шийдвэр гүйцэтгэгч нар шийдвэр гүйцэтгэх ажиллагааг явуулж байна.

2002 оны Эрүүгийн хуулиар Нийслэлийн хэмжээнд тэнсэн харгалзах ялаар шийтгэгдсэн этгээдүүдэд Цагдаагийн байгууллагын 154 хэсгийн байцаагч хяналт тавин ажиллаж байсан бөгөөд 2015 онд батлагдсан Эрүүгийн хуульд заасан албадлагын арга хэмжээ авсан шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг улсын хэмжээнд 68 гаруй ахлах болон шийдвэр гүйцэтгэгч хяналт тавин ажиллаж байна.

Иймд Шүүхээс албадлагын арга хэмжээ оногдуулсан шийдвэр гүйцэтгэх ажиллагаа хариуцсан шийдвэр гүйцэтгэгчийн орон тоог нэн даруй нэмэгдүүлж, ажлын ачааллыг тэнцвэржүүлэн, хууль журмын биелэлтийг нэг мөр хангуулан ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлэх шаардлагатай байна.

Дүгнэлт- Санал

Монгол Улс нь дэлхийн хөгжлийн чиг хандлага, эрүүгийн ялын бодлогын өөрчлөлтийн үр дүнд тулгуурлан нийгэм, эдийн засаг болон хууль зүйн салбарт үзүүлэх үр нөлөө, хэрэгжих боломж нөхцөл зэргийг харгалзан хорихоос өөр төрлийн ял, албадлагын арга хэмжээний төрөл, хэлбэрийг өөрийн орны онцлогт

тохируулан Эрүүгийн хуульд тусгаж, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд хэрэгжүүлэх арга зам, эдлэх хугацааг тодорхой болгож, ялыг ялгамжтай эдлүүлэх эрх зүйн орчин, нөхцөлийг заасан байна.

Хорихоос өөр төрлийн ял, албадлын арга хэмжээг эдлүүлэх ажиллагаанд шүүхийн шийдвэр гарцаагүй биелэгдэх зарчим алдагдаж, ялын биелэлтийг хувиар тооцдог, хорихоос өөр төрлийн ял буюу торгох, нийтэд тустай ажил хийлгэх, тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хасах ял эдлүүлэх ажиллагааг иргэний шийдвэр гүйцэтгэлийн журмаар гүйцэтгэж ирснийг өөрчилж, хуулийн зохицуулалтыг бий болгожээ.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт заасан эрүүгийн хэргийн болон иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэлийг ялгавартай зохион байгуулах зорилт, шинэ эрүүгийн болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуультай уялдуулан хорихоос өөр төрлийн ял, албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий алба, хариуцсан шийдвэр гүйцэтгэгчийг бий болгож, тухайн ялын онцлогт тохируулан шийдвэр гүйцэтгэх ажиллагааг шинээр журамласан байна.

Дээрх хууль эрх зүйн шинэчлэлийн хүрээнд албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэхэд дараах ажлыг зохион байгуулан ажиллах шаардлагатай байна. Энэ нь:

1. Ялын болон ялын гүйцэтгэлийн бодлогын чиглэлээр онолын суурь судалгааг хийх;

2. Албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэх ажиллагаанд нийгэм, олон нийтийн оролцоог хангахад чиглэсэн зохион байгуулалт, эрх зүйн зохицуулалтыг бий болгох;

3. Албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэх шаардагдах техник, тоног төхөөрөмжөөр хангах, алба, хаагчдын орон тоо, ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлэх ажлыг зохион байгуулах зэрэг болно.

ХОРИГДЛЫН ШАШИН ШҮТЭХ, ЭС ШҮТЭХ ЭРХИЙН ХЭРЭГЖИЛТ, АНХААРАХ АСУУДАЛ

IMPLEMENTATION OF PRISONERS' RIGHT TO RELIGION AND NON-RELIGION AND ISSUES TO BE CONSIDERED

Б.Өсөхбаяр

Дотоод хэргийн их сургуулийн Сургалт судалгааны 403 дугаар анги-шшгас-ийн 541 дүгээр дамжааны дэд түрүүч;

Хураангуй: Илтгэлээр хүний шашин шүтэх, эс шүтэх эрхийн мөн чанар, ач холбогдлыг тайлбарлан хорих ял эдлүүлэх ажиллагаан дахь хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх хэрэгцээ, шаардлагыг тодорхойлж, хоригдлын шашны зан үйл үйлдэх, өөр өөр шашны итгэл үнэмшил бүхий хоригдлын хэрэгцээг тэнцвэртэй хангахад чиглэсэн шийдлийг санаачлахыг зорьсон. Судалгааг хууль зүйн шинжлэх ухааны баримт бичгийн дүн шинжилгээ, харьцуулах судлах, анализ, синтез, түүвэрлэн судлан анкетын аргуудыг ашиглан гүйцэтгэсэн бөгөөд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага дахь хоригдлын шашин шүтэх, эс шүтэх эрхэд хандаж буй нийтлэг хандлага, хүний эрхийн зөрчлийг тодорхойлсон болно.

Abstract: The report explained the nature and importance of the human right to religion and non-religion, identified the need and requirements for preventing human rights violations during imprisonment, and sought to initiate a solution aimed at balancing the needs of prisoners. with different religious beliefs and performing religious rituals. The study was conducted using methods of analysis of legal and non-religious documents, comparative research, analysis, synthesis, sampling and questionnaires and determined the general attitude towards the religious and non-religious rights of the prisoner in the judicial decision-making body, namely: as well as violations of human rights.

Түлхүүр үг: Хоригдол, шашин, хүний эрх, шашны зан үйл үйлдэх, шашны зан үйл үйлийн өрөө, хэрэгцээ, зөрчил, нийгэмшүүлэх ажил, хууль зүй.

Key words: Prisoners, religion, human rights, religious practice, religious practice rooms, needs, violations, social work, jurisprudence.

Оршил

Хүний эрхийг хязгаарлах хэрэгцээ, шаардлагыг нийгмийн гишүүд нийтээрээ хүлээн зөвшөөрдөг хэдий ч ямар эрхийг ямар тохиолдолд, хэрхэн яаж хязгаарлах хүрээ, хэмжээг тогтоох тухай асуудалд анхааралтай хандах хэрэгтэй. Учир нь хүн хэмээх байгалийн бодгал нь итгэл үнэмшил, үзэл бодол буюу оюун санааны дархлааг тогтоосноор хүн хэмээх шинж чанараа хадгалж үлддэг билээ.

Хүн төрөлхтний хөгжлийн үе шатыг авч үзвэл тэдний итгэл үнэмшил, үзэл санаа нь хүний нийгмийг, нийгмийн тогтолцоог хөгжүүлэх үндсэн хөшүүрэг болж

ирсэн түүхтэй. Энэ нь нэг талаасаа хувь хүний бие даасан, тусгаар тогтносон байдлыг илэрхийлэх ойлголт болж байна. Үүний нэг томоохон илрэл нь шашны эрх чөлөөгөөр тодорхойлогдож байгаа бөгөөд шашин шүтэх, эс шүтэх эрхийг хангах нь тухайн хүний мөн чанарыг хүлээн зөвшөөрөх, оюун санааны дархлаа болдог онцлогтой. Хэдийгээр манай улс иргэнийхээ шашны эрх чөлөөг нээлттэй хангах асуудлыг Үндсэн хууль хийгээд дотоодын эрх зүйн хэм хэмжээгээр баталгаажуулсан боловч эрх нь хязгаарлагдсан хүмүүсийн хувьд уг эрх чөлөөний асуудал хөндөгдөх болоод байна.

Учир нь хорих ял эдлүүлэх ажиллагаа нь тухайн гэмт этгээдийг олон нийтээс тусгаарлаж түүний гэмт зан үйл, хандлага, дадлыг хорьж засахад чиглэсэн арга хэмжээ билээ. Дэлхий дахинд шашин болон түүнд хандах хүмүүсийн итгэл үнэмшил нь гүн гүнзгий утгатай ойлголт бөгөөд түүнд халдах, итгэл үнэмшлийг няцаах, хясан боогдуулах нь маш ноцтой үр дагаврууд хүргэж болохыг дэлхийн түүх бидэнд харуулсаар ирсэн.

Иймд хоригдлын шашин шүтэх, эс шүтэх эрхийн хэрэгжилт, агуулгад дүн шинжилгээ хийж, хорих ял эдлүүлэх ажиллагааны үр дүнг дээшлүүлэх улмаар ял эдлүүлэх ажиллагаан дахь хүний эрхийн хэрэгжилтийг хангахад илтгэлийн агуулга чиглэгдэнэ. Үүний тулд илтгэлийн агуулгыг шашин шүтэх, эс шүтэх эрх, түүний хэрэгжилт, эрх зүйн зохицуулалт, түүний үзэл санааны хүрээнд судлахыг зорилоо.

Үндсэн хэсэг

Шашны талаар авч үздэг олон үзэл хандлага, номлол, сургаал, эрдэмтдийн тодорхойлолт байдаг. Мөн шашныг нийгмийн талаас, филисофийн үүднээс, эрх зүйн үүднээс хэлзүйн үүднээс гээд олон өнцгөөр тайлбарлаж болно. “Шашин” хэмээх ойлголтыг тодорхойлолтуудыг авч үзвэл Шашин нь хүмүүсийн үйлддэг, аливаа номлолыг дагадаг сүсэг бишрэл, ёс суртахуунуудыг хэлнэ[1]. “Шашин нь бурхан эсвэл бурхад байдаг гэдэгт итгэх итгэл, тэднийг шүтэн бишрэх зан үйл эсвэл сүнслэг удирдагчийн сургаал”[2] юм гэж тодорхойлсон байдаг. Мөн Я.Цэвэлийн Монгол хэлний товч тайлбар тольд шашныг “Бурхан сүнс гэх мэтийн ер бусын хий хоосон зүйлд шүтэх бишрэх тэргүүтний цогц болох үзэл суртлын нэг зүйл давхрага”[3] гэж тайлбарлажээ. Харин Үндэсний статистикийн хорооноос 2020 онд гаргасан “Сүм хийдийн салбарын танилцуулга”-д “Шашин шүтлэг нь хүн төрөлхтөн үүсч, оршин тогтносон цагаасаа өөрсдийн амьдралд бий болгосон дэлхий дахины нийтлэг үзэгдэл бөгөөд шашныг ертөнцийг үзэх үзэл, оюун санааны учрыг тайлах, хүн төрөлхтний итгэл үнэмшил, сүсэг бишрэлийн цогц” [4] гэж тодорхойлсон байна.


[1] https://mn.wikipedia.org/wiki/
[2] https://www.oxfordlearnersdictionaries.com/
[3] Цэвэлийн Монгол хэлний товч тайлбар толь https://tsevel.toli.query.mn/;
[4] Үндэсний статистикийн хороо. Сүм хийдийн салбарын танилцуулга. 2020 он. УБ хот. 5 дахь нүүр.

Эдгээрээс үзвэл шашин гэдэг нь хүний аливаад итгэх итгэл, сүсэг бишрэл бөгөөд уг итгэл үнэмшлийнхээ хүрээнд тодорхой зан үйл үйлдэх байдал гэж ойлгож болох юм. Нэг үгээр хүний зан үйлийн салшгүй нэг хэсэг болох нь харагдаж байна.

Шашин нь танин мэдэхүйн хэлбэрээр байгаль нийгмийн үзэгдлийг тайлбарлах замаар хөгжиж ирсэн ч өдгөө хүний мөн чанар, оюун санааны дархлааг тогтоох хүмүүнлэг хийгээд хүмүүжлийн хэрэгсэл болоод байна. Шашин нь өөртөө сүм хийд, лам хуврага, сургааль номлол зэрэг олон ойлголтуудыг багтаасан өргөн хүрээтэй ухагдахуун юм. Шашин шүтлэгийн анхны хэлбэрүүд одоогоос 100-40 орчим мянган жилийн тэртээ Неандарталь /анхны ухаант хүн/ хүмүүсийн үед үүссэн гэж хэд хэдэн түүхэн эх сурвалжуудад дурдсан байна.

Дэлхий дээр 4000 гаруй шашин, шашны урсгал байна гэсэн тооцоолол байдаг[1]. Эдгээрээс дэлхийн хүн амын дийлэнх олонхи нь Христ, Ислам, Буддизм, Хинду, Йудайн гэсэн үндсэн таван шашинд сүсэглэдэг хэмээн судлаачид ангилсан байна. Буддизм, Ислам, Христийн шашин нь өөрийн сүм, лам, номлогч, мөргөл, буян үйлдэх тусгай зан үйлтэй байдаг. Эдгээрээс үзэхэд шашин болгон өөрийн үзэл баримтлал, итгэл үнэмшилд суурилсан тус тусын зан үйлийн хэлбэрээр илэрхийлэгддэг.

График №1. Олон улсын PEW судалгааны төвөөс 2023 онд гаргасан шашны томоохон бүлэглэлүүдийн дэлхийн нийт хүн амд эзлэх хувийг харуулсан судалгаа[2]:



Уг судалгаанаас харахад 2023 оны байдлаар дэлхийн нийт хүн ам болох 8.02 тэрбум[3] хүнээс огт шашин шүтлэггүй нь 15,1% болох 1.2 тэрбум орчим, шашин шүтлэгтэй хүн амын тоо нийт хүн амын 84,4% буюу 6.82 тэрбум хүнийг хамарч байгааг харж болно.

[1] https://www.caaknews.mn/view/8303808

[2] Pew судалгааны төвийн Шашин ба нийтийн амьдрал төсөл. Pew Research Center's Religion & Public Life Project. 2012 он. https://www.pewresearch.org/religion/2012/03/22/pew-forum-releases-new-50-state-survey-of-prison-chaplains/

[3] https://www.statista.com/statistics/805044/total-population-worldwide/, Сүүлд нэвтэрсэн: 2024.10.31 19:35 минут

Дэлхийн шашин шүтлэгтэй хүн амын 30,7% буюу 2.61 тэрбум орчим хүн Христийн шашныг шүтэж байгаа нь дэлхийн хамгийн нөлөө бүхий шашны урсгалд тооцогдож байгааг харуулж байна. Удаах байранд Ислам, Хинду, Будда буюу буддын шашин хамаарч байна.

Эдгээр нь хүн ялангуяа хүний хүмүүжил, төлөвшилд шашны үзүүлэх нөлөө, байр суурийг ямар гүн бат болохыг харуулж байна. Энэ ч утгаараа Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөг хуулиар баталгаажуулсан орон болохын хувьд хүмүүс өөрсдийн шүтэх шашнаа чөлөөтэй сонгох эрхтэй.

2020 оны судалгаагаар Монголчуудын 51.8 хувь нь Будда, 3.2 хувь нь Ислам, 2.5 хувь нь Бөө, 1.3 хувь нь Христ, 0.6 хувь нь бусад шашин шүтдэг гэжээ.[1] Үүнээс харахад нэг төрлийн шашны үзэл, хандлагыг хүлээн зөвшөөрөх нь нийгмийн гишүүдийн тэгш байдлыг хангах боломжгүйд хүргэх эрсдэлтэй байгааг тодорхойлж байна. Мөн үндэсний статистикийн хорооноос 2 жил тутам гаргадаг “Сүм хийд” танилцуулгын 2024 оны дугаараас Монгол улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг Сүм хийдийн тоог, шашны төрлөөр нь ялган харуулсан судалгааг авч үзье.

График №2. Үндэсний статистикийн хорооноос гаргасан Монгол улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг Сүм хийдийн тоог, шашны төрлөөр ялган харуулсан судалгаа[2].



График №3. Монгол Улсын хэмжээнд сүм хийдийн эзлэх хувь

[1] АНУ-ын Элчин сайдын яам, “Олон улсын шашны эрх чөлөөний тайлан – Монгол Улс 2019,” https://mn.usembassy.gov/mn/our-relationship-mn/official-reports-mn/2019-international-religious-freedom-report-mn/ ; “Хүн ам,” Статистикийн мэдээллийн нэгдсэн сан, https://www.1212.mn/haos/haoscount.aspx

[2] Статистикийн мэдээллийн нэгдсэн сан, Сүм хийдийн танилцуулга. 2024 он. https://downloads.1212.mn/0gCx-43Y3KuFRrtz-eM_ErwDgZWBXI6AX4sF8y7l.pdf



Судалгаанаас үзвэл 2023 оны байдлаар Монгол Улсын хэмжээнд нийт 371 сүм хийд үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд өмнөх оноос 25 (7.2%)-аар өссөн тоон үзүүлэлттэй байна. Сүүлийн 5 жилийн хугацаанд Христийн шашны урсгалын сүм хийдийн тоо тэргүүлж байгаа бөгөөд Буддын шашны сүм хийдийн тоо өсөх хандлагатай байна. Нийт сүм хийдийн 56.3 хувь нь Христийн, 35.6 хувь нь Буддын, 6.2 хувь нь Исламын, 1.9 хувь нь бусад төрлийн шашных байна.[1]

Хүний эрхийн түгээмэл тунхаглал[2]-ын 18 дугаар зүйлд "Хүн бүр чөлөөтэй бодож сэтгэх, шашин шүтэх, эс шүтэх эрхтэй. Энэхүү эрхэнд шашин буюу шүтлэгээ өөрчлөх эрх чөлөө, бие даан буюу бусадтай хамтран нийтийн өмнө болон хувийн журмаар хичээл заах, хурал мөргөл хийх, шашны хийгээд зан үйлийн ёслол үйлдэх зэргээр шашин буюу шүтлэгээ номлох эрх чөлөө багтана" гэж тодорхойлсон нь шашин шүтэх эрхийг хүндэтгэх, хүлээн зөвшөөрөх хэрэгцээг тодорхойлж өгсөн явдал юм.

Монгол Улсад төр, сүм хийдийн харилцаанд баримтлах зарчмыг Үндсэн хуулиар тогтоож өгсөн ба дараах байдлаар тодорхойлсон. Үндсэн хуулийн 9.1-д "Монгол Улсад төр нь шашнаа хүндэтгэж, шашин нь төрөө дээдэлнэ," 9.2-т "Төрийн байгууллага шашны, сүм хийд улс төрийн үйл ажиллагаа эрхлэн явуулж болохгүй," 9.3-т "Төр, сүм хийдийн хоорондын харилцааг хуулиар зохицуулна" гэж тусгайлан заасан. Мөн, төр, сүм хийдийн харилцааг хуулиар зохицуулахдаа Үндсэн хуулийн 16.15, 16.6-д хүлээн зөвшөөрсөн "шашин шүтэх, эс шүтэх," "итгэл үнэмшилтэй байх" эрх чөлөө, Үндсэн хуулийн 1.2-т "ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх" зарчмыг хүндэтгэх үүрэгтэй. Жишээлбэл, төр аливаа шашны маргаанд аль нэг талд тал засах, тодорхой шашны байгууллага эсхүл түүний удирдагчийн талд орох, шашны байгууллагыг бүртгэхэд хэлбэрийн бус агуулгын шаардлага тавих зэрэг нь төвийг сахиагүй хэрэг тул тэгш байдлыг зөрчинө. Мөн, шашин хоорондын аливаа ялгаа нь

[1] Мөн тэнд

[2] Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 217/A/III/ тогтоолоор 1948 оны 12 дугаар сарын 10-ны өдөр баталж, түүний бүх заалтыг дагаж мөрдөхийг гишүүн улсуудад уриалжээ. https://legalinfo.mn/mn/detail/1271

зүй ёсны объектив хүчин зүйл, үндэслэлээр зөвтгөгдөх бөгөөд ялгаварласан хандлага гаргахгүй байх шаардлагатай. Учир нь, Үндсэн хуулийн 14.1-д “хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна,” “Хүнийг… шашин шүтлэгээр нь ялгаварлан гадуурхаж үл болно” гэж заасан тул төрөөс шашин эсхүл итгэл үнэмшлийн эрх чөлөөг ямар ч ялгаварлан гадуурхалгүйгээр эдлүүлэх ёстой[1]. Энэ шашин шүтэх эрх болон тэрхүү эрхийг хүлээн зөвшөөрч, хүндэтгэж, хангах асуудал нь нийгмийн суурь харилцаа болохыг нэмэн тодотгосоор байна.

Тэгвэл уг эрх нь юм, үзэгдлийн мөн чанар, учир шалтгааныг тайлбарладаг тодорхой номлол, сургаалыг өөрийн дотоод сэтгэл, итгэл үнэмшлээрээ эрхэмлэн дээдлэх, түүний дагуу зан үйлийг нь бусдын албадлага, хязгаарлалтгүйгээр, нийтээр хүлээн зөвшөөрсөн ёс суртахууны хэм хэмжээний хүрээнд гүйцэтгэх боломж хэмээн авч үзэж болно. Шашин эс шүтэх эрх чөлөө гэж Монгол Улсын иргэн юм, үзэгдлийн мөн чанар, учир шалтгааныг тайлбарладаг тодорхой номлол, сургаалыг өөрийн итгэл үнэмшил болгохоос татгалзах, бусдын албадлага, шахалтаар хүлээн зөвшөөрөх, зан үйлийг нь гүйцэтгэх шаардлагаас хамгаалагдах боломж[2] хэмээн тодорхойлсон байна.

Уг үзэл баримтлалын хүрээнд Төр, сүм хийдийн харилцааны тухай хууль[3]-д “Шашны зан үйлийг тухайн шашны уламжлалт ёс журмын дагуу энэ хууль, бусад хууль тогтоомжоор тусгайлан хориглоогүй газарт сүсэгтний хүсэлтээр тэдэнд зориулж чөлөөтэй үйлдэж болно” хэмээн заасан байдаг ба хорих ял эдлүүлэх ажиллагаанд ч мөн адил хоригдлын шашны зан үйл үйлдэх боломжийг хорих байгууллагын зүгээс хангаж өгөх шаардлагатай болохыг тодорхойлж байна.

Ийнхүү шашин нь хувь хүн болон нийгмийн сэтгэл зүй, ёс зүй, дэг жаяг, амьдралын хэв маягтай уялддаг тул өөр өөр шашин шүтлэгтэй хүмүүсийн хооронд сэтгэл зүй, ёс зүй, нийгэмд мөрдөх дэг ёс, амьдралын хэв маягийн ялгааг хувь хүн, нийгмийн бүлэг, институциуд харилцан ойлголцох, харилцан хүлээн зөвшөөрөх нь чухал болохыг харуулж байна.

---

[1] Монгол Улсын Их сургуулийн Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэн. “Шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө” (Эмхэтгэл). О.Мөнхсайхан “Итгэл үнэмшилтэй байх шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө” өгүүлэл. 2022 он. 52 дахь тал.

[2] ХЭҮК, Залуу судлаачдыг дэмжих сан ТББ. Монгол улсын үндсэн хуулийн хоёрдугаар бүлэгт туссан хүний эрхийн заалтуудад системийн инженерчлэлийн аргаар тодорхойлолт боловсруулах нь судалгааны тайлан. УБ хот, 2024 он, 55 дахь тал.

“Хүний эрхийн нэр томьёонд системийн инженерчлэлийн аргаар тодорхойлолт боловсруулах нь” судалгааны ажлыг “Залуу судлаачдыг дэмжих сан” ТББ-ын нийт 12 судлаачийн багийн бүрэлдэхүүнтэйгээр 2023 оны 04 дүгээр сарын 21-ний өдрөөс 2024 оны 3 дугаар сарын 31-ний хооронд нийт 11 сарын хугацаанд 3 үе шаттайгаар хийж гүйцэтгэсэн байна.

[3] Төр, сүм хийдийн харилцааны тухай хууль. Төрийн мэдээлэл эмхэтгэл. 1993 он. №06-07

Харин хорих байгууллагын хувьд уг эрхийн агуулгыг тодорхойлохдоо Хоригдолтой харьцах наад захын жишиг дүрэм /Манделийн дүрэм/д[1] “Хорих газарт аль нэг шашныг шүтдэг хангалттай тооны хоригдол байвал тухайн шашны мэргэжлийн ламыг томилох буюу хорих газарт зохих зан үйл явуулах зөвшөөрөл олговол зохино. Хэрэв ийм хоригдол их олон бөгөөд боломжтой бол ламыг байнга ажиллуулахаар томилно. Томилогдсон буюу зөвшөөрөгдсөн мэргэжлийн лам нь шашны зан үйлийг тогтоосон цагт байнга явуулах, тухайн шашныг шүтдэг хоригдолтой ганцаарчлан уулзаж, шашны сэдвээр ярилцах боломжтой байх ёстой. Аль ч шашны мэргэжлийн ламтай хоригдол уулзах боломжийг хязгаарлаж болохгүй. Нөгөө талаас хоригдол ламтай уулзахыг эсэргүүцвэл түүний хүсэлтэд бүрэн хүндэтгэлтэй хандах ёстой. Хоригдол бүр хэрэгжүүлж болох хүрээнд шашны зан үйл явуулахад оролцож, өөрийн шашны ном зохиолтой байж шашны хэрэгцээгээ хангах боломжтой байх ёстой гэж заасан байдаг.

Үүнээс үзвэл уг харилцааг нарийвчлан зохицуулсан хууль тогтоомжоор эдгээр эрхийн агуулгыг тодорхойлох ёстой болохыг сануулж байна. Манай улсын хувьд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль[2]-аар хоригдлын шашны зан үйл үйлдэх эрхийг хүлээн зөвшөөрсөн.

Гэсэн хэдий ч хүний эрхийн үүднээс нарийвлан авч үзвэл хоригдын уг эрхийн хэрэгжилтэд тодорхой асуудлууд үүссээр байгааг анхаарах судлах, шийдэл саналуудыг санал болгох шаардлага байгааг онцлох хэрэгтэй.

Шашны зан үйл үйлдэх нь хүний сэтгэл зүй, ёс суртахуун, нийгэмшил, зан үйл, хандлагын төлөвшилд эерэг нөлөөтэй болох нь судалгаагаар тодорхойлогддог.

Монгол Улсад хорих ял эдлүүлэх ажиллагааны салбарт шашин шүтэх эрхийг төдийлөн чухалчлан авч үзэхгүй байх, хэлбэрийн түвшинд уг эрхийг хангах зэрэг өрөөсгөл хандлага оршсоор байгааг дурдах хэрэгтэй. Ингэснээр хэдийгээр хорих ял эдэлж байгаа тухайн хүний эрхийг хязгаарлах шалтгаан болж байгаа хэдий оюун санаа, итгэл үнэмшлийн хувьд гадуурхагдах, эрхээ хязгаарлуулах шалтгаан болоод байна. Нэг үгээр итгэл үнэмшлийг нь ойлгож хүндэтгэхгүй байх нь тухайн хүний олон нийтэд хүлээн зөвшөөрөгдөх, хүндлэгдэх хэрэгцээ шаардлагыг үгүйсгэж байгаа ноцтой зөрчил болно. Гэтэл Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хэмжээнд уг эрхийг чухалчлан авч үзэхгүй байгаа нь хорих ял эдлүүлэх ажиллагааны зорилго, хоригдлын нийгэмшүүлэх хэрэгцээ шаардлагад харш үйл ажиллагаа болоод байгааг нийтэд анхааруулах, түгээн дэлгэрүүлэх хэрэгтэй болсныг сануулж байна.

[1] Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрэм. 1955 онд Женевт хуралдсан НҮБ-ын нэгдүгээр их хурлаар баталж, эдийн засгийн болон нийгмийн зөвлөлийн 1957 оны 7 дугаар сарын 31-ний 663 C/XX1Y/ 1977 оны 5 дугаар сарын 13-ны 2076 /1X11/ тогтоолд сайшаав.

[2] Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль. Төрийн мэдээлэл эмхэтгэл №24. 2017 он.

“Хоригдлын шашин шүтэх, эс шүтэх эрхийн хэрэгжилтийн талаарх судалгаа”-г 2024 оны 10 дугаар сарын байдлаар хорих ял эдэлж буй хоригдлуудаас анкетын аргаар түүвэрлэн авч, нэгтгэсэн юм.

Судалгаанд ШШГЕГ-ын харьяа 3 хорих ангийн нийт 183 хоригдол хамрагдсан бөгөөд эдгээрээс 84 эмэгтэй, 99 нь эрэгтэй хоригдлууд оролцсон байна.

График №4. Хоригдлын шашин шүтэх шүтлэгийн хувийг харуулсан судалгаа




Судалгаанд хамрагдсан нийт хоригдлуудын 87% нь шашин шүтдэг, 23% нь шашингүй гэж хариулсан байна. Эдгээрийг задлан авч үзвэл буддын шашинтай гэж 44%, бөө мөргөлийн шашинтай 18%, Христийн шашинтай 10%, Исламын шашинтай гэж 3%, бусад шашныг шүтдэг гэж 2% нь тус тус хариулсан байна.

График №3. Хорих ангиудад байх шашны өрөөний нөхцөл



Дээрх судалгааны дүнгээс харахад судалгаанд хамрагдсан хоригдлуудын 72% нь хорих ангийн шашны өрөө нь буддын шашны зан үйл үйлдэхэд тохиромжтой байдлаар тохижуулагдсан байдаг гэж хариулсан байна.

Зураг №2,3 Хорих ангийн шашны зан үйлийн өрөө





Улсын хэмжээнд нийт 20 хорих анги үйл ажиллагаа явуулж байгаагаас бүх хорих анги нь буддын шашны зан үйл үйлдэх өрөөг тохижуулсан байдаг байна.

“Хоригдлын шашин шүтэх, эс шүтэх эрхийн хэрэгжилтийн талаарх судалгаа”-ны үр дүнд хорих ангийн шашны зан үйл үйлдэх өрөө хоригдлын хэрэгцээ шаардлагад хангалттай нийцдэг эсэхийг тандахад нийт хоригдолын 59.3% нь нийцдэг, 40.6% нийцдэггүй гэж хариулсан нь мөн л нийт хоригдлуудын дунд буддын шашинтан хоригдлуудын хувь хэмжээ их байдаг, шашны зан үйлийн өрөө нь буддын шашны хэв маягаар тохижуулагдсан мөн хорих ял эдлүүлэх ажиллагааны дэг журамтай байдалтай холбоотой байж болох юм.

Энэ нь буддын шашинтай хоригдлуудын хувьд шашин шүтэх эрх чөлөөг нь эдлүүлэх боломжоор хангасан ба Христ, Ислам, Хинду болон бусад шашинтай хоригдлуудын эрхийг хангахгүй байна.

Судалгааны хүрээнд хоригдлууд шашны зан үйл үйлдэхэд хүндрэлтэй асуудлуудыг тодруулахад тогтсон цагийн хуваарь байхгүй (35 хувь), шүтдэг шашны урсгалын хэрэглэгдэхүүн байхгүй (27.6 хувь), өрөөний тохижилтоос болж зан үйл үйлдэх боломжгүй (20.1 хувь), цөөхөн хүний багтаамжтай учраас багтдаггүй (17.1 хувь) гэх судалгааны үр дүн гарсан юм.

Эдгээр бэрхшээлүүд нь хоригдлуудын шашны зан үйлээ гүйцэтгэхэд тодорхой бэрхшээлүүдийг дагуулдаг бөгөөд нийт судалгаанд оролцогч нарын 27.6% нь шүтдэг шашных нь хувцас, эдлэл, хэрэглэл байхгүй байгаатай холбоотойгоор эрх нь зөрчигдөж байна гэж үзсэн.

Нийт хоригдлын хувьд авч үзвэл хоригдлын шашин шүтэх эрхийг хангаж байгаа боловч бусад шашин шүтдэг хоригдолд өөрийн итгэж үнэмшдэг шашны зан үйлийг үйлдэх боломжгүй, оюун санаа, сэтгэл зүйн хувьд тайвширах, бясалгах нөхцөлийг хангахгүй байх нь хорих ялаар дамжуулан хүмүүст сэтгэл зүйн дарамт, үл хүндлэдгэх, хүлээн зөвшөөрөгдөхгүй байх мэдрэмжийг төрүүлж байна. Мөн

хорих ангийн үйл ажиллагааны зохион байгуулалт буюу хорих ангийн дотоод цагийн хуваарь нь уг эрхийг хүлээн зөвшөөрөхгүй байх нөхцөл бүрдүүлж байна.

Эрх чөлөөгөө хасуулж нийгмээс тусгаарлагдсан ч тэдний оюун санааны эрх чөлөө, шашны итгэл үнэмшил, сүсэг бишрэлээ хадгалах, итгэн үнэмших, амар амгаланг мэдрэх тэрхүү боломж, эрх чөлөөг нь хязгаарлаж байгаа нь хувь хүний хүмүүжил, төлөвшилд ноцтой хор уршиг учруулж болно.

Тухайлбал, Бэйлорын их сургуулиас хийсэн судалгаагаар [1] шорон дахь шашны үйл ажиллагаа нь криминологийн судалгаанд хувь нэмэр оруулж, нийгэмд эерэг хандлагыг төлөвшүүлэх, хоригдолын хувийн гэмт зан үйл, шинж чанарыг өөрчлөхөд тусалдаг бөгөөд суллагдсаны дараа дахин нийгэмшихэд чухал ач холбогдолтой болохыг онцлон тэмдэглэсэн байна. Дэлхийн бусад улс орны хорих ангиуд хоригдлуудын шашин шүтэх, эс шүтэх эрхийг хамгаалах үүднээс шашны зан үйл үйлдэх өрөөгөө хоригдлын янз бүрийн шашны зан үйл үйлдэхэд боломжтой байдлаар тохижуулсан байдаг ба шашин болгон өөрийн гэсэн онцлог, хэрэглэгдэхүүн, үзэл, номлол, сургааль, зан үйлтэй тул тэд ихэвчлэн төвийг сахисан буюу аль нэг шашны хэрэгсэлийг байршуулж тохижуулахаас илүү орчин, тав тухыг сайтар хангасан, олон урсгалын шашны ном, судруудыг багтаасан, хувийн орон зай, дуу чимээний тусгаарлагчтай, аюулгүй байдлыг хангасан байдлаар тохижуулсан байдаг байна.

Америкийн Нэгдсэн улсын Хууль зүйн яамны хийсэн судалгаагаар[2] сэтгэл санаа, ёс зүйтэй холбоотой дэмжлэг авсан хоригдлуудын дахин гэмт хэрэг үйлдэх магадлал 10-20% хүртэл буурдаг ба шашин шүтлэгтэй хоригдлууд сэтгэл санааны хувьд илүү тогтвортой байж, цөөн зөрчил гаргадаг болохыг тогтоосон байна. Тус улс нь хоригдлууд нь шашны зан үйлээр дамжуулан сэтгэл санааны тогтвортой байдал, нийгэмшилт, үнэт зүйлс, ёс суртахууны мэдрэмж, гэмшил, хариуцлага хүлээх ухамсрыг олж явдаг гэж үздэг.

Америкийн нэгдсэн улсын хувьд хоригдлуудын шашин шүтэх, эс шүтэх эрхийг Үндсэн хууль, Шашны эрх чөлөөг хамгаалах тухай хууль (Religious Freedom Restoration Act, RFRA), мөн Шашны газар болон институцийн хүмүүсийн эрхийн тухай хуулиар (Religious Land Use and Institutionalized Persons Act, RLUIPA) зохицуулдаг. 1993 онд батлагдсан Шашны эрх чөлөөг хамгаалах тухай хууль

[1] Byron R. Johnson, “How Religion Contributes to the Common Good, Positive Criminology, and Justice Reform”. 2021. https://www.mdpi.com/2077-1444/12/6/402
Судалгаанд шашин нь хоригдлуудын амьдралд хэрхэн эерэгээр нөлөөлж, нийгмийн сайн сайхны төлөө ямар үүрэг гүйцэтгэж байгааг шинжилсэн байдаг. Судалгаагаар шашин шүтлэг, ялангуяа сүсэгтэн сайн дурынхан болон шашны байгууллагуудын оролцоо нь гэмт хэргийн давталтыг бууруулах, засаж хүмүүжүүлэх үйл явцыг дэмжихэд ихээхэн нөлөөлж байгааг харуулжээ. Шашны зан үйл нь хоригдлуудад ёс суртахуун, өөрийгөө хянах чадвар, өөрчлөгдөх боломжийг олгож, дахин гэмт хэрэг үйлдэх магадлалыг бууруулахад тусалдаг гэж үзсэн байна .
[2] АНУ-ийн Хууль зүйн яамны хийсэн судалгаа. https://www.ojp.gov/

(RFRA) [1] нь төрийн байгууллагуудад шашны эрх чөлөөнд саад болохоос зайлсхийх үүргийг хүлээлгэсэн байна.

АНУ-ын хорих ангийн систем нь хоригдлын шашин шүтэх эрхийг хүлээн зөвшөөрч, шашны зан үйл үйлдэх боломжийг олгож, тэдгээрт шашны итгэл үнэмшилд нийцсэн хоолны сонголтыг санал болгох, шашны удирдагч зөвлөхтэй уулзуулах, шашны итгэл үнэмшилтэй холбоотой эд зүйлсийг хангаж өгөх зэрэг байдлаар хоригдлын эрхийг хангаж, аюулгүй байдлыг хамгаалан ажилладаг болохыг анхаарах хэрэгтэй.

ДҮГНЭЛТ

Хүний оюун санаа, нийгмийн хөгжил хөдөлгөөнийг тодорхойлогч томоохон хүчин зүйл нь шашин шүтэх, эс шүтэх эрхээр дамжин хэрэгждэг бөгөөд нийгмийн суурь харилцааны нэг болох нь харагдаж байна. Иймд шашин шүтэх эрх чөлөөг хангах, бэхжүүлэх явдал нийгмийн бүхий түвшинд зайлшгүй анхаарч хүлээн зөвшөөрөх ёстой болохыг олон улсын болон дотоодын эрх зүйн хэм хэмжээгээр тодорхойлогджээ.

Дэлхий дээр нийт 4000 гаруй шашны урсгал байдаг ба Монгол Улсын хувьд Буддын шашин, Христийн шашин, Исламын шашнуудын чиг хандлага давамгайлдаг бөгөөд сүүлийн жилүүдэд Тэнгэр шүтлэг буюу Бөөгийн зан үйлийг түлхүү хэрэглэх болсон. Шашин шүтлэгийн хамгийн чухал зүйл бол итгэл үнэмшлийнхээ хүрээнд тодорхой цаг хугацаанд, орчин нөхцлөө бүрдүүлэн сүсэглэн залбирах, мөргөл үйлдэх зэрэг шашны онцлогийг шингээсэн итгэл үнэмшил бүхий зан үйл үйлдэх явдал байдаг.

Хорих ял эдлэх нь тухайн хүнийг нийгэмшүүлэх, засан хүмүүжүүлэх үндсэн зорилгыг агуулж байгаа бөгөөд түүнд үзүүлэх шашны нөлөө хоригдлын засрал хүмүүжил, сэтгэл зүйн тогтвортой байдлыг дэмжихэд ихээхэн оролцоотой болох нь харагдаж байна.

Хорих ял эдэлж буй хүмүүсийн дунд олон төрлийн шашны үзэл хандлага, итгэл үнэмшил бүхий хүмүүс байгаа нь хорих байгууллагад хоригдлын эрхийг хангасан хэд хэдэн төрлийн шашны зан үйлийг хэрэгжүүлэх боломж нөхцөл бүрдүүлэх ёстойг тодорхойлж байна.

Хорих ангийн шашны зан үйл үйлдэх өрөөг бүх урсгалын шашны зан үйл үйлдэх нөхцөл боломжоор хангаагүй, нэг төрлийн шашны урсгалыг дагнаснаараа бусад хоригдлын шашин шүтэх эрхийг зөрчиж, хүндэтгэлгүй хандсан нь иргэдийн эрхийг хангагч төрийн иргэдийгээ шашин шүтлэгээр ялгаварлахгүй хүндэтгэлтэй

[1] Religious Freedom Restoration Act of 1993. https://www.congress.gov/bill/103rd-congress/senate-bill/578

хандах үүргийи зөрчил гэж харж болох юм. Уг боломж нөхцөлөөр хангаагүйгээс хүний эрхийн ноцтой зөрчил хорих ял эдлүүлэх ажиллагаанд бий болсоор байна.

САНАЛ

Нэг. Эрх зүйн зохицуулалтын хүрээнд:

1. Ламтай хоригдол уулзах боломжийг хязгаарлаж болохгүй талаар ШШГТХ-д тусгах

2. Шашны зан үйл үйлдэх цагийн хуваарь, зохицуулалтын талаар хорих ангийн дотоод журам эсвэл холбогдох бусад дүрэм журамд тусгах.

3. Шашны төлөөлөгч лам, номлогч нартай тогтмол уулзах боломжоор хангах, тэдгээрийн уулзалтын талаар эрх зүйн зохицуулалт тусгах

4. Хорих ангийн шашны зан үйлийн өрөөний стандартыг тогтоох

Хоёр. Шашны зан үйл үйлдэх өрөөг төвийг сахисан байдлаар буюу олон шашны зан үйл үйлдэх боломжоор хангаж тохижуулах:

5. Хоригдлын хувийн орон зай, дуу, чимээний тусгаарлалт хийж төвлөрөх боломжийг олгосон байх

6. Залбирал, бясалгал хийхэд зориулагдсан сандал, дэвсгэр зэргийг байрлуулах

7. Шашны номлол, сургаалыг авч үзэх боломжоор хангасан байх

8. Шашны төлөөлөгч ламтай ганцаарчлан уулзах боломжоор хангах

9. Олон төрлийн шашны ном, сурах бичгийн хэрэгцээг хангах номын фондтой байх.

УГСААТНЫ БҮЛЭГТЭЙ АЖИЛЛАХ НИЙГМИЙН АЖЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОНЦЛОГ, АНХААРАХ АСУУДАЛ /ХОРИХ БАЙГУУЛЛАГЫН НИЙГМИЙН АЖЛЫН ЖИШЭЭН ДЭЭР/

FEATURES AND ISSUES OF SOCIAL WORK SERVICES WORKING WITH ETHNIC GROUPS /ON THE EXAMPLE OF SOCIAL WORK IN A PRISON/

Г.Батжаргал

Дотоод хэргийн их сургууль Сургалт, судалгааны 403 дугаар анги Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн Нийгмийн ажил, сэтгэл зүйн тэнхимийн ахлах багш, хошууч

Хураангуй: Глобалчлагдаж байгаа дэлхий ертөнцөд угсаатны бүлэгтэй ажиллах нийгмийн ажил туйлын чухал болоод байна. Аливаа нийгэмд амьдарч байгаа хүн нийгмийн гишүүн болохын хувьд нас, хүйс, сошиал статусаасаа хамаарааД үнэт зүйл, зан үйл, амьдрах хэв маяг, дүр нь ялгаатай байдгийн адил тухайн хүн ямар "угсаатан"-ы бүлэгт хамаарч байгаагаас шалтгаалж мөн л ялгааг үүсгэж байгаа нь угсаатны бүлэгтэй ажиллах нийгмийн ажлын үйлчилгээний арга зүйг боловсруулах үндсэн шаардлага болж байна.

Ялгаатай байдал эсвэл олон талт байдал гэж орчуулах энэ ойлголт нь хүн бүр тодорхой нийтлэг шинжээрээ өөр бусдаасаа ялгагдана. Орчин үеийн нийгэмд хүний ийм тал шинж бүр нь нийгмийн харилцаанд нөлөө үзүүлдэг. Жишээ нь АНУ-д "африк" гаралтай америкчууд арьсны өнгөөрөө, Германы "туркууд" хөдөлмөрийн гэрээгээр ирээд үлдсэн цагаачид, БНХАУ-ын "өвөрмонголчууд" нь "үндэсний цөөнх", Солонгост албан ёсоор ажил эрхэлдэг "Монголчууд" нь "гадаад ажилчин" гэдгээрээ, Европт үйл олноороо очоод байгаа сирийн "дүрвэгсэд"-ийн асуудал нь тэдний "олон талт байдал" нь холбоотой, мөн нийгэмд эзлэх байр суурь нь ижилгүй. Үүнтэй холбоотой "гадаад ажилчин", "үндэсний цөөнх", "цагаач", "дүрвэгсэд", "угсаатны бүлэг" гэсэн ялгаатай ойлголтууд гарч ирдэг. 1990 оноос хойш дэлхий ертөнцөд нэг талаас угсаатантай холбоотой үндсэрхэг үзэл, соёл, шашны сэргэлт хүчтэй болж нөгөө талаасаа глобалчлал хөгжилтэй холбоотой улс орнуудад олон янзын угсаатны бүлэг зэрэгцэн амьдрах болов. Иймд угсаатны нийгмийн ажлыг нийгмийн ажлын салбар бүрд судалж, хөгжүүлэх нь чухал байна.

Түлхүүр үг: Угсаатны бүлэг, үндэсний цөөнх, нийгмийн ажил,

Удиртгал

"Нийгмийн ажлын судалгаа" хэмээх нийгмийн ажилтнуудын мэргэжлийн сэтгүүлд Бонгки Вуу, Виктор Фугиерео, Роберт Росалес зэрэг зохиогчдын "Угсаатан ба арьсны асуудал нийгмийн ажилд байдаг уу?" гэсэн мэргэжлийн сэтгүүлд нийтлэгдсэн 634 өгүүлэлд шинжилгээ хийж үзэхэд ихэнх нь угсаатан, арьсны ялгаатай бүлгийг судалгааны ажлын үндсэн бүлэг бус харин хяналтын

хавсарга бүлгээр авч үзсэн, маш цөөхөн өгүүлэлд угсаатан, арьсны бүлгийн асуудлыг тусгайлан нухацтай судалсан өгүүлэл нийтлэгдсэн болохыг илрүүлжээ. Үүн дээр үндэслэн зохиогчид дэлхий даяар ч гэсэн нийгмийн ажлын боловсрол хөгжилд "угсаатан"-ы асуудлыг тусгах, анхаарлын төвд оруулах хандлага хүчтэй байна. [1]

Монгол орон нь (homogene) буюу нэг угсаатан давамгайлсан хүн ам зүйн бүтэцтэй орон боловч “үндэсний цөөнх" казах, тува иргэдийн нөхцөл байдлыг бодитой танин мэдэж тэдгээр бүлгийн хэрэгцээ шаардлагад нийцсэн нийгмийн ажлын үйлчилгээг үзүүлэх шаардлагатай юм.

Тухайлбал: 1. Монголын хамгийн олон үндэсний цөөнх, угсаатны дэд бүлэг оршин суудаг Ховд аймагт ажиллах нийгмийн ажилтан үйлчилгээ үзүүлэхдээ тухайн үйлчлүүлэгчийн "олон талт байдал", "хэлний ба соёлын өвөрмөц байдал"-ыг харгалзаж тохируулсан үйлчилгээ үзүүлэх шаардлагатай болно. Угсаатны бүлгүүд нь Монголд гарал үүсэл, түүх соёл, шашин шүтлэг, амьдрах хэв маяг, хэл өөр учраас олон улсын ангиллаар "үндэсний цөөнх" гэсэн бүлэгт казах, тува иргэд орно, тэдний "угсаатны бүлэг"-ийн хувьд нийгэмд тулгамдаж байгаа асуудал, хэрэгцээ нь ихээхэн өөр байна. Тиймээс нийгмийн ажилтнууд казах, тува иргэдэд нийгмийн ажлын үйлчилгээг үзүүлэхдээ тэдний ялгаатай байдалд хүндэтгэлтэй хандаж, тэдний хэрэгцээ, "ижилсэл", тулгамдсан асуудалд тусгайлан анхаарах шаардлагатай болж байна.

2. Өнөөдөр гадаадад амьдардаг Монгол гаралтай хүүхдүүд эргэж Монголд ирж суурьших нь ихэслээ. Эдгээр Монголчуудын хүүхдүүд Монгол хэл соёлыг муу эзэмшсэн бөгөөд нутагтаа эргэж ирээд амьдрахад тодорхой хэмжээний бэрхшээл учирна. Тиймээс сургууль, сум хорооны нийгмийн ажилтнууд нь ийм гэр бүлд үйлчилгээ үзүүлэхэд соёлын ялгаа, ижилсэл зэрэг ойлголтуудын талаар бэлтгэгдсэн байх ёстой.

Угсаатны нийгмийн ажил нь сүүлийн хагас зуун жилд үүсэж, сүүлийн хориод жилд хөгжих хандлагатай байгаа боловч судалгааны үндсэн чиг хандлага нь дийлэнхдээ ноёрхогч соёлын үүднээс хийгдэж байгаа тухай барууны судлаачид тэмдэглэж байна. Эрдэмтэд Шведийн нийгмийн угсаатны нийгмийн ажлын хөгжлийг судлаад "Багш нарын сургалтын арга зүй, онолын хөгжил шаардлагатай сургалтын гарын авлага материал муу байгаа нь оюутнуудад "супер- олон талт байдал"-ын төвөгтэй нөхцөл байдалд ажиллаж чаддаг ур чадварыг эмшсэн боловсролыг олгоход сорилт тулгарч байгаа дурдсан.[2]

[1] Bongki Woo, Victor Figuereo, Robert Rosales, Kaipeng Wang, Kareemah Sabur (2018) Where is race and ethnicity in Social work? A Content Analysis. Social work research, Volume 42, Lssue 3, 180-186

[2] Lill, Linda, Jacobson, Pettersson, (2019 Vol. 38), Teaching ethnicity in social work education; teachers’ experiences in Sweden. Social work education, 34-46

Монголын жишээн дээр глобал нийгмийн ажлын хөгжил ба Монголын "үндэсний цөөнх", "хэлний цөөнх", "соёлын цөөнх" бүлгийн үйлчлүүлэгчдийн хэрэгцээ шаардлагад нийгмийн ажлын боловсрол хэрхэн нийцэж ирэв? Нийгмийн ажлын боловсрол олгож байгаа одоогийн тогтолцоо нь нийгмийн ажилтныг "угсаатантай холбоотой" мэдлэг (knowledge), хандлага, ур чадвар (skill) туршлагатай болгож төгсгөж чадаж байна уу гэсэн асуулт гарч ирж байна.

Нийтлэг байдлаар анхны хөтөлбөрүүд хүн ам зүй, нийгэм соёл, угсаатны зүй, түүхийн мэдлэг олгож байсан боловч дээр дурдсан олон янзын хэрэгцээ шаардлагад нийгмийн ажлын боловсролын хандлагаар буюу "хүний эрхийн", "олон талт байдлын" (diversity), "үл ялгаварлагдах байдал" (Non-discrimination) зэрэг хандлагууд чухал байна. Ийм учраас 2020 онд Нийгмийн ажлын боловсрол, сургалтын дэлхийн стандартыг шинэчлэн баталсан бөгөөд энэ стандартад үйлчлүүлэгчийн "олон талт байдал"-ыг харгалзан үзэх ёстой гэсэн үндсэн концепци илүү хүчтэй болсон байна. [1]

Үндсэн хэсэг

Угсаатны нийгмийн ажил нь нэг талаасаа угсаатны судалгаа, нөгөө талаасаа нийгэм сэтгэл зүй, соёлын онол практикийн судалгаатай холбогддог учраас бусад салбар нийгмийн ажлаас илүүтэй нарийн төвөгтэй ойлголтуудыг хэрэглэдэг. Карол Кох ба Паул Эпгросс нар "Угсаатны ижилсэл" гэдгийг эртний, тодорхой газар нутагт нийтлэг гарал үүслээрээ холбогдсон, хамт төрсөн, эсвэл хүрч ирсэн бүлэг хүмүүсийн өөрсдийгөө "бид" гэж мэдэрдэг хамтын ухамсартай олон нийт (community) эсвэл дэд бүлэг хүмүүсийг хэлнэ. Мөн тухайн олон нийт нь угсаатан төвтэй үзэл бодолтой (ethnocentrism), бүлэгт өөрийгөө харьяалуулж байгаа гишүүд амьдрал, үйл ажиллагаандаа тухайн бүлгийн нийтлэг зан үйлийг баримталдаг, эв нэгдэлтэй (solidarity), ялгаатай бүлэг эсвэл олон нийтийн соёлын ижил биш шинж чанарыг мэдэрч байдаг. Карол Кох ба Паул Эпгросс нар угсаатны объектив ба субьектив талуудыг мөн дурдсан. Объектив талуудад нийтлэг хэл, шашин, уламжлалыг оруулдаг бол субьектив талыг хамтын мэдрэмж, харьяалсан байдал (belonging), эв нэгдэл (solidarity) зэрэг ойлголтуудыг оруулдаг.[2]


[1] О.Мөнхбат, Ш.Оюунханд, Т.Бүрэнжаргал “Нийгмийн ажил” сурах бичиг 405 тал
[2] О.Мөнхбат, Ш.Оюунханд, Т.Бүрэнжаргал “Нийгмийн ажил” сурах бичиг 407 тал

"Угсаатны линз" хэмээх ойлголт чухал юм. Учир нь дээр дурдсан "үндэсний цөөнх"-ийн түүх ба уламжлал, хэл ба соёл, шашин, үнэт зүйл ба шашин амьдрах хэв маяг нь нэг талаасаа тэдэнд "нийгмийн ба сэтгэл зүйн ижилсэл" нөгөө талдаа олонхоос ялгагдах ялгааг бий болгож байдаг. Тухайлбал манай орны хүн амны 90 гаруй хувь нь халх аялгаар ярьдаг бол 10 орчим хувь нь Монгол хэлний бусад аялга Буриад, ойрад аялгаар, Казах ба Тува нар Казах, Тувагаар ярьдаг байна. [1] График 1-т харуулав.



График 1

Мөн Монголын Шинжлэх Ухааны Академийн Философийн хүрээлэн "Монгол улс дах шашны төлөв байдал" үндэсний хэмжээний суурь судалгааг 2020 онд хийсэн ба уг судалгаанаас хүн амын шашин шүтлэгийн байдлыг харвал нийт



[1] УСХ Монголын хүн ам зүйн судалгаа 2020 он

хүн амын 56% нь буддын шашин, 9% нь бөөгийн шашин, 7% христийн шашин, 6% нь исламын шашин, 2% шашны шинэ төрлийн урсгал, 20 хувь нь шашин шүтдэггүй гэсэн судалгаа гарчээ. График 2-т харуулав.

График 2

Угсаатын линзтэй холбоотой нийгмийн ажилд "линз модель" гэдэг ойлголт нь "Олон талт байдал" (diversity) гэдэг нь хүний эрх, эрхэм байдал (dignity) зөвшөөрөх нь өөрөө "үл ялгаварлагдах байдал"-тай (non-discrimination) шууд холбоотой. 1980 оны АНУ-ын Нийгмийн ажилтнуудын үндэсний холбооны (National Association of Social Workers) ёс зүйн кодод "хувь хүний ялгаатай эрх" (right of individuals), олон талт байдал (diversity) гэдэг утгаараа туссан байдаг.

Жишээ нь хорих ял эдэлж буй казах хоригдол хорих ангийн нийгмийн ажилтан хэрхэн үйлчилгээг үзүүлэх, тухайн иргэний онцлог хэрэгцээ шаардлагад нийцсэн үйлчилгээг үзүүлэхээс эхэлнэ. Уг бүлэг нь өөрсдийн ялгаатай байдал, цөөнх гэдгийгээ мэдрэх мэдрэмж, болгоомжлол, шашны ялгаатай байдал зэргийг нийгмийн ажилтан сайтар мэддэг байх ёстой.

"Угсаатан ба экологийн хандлага: Нийгмийн ажлын практикт экологийн хандлага нь туйлын чухал юм. Үйлчлүүлэгч гадаад орчны буюу сошиал системийн нөлөө, харилцан үйлдэлд оршин байдаг. Үүнтэй холбоотой “хабитат" гэсэн ойлголт гарч ирнэ. Ер нь ямар ч хүн өөрийн амьдарч байгаа газар, дэмжлэгийн систем тогтож хийж заншсан үйлдэл, зуршлууд байдаг. Эдгээр зуршлууд нь гадаад орчны шууд нөлөөн дээр бүрэлдэж бий болдог. Өдгөө Монгол нь хэдийгээр нэг угсаатан голлосон орон боловч барагцаагаар хүн амын 4 хувийг нь казах цөөнх, 1 хувь хүрэхгүй хэсэг нь тува цөөнх эзэлдэг. Эдгээр бүлэг нь хэл, соёл, шашин, амьдралын хэв маяг, түүхэн гарал үүсэл зэрэг бүх шалгууруар “үндэсний цөөнх"-ийн шалгуурт бүрэн нийцнэ. Казахуудын хувьд Баян-Өлгий аймагт голлон төвлөрч суудаг боловч Улаанбаатар, Дархан, Эрдэнэт, Ховд зэрэг аймгуудад бий. Монголын хүн амын үндэстэн, ястны судалгааг 1956-2020 оны тоон үзүүлэлтээр график 3-т үзүүлэв.




График 3

Хорих байгууллагын нийгмийн ажлын практик ба угсаатан

Хорих байгууллагын нийгмийн ажилтан хоригдолд үйлчилгээ үзүүлэх бүхий л үе шатанд тухайн хоригдлын угсаатны онцлог, хэрэгцээ, ялгаатай байдлыг харгалзан үзэх ёстой. "Үйлчлүүлэгч-систем" буюу хоригдол ба нийгмийн ажилтан хоёр хоёул тусдаа систем юм.

Нийгмийн ажилтан нь үйлчилгээ үзүүлэх бүхий л явцад хоёр систем уулзана, хоригдол үйлчилгээ авахдаа өөрийн гэр бүл, харьяалагддаг бүлэг, хүйс, үнэт зүйл, соёлын ялгаагаа авчирна. Мөн тэдэнд өөрийнх нь угсаатны тогтсон сул болон давуу талуудаа үнэлсэн үнэлгээтэй байдаг.

Нийгмийн ажилтан бол өөрийн төлөөлж байгаа байгууллага, гишүүнчлэл, мөн хүйсийн ялгаа, мэргэжлийн үнэт зүйл ба өөрийн угсаатны ижилслийг авчирна. Үйлчилгээг үзүүлэх процесс нь ийм хоёр системийн хоорондын харилцан үйлчлэл болдог. Үйлчлүүлэгчийн /хоригдлын/ нууц нь тэдний угсаатны ижилсэл, харьяалагдаж байгаа сүлжээ, бүлэг, эргэн тойрон, гэр бүл, үнэт зүйл, соёлын хэм хэмжээтэй шууд холбогдоно. Тухайлбал тэд багаасаа "бидний нууц", "тэд мэдэх ёсгүй", "олон нийтэд ил болох ёсгүй", "угсаатны хувьд ичмээр" гэх мэт ойлголтыг суралцсан байдаг.

Угсаатны "олон нийт" бүр бусад угсаатантай харилцах, хүлээлт, туршлага бий болсон байдаг, үүнийг зохицуулж байдаг зохицуулалтууд байдаг чухам ийм зохицуулалт нь үйлчлүүлэгчийг "этник линз" буюу угсаатны нүдээр харахыг хэлнэ "Нийцтэй болох". Нийгмийн ажилтан ба хоригдолд үйлчилгээ үзүүлэх үйл явц нь дүрүүдээ (role) солилцох явц гэж үзэж болно, тэгэхээр нийгмийн ажилтан хоригдол хоёрын бие биеэсээ хүлээх "хүлээлт" (expectation) "нийцтэй байх" (matching clients and workers) нь тун чухал юм. Тухайн угсаатны ялгаатай хоригдолтой ажиллахад "хэлний" асуудал, "орчуулагч" буюу гуравдагч талтай холбоотой бүтэн багц сэдвүүд үүсдэг. "Дуугай байх", "нөгөө талын соёлын ялгаатай байдлыг ойлгосон мэт дүрд тоглох" зэрэг бэрхшээлүүд гардаг. Гэхдээ угсаатны ялгаатай байдал нь дангаараа биш хүйсийн, насны, нийгмийн, амьдралын туршлага, өвчтэй эсэх зэрэгтэй давхар, хавсарч, нийлж, цугтаа илэрдэг гэдгийг нийгмийн ажилтан санаж байх хэрэгтэй. Тиймээс "нийцтэй болох" гэдэг нь угсаатан мэдрэмжтэй хандлагын хамгийн чухал ойлголт бөгөөд үйлчлүүлэгч /хоригдол/ ба нийгмийн ажилтан хоёрын дүрийн хүлээлтийн зөрүүг багасгах нь мэргэжлийн нарийн үйл ажиллагаа юм.

Хорих байгууллагын нийгмийн ажилтан үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой дараагийн нэг чухал ойлголт бол "мэдрэмж ба тогтсон үзэл" (feeling and perceptions) юм. Хоригдол бүр өөрийн гэсэн тогтсон ойлголтыг бий болгосон байдаг. Тиймээс тэдний мэдрэмж ба тогтсон үзлийг нийгмийн ажилтан ойлгож улмаар итгэлцлийг бий болгох нь төвөгтэй гэхдээ чухал үйл явц юм. Өөрөөр хэлбэл хоригдол үйлчилгээ авч байхдаа "зөв газраа", "зөв хүнтэй" уулзаж байна гэж мэдрэх ёстой.

Нийгмийн ажилтны хувьд хоригдлын "угсаатны онцлогтой асуудал"-ыг ойлгож үр дүнтэй интервенц хийх шаардлагатай болно.

Гэхдээ хоригдлын угсаатны онцлогтой асуудал нь дангаараа бус ихэнх тохиолдолд "ялгаварлан гадуурхагдсан", "хэлний бэрхшээл", "шашин шүтэх эрх" гэх мэт бусад хүчин зүйлстэй хамтдаа илэрдэг. Тиймээс хоригдлын тулгамдаж байгаа асуудлыг оношлоход "угсаатны" онцлогийн илрэх нөлөө, харилцан хамаарал зэргийг нарийвчлан авч үзэхгүй бол үйлчилгээг үр өгөөжтэй өгөхөд саад болох болно.

"Угсаатны тэмдэг" (ethnic marker) гэдэг ойлголт нь угсаатны нийгмийн ажилд чухал байр суурийг эзэлдэг. Энэ нь угсаатан бүр өөрийн гэсэн онцлог шашин, үнэт зүйл, уламжлал, түүхээр илэрдэг. Тухайлбал Монголын цөөнх болсон казахуудын хувьд шашны хувьд муслим, гэр төвтэй үнэт зүйлтэй, өөрийн гэсэн түүх уламжлал бахархалтай угсаатан юм. Чухамдаа үүнийг ойлгохгүйгээр казах хоригдолд үзүүлэх нийгмийн ажлын үйлчилгээ нь тэдэнд “итгэл" төрүүлж үр дүнтэй болж чадахгүй гэдэг нь эргэлзээгүй.

"Угсаатны харилцаа" (ethnic relation). Угсаатнуудын өөр хоорондын харилцааны өмнөх түүхийн бодит болон зохиомол миф нь тэдний харилцаанд шууд нөлөөлж байдаг. Нийгмийн ажилтан угсаатнуудын өөр хоорондын харилцааны түүхийг мэдэж байх шаардлагатай болдог. Хоригдлын асуудлыг тодорхойлохоос эхлээд оношлох цаашилбал үйлчилгээг эхлэхээс дуусгах хүртэл үйл явц нь өөрөө үүнийг шаардана. Монголын угсаатнуудын хувьд ийм өвөрмөц харилцаа нь тэдний өнгөрсөн цаг хугацаанд бүтээсэн түүх болон одоогийн тулгамдаад байгаа асуудлуудтай нягт холбоотой байдаг.

Карол Кох ба Паул Эпгросс нарын судлаачид дараах зөвлөгөөг нийгмийн ажилтнуудад өгсөн байдаг. [1] Үүнд:

1. Үйлчлүүлэгчийн угсаатны бүлгийн олон талт байдал, соёлын уламжлал, тэдний туршлага, урамшуулж байдаг зүйлийн талаар нийгмийн ажилтан тодорхой хэмжээний мэдлэгтэй, мөн мэдрэмжтэй (sensitive) байх нь чухал.

2. Угсаатны бүлэг бүр дотроо нэг төрөл биш төрөл бүрийн дэд бүлгүүдийг үүсгэж байдаг гэдгийг санах хэрэгтэй.

3. Үйлчлүүлэгчийн "угсаатны ижилсэл" (identity) бол нийгмийн ажилтны үнэлгээнд (assessment) маш чухал зүйл гэдгийг тооцох нь чухал. "Угсаатны линз" (lenses) гэсэн ойлголт нь үйлчлүүлэгчийн байр суурийг ойлгоход тусална.

5. Угсаатны бүлгийн үйлчлүүлэгчидтэй харьцахдаа угсаатны ялгаатай байдлыг харуулах "хил хязгаар" (boundaries), түүний нөлөөг тооцож сурах нь чухал.

[1] О.Мөнхбат, Ш.Оюунханд, Т.Бүрэнжаргал “Нийгмийн ажил” сурах бичиг 415 тал

6. Угсаатны бүлгийн амьдралд чухал үүрэг гүйцэтгэдэг, зан заншил (customs), уламжлалт зан үйлийн (behavior) талаарх эерэг дүрийн (positive role) талаар нийгмийн ажилтан мэдлэгтэй байх ёстой.

7. Угсаатны ялгаа, түүнээс үүдэн бий болж байгаа дүрийг (role) нэг бол хэтрүүлэн эсвэл дутуу үнэлж болохгүй.

8. Үйлчлүүлэгчийн хэрэгцээг (need) тодорхойлоход угсаатны ялгаатай байдал нь үйлчлүүлэгчийн мэдрэмж, тогтсон ойлголтод (perception) гол нөлөө үзүүлдэг хүчин зүйл учраас нийгмийн ажилтан үүнийг тухайн бүлгийн тусгай онцлог хэрэгцээг хүлээн зөвшөөрөх нь чухал гэдгийг ойлгох ёстой.

9. Үйлчлүүлэгчид үйлчилгээ үзүүлэх явцад үйлчлүүлэгчийн ойрын гэр бүл, орон нутгийн олон нийтийн лидерүүд, гэх мэт тухайн нийгэмлэг, хүрээндээ нэр хүндтэй олон янзын хүмүүсээс туслалцаа авах нь нийгмийн ажилтны үйлчилгээг чанартай үзүүлэхэд тусалдаг.[1]

ДҮГНЭЛТ

Дэлхий дахины хэмжээнд даяарчлагдах үйл явц эрчимжихэд угсаатны зүй, хүн судлалын ухааны сэдэв улам нарийсаж, дүгнэлттэй хандах, ажиглалтын аргыг хэрэглэж ард түмний амьдрал ахуй, соёлын гүнд орж аливаа ёс заншил, зан үйлийн үүсэл, хувьслыг олж тодотгох таатай нөхцөл бүрдэж судалгааны чиг баримжаа нээгдсэн гэж үзэж болно. Угсаатны нийгмийн ажил нь АНУ-д 1950-иад оноос, Англи, Канад зэрэг орнуудад дараахнаас нь, Стандинавын орнуудад нэлээд сүүлд эрчимтэй хөгжиж эхэлсэн.

Энэхүү салбар шинжлэх ухаан нь тухайн ард түмний амьдрах орчин, мэдлэг сэтгэхүйд суурилан нийгэм, соёлын олон асуудлыг тал бүрээс нь авч үзэж нэгэн бүхэллэг зүйлийг шинжлэх ухаануудын заагт шийдэж өнгөрсөн, одоо, ирээдүйг харах боломжийг бүрдүүлдэг билээ. Өөрөөр хэлбэл барууны нийгмийн ажлын боловсролын хүчтэй нөлөөг тухайн орон нутгийн өөрийн онцлогт “нутагшуулж” зүй зохистойгоор хөгжүүлнэ гэсэн үг юм. Өөрөөр хэлбэл Монгол нийгмийн ажлын агуулгыг бид судалгаа, үйлчилгээ, сургалтад нэвтрүүлэх ёстой гэсэн үг юм.

Монголд байгаа казах иргэд бол олон улсын хуулийн статусаараа ч түүх соёл, хэл ёс заншил шашнаараа ч гэсэн Монгол дах "Үндэсний цөөнх" гэдэг ангилалд бүрэн орох ба нийгмийн ажилтнууд нь тухайн нийгмийн “үндэсний цөөнх" үйлчлүүлэгч, тэдний олон нийтийн үнэт зүйл, соёл, шашин, зан үйл, амьдрах хэв хаягийг ойлгож нийгмийн ажлын үйлчилгээндээ тусгах ёстой болдог.

[1] Carole B. Cox, Paul H. Ephross (2009), Ethnicity in American Society.

Хорих байгууллагын нийгмийн ажилтан хоригдлын угсаатны ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрч, мэдрэмжтэй хандах чинь чухал юм. Энэ нь хоригдол ба нийгмийн ажилтан хоёр нь нэг угсаатан биш тохиолдолд хэрхэн харилцан бие биеийнхээ ялгаа, онцлогийг хүлээн зөвшөөрч итгэлцэл бий болгож байгаагаас хамаарч нийгмийн ажлын үйлчилгээний чанар шууд хамаарна.

САНАЛ

Нийгмийн ажлын салбар бүрд тухайн салбарын үйлчлүүлэгчийн угсаатны ялгаатай байдлыг хүндэтгэн мэргэжлийн үйлчилгээг хүргэхэд анхаарч, мэдрэмжтэй байх арга зүйг нийгмийн ажилтан бэлтгэж буй их дээд сургуулийн сургалтын хөтөлбөрийн агуулгад оруулах, энэ төрлийн эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг өргөжүүлэх,

Нийгмийн бодлого боловсруулагч, хэрэгжүүлэгч, нийгмийн ажлын үйлчилгээг гардан хүргэгч нийгмийн ажилтан, нийгмийн ажилтны орон тоон дээр ажиллаж байгаа мэргэжилтнүүд "угсаатны линз" хэмээх ойлголтын талаарх мэдлэгээ нэмэгдүүлж, хандлагаа төлөвшүүлж, туршлагаа нэмэгдүүлэх шаардлагатай,

ШИНЭЭР ИЛЭРСЭН НӨХЦӨЛ БАЙДЛЫН УЛМААС ШҮҮГЧИЙН ЗАХИРАМЖ, ШҮҮГЧИЙН ТОГТООЛЫГ ХЯНАХ АСУУДАЛ

ISSUES OF PROCEEDINGS OF JUDGE'S ORDERS AND DECISIONS DUE TO NEWLY DISCOVERED CIRCUMSTANCES

Д.Энх-Амар

Дотоод хэргийн их сургуулийн Эрх зүй, нийгмийн ухааны сургуулийн Нийтийн эрх зүйн тэнхимийн багш, цагдаагийн ахмад

Хураангуй: Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 14 дэх хэсэгт Монгол Улсын иргэний “шүүхийн шийдвэрийг давж заалдах эрх”-ийг баталгаажуулсан байдаг төдийгүй хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрийн үндэслэлд ноцтой нөлөөлөхүйц баримт шинээр илэрсэн тохиолдолд хэргийн оролцогчийн хүсэлтээр хэргийг дахин хянан шийдвэрлүүлэх зохицуулалт ч хуульд бий.[1]

Гэвч практикт шүүгчийн захирамж, шүүхийн тогтоол нь шүүхийн шийдвэрээс ангид ойлгогдох тохиолдлууд байгаа буюу шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолыг шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хянуулах “хүчин төгөлдөр шүүхийн шийдвэр”-т хамаарахгүй гэж шийдвэрлэж байгаа тохиолдол цөөнгүй байх бөгөөд энэ нь эрх зүйн зохицуулалт, онолын үзэл баримтлалд нийцэхгүй юм. Иймд тус өгүүллээр хүчин төгөлдөр шүүхийн шийдвэр гэдэгт юуг хамааруулан ойлгох талаар холбогдох эрх зүйн зохицуулалт, онолын үзэл баримтлалыг судалсан төдийгүй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гарсан зарим шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолыг Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 131 дүгээр зүйлийн 131.1-д заасан шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хянуулах шүүхийн шийдвэрт хамааруулах нь зүйтэй эсэхийг тогтоох зорилгоор бичлээ.

Илтгэл нь Удиртгал, Үндсэн хэсэг, Дүгнэлт гэсэн үндсэн гурван хэсгээс бүрдэх бөгөөд үндсэн хэсэг нь 3 дэд хэсгээс бүрдэнэ.

Энэхүү илтгэлд дурдсан агуулга, үзэл санааг илтгэл бичигч нь хувь судлаачийн үүднээс хандаж бичсэн бөгөөд аливаа байгууллагын үзэл баримтлал, байр суурийг төлөөлөхгүй болно.

Түлхүүр үг: Шүүгчийн захирамж, шүүхийн тогтоол, хүчин төгөлдөр шүүхийн шийдвэр, шинээр илэрсэн нөхцөл байдал, шийдвэрийг дахин хянах

Удиртгал

[1] ЗХШХШтХ-ийн 14-р бүлэг

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль [1] (цаашид “ЗХШХШтХ” гэх)-ийн 14-р бүлгээр зохицуулсан шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг хянах зохицуулалт нь Үндсэн хуульд заасан иргэний “шүүхийн шийдвэрийг давж заалдах эрх”-ийг баталгаажуулсан нэг хэлбэр мөн. Гэвч тус хуульд шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолыг шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас дахин хянуулах тухай зохицуулалт байхгүй (хуулийн бичвэрт орхигдсон)-гээс үүдэж шүүгчийн захирамж, шүүхийн тогтоол нь шүүхийн шийдвэрээс ангид ойлгогдох тохиолдлууд гарч байна.

Угтаа шүүгчийн захирамж, шүүхийн тогтоол нь зарим тохиолдолд аливаа хэргийн хувьд эцсийн шийдвэр байх боломжтой байдаг бөгөөд ийнхүү шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолыг шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас дахин хянуулах боломжгүй байх нь иргэний эрхийг дордуулж буй үзэгдэл болох юм. Иймд тус өгүүллээр шүүгчийн захирамж, шүүхийн тогтоол нь шүүхийн шийдвэрийн нэгэн адил эрх зүйн чадамжтай эсэхийг тодруулах, цаашлаад шүүгчийн захирамж, шүүхийн тогтоол, түүнд гомдол гаргахтай холбоотой эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох талаар санал дэвшүүлэхийг зорилоо.

Үндсэн хэсэг

1.6 Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг дахин хянан үзэх зохицуулалтын онцлог “... хүний үндсэн эрхүүд нь гагцхүү Үндсэн хуулийн шүүхээр бус харин захиргаанышүүхээр давхар хамгаалагддаг ... Учир нь эдгээр эрхүүд нь захиргааны өдөр тутмын үйл ажиллагаанд байнга өртөгдөж байдаг бөгөөд тэдгээрийн хэрэгжилт нь захиргааны урьдчилан шийдвэрлэх ажиллагаа болон шүүхийн процессоор хянагдаж, хамгаалагдаж байдаг. Иймд Үндсэн хуулийн эхний бүлэгт заасан хүний үндсэн эрхүүд нь захиргааны шүүхийн хувьд (мөн бусад шүүхийн хувьд ч ялгаагүй) шууд хэрэглэгдэх эрх буюу хэм хэмжээ болох бөгөөд энэ утгаараа захиргааны шүүх нь үндсэн эрхийг баталгаажуулах чухалүе шат юм.”[2]

Давж заалдах шатны шүүх гомдлын үндсэн дээр анхан шатны шүүхийн шийдвэрийгхянадаг нь шүүн таслах ажиллагаанд гарсан хууль хэрэглээний болон шийдвэрт нөлөөлөхүйц процессын шинжтэй аливаа алдааг залруулах буюу давтагдахаас сэргийлэх, оролцогчийн гомдлыг барагдуулах зэргээр хүний эрхийг хангах механизм шүүхэд хэрэгжиж байгаагийн илрэл юм. [3] Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож буй хэргийн оролцогчид хуульд заасан давж заалдах эрхээ баталгаатай эдлэх боломжийг хангах нь шүүхийн үүрэг билээ.

---

[1] *Төрийн мэдээлэл эмхэтгэл* (2016) №09

[2] Г.Банзрагч, Герман-Монголын захиргааны процессын эрх зүйн харьцуулалт, (Улаанбаатар, 2007 он), 2 дахь тал. https://legaldata.mn/buteel/pdf?id=250

[3] З.Ганзориг, “Захиргааны хэргийн шүүхийн харъяаллын бус” үндэслэлээр нэхэмжлэл хүлээн авахаас татгалзахад тулгамдаж буй зарим асуудал, (Улаанбаатар, 2021 он), 1 дэх тал. https://legaldata.mn/buteel/pdf?id=971

Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар[1]-т “давж заалдах гэдэг бол анхан шатны журмаар хэрэг маргааныг шийдвэрлэсэн шүүхийн тогтоол, шийдвэр, захирамжийг хуульд зааснаар эрх олгосон хугацаанд хоёрдугаар шатны шүүхэд гомдол мэдүүлэн заргалдах хугацаа юм” гэж тайлбарлажээ. Тодруулбал, давж заалдах эрхийн хүрээ нь зөвхөн анхан шатны шүүхийн шийдвэр, давж заалдах шатны шүүхийн магадлал, хяналтын шатны шүүхийн тогтоолоор хязгаарлагдахгүй байгааг харж болно.

“Хуулийн хүчин төгөлдөр болсон шүүхийн шийдвэр, магадлал, тогтоолыг дахин хянуулах тухай хүсэлт бол эрх зүйн “онцгой” хэрэгсэл юм. Энэ хэрэгсэл нь нэгэнт явагдаад өнгөрсөн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг онцгой нөхцөл байдлын болон гэмт үйлдлийн улмаас дахин шинээр явуулан шударга ёсыг хангах, хууль зүйн үндэслэл бүхий шийдвэрийг гаргахад чиглэгддэг.”[2]

Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг дахин явуулах нь иргэний шүүхээр хамгаалуулах эрхээ бүрэн эдлэх, шүүхээс хууль зүйн үндэслэл бүхий шийдвэрийг гаргах эрх зүйн баталгаа болдог төдийгүй шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг дахин явуулах нь шүүхийн шийдвэр, магадлал тогтоолыг хойшлуулах болон дээд шатанд нь шилжүүлэх үйлчлэлгүй. Энэ талаараа давж заалдах гомдол болон бусад гомдлоос ялгаатай. Тодруулбал, хүчин төгөлдөр болсон шүүхийн шийдвэрийг шинээр илэрсэн нөхцөлөөр хянуулах тухай хүсэлт нь шүүхийн шийдвэрт маргах хэрэгсэл биш, харин эрхийн хамгаалалтын онцгой хэрэгсэл юм.[3]

Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг дахин хянан үзэх зохицуулалтад холбогдох асуудал

Хэдийгээр хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрийг хэн ч биелүүлэх үүрэгтэй боловч шүүхийн шийдвэр хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байх зарчим зөрчигдсөний улмаас шүүхийн шийдвэр үндэслэлгүй буюу хууль бус гарсан байж болох “онцгой тохиолдол”-д хүчин төгөлдөр болсон шүүхийн шийдвэрийг дахин хянах боломжийг хуулиар олгосон байна.[4]

“Захиргааны хэргийн шүүхэд шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шийдвэрийг дахин хянан үзэх зохицуулалтын онол, практикийн зарим асуудал” судалгааны тайлан[5]-д “Монгол Улсад захиргааны хэргийн шүүн таслах ажиллагаа хэрэгжүүлж буй шүүхүүдийн сүүлийн таван жилд (2017-2022 он) ЗХШХШтХ-ийн

[1] *Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар*, УБ, 2000 он, 123 дахь тал.
[2] А.Эрдэнэцогт, *Монгол Улсын захиргааны процессын эрх зүй*, УБ, 2014 он, 359 дэх тал
[3] Э.Мөнхдаваа “Шинээр илэрсэн нөхцөлөөр захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг дахин хянах үндэслэл” (2022), 3 дахь тал. https://legaldata.mn/b/1338
[4] Мөн тэнд
[5] Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэн “Захиргааны хэргийн шүүхэд шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шийдвэрийг дахин хянан үзэх зохицуулалтын онол, практикийн зарим асуудал” (2022), 14 дэх тал. https://legaldata.mn/b/1384

131 дүгээр зүйлд зааснаар гаргасан 55 шүүхийн тогтоолд дүн шинжилгээ хийсэн байна. Судалгаанд хамруулсан нийт 55 тогтоолын 16 буюу 29% нь хялбаршуулсан журмаар хэргийг хянан шийдвэрлэсэн шүүгчийн захирамжийг шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хянуулахаар хүсэлт гаргасан ба үүнээс 8 хүсэлтийг хангаж, 8 хүсэлтийг хангасан татгалзжээ" гэсэн дүгнэлтийг хийжээ.

ЗХШХШтХ-ийн 131 дүгээр зүйлийн 131.1-д "Хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэр /анхан шатны шүүхийн шийдвэр, давж заалдах болон хяналтын журмаар хэрэг хянан шийдвэрлэсэн шүүхийн магадлал, тогтоол/-ийг дараах үндэслэлээр шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хянан үзэж болно" гэжээ. Уг зохицуулалтаас үзвэл шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас дахин хянуулах хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрт анхан шатны шүүхийн шийдвэр, давж заалдах шатны шүүхийн магадлал, хяналтын шатны шүүхийн тогтоол хамаарна. Харин хэргийг хянан шийдвэрлэх явцад гарсан шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолд хамаарахгүй байхаар ойлгогдож, мөн практикт хууль хэрэглээний хувьд эргэлзээтэй байдал үүсдэг, энэ дээрх судалгааны тайлангаар ч мөн тогтоогджээ. Үгтаа ЗХШХШтХ-ийн 12 дугаар зүйлийн 12.1-д Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийн хэлбэрүүдийг заасан байх ба үүнд шүүгчийн захирамжийг хамааруулан хуульчилсан байдгийг санах хэрэгтэй.

Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг дахин хянуулах нь зөвхөн захиргааны эрх зүйд хамаарах асуудал биш бөгөөд энэ талаар "ИХШХШтХ-ийн 170 дугаар зүйлийн 170.1 дэх хэсэгт зааснаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гарсан шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолд гарсан гомдол нь тухайн шатны шүүх дээр шийдвэрлэгддэг. Зарим тохиолдолд иргэн, хуулийн этгээдийн дахин шүүхэд хандах эрхийг нэг мөр хязгаарласан ач холбогдол ихтэй гомдол энэ журмаар хэлэлцэгддэг. Тухайн шатны шүүх дотооддоо гомдол шийдвэрлэж байгаа нь хэргийн оролцогчдод шийдвэр нь хүлээн зөвшөөрөгдөх эсэхээс илүүтэйгээр Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 14 дэх хэсэгт заасан шүүхийн шийдвэрт давж заалдах эрхийг хязгаарлаж байна. Иймд давж заалдах шатны шүүхээр захирамж, тогтоолд гарсан гомдлыг хянан шийдвэрлэх нь иргэний Үндсэн хуулиар олгогдсон эрхийг хангах юм"[1] гэсэн байдаг.

Энэхүү эрх зүйн онцгой хэрэгслийг шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолд хэрэглэж болохооргүйгээр ЗХШХШтХ-д зохицуулсан нь сөрөг үр нөлөөтэй бөгөөд шүүгчийн захирамж, шүүхийн тогтоол нь хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрт хамаарах үндэслэлтэй. Тодруулбал, Шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болох гэдэг нь дараах байдлаар тодорхойлогдоно. Үүнд:

[1] Т.Бадрах "Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн шинэчлэлийн зарим асуудал" (2019), 2 дахь тал. https://legaldata.mn/b/942

а) Анхан шатны шүүхийн шийдвэрийг хэргийн оролцогч (түүний төлөөлөгч буюу өмгөөлөгч) гардан авснаас хойш 14 хоногийн дотор давж заалдах гомдол гаргаагүйн улмаас шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болно.

б) Хэргийн оролцогчоос давж заалдах гомдол гаргасан бөгөөд давж заалдах шатны шүүх гомдлын дагуу хэргийг хянан шийдвэрлэж, дараах байдлаар магадлал гаргасан:

- давж заалдах гомдлыг хүлээн авах боломжгүй буюу үндэслэлгүй бол гомдлыг хангахгүй орхиж, шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээсэн;
- анхан шатны шүүхийн шийдвэрт нэмэлт, өөрчлөлт оруулсан;
- анхан шатны шүүхийн шийдвэрийн зарим хэсгийг хүчингүй болгож, бусад хэсгийг хэвээр үлдээсэн буюу өөрчилсөн бөгөөд эдгээр магадлалд хяналтын журмаар гомдол гаргаагүй тохиолдолд шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болно.

в) Давж заалдах шатны шүүхийн магадлалд хяналтын журмаар гомдол гаргасан тохиолдолд уг гомдлыг хяналтын шатны шүүх хянаад:

- шийдвэр, магадлалыг хэвээр үлдээж, гомдлыг хангахгүй орхисон,
- шийдвэр, магадлалд нэмэлт өөрчлөлт оруулсан,
- магадлалыг бүхэлд нь буюу зарим хэсгийг хүчингүй болгож, шийдвэрийг хэвээр үлдээсэн, өөрчилсөн тохиолдолд шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болно.

Хэргийг хянан шийдвэрлэж гаргасан шат шатны шүүхийн шийдвэрүүд нь дээрх байдлаар хуулийн хүчин төгөлдөр болох бөгөөд үүнээс гадна ЗХШХШтХ-д шүүгчийн захирамж, шүүхийн тогтоол нь шүүхийн эцсийн шийдвэр байх нөхцөлүүдийг мөн хуульчилсан байдаг. Тухайлбал, хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэсэн шүүгчийн захирамж, шүүхийн тогтоол; нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан анхан шатны шүүхийн шүүгчийн захирамжийг хэвээр үлдээсэн давж заалдах шатны шүүхийн тогтоол нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гардаг гомдол гаргах эрхгүй, шүүхийн эцсийн шийдвэр болдог (ЗХШХШтХ-ийн 122 дугаар зүйлийн 122.7).

Түүнчлэн шүүхийн шийдвэрийн хүчин төгөлдөр байдлыг онолын үүднээс тайлбарлавал[1] шүүхийн шийдвэр нь формаль эрх зүй болон агуулгын хувьд хүчин төгөлдөр байх шаардлагатай. Формаль эрх зүйн хүчин төгөлдөр байдал нь шүүхийн шийдвэрт гомдол гаргах эрхгүй болох, тухайн шийдвэр эцсийн шийдвэр болж хүчин төгөлдөр болсон байхыг илэрхийлнэ. Харин агуулгын хүчин төгөлдөр байдал нь тухайн шийдвэрлэгдсэн хэрэг маргааны агуулга (нэхэмжлэлийн шаардлага)-аар дахин маргаан үүсгэх боломжгүй, тус агуулгын хувьд шүүхээр шийдвэрлэгдэж эцэслэгдсэн байхыг ойлгохоор байна. Энэ утгаараа хэргийг

[1] Б.Буянхишиг, *Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй*, (УБ. 2021), 191 дэх тал.

хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэсэн шүүгчийн захирамж, шүүхийн тогтоол; нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан анхан шатны шүүхийн шүүгчийн захирамжийг хэвээр үлдээсэн давж заалдах шатны шүүхийн тогтоол нь шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хянуулах шийдвэрт хамаарахаар байгаа юм.

ЗХШХШтХ-ийн 131 дүгээр зүйлийн 131.1-д “Хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэр /анхан шатны шүүхийн шийдвэр, давж заалдах болон хяналтын журмаар хэрэг хянан шийдвэрлэсэн шүүхийн магадлал, тогтоол/-ийг дараах үндэслэлээр шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хянан үзэж болно”, ИХШХШтХ-ийн 179 дүгээр зүйлийн 179.1-д “Хүчин төгөлдөр шүүхийн шийдвэр /анхан шатны шүүхийн шийдвэр, давж заалдах болон хяналтын журмаар хэрэг хянан шийдвэрлэсэн шүүхийн магадлал, тогтоол/-ийг дараах үндэслэл байвал шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хянан үзэж болно” гэж шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хянан үзэх шийдвэрийг тусгайлан дурджээ. Харин ЭХХШтХ-ийн 41 дүгээр зүйлийн 41.1.1-д “Дараах нөхцөл байдал тогтоогдвол шинээр илэрсэн нөхцөл байдал гэж үзэж, урьд гарсан хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, хэргийг сэргээн шалгаж болно” гэж заажээ.

Тодруулбал, дээрх процессын хуулиудад шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас дахин хянуулах хүчин төгөлдөр шүүхийн шийдвэр гэдэгт хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гарсан шүүгчийн захирамж, шүүхийн тогтоол хамаарахгүй байхаар адил зохицуулсан. Гэвч зарим шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолын хувьд шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг дахин явуулах үндэслэл илэрч болно. Тухайлбал, нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан, хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн тухай шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолтой хэргийн хувьд нэхэмжлэгчийн мэдээгүй, мэдэх боломжгүй байсан шинэ нөхцөл байдал илэрснээр нэхэмжлэлийг хүлээн авах нөхцөл бүрдсэн байх боломжтой. Мөн хэргийн оролцогчид эвлэрсний дараагаар тус нөхцөл байдлыг мэдэж байсан бол эвлэрэх шийдвэр гаргахгүй байх байсан нөхцөл шинээр илэрч болно. Товчхондоо, хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн, нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан тухай шүүгчийн захирамж, шүүхийн тогтоол нь бусад шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолоос онцлогтой юм.

Шүүх ЗХШХШтХ-ийн 66-68 дугаар зүйлд заасны дагуу бусад этгээдийн эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хөндөхөөргүй, хуульд харшлаагүй байвал хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэнэ. Хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэсэн шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолд гомдол гаргах эрхгүй, шүүхийн шийдвэрийн нэгэн адил биелэгдэнэ. Гэвч хэргийн оролцогчид эвлэрсний дараагаар тус нөхцөл байдлыг мэдэж байсан бол эвлэрэх шийдвэр гаргахгүй байх байсан нөхцөл шинээр илэрч болно.

Мөн ЗХШХШтХ-ийн 54 дүгээр зүйлийн 54.1-д заасны дагуу нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзахдаа шүүгч захирамж гаргадаг. Энэхүү шүүгчийн

захирамжийг эс зөвшөөрсөн бол давж заалдах шатны шүүхэд гомдол гаргах эрхтэй бөгөөд давж заалдах шатны шүүхээс ЗХШХШтХ-ийн 122 дугаар зүйлийн 122.6-д заасан тогтоолуудын аль нэгийг гаргана. Хэрэв давж заалдах шатны шүүхээс нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан шүүгчийн захирамжийг хэвээр үлдээж, гомдлыг хангахгүй орхисон тохиолдолд нэхэмжлэгч нь тус асуудлаар дахин шүүхэд хандах эрхгүй болно.

Нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан шүүгчийн захирамжийг хэвээр үлдээж шийдвэрлэсэн шүүхийн тогтоолд дахин гомдол гаргах эрхгүй, эцсийн шийдвэр болохоор хуульд зохицуулсан. Энэ нь шүүгчийн бие даасан, хараат бус байдал, шүүхийн аливаа шийдвэрийн хүчин төгөлдөр байдал, шүүхийн ачаалал зэрэг эерэг нөлөөлөлтэй байхыг үгүйсгэхгүй. Гэвч хэргийн оролцогч, эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсөн иргэдийн хувьд гомдол гаргах эрхээ эдэлж чадахгүй нөхцөлд хүргэж болзошгүй юм.

Дээрх 2 тохиолдол нь нэхэмжлэгчийн хувьд Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 14-д заасан "…эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах" эрхээ эдлэх боломжгүй нөхцөлд хүргэх юм. Тус шүүгчийн захирамж, шүүхийн тогтоол нь давж заалдах болон хяналтын журмаар гомдол гаргах эрхгүй, энэ үйл баримтын талаар шүүхэд дахин маргаан үүсэх боломжгүй, шүүхийн шийдвэрийн нэгэн адил албадан гүйцэтгүүлдэг [1] шүүхийн эцсийн шийдвэр байдаг. Эдгээр байдлаар нь тус 2 тохиолдлыг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гарч байгаа бусад шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолтой адилтган үзэх боломжгүй юм.

1994 оны ИХШХШтХ-ийн 129 дүгээр зүйлийн 129.1-д "Энэ хуулийн 128 дугаар зүйлд заасны дагуу бичгээр гаргасан шүүхийн тогтоол, шүүгчийн захирамж нь илт үндэслэл муутай гарсан буюу, эсхүл хэргийн байдал өөрчлөгдсөн бол тухайн шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжаар хүчингүй болгох буюу өөрчилж болно" гэж заасан байжээ.

Мөн Улсын дээд шүүхийн 1997 оны "Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг дахин хянах тухай Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим зүйл, хэсэг заалтыг тайлбарлах тухай" 318 дугаар тогтоолд[2] ""шүүхийн тогтоол, шүүгчийн захирамж" гэдэгт анхан шатны шүүхээс

[1] Нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан шүүгчийн захирамжийг хэвээр үлдээж шийдвэрлэсэн шүүхийн тогтоол нь ЗХШХШтХ-ийн 122 дугаар зүйлийн 122.7-д заасны дагуу эцсийн шийдвэр байдгаараа мөн хуулийн 69 дүгээр зүйлийн 69.2-т хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолд гомдол гаргах эрхгүй бөгөөд шүүхийн шийдвэрийн нэгэн адил биелүүлнэ гэж заасантай эрх зүйн үр дагаврын хувьд адил нөхцөл үүсгэнэ. Тодруулбал, ЗХШХШтХ-ийн 54 дүгээр зүйлийн 54.1.6-д нэхэмжлэлд заасан үйл баримт, захиргааны үйл ажиллагааны талаар ... хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэр болон шүүгчийн захирамж, шүүхийн тогтоол байгаа бол нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах үр дагаврыг үүсгэнэ.

[2] УДШ-ийн 1997 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн 318 дугаар тогтоол "Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг дахин хянах тухай Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх

иргэний хэргийг хянан шийдвэрлээд Монгол Улсын нэрийн өмнөөс гаргасан шийдвэрээс бусад хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах болон шийдвэр биелүүлэхтэй холбогдуулан гаргасан шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжийг хамааруулан ойлгоно"; "хэргийн байдал өөрчлөгдөх" гэдэгт бичгээр гаргасан шүүхийн тогтоол, шүүгчийн захирамж хүчин төгөлдөр болсны дараа хуулийн 188 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасантай адилтгах нөхцөл байдал шинээр илэрсэн, ... зэргийг хамааруулан ойлгох бөгөөд энэ үндэслэлээр хэргийн оролцогчдын гаргасан хүсэлтийг тухайн шүүх буюу шүүгч эсхүл тухайн шүүхийн өөр бүрэлдэхүүн буюу шүүгч тогтоол, захирамж гарган шүүхийн тогтоол, захирамжийг хүчингүй болгох буюу өөрчилж болно" гэж заасан байжээ. Өөрөөр хэлбэл шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хянан үзэх шүүхийн шийдвэрт ХХША-тай холбогдуулан гаргасан шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолыг хамааруулан ойлгодог байсан байна.

УДШ-ийн 2007 оны "Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг дахин хянах тухай" зөвлөмжид[1] ""хүчин төгөлдөр шүүхийн шийдвэр" гэдэгт ... шүүхийн шийдвэрийн нэгэн адил хэрэгждэг хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэсэн шүүгчийн захирамж хамаарна" гэжээ.

Дээрх УДШ-ийн тайлбар, зөвлөмж болон 1994 оны ИХШХШтХ-ийн зохицуулалтаас үзвэл ЗХШХШтХ-ийн 131 дүгээр зүйлийн 131.1-д заасан "хуулийн хүчин төгөлдөр анхан шатны шүүхийн шийдвэр"-т шүүгчийн захирамжийг хамааруулж ойлгож байсан гэж дүгнэж болох юм.

ДҮГНЭЛТ

Захиргааны хэргийн шүүх байгуулагдаж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулаад багагүй хугацаа өнгөрч байгаа боловч захиргааны процессын эрх зүйн салбарт тулгамдсан асуудал цөөнгүй байна. Хэргийг хянан шийдвэрлээд гаргасан эцсийн шийдвэрийн тухайд тухайлсан асуудлыг энэ өгүүллээр хөндөөгүй. Харин хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гаргасан шийдвэр буюу шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолтой холбоотой эргэлзээ бүхий асуудлуудыг тодруулан авч үзсэн болно.

Үндсэн хуульд заасан иргэний давж заалдах гомдол гаргах эрхийг хуулиар баталгаажуулах нь төрийн үүрэг. Харин тэрхүү хуулиар баталгаажуулсан эрхийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад ч, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны дараа ч найдвартай эдлүүлэх нь шүүхийн үүрэг юм. Хууль тогтоогч давж заалдах шатны шүүхэд анхан шатны шүүхийн шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолыг хянах эрхийг олгосон нь шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолтой

тухай хуулийн зарим зүйл, хэсэг заалтыг тайлбарлах тухай" https://legalinfo.mn/mn/detail/640?fbclid=IwAR2Ch748_AXkgQ0tS3C-YxZVczRjez797e2dmOfTgHwmmZNUoVezsj_kjzg

[1] УДШ-ийн 2007.11.15-ны өдрийн "Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг дахин хянах тухай" зөвлөмж, https://legalinfo.mn/mn/detail?lawId=16231250921371

холбоотой гомдлыг аль болох хугацаа алдалгүйгээр түргэн шуурхай шийдвэрлэх зорилготой.

Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрийг дахин хянах тухай зохицуулалт нь процессын бие даасан хуулиуд батлагдах үед байсан тул шинэ зохицуулалт гэж үзэх боломжгүй. Гэвч онолын ойлголт, хууль хэрэглээний хувьд тогтворжоогүй, эргэлзээ бүхий зохицуулалт байсаар байна. Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрийг хянан үзэх асуудал нь хэргийн оролцогчдын хувьд давж заалдах гомдол гаргах эрхийн нэгэн адил ач холбогдолтой зохицуулалт юм. Тиймээс давж заалдах болон хяналтын журмаар гомдол гаргах эрхгүй, энэ үйл баримтын талаар шүүхэд дахин маргаан үүсэх боломжгүй байдлаараа шүүхийн эцсийн шийдвэртэй үр дагаврын хувьд ижил шинжтэй шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолыг шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрт хамааруулах шаардлагатай.

Иймд ЗХШХШтХ-ийн 131 дүгээр зүйлийн 131.1-д заасан хүчин төгөлдөр шүүхийн шийдвэр гэдэгт, мөн хуулийн 66-68 дугаар зүйлд заасан хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэсэн шүүгчийн захирамж, шүүхийн тогтоол, нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан шүүгчийн захирамжийг хэвээр үлдээж шийдвэрлэсэн шүүхийн тогтоолыг хамааруулах нь зүйтэй тул энэ талаар Шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8.4-д зааснаар Улсын дээд шүүхээс ЗЕХ-ийн 3 дугаар зүйлийн 3.1.7 дахь заалтыг хэрхэн хэрэглэх талаар албан ёсны тайлбар гаргах нь зүйтэй болов уу гэж хувь судлаачийн зүгээс үзэж байна.

УЛАМЖЛАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙД ХИЙМЭЛ ОЮУН УХААН АШИГЛАХ БОЛОМЖ

THE POSSIBILITY OF USING SCIENCE IN ARTIFICIAL INTELLECTUALITY IN TRADITIONAL ANALYTICAL METHODS

Д.Алтантуяа

ШМИ-ийн БУТЗШТ-ийн ахлах багш, цагдаагийн дэд хурандаа;

Хураангуй: Хүн төрөлхтөний түүхэн дэх 21-р зуун буюу техник технологийн эрин зуун нь түүнд дасан зохицож амьдарч буй иргэд бидэнд алхам тутамдаа дэвшлийг авчирч байгаа гэж хэлэхэд хэлсдэхгүй биз ээ. Технологи хэмээх зүйл хууль, шүүх, анагаах, эдийн засаг, төрийн үйл ажиллагаа гэх мэт хүний амьдралын бүх салбарт эргэлт буцалтгүйгээр нэвтрэн орсон энэ цаг үед шүүх шинжилгээний салбарт ч мөн адил технологийн инновацыг нэвтрүүлэх шаардлага нэн тэргүүнд үүсэж байна. Уг илтгэлээр Шинжлэх магадлахуйн технологи ба хүний оюун ухааны хамтарсан хослол, хиймэл оюун ухааны хамтран ажиллах боломж, орчин нөхцөлийг судалж, Монгол улсад хэрэгжих боломжийг олон улсын бусад орнуудтай харьцуулан судлах замаар арга зам илэрхийллээ.

Түлхүүр үг: Шүүх шинжилгээний уламжлалт арга, Хиймэл оюун ухаан, арга зүй,

Сэдэв сонгосон үндэслэл:

I.Шинжлэн магадлахуйн ухаан бол аливаа улс орны эрх зүйн системд томоохон байр суурь эзэлж цаашдын хөгжлийг тодорхойлогч дэд институтийн нэг билээ. Тэр ч утгаараа дэлхийн улс орон бүр уг салбарт ихээхэн анхаарал хандуулж, түүнийг хөгжүүлэх шат дараатай арга хэмжээг авсаар байгаагийн нэгэн том илрэл нь техник технологийн шинэчлэлийг шинжлэн магадлахуй ухааны шинэтгэлтэй хослуулан ахиц дэвшил гаргах явдал юм. Харин өнөөгийн Монгол улсын тухайд Шүүх шинжилгээний салбарт томоохон асуудлуудтай нүүр тулж байгаагаас жишээ болгон дурдвал шинжээчийн ажлын ачаалал, техник технологийн хангамж, хүрэлцээ зэрэг асуудлууд маш хурцаар тавигдсаар байгаа нь Шүүх Шинжилгээний хүрээлэнгийн статистикийн он оны /2020[1], 2021[2]/, мэдээллээр баталгаажиж байгаа бөгөөд уг салбарт эрх зүйн нэн чухал шинэтгэл хийгдэх хэрэгтэй гэж хэлэхэд хэлсдэхгүй биз ээ.

II. Шүүх шинжилгээний салбарт тэр дундаа уг салбарын шинжилгээний уламжлалт аргатай хиймэл оюун ухааныг хамтран ажиллах онол, практикийн асуудлаар Монгол Улсад тусгайлан судалсан нэг сэдэвт бүтээл ховор бөгөөд энэ талаархи иргэдийн мэдлэг хангалтгүй түвшинд байгаа юм. Харин олон улсад уг

[1] https://sudalgaa.gov.mn/shkh-shinzhilgeeniy-statistik-2021-wst 2024.04.05-нд хандав.
[2] https://sudalgaa.gov.mn/shkh-shinzhilgeeniy-statistik-2020-wst 2024.04.05-нд хандав.

асуудлаар Application of Next-Generation Technology in Forensic Science[1], The interface between forensic science and technology: how technology could cause a paradigm shift in the role of forensic institutes in the criminal justice system[2], Use of DNA technology in forensic dentistry[3], Applications of artificial intelligence in forensic sciences: Current potential benefits, limitations and perspectives[4], Artificial intelligence in forensic science[5] зэрэг судалгааны ажлууд тус тус судлагдсан бөгөөд өдгөөг хүртэл үр дүнгээ үзүүлсээр байна.

Эрх зүйн үндэслэл:

"Алсын хараа-2050" урт хугацааны хөгжлийн бодлогын үндсэн 9 зорилгын нэг болох "Амар тайван аюулгүй нийгэм" зорилгын үе шатанд багтах Хууль сахиулах салбарын эрх зүйн орчинг сайжруулах зорилготойгоор Эрх зүйн шинэтгэлийг гүнзгийрүүлэх, салбарын алба хаагчдыг бэлтгэх, мэргэшүүлэх тогтолцоог олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлж, мэргэшсэн чадварлаг хүний нөөцийг бүрдүүлэх болон салбарын инновацийн үйл ажиллагааг дэмжих, эрх зүйн орчинг бүрдүүлэх үе шатны нэг хэсэг нь судлаач бидний техник технологи, хиймэл оюун ухааныг уг салбарт амжилттай нэвтрүүлэх асуудал юм.

Нэг. Онолын болон практик үндэслэл

Тусгаар тогтнолоо бий болгож ардчилсан нийгмийг цогцлоосон Монгол улсад хүний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг ханган,хамгаалах дээд эрх бүхий байгууллага нь Шүүх эрх мэдлийн байгууллага болон түүнээс салаалсан төрөл бүрийн чиг үүрэг бүхий дэд институтүүд билээ. Тэр ч утгаараа Монгол улс шүүх шинжилгээ болон түүнтэй холбоотой үйл ажиллагааг "Шүүх шинжилгээний тухай хууль"[6] -иар зохицуулдаг бөгөөд нэг мөр ойлгож хэрэглэдэг.

Хиймэл оюун ухаан буюу олон улсын хэллэгээр "**Artifical Intelligence**" нь хүн төрөлхтөний түүхэнд гарсан нэг том ахиц дэвшил яахын аргагүй мөн бөгөөд энэ нь компьютерын программ хангамжаар бүтээгдсэн, хүний сэтгэхүйг дуурайлгасан ба бараг ижил түвшинд хүргэсэн технологийн төрөл бөгөөд хүний хийдэг аливаа үйл ажиллагааг удирдах зориулалттай. Анх "Хиймэл оюун ухаан" хэмээх нэр томьёог Жон Маккарти[7] 1955 онд өөрийн бүтээлдээ ашиглаж, "Ухаант

[1] https://academic.oup.com/gpb/article/12/5/190/7221964 2024.04.05-нд хандав.
[2] https://royalsocietypublishing.org/doi/full/10.1098/rstb.2014.0264 2024.04.05-нд хандав.
[3] https://www.scielo.br/j/jaos/a/fmTm8bvgy5dvdwzMk8hfzTn/ 2024.04.05-нд хандав.
[4] https://link.springer.com/article/10.1007/s00414-022-02928-5 2024.04.05-нд хандав.
[5] https://d1wqtxts1xzle7.cloudfront.net/64615823/IRJET-V7I51354-libre.pdf?1602057328=&response-content-disposition=inline%3B+filename%3DIRJET_ARTIFICIAL_INTELLIGENCE_IN_FORENSI.pdf&Expires=1697550828&Signature 2024.04.05-нд хандав.
[6] Шүүх шинжилгээний тухай хууль https://legalinfo.mn/mn/detail?lawId=16532614235741- 2023.10.12-нд хандав.
[7] John McCarthy (September 4, 1927 – October 24, 2011) was an American computer scientist and cognitive scientist. He was one of the founders of the discipline of artificial intelligence. McCarthy spent most of his

машин техник бүтээх онолын болон инженерийн шинжлэх ухаан” гэж тодорхойлсон байдаг.

Нийгэм хөгжин дэвших, хотжилт, хүн амын нягтаршил нэмэгдэхийн хэрээр гэмт хэргийн гаралт нэмэгдэж, гэмт хэрэг үйлдэх шинэ арга барил, судалгааны шинэ объектууд бий болж байгаа тул иргэдийн эрх зүйн ухамсрын эсрэг хариу үйлдэл үзүүлэгч хууль сахиулагчид гэмт хэргийн шинэ хэлбэрүүд хэдий чинээ ер бусын байна, төдий чинээ шинжээчдийн судалгаа илүү төвөгтэй, илрүүлэхэд хэцүү болж байгааг дурдах нь зүйтэй болов уу?

Дэлхий нийтэд шүүхийн шинжилгээний практикийг боловсронгуй болгох нэг арга бол шинжээчийн үйл явцыг автоматжуулах /automating the expert process/ явдал юм. Түүгээр зогсохгүй шүүх шинжилгээнд технологийг нэвтрүүлэхдээ хүний туйлын эрх ба үндсэн эрхийг хангаж хамгаалахын тулд цахим нотлох баримтын дэлхийн стандарт буюу ISO:17025 [1] -д нийцсэн нотлох баримтын стандартыг баримталснаар хүний эрхийг бүрэн байдлаар хангаж, хамгаалах төрийн үндсэн үүргээ хэрэгжүүлэх баталгаа бий болно. Ийм автоматжуулсан системийг ажиллуулах зорилго нь хамгийн бага цаг хугацаа, хүчин чармайлтаар хамгийн их үр дүнд хүрэх явдал юм.

Дэлхий дахинд хиймэл оюун ухаан нь шүүх шинжилгээний салбарт нэвтэрснээр нь дүрс таних, зураг болон видео шинжилгээ, галт зэвсгийг таних буюу баллистик судлал, сум илрүүлэх, хэргийн газрыг 3 хэмжээстээр сэргээн засварлах, гар бичмэлийг таних, баримт бичгийн шинжилгээ, видео нотлох баримтыг задлан шинжлэх, нь уруул, хазуулсан, гутлын хээ, сумны тэмдэг зэрэг гэмт хэргийн газрын нотлох баримтыг таних гэх мэт шүүхийн шинжлэх ухааны олон талт үйл ажиллагаанд маш их ашиг тустай болох нь батлагдсан [2] . Цаашилбал, энэхүү технологи нь шүдний үзлэгийн өгөгдөл, араг ясны хүйсийг тодорхойлох, үл мэдэгдэх гавлын яснаас нүүр царайг 3D дүрсээр сэргээн засварлах, цахим гэмт хэрэг, дижитал нотлох баримтыг илрүүлэх замаар нас барснаас хойших цаг хугацаа, нас, тодорхойлох боломжтой болсон төдийгүй криминалистикийн үндсэн категори болох адилтгал, оношлолын шинжилгээг хийж болох хүртэл арга хэмжээ болно[3].

Харин нөгөөтээгүүр шүүх шинжилгээний салбарт технологийн инновацыг нэвтрүүлэх асуудлын үндсэн агуулга нь өнөөгийн нөхцөлд шинжээчдэд оногдох нэг хэргийн тоо болон түүний ажлын ачааллыг хөнгөвчлөх, хэргийн эрлийн цар

career at Stanford University.[2] He received many accolades and honors, such as the 1971 Turing Award for his contributions to the topic of AI,[3] the United States National Medal of Science, and the Kyoto Prize.

[2] Artificial Intelligence: An Advanced Evolution In Forensics And Criminal Investigation https://www.researchgate.net/publication/362815618_Artificial_Intelligence_An_Advanced_Evolution_In_Forensics_And_Criminal_Investigation 2023.09.25-нд хандав.

[3] The impact of automation and artificial intelligence on digital forensics https://wires.onlinelibrary.wiley.com/doi/abs/10.1002/wfs2.1418 2023.09.25-нд хандав.

хүрээг хумих, эрүү, иргэн, захиргааны процесс үйл ажиллагааг ханган хэрэгжүүлэхтэй холбоотой алдаа дутагдал дээр үндэслэгдсэн бөгөөд төрийн үйл ажиллагааг иргэд бүрэн дүүрэн шуурхай авч хэрэгжүүлэхийн тулд уг салбарт мэдээллийн автоматжуулалт болон зарим процессыг боловсронгуй болгох хэрэгцээ шаардлага маш их байна. Үүн дээр нэгэн сайн жишээг дурдвал Монгол улс сүүлийн жилүүдэд "E Mongolia" цахим системийг төрийн үйл ажиллагаандаа нэвтрүүлж үндсэн цахим портал нь маш авууштай хэрэг юм. Тэгэхээр судлаач бидний зүгээс өөрийн улсын Шүүх шинжилгээний салбарт мэдээлэл, хиймэл оюун ухааны сүүлийн үеийн хувилбар болон техникийн автоматжуулалт хийх цахим нэгдсэн систем бий болгох нь өнөөгийн нөхцөлд таарч буй арга зам гэж үзэж байгаа юм.

КРИМИНАЛИСТИКИЙН УЛАМЖЛАЛТ ШИНЖИЛГЭЭ БА ХИЙМЭЛ ОЮУН УХААН

Дэлхий ертөнц эрин зуунаар өөрчлөгдөн хувьсаж, техник технологи хүн төрөлхтний амьдралд асар хурдацтайгаар нэвтрэн орж буй өнөө цаг үед хүний эрхийг хангах, хамгаалах, гэмт хэрэгтэй тэмцэхүй ажиллагааны тодорхой процессууд ч мөн адил нарийн төвөгтэйгөөр шинэчлэлт бий болж байна. Тийм ч учраас шинжлэх ухаан, технологийг ашиглах, түүнчлэн хиймэл оюун ухаан зэрэг хамгийн сүүлийн үеийн бөгөөд ирээдүйн технологийг ашиглах замаар түүний шүүх шинжилгээний салбар дахь үр өгөөжийг судлах, таниулах, нэвтрүүлэх арга замыг дэлхийн бусад оронтой харьцуулан дүн шинжилгээ хийх нь уг салбарын дэвшилтэт байдалд нөлөөлөх боломж байх магадлалтай гэсэн таамаглалын хүрээнд судлалаа.

Хиймэл оюун ухаан буюу компьютерын программ ба хүний тархины үйл ажиллагааны хослол нь хүний харааны мэдрэмж, ялгах чадвар, тархины эргэцүүлэн бодох, дүн шинжилгээ хийх, дуу хоолойг таних, стратегийн сэтгэлгээ, төвөгтэй асуудлыг шийдвэрлэх гэх мэт олон талт чадварыг өөртөө багтаасан

Орчин үед дэлхий дахинаа криминалистикийн шинжлэх ухаан нь уламжлалт болон дижитал гэсэн хоёр чиглэлтэйгээр хөгжиж байгааг дурдах нь зүйтэй юм. Түүнчлэн хиймэл оюун ухаан нь шүүх шинжилгээний салбарын тогтолцооны дэвшилд хамгийн их тохиромжтой хөгжиж буй салбар юм. Өнөөгийн нөхцөл байдалд асар их хэмжээний өгөгдөл, эмх замбараагүй, ээдрээтэй байгаа орчинд уламжлалт лабораторийн бүтэц зэргээс үүдэн бүх төрлийн хэрэг бүртгэлт мөрдөн байцаалт, хууль зүйн шинжлэх ухааны бодит үр нөлөөг багасгах эрсдэл тулгарч байна[1].

[1] Artificial intelligence: An advanced Evolution In Forensic and Criminal Investigation review. https://www.researchgate.net/publication/362815618_Artificial_Intelligence_An_Advanced_Evolution_In_Forensics_And_Criminal_Investigation/link/632c57ca873eca0c00a8f803/download?_tp=eyJjb250ZXh0Ijp7ImZpcnN0UGFnZSI6InB1YmxpY2F0aW9uIiwicGFnZSI6InB1YmxpY2F0aW9uIn19 2024.04.10 – нд хандав.

Монгол улсын шүүх шинжилгээний салбар нь уламжлалт арга барилд суурилсан бөгөөд тэдгээрт:

- Мөр судлалын шинжилгээ
- Гар бичмэл, бичиг техник, гарын үсгийн шинжилгээ
- Галт зэвсгийн шинжилгээ
- Биологи, хими, бактериологи,
- Тоон технологийн шинжилгээ
- Мөнгөн тэмдэгтэд хийх шинжилгээ
- Гал түймрийн хэрэгт хийх шинжилгээ
- Хүрээлэн байгаа орчны эсрэг хэрэгт хийх шинжилгээ
- Хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэгт хийх шинжилгээ
- Хөдөлмөр хамгааллын хэрэгт хийх шинжилгээ хамаарч байна.

Биометрийн технологи:

Эрүүгийн мөрдөн байцаалтын явцад хурууны хээ нь хувь хүн бүрд өвөрмөц байдаг тул ихэвчлэн ашигладаг. Биометрийн технологийн хөгжил нь бие махбодын (хурууны хээ, гарны сканнер, ДНХ, зан үйлийн) шинж чанартай (хувийн алхалт, дуу хоолой гэх мэт) хувь хүнийг тодорхойлох одоогийн автоматжуулсан арга юм. Хурууны хээний биометрийн системүүд нь хурууны хээний өвөрмөц шинж чанарууд, тухайлбал, хээний зураас, хээний хоорондох хонхорхой гэх мэтийг судалж, дараа нь ухаалаг системүүдэд сайн мэддэг код болж хувирдаг. Биометрийн системд хэт олон сайн оролдлого хийх нь баталгаажуулалтын процессыг буруу хийхэд хүргэж болзошгүй [1] . Ухаалаг системүүд нь биометрийн системийг баталгаажуулах асуудлыг шалгах боломжийг олгодог. Биометрийн алгоритмыг удалгүй ашиглах нь эмнэлгийн болон хууль эрх зүйн нөхцөл байдал нь хэргийн газарт гэмт этгээдийг илрүүлэхэд ашигтай байх нь дамжиггүй.

Өнөөгийн орчин үеийн ертөнцөд биометрийн мэдээлэл нь хувь хүнийг үнэн зөв таних, баталгаажуулахад дэлхий даяар асар их ач холбогдол өгч, хүлээн зөвшөөрч байна. “Биометр” гэдэг үг нь хурууны хээ, гарын геометр, царай, дуу хоолой, цахилдаг, алхалт, товчлуурын даралтын динамик, гарын үсэг зэрэг физиологийн болон зан үйлийн шинж чанарыг агуулсан биологийн хэмжилтийг илэрхийлдэг[2].

Олон жилийн туршид биометрийн технологид асар их дэвшил гарсан. Үүний үр дүнд энэ нь үйл ажиллагаа, гүйлгээ, өдөр тутмын амьдралыг илүү

[1] Dilek S, Çakır H, Aydin M. Applications of artificial intelli gence techniques to combating cyber crimes: A review. 2015. http://dx.doi.org/10.1007/s11227-021-03992-1 2024.04.13-нд хандав.
[2] Maltoni D, Cappelli R, Meuwly D. Automated fingerprint iden- tification systems: From fingerprints to fingermarks.Handbook of Biometrics for Forensic Science. Cham: Springer 2017; pp. 37-61. http://dx.doi.org/10.1007/978-3-319-50673-9_3 2024.04.24-нд хандав.

аюулгүй, илүү тохиромжтой болгодог олон тооны программуудтай өргөнөөр нэгдсэн. Одоогоор биометрийн технологийг нэвтрүүлж буй зарим газар нь нисэх онгоцны буудал, хилийн аюулгүй байдал, цаг, ирцийн систем, шүүх эмнэлэг, хууль сахиулах, арилжааны салбар, гар утасны биометр, физик хандалтын хяналт ба тандалт.

Хурууны хээ нь хүн бүрд байдаг өвөрмөц хэв маягаас бүрддэг [2]. Өвөрмөц чанар, мөнхийн чанар, зайлшгүй чухал, олон нийтийн шинж чанар, цуглуулах чадвар өндөр, хадгалалт сайтай, өндөр гүйцэтгэлтэй байдгаараа хувь хүний мөн чанарыг тогтоох, баталгаажуулахад ашигладаг хамгийн алдартай, нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн биометрийн шинж чанар юм [3]. Олон зууны турш хурууны хээг гэмт хэрэгтнүүдийг илрүүлэх, яллах зорилгоор мөрдөн байцаалтын ажиллагаанд ашиглаж ирсэн. Өмнө нь гэмт хэрэгтэн, сэжигтний хурууны хээг бэх, хавтан, булгаар авч, хурууны хээний 10 хээтэй картад хадгалдаг байсан. Цаг хугацаа өнгөрөх тусам гэмт хэргийн тоо өсөхийн хэрээр эрүүгийн хэргийн тоо нэмэгдэж байгаа тул эдгээр 10 хэвлэх картыг гараар хадгалах, хайхад хэцүү болж байна. Технологийн хөгжлийг дагаад хурууны хээ таних автомат систем (AFIS) бий болсон. AFIS гэдэг нь компьютержсон мэдээллийн сан дахь 10 хэвлэх картыг дижитал хэлбэрт оруулах замаар хурууны хээг хадгалах, хайх, тааруулах үйл явцад туслах зорилгоор боловсруулсан компьютерын системийг хэлнэ. Үүний дараа таних үйл явцыг сайжруулж, хурдасгахын тулд AFIS системийг өргөн хүрээнд хэрэгжүүлсэн.[4]

Баллистик шинжилгээ ба буудлагын хүчин зүйл

Сум зэвсгээс гарахдаа баллистикийн ул мөр, дарь бодис ба хуруу болон гарын хээ гэх мэт гэмт хэргийн ул мөрөө үлдээж байдаг. Хиймэл оюун ухаан нь мэргэжилтнүүдийг хүний оролцоогүйгээр дарь, сумны хошууг эрэн хайх шаардлагатай газар луу чиглүүлж, зураг төсөл боловсруулах замаар мөрийг мэдээллийн сантай харьцуулж, буудлагын хүчийг тооцоолон алдагдсан сум болон бусад иж бүрдлийг илрүүлэх боломжийг олгодог. Одоогийн нөхцөл байдалд зарим алгоритмууд нь галт зэвсгээр буудсаны улмаас үүссэн ул мөрний үлдэгдлийг тодруулах, объект доторх дэлбэрэлтийн хүрээ, хэмжээг тооцоолох, цочролын долгионы өөрчлөлтийг илрүүлэх, түүгээр ч зогсохгүй гэмт хэргийн газарт буюу хэргийн орчинд бий болсон хохирогчийн шарх, гэмтэл нь ямар төрлийн галт зэвсгээр үүссэн болохыг тодорхойлох бүрэн боломж байгааг эрдэмтэд дурджээ.

Харьцуулсан судалгаа

№	***Улсууд /Nations/***	***Шүүх шинжилгээний салбарт AI болон мэдээллийн автоматжуулалтыг хийж буй туршлага***

1	АНУ /USA/	Шүүхийн шинжлэх ухаанд хиймэл оюун ухаан, автоматжуулалтыг ашиглах тал дээр АНУ тэргүүлж байна. Төрөл бүрийн хууль сахиулах байгууллагууд гэмт хэргийг илрүүлэхийн тулд нүүр царай таних технологи, хурууны хээ таних автомат систем, баллистик судлал[1], ДНХ шинжилгээний хэрэгслүүдийг ашигладаг[2]. Нэмж дурдахад ShotSpotter[3] зэрэг буу илрүүлэх системийг хэд хэдэн хотод буун дууны ослын үед хурдан хариу үйлдэл үзүүлэх зорилгоор ашигладаг[4].
2	Хятад /China/	• Хятад улс хурууны хээний шинжилгээ, царай таних, дуу хоолойд дүн шинжилгээ хийх хиймэл оюун ухаанд суурилсан нэгдсэн системийг өөрсдөө зохион бүтээсэн бөгөөд уг технологи болон эрх зүйн хослол нь иргэд болон төрийн байгууллагын хамтын үйл ажиллагааг үр дүнтэй арга болж чадсан хэмээн уг улсын хуульчид онцолж, цаашдаа уг үйл ажиллагаатай холбоотой судалгааны ажлыг дэлхий дахинд явуулна гэдгээ мэдэгдсэн[5]. Мөн БНХАУ-ийн хуульч, судлаачдын үзэж буйгаар уг технологи болон хиймэл оюун ухааны хосолмол нэгдэл нь зөвхөн шүүх шинжилгээгээр хязгаарлагдахгүй бүх талын хууль зүйн салбарт үр дүнгээ өгөх өндөр магадлалтай байна[6] хэмээн хэлэлцэж байгааг дурдах нь зүйтэй. • Хятадад хиймэл оюун ухаан (AI) ашиглан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нь технологийн шинэчлэл, хуулийн хяналтын гол цэг болсон. Энэхүү нийтлэлд Хятад улсын хиймэл оюун ухааныг гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд хэрхэн хэрэгжүүлж байгааг судалж, түүний үр нөлөө, тулгамдаж буй бэрхшээл, хууль эрх зүйн үр нөлөөг үнэлнэ. Шинжилгээ нь сүүлийн үеийн хөгжил дэвшил, эрдэм шинжилгээний ойлголтод үндэслэсэн бөгөөд энэхүү нарийн төвөгтэй, хувьсан өөрчлөгдөж буй салбарын талаар иж бүрэн ойлголт өгөх зорилготой юм.

[1] Forensic ballistics tools and software are employed to analyze firearms and ammunition, linking bullets and cartridge cases to specific weapons.

[2] DFS Laboratory Assessment Report. Washington, DC .2021 56 дах тал https://dfs.dc.gov/ 2023.10.19-нд хандав.

[3] is a publicly traded, Fremont, California-based company known for its controversial gunfire locator service.[2][3] ShotSpotter claims it can identify whether or not a gunshot was fired in an area in order to dispatch law enforcement, though researchers have noted concerns about effectiveness, reliability, privacy, and equity.

[4] DFS Laboratory Assessment Report. Washington, DC .2021 56 дах тал https://dfs.dc.gov/ 2023.10.19-нд хандав.

[5] 本词条缺少概述图，补充相关内容使词条更完整，还能快速升级，赶紧来编辑吧 https://baike.baidu.com/item/%E6%8A%A5%E5%91%8A/5481496?fromModule=lemma_search-box 2023.10.19-нд хандав.

[6] 本词条缺少概述图，补充相关内容使词条更完整，还能快速升级，赶紧来编辑吧 https://baike.baidu.com/item/%E6%8A%A5%E5%91%8A/5481496?fromModule=lemma_search-box 2023.10.19-нд хандав.

		• Мөн түүнчлэн Хятад улс гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор хиймэл оюун ухааныг ашиглаж байгаа нь урьдчилан таамаглах аналитик, царай таних, том өгөгдөл зэргээс шалтгаална (Futurism, 2024). Гуанжоу хотод байрладаг Cloud Walk компани нь болзошгүй гэмт хэрэгтнүүдийг илрүүлэхийн тулд зан үйлийн хэв маягийг хянадаг царай таних болон том мэдээллийн системийг хөгжүүлсэн (Futurism, 2024). Засгийн газар гадаад төрх нь өөрчлөгдсөн хэдий ч өөр өөр байршилд байгаа хүмүүсийг хянахын тулд "хувийн дахин таних" аргыг ашигладаг (Futurism, 2024). Ойролцоогоор 200 сая хяналтын камертай Хятад улс хиймэл оюун ухааны системийг үр дүнтэй сургах өргөн хүрээний мэдээллийн санг бий болгосон (Харвард, 2024; Futurism, 2024). Эх сурвалж: https://www.tpa.moj.gov.tw/
3	Герман [1] /Germany/	Герман улс хиймэл оюун ухааныг салбартаа нэвтрүүлээд удаагүй бөгөөд уг салбарт шинэ төрлийн инноваци нэвтрүүлэх алхмыг системчилсэн загвараар хэрэгжүүлэхээр төлөвлөж, улс төрийн хөгжлийн бодлогынхоо төлөвлөгөөнд тусгаж өгсөн бөгөөд орон нутагруу чиглэсэн шуурхай үйл ажиллагааг хэрэгжүүлж буй нь авууштай бөгөөд түүнийг цаг алдалгүй хэрэгжүүлэх боломжийг олгож байгаагаараа хууль зүйн салбартаа томоохон ахиц дэвшлийг бий болгосон байна. Ийнхүү уг хосолмол инновацийг зөвхөн шинжээч, эмч нарлуу чиглүүлэх бус ард иргэд рүү нээлттэй байдлаар чиглүүлсэн нэгдсэн платформыг үүсгэж иргэд төрийн байгууллагаас үйлчилгээ авах, шинжилгээний хариу авах, шинжилгээний цаг авах гэх мэт үйл ажиллагаа буюу процесстой холбогдсон бүх төрлийн ажиллагааг нэг дор цогцлоон бүтээж чадсан бөгөөд 2021 оны “Төрийн мэдээллийн албан ёсны судалгаа”-ны дүн мэдээ[2] болон уг сайтын хандалтын тоо өсөн нэмэгдэж байгаа нь уг таамаглалыг баталж байгаа хэрэг юм.
5	Япон /Japan/	Япон улс уг салбартаа технологийн хөгжлийг хиймэл оюун ухаантай уялдуулан зохицуулж “Хурууны хээ болон гарын алганы хээний, царай таних программ ДНХ шинжилгээ, видео нотлох баримтын, хэлний болон баримт бичгийн, баллистик мөр судлал” гэх мэт шүүх шинжилгээний дийлэнх шинжилгээнд амжилттайгаар нэвтрүүлэн ашиглаж[3] буй орны нэг бөгөөд мөн тусгайлсан платформыг үүсгэн байгуулж уг нэгдсэн иж бүрэн платформоор 24 цагийн мэдээллийн лавлах ажилтантай иргэд

[1] Germany uses AI for analyzing complex evidence, including DNA and bloodstain pattern analysis. Machine learning algorithms are applied to assess and interpret this evidence efficiently.

[2] https://www.fr.de/politik/massregelvollzug-hinter-dicken-mauern-herrschen-zustaende-die-untragbar-sind-92044461.html 2023.10.20-нд хандав.

[3] https://www.smcgov.org/media/137811/download?inline= 2023.10.19-нд хандав.

		шууд харилцах боломжийг нээсэн байгаа нь иргэдийн дунд ихээхэн сайшаалтай хэрэг болж байгааг уг сайтыг үнэлсэн иргэдийн үнэлгээнээс харагдаж байна. Мөн Шүүх Шинжилгээний байгууллага болоод шинжээчдэд итгэх итгэлийн судалгаа[1] нь тус платформыг нэвтрүүлсэн цагаас хойш 17.8%-иар өссөн үзүүлэлтийг илэрхийлсэн байна[2].

ДҮГНЭЛТ, САНАЛ

Аливаа орны хууль зүйн шинжлэх ухааны нэн чухал бөгөөд дэд институт болох шүүх шинжилгээний салбар ухааныг дэлхий нийтийн чиг хандлага руу хөтлөн оруулах, шинэ төрлийн арга замыг эрэлхийлэн хайж түүнд хүрэх боломжит хувилбар нөхцөл байдлыг судлан тогтоохыг судлаач бид хүссэн бөгөөд асуудлынхаа шийдэл буюу хариулт гарц гаргалгаанд хүрэхэд нэг алхам ойртлоо.

Шүүхийн шинжлэх ухаан нь гэмт хэргийг мөрдөн шалгах, шударга ёсыг тогтооход илүү үр дүнтэй шинжлэх ухааны зарчим, арга техникийг ашиглахыг хамардаг бөгөөд асар их хэмжээний нарийн төвөгтэй мэдээллийг танин мэдэхүй шаарддаг. Тиймээс хиймэл оюун ухаан нь өнөөгийн олон бэрхшээлийг даван туулахад тохиромжтой арга юм. Монгол улсын Шүүх шинжилгээний салбар дахь уламжлалт арга ухаан, материаллаг хүний нөөцийн асуудал, ажлын ачаалал зэрэг асуудлуудын доор хариулт хайж технологийн салбар дахь “реформ”-ийг үүсгэх боломжтой гэж үзэж байна.

Дэлхийн бусад орны сайн туршлагыг шүүх шинжилгээний салбарт нэвтэрснээр нь дүрс таних, зураг болон видео шинжилгээ, галт зэвсгийг таних буюу баллистик судлал, сум илрүүлэх, хэргийн газрыг 3 хэмжээстээр сэргээн засварлах, гар бичмэлийг таних, баримт бичгийн шинжилгээ, видео нотлох баримтыг задлан шинжлэх, гутлын хээ, сумны тэмдэг зэрэг гэмт хэргийн газрын нотлох баримтыг таних, үл мэдэгдэх гавлын яснаас нүүр царайг 3D дүрсээр сэргээн засварлах гэх мэт шинжлэн магадлах үйл ажиллагааг шинжлэх ухааны олон талт үйл ажиллагаанд маш их ашиг тустай төдийгүй криминалистикийн үндсэн категори болох адилтгал, оношлолын шинжилгээг ерөнхийлөн ашиглаж байгаа нь харагдаж байгаа нь уг арга барилыг улс орондоо нутагшуулан ашиглах боломжийг илэрхийлж байна. Иймд судлаач бидний зүгээс өөрсдийн судалгааны нэгдсэн дүгнэлт болгож дараах саналыг дэвшүүлж байна.

- Юун түрүүнд шинэ зууны техник хэрэгсэл, мэдээллийн технологитой ажиллах мэргэжлийн ур чадварыг нэмэгдүүлж, уг салбарт мэргэшсэн шинжээчдийг бэлтгэх, чадавхжуулах, сургалт зохион байгуулах

[1] https://www.mhlw.go.jp/shingi/2007/05/dl/s0511-3a_04_0005.pdf 2023.10.22-нд хандав.
[2] https://www.smcgov.org/media/137811/download?inline= 2023.10.19-нд хандав.

- Шүүхийн шинжилгээний байгууллага түүний тодорхой төрлийн үйл ажиллагааг иж бүрэн хэлбэрээр хэрэгжүүлж болох нэгдсэн цахим хэлбэрийн платформ үүсгэх боломж, түүнийг ашиглах орчин нөхцөлийг судлан тогтоох
- Иргэдэд шүүх шинжилгээ болон хиймэл оюун ухааны талаар мэдээлэл, заавар зөвлөгөөг хүргэж нийтэд таниулах, сургалт үйл ажиллагаа зохион байгуулах
- Дэлхий нийтийн бусад орны сайн туршлагыг дэлгэрүүлэн судлаж, өөрийн оронд нутагшуулах замаар хэрэгжүүлэх

ХИЙМЭЛ ОЮУН УХААНД СУУРИЛСАН ЦАРАЙ ТАНИХ ТЕХНОЛОГИ

Х.Түвшин-Эрдэнэ
Дотоод хэргийн их сургуулийн ШМУС-ийн БУТЗШТ-ийн багш, цагдаагийн дэд хурандаа
Ч.Цогтбаяр
Дотоод хэргийн их сургуулийн ШМУС-ийн магистрант, дэд ахлагч

Хураангуй: Хиймэл оюун ухааны тусламжтайгаар олон зуун ажилчдын хөдөлмөрийг автомат машинаар орлуулж хэмнэлт хийх боломжтой бөгөөд нэн ялангуяа царай таних алгоритмыг илүү нарийвчлалтай болгоход түлхүү ашиглаж, улам боловсронгуй болгон хөгжүүлж байна. Царай таних технологийн программ хангамжийг аюулгүй байдлын үүднээс олны дунд байгаа хүмүүсийг таних, эсвэл олон нийтийн газар хүмүүсийн хөдөлгөөнийг хянахад ашиглаж болно. Мөн хууль сахиулах байгууллагад эрүүгийн мөрдөх ажиллагааны явцад сэжигтнийг илрүүлэхэд ашигладаг. Нөгөөтээгүүр, царай илрүүлэх технологи нь хувь хүний царайны онцлогийг зөвшөөрөлгүйгээр авч, шинжилдэг тул хүний эрхийн асуудал, түүнийг дагалдан нууцлалын асуудал үүсгэдэг. Ерөнхийдөө царай илрүүлэх технологи нь олон давуу талтай боловч түүнийг хариуцлагатай, ёс зүйтэй ашиглахын тулд анхаарах, ёс зүй, хувийн нууцтай холбоотой асуудлуудыг бий болгоно.

Түлхүүр үг: “Хиймэл оюун ухаан” нь компьютерын программ хангамжаар, хүний сэтгэхүйг дуурайлган бүтээсэн алгоритмд суурилсан технологи бөгөөд түүнийг улам боловсронгуй болгон, хүний сэтгэхүйтэй бараг ижил түвшинд хүргэхийг хичээж хүний хийдэг үйл ажиллагааг хийж орлуулахад зориулагддаг болно.

“Царай таних систем” гэдэг нь видео бичлэг дээр суурилсан хүний царайг таньж, тогтоох чадвартай программ хангамж юм.

"Хүний гадна дүр төрхийн шинжилгээ" нь хүний биометрт мэдээллийн физик, антропологи, геометрийн шинж тэмдгийг ашиглан тогтоох, адилтган шинжилж, дүгнэлт гаргах ажиллагаа;

"Цахим технологийн зарим төрлийн шинжилгээ" нь хиймэл оюун ухаан болон интеграцчилсан (IoT) бүтэцтэй технологи, төхөөрөмжийг шинжилж, дүгнэлт гаргах ажиллагаа

Нүүр, царай таних системийн товч түүх

Компьютерын хувьсал 1960-аад оноос эхлэлтэй бөгөөд мэдээллийн сан дахь царайны цуглуулгаас нүүрний онцлогийг хэмжих, тодорхойлоход зориулсан компьютерийн программуудыг тэр үеэс зохион бүтээж, туршиж, ашиглаж иржээ. Нүүр, царайг таних аргыг 1964 онд компьютерийн эрдэмтэн, математикч Вуди

Бледсо, Чарльз Биссон, Хелен Чан Вольф нар албан ёсоор анхлан санаачилсан байна.

Жаран жилийн өмнө тариачны хүү Вуди Бледсо нүүр царай таних технологийг зохион бүтээсэн боловч түүний судалгаандаа ашиглан нээлт хийсэн материал, нотлох баримтууд үрэн таран болж олдохоо больжээ. Вуди Бледсо бараг гучин жилийн турш Остин дахь Техасын Их Сургуулийн профессороор ажиллаж, автомат үндэслэл, хиймэл оюун ухааныг хөгжүүлэх чиглэлээр ажилласан хүн юм. Бледсогийн хүү Лансын дурдатгалд дурдсанаар профессор 1950-иад оны сүүлчээр хүний чадавхаар хангагдсан, нарийн төвөгтэй математик теоремуудыг нотлох, харилцан яриа өрнүүлэх, зохистой пинг тоглох чадвартай компьютер бүтээхийг мөрөөддөг урам зоригтой, өөдрөг эрдэмтэн байжээ. Гэвч Бледсо карьерынхаа эхэн үед машинд нүүр царайг танихыг заах хүсэл эрмэлзэл их байсан бөгөөд тухайн үед үнэлэгддэггүй байсан ч уйгагүй хөдөлмөрлөж байв.





Эдгээр нь нүүр царайг тодорхойлох анхны судалгаанууд (1960) бөгөөд профессорын ажил нь АНУ-ын тагнуулын байгууллагуудын сонирхлыг татсан юм.

1970-аад он гэхэд үсний өнгө, уруулын хэлбэр болон бусад гол таних шинж тэмдгүүдийн хувьд нүүр царайг таних нарийвчлал хурдацтай хөгжих болсон. Системийг илүү нарийн болгохын тулд шугаман алгебрыг дараагийн хэдэн арван жилийн турш улам бүр ашиглах болсон.

1993-2000-аад онд АНУ-ын Батлан хамгаалахын дэвшилтэт судалгааны төслүүдийн агентлаг (DAPRA) болон Үндэсний стандарт, технологийн хүрээлэн (NIST) хамтран нүүрний хамгийн өргөн мэдээллийн сан болох 14 мянга гаруй зураг бүхий FERET программыг гаргасан бөгөөд түүнийг дэлхийн өнцөг булан бүрээс гэмт хэрэгтнүүдийг олоход анх ашиглаж байв. Дараа нь нүүр царай таних арилжааны зах зээлд түлхэц өгөн өдөөх зорилгоор олон нийтэд ил гаргажээ.

2001 онд АНУ-ын хууль сахиулах байгууллага Super Bowl-ын хөл бөмбөгийн үзэгчдийг тасалдуулах хохирол учруулж болзошгүй иргэдийг илрүүлэхийн тулд


нүүр таних системийг анх удаа ашигласан нь чухал үйл явдал болсон юм. Өнөөгийн дижитал экосистем дэх ач холбогдол, орчин үеийн амьдралын бүхий л салбарт биш юмаа гэхэд нүүр царай таних систем нь улам бүр түгээмэл болж байна.


Нүүр, царай таних систем

Царай таних систем бол дижитал зураг эсвэл видео кадр боловсруулдаг алгоритмыг ашиглан хэн нэгний биеийн байцаалтыг баталгаажуулах нарийн төвөгтэй арга технологи бөгөөд ажиллах үндсэн зарчим нь зурагт үзүүлсэн хүний царайны гадаад төрхийн онцлог шинжээр мэдээллийн санд өмнө авч хадгалсан байгаа адил дүрстэй харьцуулан адилтгаж тодорхойлох явдал юм. Орчин үед царай таних технологи улам бүр түгээмэл болж, шинэ хэрэглээг байнга хөгжүүлсээр байна. Тохиромжтой программ хангамж, алгоритмууд нь өгөгдлийн эх үүсвэр, нарийвчлалыг нэмэгдүүлснээр дижитал зураг, видео бичлэгүүдэд дүрслэх хүний гадна төрхийн онцлог шинжүүдийг бүр нарийн болгон, хүний царайг ялгахад улам хялбар болж байна. Царай таних болон өгөгдлийг ашиглах нь арилжааны танилтын амин чухал хэсэг болж, хувь хүмүүст чиглэсэн, борлуулалт, маркетингийн мессежийг хувийн болгоход тусалдаг. Царай таних нь зургийг автоматаар индексжүүлэх, хүн ба технологийн харилцан үйлчлэл, видео тандалтын системд улам өргөн ашиглагдаж байна. Технологийн дэвшил нь мэдэгдэхүйц шинэчлэлтүүдийг авчирдаг.


Нүүр, царай танигчийн ажиллагааны зарчим

Виола-Жонсын царайг илрүүлэх алгоритмыг Пол Виола, Майкл Жонс нар хамтран санал болгосон. Хэдийгээр энэ нь нүүр царайг бодит цаг хугацаанд нь илрүүлэх боломжийг тодорхой хэмжээгээр хэрэгжүүлсэн ч илрүүлэх түвшин харьцангуй бага магадлалтай байсан. Гэсэн хэдий ч орчин үеийн нүүр царай таних технологи нь “convolutional neural network” буюу “эргэлтийн мэдрэлийн сүлжээ” гэж нэрлэдэг мэдрэлийн тодорхой сүлжээнд суурилдаг. Гаднаас оруулж ирж байгаа нүүрний онцлог шинжүүдийг санамжид байгаа царайнуудын онцлог шинжүүдтэй адилтган танихын тулд эргэлтийн мэдрэлийн сүлжээ нь зураг бүрийг хэд хэдэн алхмаар боловсруулдаг.





Зураг-1. Viola Jones Algorithm



Зураг-2.Convolutional neural network- Эргэлтийн мэдрэлийн тор

Царай илрүүлэх: Эхний алхам бол том зураг эсвэл үзэгдэл дотор дүрслэгдсэн олон дүрсээс зөвхөн царайг таньж илрүүлэх явдал бөгөөд энэ үйл явц нь зурагт дүрслэгдсэн царайны онцлогийг хамт дүрслэгдсэн бусад дүрсээс ялгаж, царайг бүрдүүлж буй хүрээн доторх байршлыг тогтоох явдал юм.

Нүүрний онцлог шинжийг тодорхойлох: Царайг илрүүлсний дараах технологи нь нүүрний дүрсийг бүрдүүлж буй гадна төрхийн онцлог шинжид дүн шинжилгээ хийдэг. Энэ дүн шинжилгээ ихэвчлэн нүүрний геометр дүрс дээр суурьлах бөгөөд хүхэн харааны хоорондын зай, дух, шанаа, эрүүний цэгүүд, түүнчлэн хацрын, уруулын дээд доод ирмэг, 2 үзүүр, завьж зэрэг антропологийн зангилаа цэгүүдээр баримжаа тогтоож нүүрний хэсгүүдийн гол цэгүүдийг нарийвчлан хэмждэг.

Хувийн онцлог шинжийн нийлбэрийг боловсруулах: нүүрний гадна төрхийн онцлог шинжийг тодорхойлсны үр дүнд тодорхой нэг царай бусад хүний царайнаас ялгарах, дахин давтагдашгүй, хувийн онцлог шинжийн нийлбэрээр нүүрний гадна төрхийн онцлог шинжүүдийг системчлэн тогтоож, түүний хэлбэр, “загвар” буюу нүүрний геометр дүрсийн дижитал зургийг граган боловсруулж улмаар адилтган тогтоох процесст ашигладаг.

Харьцуулалт: Нүүрний гадна төрхийн онцлогт хийсэн дүн шинжилгээгээр тодорхойлсон хэмжилт дүрсийг өмнө авч бүрдүүлсэн, мэдээллийн санд буй царайнуудын онцлог шинжтэй харьцуулна. Хүний гадна төрхийн онцлог шинж түүний зургийг авах үеийн гэрэлтүүлэг, толгой хажуу тийш гилжийх болон тонгойж гэдийсэн өнцөг зэргээс шалтгаалан өөр өөр дүрс үүсгэдэг бөгөөд эдгээр өөрчлөлтийг зохицуулан аль болох адил болгон жигдлэх нарийн төвөгтэй алгоритмуудыг ашиглан адилтгал хийдэг. Хувиралт мэдрэлийн сүлжээ нь нүүрний загвар бүрийг тоон вектор хэлбэрээр илэрхийлсэн, загвар бүрийн тоон код болгон

хувиргадаг. Хоёр вектор бие биендээ ойртох тусам тэдгээрийн хооронд нүүр таарах магадлал өндөр байна.

Нүүр царайг таних технологи нь нүүрний дүрсийг үүсгэж буй дижитал зураг эсвэл видео хүрээ авах замаар ажилладаг. Энэ зургийг антропологийн зангилаа цэг гэж нэрлэдэг нүүрэн дээрх тодорхой тэмдэглэгээ, эсвэл онцлог шинжийг тодорхойлохын тулд нарийн шинжилгээ хийдэг. Хүүхэн харааны хоорондын зай, самсааны өргөн, дух ба эрүүний өргөн гэх мэт, хүний нүүрний геометр дүрсийн чухал элемент болох эдгээр зангилаа цэгүүдийг тодорхой нэг хүний царайны хэлбэрийг бусад царайнаас ялгах хувийн онцлог шинжүүдийн нийлбэрийг боловсруулан гаргахад ашигладаг. Орчин үеийн царай таних системүүд хүний гадна төрхийн онцлог шинжийг 80 гаруй зангилааны цэгийн нийлбэрээр ялган таних боломжтой нарийн алгоритмуудыг ашигладаг. Энэхүү хувийн онцлог шинжүүдийн нийлбэрийг бүрдүүлэгч зангилгаа цэгүүдийн баримжаагаар авсан мэдээллийг математик томьёо болгон хувиргаснаар давтагдашгүй нэгэн өвөрмөц дүрсийн алгоритмыг гарган авах ба түүнийг “нүүрний гарын үсэг” гэж нэрлэдэг. Энэхүү “гарын үсэг” нь мэдээллийн санд хадгалагдсан нүүрний дүрсийг бүрдүүлэгч хувийн онцлог шинжүүдийн нийлбэрийг агуулсан өвөрмөц тоон код юм. Нүүр царай таних технологи нь шинэ зурагтай тулгарах үед, өөрөөр хэлбэл, нүүр царай таних системд өмнө бүртгэгдэж байгаагүй шинэ дураг оруулах үед шинээр оруулж буй царайны гадна төрхийн онцлог шинжийн нийлбэрийг дээр дурдсанчлан 80 гаруй зангилгаа цэгийн нийлбэрээр боловсруулж, өмнө тодорхой байгаа буюу мэдээллийн санд байгаа царайнуудын өгөгдөлтэй харьцуулдаг. Ийнхүү хүний гадна төрхийн онцлог шинжийг өөр бусад хүнийхээс ялган нарийвчилж, тухайлан тогтоох процесс хүний гадна төрхийн салангид ганц 2 шинж тэмдэгт бус, дахин давтагдашгүй онцлог шинжийн нийлбэр дээр үндэслэдэг тул криминалистикт хүний гарын мөрийг “хээний гарын үсэг”, хүний үнэрийг түүний “химийн гарын үсэг” хэмээн нэрлэдгийн адил “царайны гарын үсэг” гэж нэрлэх болсон байна.

Хиймэл оюун ухааны нарийн төвөгтэй алгоритмуудыг ашиглах систем нь хүний нүүрний гадна төрхийн онцлог шинжийг нийлбэрийг гайхалтай хурд, нарийвчлалтайгаар үнэлдэг бөгөөд хадгалагдсан нүүрний “царайны гарын үсэг”-тэй таарч байгаа эсэхийг адилтган тогтоодог. Нүүр, царай таних технологийн амжилтын гол түлхүүр нь хүний гадна төрхийн оэцлог шинж тэмдгийн нийлбэрээр дахин давтагдашгүй өвөрмц нэг загвар үүсгэх, түүнийг харьцуулах үйл явцыг боловсронгуй болгож буй машин байнга боловсронгуй болон хөгжиж, дэвшиж буй явдал юм.

Царай таних систем нь боловсруулж буй нүүр царай бүрээсээ суралцах тусам түүний нарийвчлалыг аажмаар нэмэгдүүлж, аюулгүй байдал, хувийн баталгаажуулалт, дижитал системийн янз бүрийн хэрэглээ зэрэг салбарт технологийн гол үүргийг бэхжүүлдэг.

Нүүр царай таних технологийн давуу тал.

Нүүр царай таних программ нь олон давуу талтай. Гол чиглэл бол олон нийтийн газар болон банк, сургууль, хорих анги, нисэх онгоцны буудал зэрэг компани, байгууллагуудын аюулгүй байдлыг сайжруулах явдал юм. Энэ нь хууль сахиулагчдад сонирхсон хүмүүсийг илүү хурдан илрүүлж, тэднийг мөрдөж, ямар нэгэн хохирол учруулахаас урьдчилан сэргийлэхийн тулд тэдний хөдөлгөөнийг боловсруулахад тусалдаг. Энэ нь нисэх онгоцны буудал, хилийн боомт, банк, ажлын байр болон бусад барилга руу орох, гарах гэх мэт захиалагчийн даалгаврын шалгалтыг хурдасгах боломжтой. Энэ нь олон нийтийн мэдээллийн хэрэгсэлтэй маш сайн ажилладаг бөгөөд нууц үг, код оруулахаас илүүтэйгээр данс руу нэвтрэх өөр бусад аргыг санал болгодог. Жижиглэн худалдаачид болон маркетингийн мэргэжилтнүүд ч мөн энэ технологийг ашиглан зар сурталчилгаа, арилжааны мессежийг хэрэглэгчдэд илүү нарийвчлалтай хүргэх боломжтой. Мөн нүүр царай танигчийг утас, зөөврийн компьютер, паспорт, төлбөрийн хэрэглүүрийн аюулгүй байдлыг хангахад ашигладаг.

Өнөөгийн хурдацтай хөгжиж буй дижитал системд нүүр таних технологи нь аюулгүй байдал, санхүүгээс эхлээд жижиглэн худалдаа, зугаа цэнгэл хүртэлх олон салбарыг өөрчлөн хувиргах технологи гэдгээрээ онцлог юм. Хувь хүнийг хурдан бөгөөд үнэн зөв тодорхойлох чадвар нь баталгаажуулалтын үйл явцыг хялбарчилж, уламжлалт нууц үг эсвэл физик ID-н хэрэгцээг арилгаад зогсохгүй хэрэглэгчийн хувийн туршлагыг бий болгосон. Бизнесүүд өөрт тохирсон үйлчилгээг санал болгохыг эрмэлзэж, засгийн газрууд олон нийтийн аюулгүй байдлыг сайжруулахыг эрмэлзэхийн хэрээр царай таних системийн ач холбогдол улам бүр нэмэгдсээр байгаа нь улам бүр харилцан уялдаатай болж буй манай ертөнцөд инновацийг хөгжүүлэх, аюулгүй байдлыг хангахад чухал үүрэг гүйцэтгэж байгааг онцолж байна.

Нүүр царай таних технологи нь хурдан бөгөөд найдвартай баталгаажуулах болон таних үйлчилгээг үзүүлэх чадамжтай учраас өнөөгийн дижитал системийн чухал бүрэлдэхүүн хэсэг болон хөгжиж байна. Аюулгүй байдал, хэрэглэгчийн баталгаажуулалт хамгийн чухал байгаа өнөө үед нүүр царай таних технологи нь уламжлалт аргуудаас өөр хэрэглэгчдэд хялбар, хамгаалалтыг санал болгодог. Бизнесийн салбарт энэхүү технологи нь байшин барилга, байгууламжид аюулгүй, түлхүүргүй нэвтрэх боломжийг олгож, хэрэглэгчийн баталгаажуулалтын үйл явцыг хурдасгаж, улмаар цаг хугацаа хэмнэж, хүндрэлтэй асуудлыг багасгадаг. Хэрэглэгчдэд чиглэсэн салбаруудад нүүр царай таних нь хувь хүний үйлчилгээ, зорилтот маркетингаар дамжуулан хэрэглэгчийн туршлагыг сайжруулж, өндөр оролцоо, үнэнч байх боломжийг бий болгодог. Түүнчлэн, дижитал өөрчлөлтийн дараа нүүр царай таних нь цахим платформуудын хувьд чухал ач холбогдолтой бөгөөд дижитал баримжааг удирдаж, залилан мэхлэхээс хамгаалах системд

үндэслэдэг. Үүнийг ухаалаг гар утас, зөөврийн компьютер зэрэг өдөр тутмын төхөөрөмжүүдэд нэгтгэснээр биометрийн аюулгүй байдлыг хэрэглэгчийн технологийн тэргүүн эгнээнд авчирч, хувийн нууцлал, өгөгдөл хамгаалах шинэ стандартуудыг бий болгосон. Технологийн өргөтгөх чадвар, олон талт байдал нь хувийн зар сурталчилгаагаар жижиглэнгийн худалдааны туршлагаа сайжруулахаас эхлээд хяналтын дэвшилтэт чадавхаар дамжуулан хилийн аюулгүй байдлыг бэхжүүлэх хүртэл янз бүрийн салбар дахь өргөн хүрээний хэрэглээг дэмжих боломжийг олгодог. Иймээс нүүр царай таних нь инновацын тулгын чулуу болж, илүү аюулгүй, илүү хувь хүний дижитал ирээдүйг урагшлуулна.

Энэхүү технологи нь зар сурталчилгааны зорилтот зах зээлийг үндсээр нь өөрчилж, зарим өвчний оношилгоог хурдасгах төлөвтэй байна. Үүний зэрэгцээ нүүр царайг таних технологи нь засгийн газрын дарамт шахалт, аж ахуйн нэгжийн хяналтын хэрэгсэл болж байна. Хятадад засгийн газар энэ технологийг ашиглан олон зуун мянган Уйгур үндэстний цөөнхийн гишүүдийг мөрдөж байгаа бөгөөд тэдний олон зуун мянган хүн улс төрийн хорих лагерьт хоригдож байна. Мөн АНУ-д "Вашингтон Пост" сонинд бичсэнээр Цагаачлал, Гаалийн алба болон Холбооны мөрдөх товчоо дижитал хайлт хийж байна: засгийн газрын жолооны үнэмлэхийн мэдээллийн сангаас сэжигтнийг хайж, заримдаа шүүхэд хандахгүйгээр хайх боломжийг олгож байдаг.

2019 онд Financial Times сэтгүүлийн мөрдөн байцаалтаар Майкрософт болон Стэнфордын их сургуулийн судлаачид гэрэл зураг авсан хүмүүсийн мэдээлэл, зөвшөөрөлгүйгээр хүмүүсийн зургийг агуулсан их хэмжээний мэдээллийг цуглуулж, олон нийтэд дэлгэсэн болохыг тогтоожээ. Британийн Surfshark компани 194 орны засгийн газрын түвшинд царай таних технологийг ашигласан газрын зургийг эмхэтгэсэн байна. Улс орнуудад уг технологийг хэрхэн нэвтрүүлж байгаагаас хамааран: “ашиглаж байгаа, ашиглахыг зөвшөөрсөн (хэрэгжүүлээгүй), хэлэлцэж байгаа, ашиглалтын мэдээлэл байхгүй, хориглосон” гэсэн 5 статусын 1-д хамаарч байна. Одоогоор нийт 109 улс нүүр царай таних технологийг тандалтын зорилгоор ашигладаг эсвэл ашиглахыг зөвшөөрсөн улс байна. Эдгээр улсуудын ихэнх нь үндэсний мэдээллийн сан, орон нутгийн алгоритмтай. Сонирхуулахад, энэ технологийг олон нийтэд ашиглахыг хууль бус гэж зарласан цорын ганц улс нь Бельги юм. Мөн олон улсын засгийн газар болон тэдний иргэд олон нийтийн хяналт шалгалтын ёс зүй, хууль ёсны талаар дэлхий нийтийн мэтгэлцээний дунд байна. Нүүр царай таних судалгааны ёс зүйн өнгө аясыг тодорхойлсон бөгөөд бөгөөд асуудалтай байна.

ДҮГНЭЛТ

Олон улсын практикт царай таних технологийн системийг олон нийтийн газар болон банк, сургууль, хорих анги, нисэх онгоцны буудал зэрэг компани, байгууллагуудын аюулгүй байдлыг хянахад хэрэглэж байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, эрэн сурвалжлах, эрүүгийн мөрдөн байцаалтын явцад сэжигтнийг илрүүлэхэд мөн ашиглаж байна.

Хууль сахиулах байгууллагууд өөрсдийн үйл ажиллагааны чиглэлээр гэмт хэргийн цахим дүр зургийн биометрийн сан үүсгэн гэмт этгээдийг эрэн сурвалжлах, адилтгахад ашигладаг байна.

Царай таних системийг ашиглан хүний гадаад төрх болон сэтгэл хөдлөлийг таних боломж нээгдэх юм.

Нүүр танилтын системийн алгоритмыг зохион бүтээх дотоодын мэргэжилтнүүдийн хүчээр монгол хүний онцлогт суурилсан платформ хийх боломжтой байна.

ХУУЛЬ САХИУЛАГЧИЙН ХҮНИЙ ЭРХЭД СУУРИЛСАН ШИЙДВЭР ГАРГАЛТ

HUMAN RIGHTS-BASED DECISION-MAKING BY LAW ENFORCEMENT

Э.Өнөболд

Дотоод хэргийн их сургуулийн Сургалт, судалгааны 403 дугаар анги-Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн багш, хошууч,

Хураангуй: Хууль сахиулах байгууллагын алба хаагч нь хуулийг нэг мөр хэрэгжүүлж, сахин хамгаалахад чиглэгддэг. Харин хуулийг сахин хамгаалах чиг үүрэг нь хүний эрх, эрх чөлөөтэй хэрхэн холбогдож, хууль сахиулагч хүний эрхэд суурилсан шийдвэрийг хэрхэн гаргах боломжтойг тодорхойлохыг зорьсон.

Уг зорилгод хүрэхийн тулд өгүүллийг хууль зүйн шинжлэх ухааны норматив арга зүйд суурилан боловсруулаа. Энэ арга зүйн хүрээнд хөгжлийн хандлагын ерөнхий агуулгыг судлан түүнд агуулагдах үзэл санааг хууль сахиулагчийн шийдвэр гаргалтад авч үзэх шалгууруудыг болгох байдлаар судалгааг хийсэн.

Төрийн байгууллагын үйл ажиллагаа нь хууль хэмээх бодлогын шийдвэрт суурилах бөгөөд хуулийг боловсруулах, батлах үйл ажиллагаа болон хуулийг хэрэгжүүлэх үе шатанд төрийн албан хаагч, хууль сахиулагчаас хүний эрхийн шалгууруудаар шийдвэр гаргах бүрэн боломжтой болохыг дүгнэсэн.

Түлхүүр үг: Хүний эрх, хууль сахиулагч, шийдвэр, шийдвэр гаргалт, хөгжил, хандлага, алба хаагч, ач холбогдол.

Удиртгал

Хүний эрх ба хөгжил хоёр нь харилцан хамаарал бүхий үнэт зүйлс болохын хувьд учир шалтгаант холбоогоор холбогддог. Хүний эрх болон хөгжлийн хоорондын хамаарал нь Хүний хөгжлийн хандлага, НҮБ-ын Хөгжих эрхийн тунхаглал, Мянганы хөгжлийн зорилтууд, Тогтвортой хөгжлийн зорилтууд[1] зэрэг баримт бичгүүдэд тусгагдсан байдаг. Эдгээр баримт бичгүүд нь хүний эрх ба хөгжлийн хоорондын харилцан хамаарлыг чухалчлан үзэхийн хамт олон улсын болон үндэсний хөгжлийн бодлогод тусгахыг эрмэлздэг. Мөн иргэний, улс төрийн, нийгэм, эдийн засгийн болон соёлын ямар нэгэн эрхийг эдлэх боломжгүй байх нь хөгжилд тулгарч буй бэрхшээл саад мөн болохыг онцлон үзсэн байдаг. Иймд хүний эрх болон хөгжлийн хоорондын нэгдмэл чанарт үндэслэсэн эрхэд суурилан хөгжих хандлага, түүний үнэт зүйлсийг чухалчлан үзэх байдал нэмэгдэж байна.

[1] Тогтвортой хөгжлийн зорилго. НҮБ-ийн Ерөнхий Ассамблей. Женев., 2015 оны 09-р сар.

Улс орны хөгжлийг тодорхойлох хамгийн том хүчин зүйл бол шийдвэр гаргалт бөгөөд тухайн шийдвэрийн үзэл санаа, зорилго нь улс орны хөгжлийн чиг хандлага, тогтвортой хөгжлийг тодорхойлж байна.

Төрийн байгууллага, албан тушаалтны шийдвэр гаргалт нь хүний эрх, хүний хэрэгцээнд тулгуурласан оновчтой, шударга байх ёстой. Бүх шатны шийдвэр гаргалт тухайн улсын хөгжлийн түвшин чиг баримжааг тодорхойлох бөгөөд дан ганц эрх барих байгууллага, бодлого боловсруулагчийн шийдвэр гаргалтыг онцлон авч үзэх нь хүний эрхэд суурилсан шийдвэр гаргалтыг бүрэн илэрхийлэхгүй юм. Харин төрийн нэрийн өмнөөс албан үүрэг гүйцэтгэх байгаа хэн бүхний оролцоо үүнд чухал нөлөөтэй.

Иймд албан хаагч буюу хууль сахиулачгийн хүний эрхэд суурилсан шийдвэр гаргалт болон шийдвэр гаргах үйл ажиллагааг судлан, шинжлэх хэрэгтэй.

Үндсэн хэсэг

Хүний эрхийн хандлага нь нийгмийн хөгжилтэй салшгүй холбоотой болохын хувьд шийдвэр гаргалт, шийдлийн хувилбаруудыг боловсруулахад хүний эрхийн суурь ойлголт, зарчим, хүний хэрэгцээний асуудал чухал байх суурь эзэлдэг.

“Хөгжил нь нийт иргэд, хувь хүмүүсийн идэвхтэй, чөлөөт оролцоонд үндэслэн нийгэмд бий болж буй үр ашгийг шударгаар хуваарилах, бүх нийтийн сайн сайхан байдлыг хангах зорилго бүхий улс төр, эдийн засаг, нийгэм соёлын цогц үйл явц мөн”[1] гэж тодорхойлж байгаа бөгөөд биет байдлаар оюун санаанд бий болон хэрэгждэг ойлголт юм.

Хөгжлийн хандлагыг халамжид суурилсан, хэрэгцээнд суурилсан, эрхэд суурилсан хэмээн ангилж байна[2].

Халамжид суурилсан хандлагын шинжүүд:

- Үр дүнд бус өгөгдөхүүнд анхаардаг
- Халамжийг нэмэгдүүлэхийг чухалчилдаг
- Баячууд ядуусыг тэтгэх ёстой гэсэн ёс суртахууны хариуцлагыг дэмждэг
- Бие хүнийг хохирогч гэж хардаг
- Хүмүүсийг тусламж дэмжлэг авах шаардлагатай гэж хардаг
- Асуудлын илрэн гарч буй хэлбэрт анхаарал хандуулдаг.

Хэрэгцээнд суурилсан хандлагын шинжүүд:

- Үр дүнд бус өгөгдөхүүнд анхаардаг
- Хэрэгцээг хангахыг чухалчилдаг

[1] Хүний эрхийн үндэсний комисс. Хүний эрхийн ойлголт, хүний эрхэд суурилсан хандлага. Илтгэл. УБ., 2024. 20 дахь тал.

[2] Хүний эрхийн үндэсний комисс. Хүний эрхийн ойлголт, хүний эрхэд суурилсан хандлага. Илтгэл. УБ., 2024. 21 дэх тал.

- Хэрэгцээг бодит баталгаа гэж үздэг
- Хувь хүнийг хөгжлийн оролцооны обьект гэж үздэг.
- Хүмүүсийг тусламж дэмжлэг авах шаардлагатай гэж хардаг
- Асуудлын шууд шалтгаанд анхаарлаа хандуулдаг.

Эрхэд суурилсан хандлагын шинжүүд:

- Үйл явц болон үр дүнд анхаардаг.
- Эрхийг танин мэдэхийг чухалчилдаг
- Үүрэг хүлээгчдийг эрх зүйн болон ёс суртахууны үүрэг хариуцлагаа хүлээхэд хувь хүний болон бүлгийн эрх чухал баталгаа болно гэж үздэг.
- Эрхээ баталгаатай эдлүүлэхийн тулд хувь хүн болон бүлгийг чадавхжуулах
- Хүмүүсийг тусламж дэмжлэг авах эрхтэй гэж хардаг.
- Суурь шалтгаан болон түүний илрэл дээр анхаарлаа хандуулдаг.

Үүнээс хүний эрхэд суурилсан хандлага нь үйл явцын турш тухайн хүнд тодорхой үйл ажиллагаа, шийдвэр нь хэрхэн нөлөөлөхийг анхаарч, эрхийн мөн чанарыг нэн тэргүүнд авч үздэг байна.

Хөгжлийн гол асуудлууд болох тэгш бус байдал, ялгаварлан гадуурхах практик, эрх мэдлийн шударга бус хуваарилалт зэрэгт дүн шинжилгээ хийж, анхаарал хандуулах замаар хөгжлийг илүү сайн, тогтвортой үр дүнд чиглүүлдгээрээ хүний эрхэд суурилсан хандлага давуутай юм. Мөн энэхүү хандлага, арга зүй нь хоёр талт болон олон талт хөгжлийн байгууллагууд, төр, иргэний нийгмийн байгууллага болон ТББ-ыг хөгжлийн үйл явцад оролцож, хувь нэмрээ оруулах боломжийг олгодог. Хүний эрхэд суурилсан хандлага, арга зүй нь хүнийг эрх-агуулагч болохыг, үүрэг хүлээгчдийн үүрэг хариуцлагыг тогтоох нь зүйтэй болохыг чухалчлан үздэг. Хүний эрхэд дэвшилттэйгээр хүрэхийг зорихын зэрэгцээ аливаа бодлого, хөтөлбөрийн гадна үлдсэн, эрх мэдэл багатай, ялгаварлагдсан бүлгийг онцгойлон анхаардаг бөгөөд хөгжлийн үйл явц, үр дүнд адил ач холбогдол өгдөг онцлогтой юм. Хөгжлөөс үүдэн гарсан шударга бус байдлыг тодорхойлж, ялгаварлан гадуурхсан болон эрх мэдлийн тэнцвэргүй хуваарилалтыг залруулахыг эрмэлздэг.

Хүмүүсийн хэрэгцээ шаардлагыг хангахаас илүүтэйгээр хүний эрхийг хангахад хүний эрхэд суурилсан хандлага арга зүй чиглэж байна. Хэрэгцээ нь хүнийг сэтгэл дундуур байдалд хүргэхийг хүсдэггүй бол эрх нь хүчирхийллийг хүлээн зөвшөөрдөггүй ба тэрхүү эрхийн зөрчлийг хууль ёсоор сэргээхийг шаарддагаараа онцлогтой. Хүний эрхэд суурилсан хандлагыг удирдлага болгох нь эрх оршин байдаг гэдгийг зөвшөөрснөөрөө хэрэгцээнд суурилсан хандлагаас ялгардаг. Энэ нь төр болон үүрэг хүлээгчдийн хүний эрхийг хүндэтгэх, хамгаалах, хангах чадавхыг баталгаажуулдаг байна.

Нэг үгээр бол хүний эрхэд суурилсан хандлага нь эрхийг хэрэгцээтэй холбон илэрхийлдгээрээ онцлогтой.

Тухайлбал хүн бүр сурч боловсрох эрхтэй. Сурч боловсрох эрх нь боломжтой, байх, хүртээмжтэй байх, хүлээн авахуйц байх, амьдралд тохирохуйц байх зэрэг шинжийг өөртөө агуулдаг. Ингэснээр сурч боловсрох эрх, түүнд тавих шаардлагыг ойлгох боломжийг нэмэгдүүлдэг. Эдгээр тухайн эрх ямар байх ёстой гэдэг агуулгыг тодорхойлдог юм.

Харин хэрэгцээ бол байх тухай асуудлыг хөнддөг. Яагаад байх ёстой болохыг тодорхойлдог. Яагаад сурч боловсрох эрх байх ёстой болох агуулгыг хөнддөг. Сурч боловсрох эрхийг хэрэгжүүлснээр мэдлэг эзэмших, түүний хэрэгжүүлэх чадвар эзэмшиж, нийгэм, гэр бүлээ өөрчлөх боломжийг нэмэгдүүлдэг[1].

“Тухайн эрх оршин байх ёстой төдийгүй, заавал байх шалтгаантай учраас” хэмээн эрхийг хэрэгжүүлэх үр дүнд чиглэх бус тухайн эрх хэрэгжих үеэс эхлэн үр дүнд хүрэх хүртэл анхаарч шийдвэр гаргадаг хөгжлийн чиг хандлагыг эрхэд суурилсан хандлага гэж үзэж байна.

Хүний эрхийг хангах, хамгаалах, хууль сахиулах ажиллагаанд сүүлийн жилүүдэд нэлээдгүй анхаарал хандуулж байгаа судлагдахуун нь хүний эрхэд суурилсан шийдвэр гаргах, хүний эрхийн хандлагын тухай асуудал болоод байна.

Учир нь хууль, тогтоомжийг хэрэгжүүлэх нь хуулиар тогтоосон заалт, зохицуулалт хэрэгжсэн байх буюу илүүтэйгээр үр дүнд чиглэсэн байх агуулгатай байна. хууль болон түүнийг хэрэгжүүлэх ажиллагаа нь илүү объектив хүчин зүйлсэд тулгуурласан байдаг бол хандлага нь субъектив хүчин зүйлсийн нөлөөг хуул сахиулагч үнэлэхийг шаарддаг. Энэ нь нийгмийн харилцаа, нийгмийн хөгжлийн гол чиглэл болоод байгааг авч үзэх хэрэгтэй.

Хүний эрхийн хандлага нь тодорхой зарчмуудыг өөртөө агуулдаг[2]. Үүнд дараах зарчмууд хамаарна.

- Түгээмэл, салшгүй байх- Хүний эрх нь дэлхийн өнцөг булан бүрт амьдарч буй хүн бүрт адил тэгш, салшгүйгээр заяагдсан билээ. Хувь хүн сайн дурааараа өөрийн эрхээ эдэлж чадахгүй. Үүний адилаар хэн нэгэн үүнийг бусдаас салгаж болохгүй юм. Хүний эрхийн түгээмэл тунхаглалын нэгдүгээр зүйлд заасанчлан “Бүх хүмүүс нэр төр, эрхийнхээ хувьд адил тэгш, эрх чөлөөтэй төрсөн” билээ. (А1)[3]

[1] Хүний эрхийн үндэсний комисс. Хүний эрхэд суурилсан хандлага. Сургалтын гарын авлага. УБ., 2016. 86 дэх тал.

[2] Хүний эрхийн үндэсний комисс. Хүний эрхэд суурилсан хандлага. Сургалтын гарын авлага. УБ., 2016. 80-81 дэх тал.

[3] Сургалтад ашиглахад хялбаршуулах зорилгоор “(А1)” буюу товчлол ашиглав.

- Хуваагдашгүй байх- Хүний эрх хуваагдашгүй байна. Иргэний, улс төрийн, эдийн засгийн, соёлын эрх зэрэг олон төрлөөс үл хамааран хүн бүрийн эрхэм чанартай салшгүй холбоотой. Иймээс, эдгээр нь эрх болохынхоо хувьд адил тэгш статустай бөгөөд ямар нэгэн байдлаар зэрэглэн үзэж болохгүй юм. (А2)

- Харилцан хамааралтай, уялдаатай байх- Аливаа нэг эрхийг хангах нь бусад эрхээсээ хэсэгчлэн буюу бүхэлдээ хамаардаг. Тухайлбал, эрүүл байх эрхээ эдлэх нь мэдээлэлтэй байх эрхээс хамаарч болно. (А3)

- Тэгш, үл алагчлах- Аливаа хүн бүр өөрийн төрөлхөөс заяасан эрхэм чанарын хувьд адил тэгш бөгөөд эрх эрх чөлөө нь ямар нэгэн алагчлалгүйгээр тэдэнд заяасан юм. Эрхэд суурилсан хандлага нь алагчлал болон тэгш бус байдлын асуудалд тусгайлан анхаарал хандуулах шаардлагатай байдаг. Хөгжлийн бодлого, хөтөлбөрүүдэд нийгмээс тусгаарлагдаж буй бүлгүүдийн сайн сайхан байдал, эрхийг хамгаалах асуудлыг тусгах хэрэгтэй байна. Эмзэг бүлгийнхэнд илүү их бололцоог нээхийн тулд мэдээллийг аль болох олон төрлөөр тухайлбал, хүйс, шашин, үндэс угсаа, хэл болон хөгжлийн бэрхшээлтэй эсэх зэргээр нарийвчлах шаардлагатай байна. Хөгжлийн бодлого, шийдвэр, санаачлагууд нь орон нутгийн оршин суугчдыг гэгээрүүлэх арга замыг хайдаг бөгөөд хүчний тэнцвэргүй харилцааг хадгалахын эсрэг тэмцэх буюу дахин шинэ бүтцийг бүрдүүлэхэд зохих хувь нэмэр оруулдаг. (А4)

- Оролцоог хангах, тэгш хамруулах- Хүн бүр эрх, эрх чөлөөгөө эдлэх замаар иргэний, нийгэм, эдийн засгийн, улс төрийн болон соёлын хөгжилд өөрийн хувь нэмрээ оруулах, чөлөөтэй, идэвхтэй, утга учиртай оролцох эрхтэй билээ. (А5)

- Гэгээрэл- Гэгээрэл гэдэг нь хүмүүс өөрсдийнхөө эрхийн төлөө тэмцэх боломжийг бий болгогч үйл явц юм. Хүмүүс өөрт нь чиглэсэн бодлого, хууль шийдвэр болон үйлчилгээг хүлээхээс илүү өөрийн эрхийн төлөө тэмцэх талаар гэгээрүүлэх шаардлагатай. Эдгээр санаачлагууд нь хувь хүмүүс болон нийгмийн бүлгүүдийн хариуцлагатай үйлдэх чадавхыг бүрдүүлэхэд чиглэн ажиллана. Үүний зорилго нь хүмүүст өөрсдийн амьдралыг өөрчлөх, амьдарч буй нийгмээ шинэчлэх, хувь заяагаа мэдэх боломж, хүч чадлыг өгөхөд оршино. (А6)

- Эрх зүйт ёсыг дээдлэх, хариуцлагатай байх- Эрхэд суурилан хөгжих хандлага нь “эрх эдлэгч”, “үүрэг хүлээгч” нарыг уялдуулан үзэх замаар хөгжлийн үйл явц дахь хариуцлагын түвшинг нэмэгдүүлж, үүрэг хүлээгчдийн хариуцлагаа биелүүлэх бололцоог дээшлүүлдэг. Үүнд хүний эрхийг хангах, хамгаалах, хүндэтгэх болон хүний эрхийг зөрчихөөс татгалзах зэрэг эерэг, сөрөг бүхий л үүрэг хариуцлагыг багтаан ойлгоно. Засгийн газрын хувьд хувь хүн, орон нутгийн байгууллага, албан тушаалтнууд, хувийн хэвшил, хэвлэл мэдээлэл, ивээн тэтгэгчид болон хөгжлийн түншлэгчид, олон улсын байгууллагууд зэрэгтэй харьцуулахад хүний эрхийг хэрэгжүүлэх талаар бусад оролцогчдоос илүү өргөн цар хүрээ бүхий үүрэг хариуцлага хүлээлгэдэг. Харин олон улсын хамтын нийгэмлэгийн хувьд нөөц болон чадавхын хувьд хязгаарлагдмал хөгжиж буй орнуудтай үр дүнтэй хамтран ажиллах үүрэг ноогддог. Эрхэд суурилан хөгжих хандлага нь хүн бүрийн хувьд

зөрчил, үгүйсгэлээс хамгаалагдах, эрхээ бүрэн эдлэхүйц эрх зүй, захиргааны практик, механизм, тогтолцоог хөгжүүлэхийг шаарддаг. Мөн олон улсын нийтлэг хэм хэмжээг орон нутгийн түвшинд нийцүүлэн хариуцлагыг дээшлүүлэх, дэвшлийг хэмжих үлгэр загвар буюу шалгуурыг (бенчмарк) бий болгохыг шаардана. (А7)

Дээрх зарчмууд нь хууль хэрэгжүүлэгч этгээдээс иргэдтэй харилцахдаа заавал баримтлах зарчим бөгөөд хүний эрх нь түгээмэл салшгүй гэдгийг ухамсарлан аль нэг эрхийг нөгөөгөөр нь орлуулах, дур мэдэн хязгаарлах, нэг эрхийг хэрэгжүүлсэн боловч нөгөө эрхийг хэрэгжүүлэх боломжийг хязгаарлан хясан боогдуулах, хуулийн хүрээнд ижил боломжоор хангах агуулгыг илэрхийлдэг.

Мөн хууль хэрэгжүүлэгч этгээд нь тухайн харилцаанд оролцогдчын оролцоог бүрэн нээлттэй хангах, соён гэгээрүүлэх үүргийг хүлээх шаардлагатай. Ингэснээр хүний эрхийг тэгш хүртээмжтэй хангах, эрх зүйн хэрэглээ, эрх зүйн ач холбогдлыг тайлбарлан таниулж, эрхийн хязгаарлалтын ач холбогдлыг харилцагч иргэдэд ухамсарлуулан өөрөөр нь хүлээн зөвшөөрүүлэх боломж олгох юм.

Эдгээр нь хүний эрхэд суурилсан хандлагын үндсэн агуулга бөгөөд эдгээр нь үр дүнд бус процесст илүү анхаардаг бөгөөд хууль тогтоомж нь өөрөө үр дүнг тодорхойлдог болохыг ямагт санах хэрэгтэй.

Хүний эрхэд суурилсан шийдвэр гаргалт:

Хүмүүс өдөр бүр олон янзын шийдвэр гаргадаг. Эдгээр шийдвэрийн зарим нь ямар хувцас өмсөх, үдийн хоолон дээрээ юу идэх гэх мэт харьцангуй жижиг зүйл байхад зарим нь бидний амьдралд арай чухал нөлөө үзүүлэхүйц их сургуульд ямар мэргэжлээр суралцах, ямар хүнтэй гэрлэх, тамхи татаж эхлэх эсэх, бэлгийн харилцаанд хэзээ, хэнтэй орох гэх мэт байж болно. Гэсэн хэдий ч илтэд энгийн буюу чухал биш шийдвэр нь ч гэсэн тодорхой нөхцөл байдалд чухал ач холбогдолтой байж болох ба улмаар шийдвэр гаргах чадвар сайтай байх шаардлагатай болдог. Жишээ нь, хэрвээ чи ажил олгох хүнтэй уулзах гэж байгаа бол өмсөх хувцсандаа анхаарах шаардлагатай болно. Мөн эрүүл мэндийн байдлаасаа хамаарч идэх хоолоо сонгохдоо ч анхаарал тавих шаардлага гарна гэх мэт.

Харин хууль хэрэгжүүлэх үйл ажиллагаанд шийдвэр гаргах нь нөгөө талд хүний эрхийн хязгаарлалт, хүний эрхийн зөрчил болдог тул онцгой анхаарах шаардлагатай.

“Шийдвэр” гэж асуудлыг үүсгэж буй шалтгааныг арилгах эсвэл тодорхой зорилгыг хэрэгжүүлэхийн тулд дүгнэлтэд үндэслэн гаргасан шийдэл [1] хэмээн тодорхойлсон байна. үүнээс авч үзвэл тухайн шийдвэрийг гаргахын тулд хууль

[1] Хүний эрхийн үндэсний комисс. Монгол улсын үндсэн хуулийн хоёрдугаар бүлэгт туссан хүний эрхийн заалтуудад системийн инженерчлэлийн аргаар тодорхойлолт боловсруулах нь. Судалгаа. УБ., 2024. 59 дэх тал.

хэрэгжүүлэгч этгээд нь тодорхой хүчин зүйлс, шалгууруудыг үндэслэн дүн шинжилгээ хийж, дүгнэлт гаргах явдлыг ойлгож болохоор байна. Тэгвэл хүний эрхэд суурилсан шийдвэр гаргалт нь хүний эрхэм чанар, хүний эрхийн зарчмуудыг удирдлага болгон тэдгээрт үндэслэн хуульд заасан шийдвэр гаргах, үйл ажиллагаагаа хэрэгжүүлэх хүний эрхэд суурилсан шийдвэр гаргалтын үндсэн агуулга гэж үзэж болно.

Энэ нь нэг үгээр бол хууль хэрэгжүүлэг аливаа нөхцөл байдалд хүний эрхэм чанар, хүний эрхийн зарчим, хүний эрхийн хандлагыг удирдлага болгон хуульд заасан хэм хэмжээг сонгон хэрэглэх явдал бөгөөд тухайн шийдвэр нь хүний оролцоог хангасан, ойлгомжтой, үндэслэлтэй, соён гэгээрүүлэх агуулгыг илэрхийлсэн байх ёстой.

Хүний эрхэд суурилсан шийдвэр гаргалтад хууль ёсны байх зарчим хамгийн чухал нөлөөтэй хэдий ч шийдвэр гаргалт нь менежментийн шинжлэх ухааны судлагдахуун болдог тул менежментийн суурь үзэл санааг хүний эрхэм чанар, хүний эрхийн зарчмуудтай уялдуулан авч үзэх нь оновчтой.

Шийдвэр гаргалт бол хэд хэдэн боломжит хувилбаруудын дундаас итгэл үнэмшил, үйл ажиллагааны чиглэлээс шалтгаалан сонгоход хүргэж байгаа танин мэдэхүйн үйл явц юм. Харин тэрхүү боломжит шийдвэр гаргахад баримтлах зарчмуудыг хүний эрхэд суурилсан хандлагаар шийдвэр гаргагч заавал мэдэх ёстой.

Хүний эрхийн салбарт нийтлэг хэрэглэгддэг зарчим бол “PANEL”-ийн зарчим юм.

Participation – тухайн хүний эрхийг хөндсөн шийдвэр гаргахдаа тухайн этгээдийн оролцоог хангасан байх буюу шийдвэр гаргалтад оролцох боломжийг хангах;

Accountability – хариуцлагатай байх зарчим. Энэ нь шийдвэр гаргагчаас хүний эрхийн олон улсын болон дотоод эрх зүйн хэм хэмжээг мөрдөх бөгөөд хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, арилгах зэрэг механизмыг хэрэгжүүлэх агуулга юм.

Non-discrimination and Equality – хүний хувийн болон нийгмийн шинжээр нь ялгаварлан шийдвэр гаргахаас урьдчилан сэргийлж бүх хүмүүст ижил боломжийг олгох ёстой.

Empowerment – хүн бүр эрхээ хэрэгжүүлэхээр шаардах боломжтой байх. Хувь хүн болон бүлэг хүмүүс тэдний эрхийг ойлгож хүлээн зөвшөөрөх хэрэгтэй.

Legality – хуулиар хүний эрх, эрх чөлөөг хамгаалдаг, хууль тогтоомж нь хүний эрхийн зарчмуудыг агуулсан байх ёстой.[1] Ингэснээр шийдвэр гаргагч нь шийдвэр гаргахдаа тухайн этгээдийн оролцоог хангаж, тэгш-ялгаварлан гадуурхахгүй хандах ба тэднээс эрхээ шаардах боломжийг хүлээн зөвшөөрч, аливаа зөрчилд хариуцлага хүлээлгэдэг байдлаар илэрнэ.

Ийнхүү хүний эрхэд суурилсан хандлагад тавигдах нийтлэг зарчим, шалгууруудыг эзэмшсэн хууль сахиулагчийг бэлтгэхэд бакалаврын сургалтын хөтөлбөрийн агуулга, хичээлүүдийн агуулгад хүний эрхэд суурилсан хандлагаар дүн шинжилгээ хийх, төлөвлөх, сайжруулж, дүн шинжилгээ хийх боловсролын байгууллагын хүлээх үндсэн үүрэг болж байна.

Хүний эрхэд суурилсан шийдвэр гаргалт нь хууль хэрэгжүүлэгч этгээдээс тухайн хэм хэмжээ, хязгаарлалт нь хүний эрхэд хэрхэн нөлөөлөхийг үнэлсний үндсэн дээр боломжит сонголтуудаас хүний эрхэм чанарыг хүндэтгэсэн хувилбарыг сонгож хэрэгжүүлэхийг ойлгоно. Энэ нь хууль хэрэгжүүлэгчээс авч хэрэгжүүлэх тодорхой арга хэмжээ, эрхийн хязгаарлалтууд нь оролцогч этгээдийн эрхэд хэрхэн нөлөөлөх байдлыг үнэлэх, таамаглах байдлаар шийдвэр гаргах арга хэмжээ юм.

Шийдвэр гаргах талаар зохих чадвар эзэмшээгүй байх, эсвэл яарч шийдвэр гаргаснаар тухайн асуудалтай холбоотой байгаа бусад хүчин зүйлийг харгалзан үзэлгүй тааруухан шийдвэр гаргахад хүрч, улмаар тухайн хүн эцэстээ өөрөө харамсаж мэдэх үр дагавар бүхий нөхцөл байдалд орчихсон байх магадлалтай.

Нөгөө талаасаа сайн шийдвэр гаргах чадвар нь шийдвэр гаргах үйл явцад өөрөө идэвхтэй оролцох, цаг хугацаагаа зөв сонгох, бүтээлч байх боломжийг хүнд олгодог. Аль шийдвэр нь чухал ач холбогдолтой, аль нь илүү анхаарах шаардлагатай, аль нь арай бага хүчин чармайлттайгаар шийдвэрлэж болох асуудал вэ гэдгийг тогтооход шийдвэр гаргах чадвар нэн чухал шаардлагатай. Шийдвэр гаргах чадвар сайтай хүн шийдвэрийг гаргахаа хойшлуулах, түүнээс зайлсхийх зэрэг алхам хийдэггүй. Тэд өөрт нь байгаа хувилбарт сонголтуудаас гарч болох үр дагаврууды жагсаан бичээд дүн шинжилгээ хийж, эдгээр үр дагаврын тохиолдох магадлалд үнэлгээ дүгнэлт өгөхдөө өөрсдийнхөө мэдрэмж болон эрхэмлэдэг үнэт зүйлсийг тооцож чаддаг. Тэдний гаргасан шийдвэр нь бодит хүлээлт дээр тулгуурласан, өөрсдийнх нь үзэл бодол, үнэт зүйлтэй нийцсэн байдаг ба тэд нэгэнт гаргасан шийдвэрээ бусад хүний нөлөөнд авталгүйгээр хэрэгжүүлэх чадвартай байдаг.

Тухайн нөхцөлд байж болох хувилбарт сонголт хийх түүний үр дагавар нь сонголт тус бүрийн давуу болон сул талыг тооцоолохын зэрэгцээ өөрийн эрхэмлэдэг үнэт зүйл, төрж буй дотоод мэдрэмжийг цэгнэж үзэх боломжийг хууль

[1] https://humanrights.gov.au/ Human rigths based approaches

хэрэгжүүлэгчээс шаардана. Өөрийн ирээдүйн төлөвлөгөө, зан үйлийнхээ талаар, эсвэл бусад хүнтэй тогтоосон холбоогоо хэрхэн зохицуулах талаар сонголт хийхэд энэхүү сэдэв тус нэмэр болно. Иймд хууль хэрэгжүүлэгчийн шийдвэр гаргах чадварыг хөгжүүлэх нь чухал байна. Ялангуяа иргэдийн ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрч шийдвэр гаргах нь алба хаагчийн хувьд чухал төдийгүй төрийн өөрийн чиг үүргээр хариуцлага хүлээх нь хүний эрхэд суурилсан шийдвэр гаргалтыг өргөжүүлэх ач холбогдолтой.

Төрийн үүрэг хариуцлагыг 3 хэсэгт авч үзэж байна[1].

Тэгвэл шийдвэр гаргалтад тодорхой шинжүүдийг зайлшгүй авч үзэх шаардлагатай бөгөөд эдгээр нь шийдвэр гаргах чадварыг хөгжүүлдэг байна. Харин хүний эрхэм чанар, хүний эрхийн зарчим, хандлагыг шийдвэр гаргах шинжүүдэд баримтлах нь хүний эрхэд суурилсан шийдвэр гаргах үндсэн нөхцөл болно. Үүнд:

- Мэдээллийн хүртээмжтэй байдал. Энэ нь тухайн шийдвэр гаргахад нөлөөлж байгаа үндсэн мэдээлэл нь тухайн харилцаанд оролцогчдод жигд хүртээмжтэй байх ёстой. (B1)[2]
- Шийдвэр гаргалтын хугацаа. Энэ нь шийдвэр гаргах боломжит хугацааг илэрхийлсэн ойлголт бөгөөд тодорхой хугацаа нь шийдвэр гаргалтын хурдан, нарийвчлалтай гаргах нөлөөлдгийг санах хэрэгтэй. (B2)
- Эрсдэл ба тооцоолоогүй нөхцөл байдал. Тухайн шийдвэрээс гарч болох эрсдэлийг таамаглах шаардлагатай бөгөөд тооцоолоогүй нөхцөл үүсэхээс аль болох сэргийлэх. (B3)
- Зорилго. Шийдвэр нь тооцоолсон эсхүл эерэг үр дүнд хүрэх ёстой. Тооцсон үр дүндээ чухлыг эрэмбэлэх хэрэгтэй. (B4)
- Хувийн болон байгууллагын үнэт зүйлийг харгалзан үзэх. Энэ нь алба хаагч болон хууль сахиулагчийн хувьд үйл ажиллагаандаа баримтлах хүний эрх, үндсэн хуулийн зарчмууд байж болно. (B5)
- Нөөц боломжоо үнэлэх. Санхүүгийн болон бусад шаардлагатай нөөцүүдийг үнэлэх. (B6)
- Гадаад орчны нөлөөлөл. Нийгэм болон хууль эрх зүйн хувьд таны гаргасан шийдвэр нь хүлээн зөвшөөрөгдөж чадах эсэхийг үнэлэх хэрэгтэй. (B7)
- Туршлага. Шийдвэр гаргагч этгээдийн энэ төрлийн болон бусад харилцаанд хэрхэн оролцож шийдвэр гаргаж байсан туршлагыг хамааруулна. (B8)
- Сэтгэл хөдлөлийн хүчин зүйлс. Нийгмийн тодорхой харилцаанд оролцогч нь тухайн нөхцөл байдлаас хамаарч сэтгэл хөдлөлийн түвшин харилцан адилгүй байх бөгөөд хэвийн сэтгэл хөдлөлтэйгөөр шийдвэр гаргахыг эрмэлзэх. (B9)
- Сонголтын хувилбар. Хамгийн сайн бөгөөд оролцогч талуудын хэн хэний ашиг сонирхлыг дэмжих хувилбарыг сонгох, эрэлхийлэх. (B10)

[1] A human rights based approach. Manual. 2021

[2] Сургалтад ашиглахад хялбаршуулах зорилгоор “(B1)” буюу товчлол ашиглав.

- Урт болон богино хугацааны үр дүн. Таны гаргасан шийдвэр урт, богино хугацаанд таны төсөөлсөн эсвэл, тооцоолоогүй ямар үр дүнд гаргах, хэрхэн нөлөөлөхийг тооцоолох шаардлагатай. (B11)

Дээрх шинжүүд нь шийдвэр гаргахад анхаарах үндсэн нөхцөлүүд бөгөөд эдгээр нөхцөлүүдийг үнэлэх ерөнхий шалгуур нь хүний эрхэм чанар, хүний эрхийн зарчим байдаг. Ингэснээр тухайн шийдвэр нь хүний эрхэд суурилсан, хүний эрхийг дэмжсэн шийдвэр болох боломжтой.

Эдгээрийг анхан шатны буюу үйл ажиллагааны түвшний шийдвэр гаргалтад өргөн ашиглах нь хууль сахиулах үйл ажиллагаанд хүний эрхийг хангах, эрхэд суурилсан шийдвэр гаргалтын гол нөхцөл болно.

Тухайлбал менежментийн шинжлэх ухаанд шийдвэр гаргалтын үе шатуудыг тодорхойлсон байдаг ба уг үе шатуудыг гүйцэтгэхдээ хичээлийн нэгдүгээр хэсэгт дурдсан хүний эрхийн хандлагын зарчмуудыг баримтлах шаардлагатай.

Үүнд дараах үе шат хамаарна.


- Асуудлыг тодорхойлох
- Шийдвэрийн хувилбаруудыг боловсруулах
- Хувилбарыг үнэлэх
- Сонголт
- Үр дүнг тооцох

Тухайлбал:

Эрүүгийн хэрэг хянан, шийдвэрлэх тухай хуульд “цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ”-г авах үндэслэлүүдийг заасан байдаг бөгөөд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас оргон зайлахыг завдсан, эсхүл оргон зайлсан гэх үндэслэлийг заасан байна.

Үүнийг авч үзвэл дээрх үйлдэл нь завдсан, эсхүл оргон зайлахыг завдсан үр дүн байх бөгөөд тухайн үр дүнд шууд авч хэрэгжүүлэх боломжтой хүний эрхийн хязгаарлалт тогтоох зохицуулалт юм. Харин хүний эрхийн хандлага нь тухайн этгээд оргон зайлахыг завдах эсхүл оргон зайлах хүртэл процесст хамаарах ойлголт бөгөөд эрүүгийн хэрэг үүсгэхээс эхлэн тухайн этгээдийг цагдан хорих шийдвэрийг гаргах хүртэл хугацаанд хууль сахиулагчийн зүгээс хүний эрхэм чанар, хүний эрхийг дээдлэх зарчмын хэрэгжилтээр тодорхойлогдох юм. Хэрэв гэмт этгээд оргон зайлах хүртэл процессын турш хүний эрхэд суурилсан хандлагаар шийдвэр гаргаж ажилласан бол заавал хүний халдашгүй байх эрхэд ноцтой халддаг цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг хэрэглэхгүй байх боломж үүснэ.

Эцэст хүний эрхэд суурислан шийдвэр гаргалт дараах үе шатыг дамжина.



Эдгээрээс үзвэл хүний эрхэд суурилсан шийдвэр гаргалт нь аливаа шийдвэрийг хүний эрхийг хангах төдийгүй хүний хэрэгцээг бүрэн илэрхийлэх боломжтойгоор гаргах бөгөөд шийдвэр гаргах үе шатанд бусдын оролцоог хангах, оролцох боломжийг бүрдүүлсэн, эрхийн зөрчилгүй байх буюу үр дүн болон үр дүнд хүрэх үе шатуудад хүний эрхийг эрхэмлэсэн үйл ажиллагааг хамааруулж болно.

ДҮГНЭЛТ

1. Дэлхийн улс орнуудын туйлын ашиг сонирхол нь тухайн улсын хөгжил, цэцэглэлтэд төвлөрч байна. харин хөгжлийг гол үзэл санаа нь ард иргэдийн ашиг сонирхол, хэрэгцээг хангахад чиглэгддэг ажээ. Учир нь хүний эрх, хүний хэрэгцээнд суурилаагүй хөгжлийн бодлого, үзэл баримтлал нь үр дүнгүй, тогтворгүй болохын нийгмийн гишүүдийн оролцоог бүрэн хангаж чадахгүй.

2. Хүний эрхэд суурилсан хандлага нь тодорхой зорилгод хүрэхийн эрмэлздэг хэдий ч тэрхүү зорилгод чиглэсэн арга хэмжээ, үйл ажиллагаа нь бүрийн хүртээмж, үр өгөөжид төвлөрдөг байна. нэг үгээр хэлбэр үр дүн чухал хэдий ч тэрхүү үр дүнд хүрэх арга зам нь ч мөн адил хүний эрхэд суурилсан байх ёстой болохыг илэрхийлж байна.

3. Хууль сахиулах үйл ажиллагаа нь хэдийгээр хууль тогтоомжийг нэг мөр хэрэгжүүлэх, сахин хамгаалах үйл ажиллагаа боловч эрх зүйн онол, үзэл хандлагын үүднээс авч үзвэл хүний эрхийг зохистойгоор хангах, хамгаалах чиглэсэн арга хэмжээ болохыг илэрхийлж байна. мөн хууль сахиулах үйл ажиллагааг хүний эрхэд суурилсан хандлага, алба хаагчийн хүний эрхэд суурилсан шийдвэр гаргалтын байдлаар авч үзвэл хууль, тогтоомжийг хүний эрхэд суурилсан байдлаар боловсруулах шаардлагатай үндсэн судалгааны эх сурвалж болох нь харагдаж байна.

4. Хууль сахиулагчийн шийдвэр гаргалтын үе шат болон шалгуур үзүүлэлтүүдийг оновчтой тодорхойлж, алба хаагчдад санал болгох нь хүний эрхэд суурилсан хууль сахиулах ажиллагааг хөгжүүлэх суурь хүчин зүйл болж байна. Энэ хүчин зүйлсийн гол агуулга нь иргэдийн эрх, эрх чөлөөг хүндэтгэж, оролцоог нь хангаж, зөрчилдөөнийг эергээр шийдвэрлэх зорилготой болохыг тодорхойлж байна.

АМЕРИКИЙН НЭГДСЭН УЛСЫН ЭРҮҮГИЙН ХУУЛИЙГ МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮГИЙН ХУУЛЬТАЙ ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

A STUDY COMPARISON OF THE CRIMINAL LAW OF THE UNITED STATES OF AMERICA WITH THE CRIMINAL LAW OF MONGOLIA

И.Санчиргарав

Дотоод хэргийн их сургуулийн Шүүхийн шийдвэр Гүйцэтгэлийн албаны сургуулийн Аюулгүй байдлын тэнхимийн багш, хууль зүйн магистр, хошууч

Хураангуй: Америкийн нэгдсэн улсын эрүүгийн хууль, ялын бодлого, гэмт хэргийн ангилал, томьёолол, гэмт хэрэгт тавигдах шалгуур шинжүүд, ялын төрөл, хэмжээ зэргийг судалж мөн тодорхой нэг төрлийн гэмт хэргийг Монгол Улсын эрүүгийн хуульд заасан гэмт хэрэгтээ харьцуулж онцлог талуудыг тодорхойлж сайн жишиг, шийдлийг нээн илрүүлэхэд чиглэгдэнэ.

Түлхүүр үгс: Америкийн нэгдсэн улс, Монгол Улс, эрүүгийн хууль, гэмт хэрэг, ял, эрүүгийн хариуцлага, ялын бодлого

Abstract: By studying the criminal law and sentencing policy of the United States of America, the classification of crimes, formulas, the criteria for crimes, the type and amount of punishment, and comparing a specific type of crime with the crime spaecified in the criminal law of Mongolia, identifying the features and discovering good standards and solutions. Will be directed

Keywords: United States of America, Mongolia, criminal law, crime, win, criminal liability, sentencing policy.

Үндсэн хэсэг

Америкийн нэгдсэн улс нь холбооны улс учир тэнд 51 бие даасан эрх зүй үйлчилнэ, өөрөөр хэлбэл холбооны Эрүүгийн хууль тогтоомж болон 50 муж улсын Эрүүгийн хууль тогтоомж үйлчилдэг байна. АНУ-д шүүхийн прецедент (*хэвшүүлэн жишиг болгосон*) нь хууль тогтоомжийн нэгэн адил эрх зүйн эх сурвалж болно. 50 муж улсын хагас нь төрөлжүүлэн нэгтгэсэн Эрүүгийн хуультай бол зарим мужид Эрүүгийн хууль гэж байхгүй зэрэг нэлээд онцлогтой. Тухайлбал АНУ-ын 50 муж улсын 36 нь цаазаар авах ялыг хэрэглэдэг гэхээр 50 өөр улс шиг санагдаж болох юм.

АНУ-ын эрүүгийн хууль тогтоомжийн үндсэн эх сурвалж бол Үндсэн хууль бөгөөд хууль, хуульчилсан актууд Үндсэн хуульд яв цав нийцсэн байх ёстой. Ялангуяа Эрүүгийн хууль нь Үндсэн хуулийн хэм хэмжээг улам бэхжүүлж хамгаалдаг. Муж улс тус бүрдээ Эрүүгийн хуультай болохоор нэг буюу төсөөтэй гэмт хэргүүдэд өөр өөр төрлийн ял оноож байх жишээтэй.

Бие даасан хуультай болоход 1962 оны Эрүүгийн хуулийн загвар шийдвэрлэх үүрэг гүйцэтгэсэн гэж үздэг байна.

Гэмт хэргийн шинж, ойлголт, ангилал

Америкийн хууль зүйн шинжлэх ухаанд гэмт хэргийн шинж ойлголтыг тодорхойлох хандлагыг а) формаль б) либерал гэсэн хоёр хандлага давамгайлдаг.

Формаль хандлагын хувьд түгээмэлчлэн томъёолвол эрүүгийн эрх зүйн тодорхой журам зөрчсөн, норматив стандартад халдсан хууль зүйн үр дагавар бүхий гэмт халдлага гэж үздэг. Тухайлбал: профессор П.Таппейний томъёолсноор бол "Гэмт хэрэг гэдэг нь ял ба хариуцлагаас чөлөөлөгдөх нөхцлийг үгүйсгэж, заавал яллагдах үр дагавар бүхий эрүүгийн эрх зүйн хэм хэмжээг санаатай зөрчсөн үйлдэл эс үйлдэл" гэж тодорхойлсон [1] бол профессор Дж.Зиглер "Гэмт хэрэг гэдэг нь хууль тогтоомжоор яв цав тодорхойлсон ялын цээрлэл зайлшгүй хүлээх зайлшгүй хүлээх гэмт зан үйл" гэжээ.[2] Тэгвэл Америкийн профессор Брикс Жексон "Тухайн муж улс өөрсдийн статут хууль, эрүүгийн эрх зүйн хэм хэмжээгээр гэмт хэрэг гэж заагаагүй тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээс татгалзах ёстой"[3] гэж бичиж байв.

Либераль хандлагын хувьд сүүлийн жилүүдэд нилээд илрэх болсон бөгөөд нийтлэг эрх зүй ба статут хуулийн хоорондох уялдаа, хамааралт хэм хэмжээгээр хориглосон үйлдэл, эс үйлдлийн шууд ба шууд бус хэлбэрүүд гэж үзэх болжээ. Түүнчлэн натуралист болон индивидуалист зарим онолын чиглэл бий. Тухайлбал: "Гэмт хэрэг нь нийгэмд бодит хохирол, гамшиг авч ирдэг тул ямар ч хэргийн хувьд хүнд хөнгөн гэж ялгахгүй хатуу шийтгэх ёстой. Ингэхдээ нийгмээс тусгаарлан гэсгээн цээрлүүлэх ёстой. Гэмт хэрэг үйлдэгчийг нийгмийн зүгээс хүмүүжүүлэх төлөвшүүлэх зорилго тавьж болохгүй, гагцхүү нийгмээс хатуу тусгаарлаж, залхааж цээрлүүлэх ёстой. Гэмт хэрэг хийсэн этгээд өөрөө өөрийгөө ойлгох, ухаарах, төлөвших замаа өөрийн ухамсар, гэмшилээс л олж авах ёстой гэж тайлбарладаг байна. Дээрх хандлага Америкийн эрүүгийн ялын бодлогод гүнзгий тусгагдсан. Иймээс ч баруун Европын судлаачид Америкийн ялын бодлогыг шүүмжлэх нь түгээмэл байдаг.[4] Ер нь АНУ-д гэмт хэргийг категорчлох замаар гэмт халдлагын илрэх түвшинд өргөн хүрээнд ойлгох хандлага түгээмэл байдгаас үүдэн Америкийн үндсэн хуулийн дагуу Америкийн хууль тогтоомжоор хамгаалагдсан хүний эрх, эрх чөлөө, эрх зүйн дэг журам, аюулгүйн горим, технологи, стандарт зөрчсөн ихэнхи зөрчлийг гэмт халдлагын хүрээнд гэмт үйлдэхүйн илрэл болгон авч үзэх нь олонтаа ажээ.[5] "

[1] Нерсесян А.А. Вопросы наказуемости в уголовныи праве ФРГ и США. М., 1992
[2] Sigler Jay S. Understaning criminal law. Boston. 1981. P 14-15
[3] B.Jackson. Criminal Justice in America 1984 p 11
[4] Монгол Улс дахь эрх зүйн шинэтгэл, шилжилтийн үе. УБ.,2006. 183-184-р тал
[5] Козочкин И.Д. Уголовное право США: Успехи и проблемы реформирования СПБ.Пресс.2007

Зарим муж улсын эрүүгийн хуулинд гэмт хэргийн ойлголтыг тодорхойлсон нь бий. Жишээ нь АНУ-ын Колорода муж улсын эрүүгийн хуулийн 40.4.104-т: “Гэмт хэрэг (crime) гэдэг нь хорих болон торгох ялыг оногдуулахаар журамлан заасан бөгөөд муж улсын хууль тогтоомжийг зөрчсөн зүй бус үйлдэл” бол Нью-Йорк муж улсын эрүүгийн хуулийн 10.1.1-т “Гэмт халдлага (criminal offenses) гэдэг нь хугацаатай хорих ял болон торгох ялыг муж улсын хуулиар тогтоохоор зааснаас гадна хууль тогтоомжоор ирэх олгосны дагуу орон нутгийн засаг захиргааны тогтоол захирамж (ордонанс) ба засгийн газрын байгууллагын баталсан дүрэм журмыг зөрчсөн гэмт зан үйл” гэж заажээ. Тэгвэл мөн хуулийн 10.1.6-д: “Гэмт хэрэг (crime) гэдэг нь мисдиминор ба фелони” гэж тодорхойлжээ.

Гэмт хэргийн категори ангилал төрөл

Америкийн эрүүгийн эрх зүйд гэмт үйлдэхүйг (гэмт халдлага) (criminal offenses) дараахь дөрвөн категорт ангилан авч үздэг нь харьцангуй түгээмэл ажээ. Үүнд:

1. Фелони (*felony*) Нэг жилээс дээш хугацаагаар хорих ял шийтгэхээр заасан гэмт үйлдэхүй:
2. Мисдиминор (*misdemenour*) 15 хоногоос 1 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэхээр заасан гэмт үйлдэхүй:
3. Эрүүгийн зөрчил (*delict*) 15 хоног хүртэл хугацаагаар баривчлах ба хорихоор шийтгэхээр заасан гэмт үйлдэхүй:
4. Замын хөдөлгөөний хэрэг (*minority offences*) замын хөдөлгөөн олон зам тээврийн хууль тогтоомж зөрчсөн хэрэг зөрчил:

Нью-Йорк муж улсын эрүүгийн хуулинд гэмт халдлагын төрөл хүрээг дараахь байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хүний эсрэг гэмт халдлага; (*Хүний амины эсрэг, хүчин, хүнд гэмтэл учруулах*)
- Хүний өмч, эд хөрөнгийн эсрэг гэмт халдлага; (*Бэрглэри, өмчлөх, эзэмшихийн эсрэг гэмт хэрэг, галдан шатаах*)
- Хуурч мэхлэх, залилангийн гэмт халдлага
- Нийтийн засаг захиргааны эсрэг гэмт халдлага
- Нийтийн эрүүл мэнд, ёс суртахууны эсрэг гэмт халдлага;
- Өрх гэр, гэр бүл, хүүхэд, эрх зүйн чадамжгүй этгээдийн эсрэг гэмт халдлага гэх мэт

Түүнчлэн гэмт халдлагын төрлийг эх сурвалжийн шинж, байдлаар нь дээр дурьдсан ерөнхий гэмт хэргүүд ба тусгайлсан гэмт хэргүүд гэж ангилдаг. Тусгайлсан гэмт хэргүүд гэдэгт татварын, экологийн, санхүүгийн үйлдвэрлэлийн технологийн, захиргааны журам зөрчсөн гэмт үйлдлүүд багтах бөгөөд тусгайлсан буюу салбарын чиглэлээр гарсан хуулиудаар зохицуулагдсан байдаг.

Америкийн эрүүгийн эрх зүйд бэрглэри (berglery) гэдэг ойлголтын хүрээнд бусдын орон байр, бусдын амьдарч буй байршил, эзэмшил газар луу шөнийн болон эзгүй үед зөвшөөрөлгүй нэвтрэх, бусдын эд зүйлсийг хулгайлах, ашиглах, завших гэмт хэргийг хамааруулдаг ба Пенсильваний эрүүгийн хуулийн 3502-р зүйлийн “С”-д зааснаар бол бэрглэри бол фелонийн 1-р түвшинд хамаардаг байна.

АНУ-д ихэнх гэмт хэрэг хүндрүүлэх бүрэлдэхүүнтэй дээрэм эсвэл ашиглан шамшигдуулах гэх мэт буруу үйлдэл байдаг бол цөөн гэмт хэрэг авто ослын дараа зогсож, тусламж үзүүлээгүй эсвэл орлогын татварын тайлангаа гаргаж өгөөгүй гэх мэт эс үйлдэл байна. Зогсоолд давхарлаж зогсох эсвэл амгалан тайван байдал алдагдуулах зэрэг зарим гэмт хэрэгт бага хэмжээний торгууль эсхүл орон нутгийн албадан саатуулах байранд нэг шөнө өнгөрөөх зэрэг шийтгэл оногдуулдаг.[1]

Одоогийн байдлаар АНУ-д эрүүгийн үндсэн гэмт хэргүүдийг уламжлалт, эдийн засгийн, зохион байгуулалттай, улс төрийн болон тохиролцсон гэмт хэрэг гэсэн 5 том ангилалд хуваадаг.

1. Уламжлалт гэмт хэрэг: АНУ-д жилд бүртгэгддэг 31 сая гэмт хэргийн ихэнхи нь өмчийн эсрэг гэмт хэрэг байдаг.
2. Эдийн засгийн гэмт хэрэг: 4 том ангилалд хуваадаг.

Хувийн гэмт хэрэг-Мөнгөн ашиг хонжоо олох зорилгоор нэг хүн нөгөө хүний эсрэг хүч хэрэглээгүй гэмт үйл ажиллагаа явуулдаг. Жишээ нь хуурамч чек бичих, орлогын албан татвараа нуух, нийгмийн халамжийн луйвар хийх гэх мэт

Итгэл урвуулан ашиглах гэмт хэрэг-Бизнесийн ажилтнууд буюу төрийн албан хаагчид ажил олгогч эсвэл үйлчлүүлэгчдээ үнэнч байх үүргээ зөрчиж бизнесийн хээл хахууль, эд хөрөнгө ашиглан шамшигдуулах, зардлын хуурамч тооцоо бүрдүүлэх зэрэг үйлдэл байна.

Бизнесийн гэмт хэрэг-Бизнесийн байгууллагын үндсэн зорилго болсон гэмт хэрэг биш, харин түүнтэй холбоотойгоор үйлддэг гэмт хэрэг юм. Буруу, төөрөгдүүлсэн ойлголт өгөх сурталчилгаа, шударга өрсөлдөөний хуулийг зөрчих, байгууллагын орлогын зорилгоор хөрөнгийн тооцоог худал гаргах зэрэг нь бүгд бизнесийн гэмт хэрэг юм.

Луйвар- Бизнесээр халхавчлан цагаан захтнуудын явуулж буй гэмт үйл ажиллагаа юм.

3. Зохион байгуулалттай гэмт хэрэг: Бүлэг этгээд ихэвчлэн ямар нэг шатлалын үндсэн дээр хэн нэгний удирдлага дор үйлдэгддэг гэмт хэрэг юм. Зохион байгуулалттай гэмт хэрэг нь онцгой ашиг орлоготой салбарт чиглэсэн байдаг. Тухайлбал, хууль бусаар хар тамхи наймаалах, мөрийтэй тоглох, биеэ үнэлэх, өндөр хүүтэйгээр мөнгө зээлдүүлэх гэмт хэрэг байна.

4. Улс төрийн гэмт хэрэг: Засгийн эсрэг гэмт хэрэг байдаг. Эх орноосоо урвах,зэвсэгт үймээн дэгдээх, төрийн албан тушаалтны амь насанд халдах, мөн энэ

[1] АНУ-ын Эрх зүйн тогтолцооны товчоон. 118 дахь тал

бүлэгт засгийн газраас хувь хүмүүс, тэрслэгч бүлэг, гадаадын засгийн газар буюу иргэдийн эсрэг үйлдсэн гэмт хэргийг мөн багтаана.

5. Тохиролцсон гэмт хэрэг: Биеэ үнэлэх, мөрийтэй тоглох, хууль бусаар хар тамхи хэрэглэх, харилцан зөвшөөрсөн насанд хүрсэн хүнтэй ёс бус бэлгийн харьцаанд орох гэх мэт хохирогчгүй гэж нэрлэгддэг гэмт хэрэгт гэмт хэрэгтэн ба үйлчлүүлэгч хоёулаа хориглосон үйл ажиллагаа явуулахыг хүссэн байдаг учраас үүнийг тохиролцсон гэмт хэрэг гэдэг.[1]

Эрүүгийн хариуцлага хүлээх этгээд (субъект)

АНУ-н хэмжээнд бүхэлд нь авч үзвэл эрүүгийн хариуцлага хүлээх этгээдийн насны шалгуурыг нэгэн мөр нарийвчлан зохицуулаагүй, тухайн хэргийн байдлаас хамаарч өөр өөр тогтоосон байна. Нью-Йорк муж улсын эрүүгийн хуульд зааснаар бол ерөнхий нөхцлийн хувьд 16 насанд хүрээгүй этгээдэд эрүүгийн ял шууд оноож болохгүй боловч онц ноцтойгоор хүний амины хэрэгт 13 наснаас, ердийн хүний амины хэрэгт 14 наснаас эрүүгийн хариуцлага хүлээх нөхцөл бүрдэнэ. Субъектын насны шалгуурын доод хязгаарын хувьд муж улс бүхэнд харилцан адилгүй жишиг тогтсон байх ажээ. Жишээ нь АНУ-ын Оклахома муж улсад зарим хэргийн хувьд 7 наснаас эхэлж тооцдог бол Техас, Нью Тэмпшир муж улсад 15 наснаас, Орегand 12 наснаас, Иллойнис, Джоржиа мужид 13 наснаас, Колорадад 10 наснаас Айдохо, Калифорния мужид 14 наснаас гэх мэтчилэн харилцан адилгүй тогтоожээ.

Хэрэг хариуцах чадварын шалгуурыг нарийвчлан хуульчлаагүй боловч прецедентийн ба жишгийн практикаар зохицуулсан байх ба Макнаменийн (Англиин) ба Дурхэмийн гэсэн 2 дүрмээр тогтоож журамладаг ажээ.

Макнамений дүрмээр бол ихэнхи тохиолдолд сэтгэхүйн чадамж, ухамсрын хариуцлага, чадвартай холбон авч үздэг бол

Дурхэмийн дүрмээр сэтгэц-эмгэгийн өвчний шинж, эмнэлгийн шалгууруар голчлон тодорхойлж үздэг.

Америкийн эрүүгийн эрх зүйд хэрэг хариуцах чадварын шалгуурыг тухайн этгээд өөрөө нотлох ба үгүйсгэх боломжтой байх нөхцлийг зөвшөөрсөн байдаг. Хуулийн этгээд буюу корпораци эрүүгийн хариуцлага хүлээх субъект болно.

Ялын төрөл ба ялыг хэрэглэх

АНУ-д эрүүгийн ялын бодлого нь баруун Европ, эх газрын системтэй харьцуулахад зарим ялгаа бий.

Гэмт хэргийн тусгай төрлүүдээс хулгайн хэрэг, түүнд холбогдох бүрэлдэхүүний асуудал нилээд онцлогтой.

[1] АНУ-ын Эрх зүйн тогтолцооны товчоон. 120-121 дэх тал

Хулгайн гэмт хэргийг өргөн хүрээнд авч үздэг. Хулгай нь зөвхөн далд нууц аргаар үйлдэгдэхээр хязгаарлагдахгүй ил буюу эзнийг нь байхад түүнчлэн эзэнд нь мэдэгдэхгүйгээр буюу зөвшөөрөлгүй авах, итгэл эвдэх, төөрөгдүүлэх замаар авах, түүнчлэн энэ нь мөнгө болон эд хөрөнгө төдийгүй төлбөрөөр тооцогдож хэмжигдэж болох (цахилгаан, ус, шатахуун) зүйлс түүнчлэн шууд бус обьект (зохиогчийн эрх, оюуны бүтээл)-д халдсан байхыг ойлгоно. Хулгайн гэмт хэргийн катологт бусдын технологи, бусдын эрхийг эрхийг хулгайлах, завших зэргийг мөн адил хамааруулж ойлгодог.

Гэмт хэрэгт бэлтгэх, завдах болон гэмт хэрэгт хамтран оролцогчийн эрх зүйн байдал, ял хүлээх үндэслэлийг шүүхийн прецедент болон муж улсуудын эрүүгийн хууль тогтоомжоор зохицуулж өгчээ.

Гэмт хэрэгт завдах болон гэмт хэрэгт бэлтгэх хоёрын ялгааг заагласан байх ба эрүүгийн ял хүлээх эсэх нь зарим хэрэг дээр (зохион байгуулалттай гэмт хэрэг) ихэнхдээ шүүхийн прецедентээр тогтоосон байна.

Дахин гэмт хэрэг үйлдэх боломжийг хаах, тийм нөхцөл гаргуулахгүй байх зорилгоор (three strikes and you are out) “Гурван удаа давтан хэрэг үйлдвээс шахан зайлуулах” гэсэн зарчмыг мөрдлөг болгожээ. Энэ зарчмын дагуу АНУ-ын олон муж улсад гэмт этгээдийг хоёр удаагийн давтан хэрэг буюу гурав дахь удаагаа гэмт хэрэг үйлдэхэд нь хамгийн сүүлийн хэргийн хүнд, хөнгөн эсэхийг үл хамааран бараг бүх тохиолдолд бүх насаар нь хорих ял оноодог болоод байгаа ажээ.[1]

Ялын төрлүүдэд

АНУ-ын ялын төрөл	Монгол Улсын ялын төрөл
1. Цаазаар авах	1. Торгох ял
2. Бүх насаар нь хорих	2. Нийтэд тустай ажил хийлгэх ял
3. Хугацаатай хорих	3. Зорчих эрх хязгаарлах ял
4. Хянан харгалзах, (Тэнсэх)	4. Хорих ял
5. Гэрийн хорионд баривчлах	5. Эрх хасах ял
6. Торгох ял зэрэг болно	

Цаазаар авах ялыг АНУ-д 36 муж улс түгээмэл хэрэглэж байгаагийн дээр тухайн муж бүрд 2-5 тохиолдолд Холбооны хэмжээнд нийтэд нь авч үзвэл 60 шахам төрлийн (*давхардсан бус байдлаар*) гэмт хэрэгт хэрэглэдэг ажээ. Ялангуяа 1994 онд “Хүч хэрэглэсэн буюу хүчирхийллийн гэмт хэрэгтэй тэмцэх тухай хууль”

[1] Монгол Улс дахь эрх зүйн шинэтгэл, шилжилтийн үе. УБ., 2006 184-р тал

баталснаас хойш цаазлах ялыг хэрэглэх тохиолдол 30-60 хэрэг хүртэл өсч, уг ялыг хэрэглэх хүрээ нь өргөжин тэлж иржээ.[1]

Ихэнхдээ онц ноцтой хүний амины хэрэг, терроризм, хууль бусаар хар тамхи борлуулах, онгоц хулгайлах, барьцаалах, хэрцгийгээр хүчирхийлэх, хүчиндэх, эх орноосоо урвах, тагнуул хийх болон онц ноцтой коррупцийн хэрэг зэрэг цөөнгүй хэрэгт оноодог.

Америкийн зарим муж улсын эрүүгийн хууль тогтоомжид 16 наснаас доош насны этгээдэд цаазаар авах ял оноож байсан түүхэн баримт бий жишээ нь Флорида, Алабама муж улсад эрүүгийн хариуцлага хүлээх насны хязгаарыг тогтоогоогүйгээс болж 10-12 насны этгээдэд цаазаар авах ял хэрэглэж (7 наснаас доошгүй) ирсэн байна. Харин АНУ-ын Дээд Шүүх (Оклахомагийн эсрэг Томпсоны хэрэг) 1989 оны тогтоол гаргаж 13 нас хүрээгүй этгээдэд цаазаар авах ял оноох нь үндсэн хуулийн эсрэг хэрэг гэж зарлажээ.

Цаазаар авах ялыг эмэгтэйчүүдэд хэрэглэх явдлыг хориглоогүй. АНУ цаазаар авах ял хэрэглэдэг ихэнхи муж улсад уг ялыг гүйцэтгэхдээ цахилгаан сандалд суулгах аргыг хэрэглэдэг ба зарим мужид хорт хийгээр хордуулах (Аризон, Невада) буудах, (Юта) дүүжлэх, (Монтана, Вашигтон) аргыг хэрэглэдэг ажээ. [2] Нийт америкчуудын 78 хувь нь цаазаар авах ял байх ёстой гэж үздэг байна.

Бүх насаар хорих ял нь АНУ-д хэрэглэгддэг хорих ялын нэг төрөл юм. Энэ ялыг голдуу цаазаар авах ялтай дүйцэхүйц тохиолдолд хэрэглэдэг боловч онц хүнд гэмт хэрэг үйлдсэн түүнчлэн фелони гэмт хэрэгт 2 буюу гурван удаагийн шийтгэлтэй этгээдэд хэрэглэнэ. Ялангуяа 3 удаа хэрэг үйлдэж, 3 удаа ял шийтгүүлсэн этгээд дөрөв дэх удаа яллуулах үед бүх насаар нь хорих ял оноодог зарим онцгой тохиолдолд тодорхой нөхцөл байдалд цаазаар авах ял шийтгүүлсэн этгээдийн хувьд ялыг орлуулан солих замаар хэрэглэдэг.

Хугацаатай хорих ялын хувьд түүний нөхцөл, хугацаа, дэглэмийг эрүүгийн хууль тогтоомжоор нэг мөр нарийвчлан тогтоодоггүй бөгөөд харин ихэнхдээ шүүхийн прецедентийн жишигт нийцүүлэн шүүх, тангарагтны шүүх болон ял эдлүүлэх байгууллага өөрсдөө тодорхойлно. Өөрөөр хэлбэл хугацаатай хорих ялын доод хугацаа ба дээд хэмжээний хувьд дундаж ерөнхий нөхцөл гэж байхгүй, ихэнхи тохиолдолд шүүх тодорхой бус таслан шийдвэрлэх тогтоол гаргадаг байна.

ДҮГНЭЛТ

Судалгааны хүрээнд дараах дүгнэлтийг хийж байна.

1. Эрүүгийн хэргийг мөрдөн шалгах ажиллагааг ихэнхдээ ял тохиролцох, гэм бурууг хүлээн зөвшөөрүүлэхэд чиглэгдсэн түргэвчилсэн процесс болгон уян

[1] В.Н.Додоно. Сравнительное уголовное право. Обшая часть. М.,2009 с.278
[2] А.А. Малиновский Уголовное право зарубежных государств. М., 1998 27-р тал

хатан нөхцөлөөр явуулдаг нь хэргийг түргэн шуурхай шийдвэрлэх, хүний эрх, нэр төрийг хамгаалах, хохирол, үр дагаврыг богино хугацаанд арилгуулах зэрэг сайн талтай ба эерэг, нааштай олон хүчин зүйлийг агуулдаг байна. Зарим тохиолдолд хэргийг бүх талаас нь бүрэн бодитойгоор, үнэн зөв шалган шийдвэрлэх зарчимтай зөрчилддөг ба нотлох ажиллагааг бүрэн хангахад шүүхийн оролцоо хязгаарлагдмал, мэтгэлцэх талуудын субьектив хүсэл зориг хэргийн хувь заяаг тодорхойлдог зэрэг нь сөрөг хүчин зүйл болдгийг үгүйсгэх аргагүй. Харин эрүүгийн процессын албадлагын арга хэмжээнд хүний эрхийг хангуулах, шүүхийн мэтгэлцээний сонгодог хэв шинжийг тогтвортой хадгалсаар ирсэн нь үнэ цэнэтэй бөгөөд олон улс оронд үлгэр загвар болж, тархан дэлгэрсээр байна.

2. Гэм бурууг хүлээн зөвшөөрч, ялын тохиролцоог хийхийн өмнө тухайн яллагдаж буй этгээд зөвхөн өөрийн ухамсар, өөрийн сайн дурын ухаалаг шийдвэрт үндэслэх ба прокурор өмгөөлөгчийн зүгээс ямар нэгэн байдлаар айлган сүрдүүлэх барьцаанд оруулах дарамт шахалт үзүүлэхийг хориглосон байдаг байна. Сүүлийн үед хийгдсэн нэгэн судалгаагаар Америкийн хэмжээнд нийт гэмт хэргийн 95 хувь нь ял тохиролцох үндсэн дээр шийдэгдсэн байдаг бол ердөө 5 хувь нь шүүх хуралдааны дүнд шийдвэрлэгдсэн болох нь тогтоогджээ.

ХОРИГДЛЫГ ГЭМТ ХЭРЭГ ҮЙЛДЭХЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТАД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ

ANALYSIS OF THE LEGAL REGULATION ON PREVENTING PRISONERS FROM COMMITTING CRIMES

Ч.Батболд
Дотоод хэргийн их сургуулийн Удирдлагын академийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн удирдлага, стратегийн тэнхимийн дэд профессор, хууль зүйн доктор (Ph.D), дэд хурандаа

Товч агуулга: Хорих ял эдлүүлэх ажиллагааг зохицуулж буй дотоодын эрх зүйн зохицуулалт нь Олон Улсын гэрээ, конвенц болон дотоодын хууль, тогтоомжид нийцсэн байгаа хэдий ч Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, түүнд нийцүүлэн баталсан эрх зүйн актуудад шинжилгээ хийхэд хоригдлыг гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хорих ангийн төрөл мэргэжлийн албадын мэдээлэл солилцох ажиллагаа, тохиолдлоос урьдчилан сэргийлэх, таслан зогсоох арга зүй дутагдалтай байна.

Түлхүүр үгс: Хорих ял эдлүүлэх ажиллагаа, гэмт хэрэг, зөрчил, арга зүй, урьдчилан сэргийлэх ажил.

Үндсэн хэсэг

Аливаа улс орны үндэсний эрх зүй нь тухайн улсын эдийн засаг, улс төр, соёл газар нутаг, үндэстэн ястан, эрх зүйн эх сурвалж зан заншил, шашин шүтлэгийн түүхэн болон тухайн цаг үеийн хүчин зүйлүүдээс нөхцөлдсөн уялдаа холбоо, харилцан хамаарлын нэгдэлд байдаг бөгөөд энэхүү шинжээс үүдэн эрх зүйн тогтолцоог хэд хэдэн бүлд хуваан авч үздэг.

Эрх зүйн бүл гэдэг нь эрх зүйн үүсэл, хувьсал, хөгжлөөрөө нэгдмэл, эрх зүйн эх сурвалж, эрх зүйн ухамсар, соёл боловсрол, бусад шинжээрээ ижил төсөөтэй улс орнуудын эрх зүйн тогтолцоог бүлэглэн авч үздэг ойлголт юм. Улс орнуудын эрх зүйн бүлийг хууль бүтээх зарчим, хуулийн хэрэглээ зэрэг үндсэн шинжээр Ром-германы, Англо-саксоны гэсэн хоёр үндсэн бүлд хуваах ба шашны болон овгийн уламжлалт, социалист эрх зүйн бүлд хамаардаг улс орнууд бас бий.

Ром-германы эрх зүйн бүлд эх газрын улс орнуудаас гадна, Латин Америкийн ихэнх улс, Африкийн зарим улс ч хамаардаг бөгөөд энэ эрх зүйн бүлийн онцлог нь Үндсэн хуулийн хэм хэмжээ тэргүүлэх байр суурь эзэлдэг ба хууль дээдлэх зарчим хэрэгждэг, материаллаг эрх зүйд тулгуурласан бүл юм. Харин Англо-саксоны эрх зүйн бүлд англи хэлтэй улс орнууд бүгд хамаарах ба энэ эрх зүйн бүл нь уламжлал ихтэй, эрх зүйн эрх сурвалж нь шүүхийн прецедент байна.

Монгол Улс нь эрх зүйн бүлийн хувьд Ром-германы эрх зүйн бүлд хамаарах хэдий ч хууль тогтоогчийн зүгээс зарим хууль тогтоомж, төрийн болон боловсролын байгууллагын тогтолцоо, бүтэц, эрх зүйн байдлын хэв маяг, агуулга нь Англо-саксоны хэв шинжийг агуулсан байх эсвэл холимог шинжтэй байх нь түгээмэл байна. Хэдийгээр Англо-саксон, Ром-германы эрх зүйн бүлийн хоорондын ялгагдах шинж нь тодорхой боловч аль давуу, илүү зөв үр дүн бүхий хувилбарыг сонгон холимог болон дангаар хэрэглэж болох талаар шууд үгүйсгэх нь өрөөсгөл болно.

Харин эрх зүйн хувьд хууль бүтээх, эрх зүйн аль бүлээс жишиг авч хорих ял эдлүүлэх ажиллагаа, хорих байгууллагын тогтолцоо, бүтцийн үндсийг тодорхойлохдоо маш хянуур хандах шаардлагатай бөгөөд энэ нь хорих байгууллагын аюулгүй байдалд шууд бусаар нөлөөлөх нэг хүчин зүйл болох юм. Өөрөөр хэлбэл, хоригдлыг гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх ажлын зорилго, зорилт, аюулгүй байдлыг хангах ажиллагааны тогтолцооны үр дүн нь эрх зүйн зөв зохицуулалт, гадаад улс орны дэвшилтэт жишгийг тусгасан, дотоодын онцлогийг бүрэн дүүрэн илэрхийлсэн хууль тогтоомжийн мөн чанараас тодорхой хэмжээгээр хамаарах зүй тогтолтой байна[1].

Хоригдлын үйлдэж болзошгүй гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын талаар олон талаас нь судлахдаа хорих ял эдлүүлэх ажиллагааны хэлбэр, агуулга, хэрэгжүүлэх байгууллагын бүтэц, тогтолцоо, хөгжлийн бодлого, хүний нөөцийн бодлого зэргийг эрх зүйн хувьд хэлбэршүүлэн тогтоох талаар судлан авч үзэх нь зүйтэй.

Судлаачийн зүгээс Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль, тогтоомжийн хүрээнд хорих ял эдлүүлэх ажиллагаанд тулгарч буй сорил, бэрхшээлийг хөндөн гаргахыг зорилоо.

1. Гэмт хэрэг хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль[2].

Хорих байгууллага нь төрийн зүгээс нийгмийг гэмт халдлагаас хамгаалах, гэмт явдалтай тэмцэх чиглэлээр явуулж буй эрүүгийн ялын бодлогыг хэрэгжүүлэгч нэг чухал субъект болохын хувьд Монгол Улсын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, төсөл, хөтөлбөрийн тусламжтайгаар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг хуулийн хүрээнд явуулах учиртай.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд хорих байгууллагад үйлдэж болзошгүй гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр тусгайлан заасан зохицуулалт байхгүй байгаа нь орон нутгийн гэмт хэргээс урьдчилан

[1] Очгэрэл, Ц. Хорих байгууллагын аюулгүй байдал. Уб., 2017. 132 дахь тал.

[2] Төрийн мэдээлэл. №42. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль (шинэчилсэн найруулга). Уб., 2019.

сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд тус байгууллагад үйлдэгдэж болзошгүй гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хийж хэрэгжүүлэх ажил, арга хэмжээг тусгадаггүй байна.

Өнөөдрийн байдлаар орон нутгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн санхүүжилтээр гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд шаардлагатай хамгаалалтын техник хэрэгслийг ажил хэргийн шугамаар биш гуйлга, хандив тусламж мэт өгч байгаа нь хуулийн зорилго, зорилт биелэгдэхгүй байна.

2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль[1].

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн зорилго нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны үндэслэл, журмыг тогтоож, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тогтолцоо, алба хаагчийн эрх зүйн байдалтай холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.

Уг хуулийн 22 дугаар бүлэгт хорих байгууллагын аюулгүй байдлыг хангах ажиллагааг аюулгүй байдлын удирдлага, зохион байгуулалт, техникийн хяналт, хамгаалалт, биечилсэн хяналт, хамгаалалт, аюулгүй байдлын түвшин, эрсдэлийг үнэлэх, гүйцэтгэх ажил гэсэн төрөл, бүрэлдэхүүн хэсэгтэй байхаар хуульчилж өгсөн нь өмнөх хуулиудаас онцлог зохион байгуулалт болж өгчээ.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд байгууллага, алба нэгжийн чиг үүрэгт гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр зөвхөн үүргээр тусгаж өгсөн боловч түүнийг хэрэгжүүлэх арга, аргачлал арга зүй тусгагдаагүй.

3. Хорих ангийн дотоод журам[2].

Уг журмын зорилго нь хоригдлыг хуульд заасан үндэслэл, журмын дагуу ял эдлүүлэх, ахуй нөхцөлөөр хангах, хорих ангид тогтоосон цагийн хуваарьт үйл ажиллагааг мөрдүүлэхэд оршино гэж заасан ба хоригдлын анх хорих ангид хүлээн авахаас суллагдах хүртэлх бүхий л үйл ажиллагааг зохицуулсан.

Цагийн хуваарийн дагуу явагдаж буй хөдөлмөр, сургалтын үед тэдгээрт хамрагдахаас татгалзсан хоригдлыг тогтоосон цэгт харуул хамгаалалтын хяналтад байршуулан хариуцсан нийгмийн ажилтан нь сургалт, хөдөлмөрт хамрагдахын ач холбогдол, хуулиар олгогдсон эрх зүйн боломжийн талаар яриа, таниулга хийнэ

[1] Төрийн мэдээлэл. №24. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль (шинэчилсэн найруулга). Уб., 2017.

[2] ШШГЕГ. ШШГБ-ын үйл ажиллагаанд дагаж мөрдөх хууль, тогтоомжийн эмхэтгэл. Уб., 2020. 160 дахь тал.

гэж тус тус хорих ангид явагдах үйл ажиллагааг нийтлэг байдлаар журамлаж өгсөн байна.

Хоригдлыг тогтоосон цэгт харуул хамгаалалтын хяналтад байршуулж байгаа нь гэмт хэрэг, зөрчлийг бууруулж байгаа мэт боловч хоригдол бүтэн өдөр хяналтын цэгт сууснаар бухимдах, сэтгэл зүйн байдал тогтворгүй болж улмаар гэм хэрэг, зөрчил үйлдэх шалтгаан болж байна.

4. Хорих ангийн харуул хамгаалалтын журам[1].

Энэ журмаар хорих ангийн харуул хамгаалалтын зохион байгуулалт, хамгаалалтын бүс, хамгаалалтын ажилтны гүйцэтгэх чиг үүргийг тогтоож, хоригдолд байнгын хяналт тавих үйл ажиллагаатай харилцааг зохицуулна. Хоригдлын үйлдэж болзошгүй гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга, ажиллагааг зохицуулсан заалтыг судалж үзвэл, журмын 2.1-д харуул хамгаалалт нь хорих ангид гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, цагийн хуваарьт үйл ажиллагааг чанд мөрдүүлэх, хорих анги, хоригдлын аюулгүй байдлыг хангахад чиглэгдэнэ, 2.2-д харуул хамгаалалтыг тасралтгүй зохион байгуулах бөгөөд байнгын, хүч нэмэгдүүлсэн, өндөржүүлсэн бэлэн байдлын зэргийн гэсэн төрөлтэй ба хорих ангийн өдөр тутмын үйл ажиллагаа байнгын хамгаалалтад байна гэжээ.

Мөн журмын 7 дугаар зүйлд хорих ангийн дарга, харуул хамгаалалт гүйцэтгэх ажил эрхэлсэн дэд дарга нар харуул хамгаалалтыг удирдан зохион байгуулах, жижүүрийн бүрэлдэхүүний гүйцэтгэх үүргийг тодорхой зааж өгсөн. Тухайлбал, ***ерөнхий жижүүр*** жижүүрийн бүрэлдэхүүнийг хоригдлын зүгээс үйлдэгдэж болзошгүй гэмт хэрэг, зөрчил түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр үүргээр хангана, хоригдол оргох, гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох арга хэмжээг шаардлагатай авч удирдлагад шуурхай мэдэгдэх, ***гадна хамгаалалтын байцаагч*** орголт, хамгаалалтын бүсийн тоног төхөөрөмжид халдахаас урьдчилан сэргийлэх, ***ерөнхий жижүүрийн туслах*** хорих ангийн гэрэлтүүлэг, хаалга, цоожны бүрэн бүтэн байдалд хяналт тавих, ***хамгаалалтын ажилтан*** хоригдлын бие, эд зүйлд үзлэг, нэгжлэг хийн, хориотой эд зүйлийг хураан авах, анхаарал татсан хоригдлыг байнгын хяналтад байлгаж, хөдөлгөөн бүрийг мэдэж байх, хариуцсан хэсгийг 20 минут тутам эргэж шалгах, ***дүрс бичлэгийн хяналтын ажилтан*** илэрсэн зөрчлийг холбогдох албан тушаалтанд шуурхай мэдээлэх, 30 минут тутам дүрс бичлэгийн хяналтын нөхцөл байдлыг ерөнхий жижүүрт илтгэх, дүрс бичлэг хийгдэж буй эсэхэд тогтмол хяналт тавих талаар үүргийг зааж өгсөн боловч тухайн үед ямар үүрэг гүйцэтгэх талаар тодорхой тусгаагүй, аргачлал байхгүй.

[1] ШШГЕГ. ШШГБ-ын үйл ажиллагаанд дагаж мөрдөх хууль, тогтоомжийн эмхэтгэл. Уб., 2020. 175 дахь тал.

5. Нийгмийн ажлын заавар[1]:

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2022 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн А/269 дүгээр тушаалаар нийгмийн ажлын зааврыг шинэчлэн баталсан.

Хоригдлыг нийгэмшүүлэхэд чиглэсэн сургалт, нөлөөллийн ажлыг хэрэгжүүлэх, хэрэгцээ шаардлагыг тодорхойлох, орчин нөхцөлд дасан зохицох чадварыг нэмэгдүүлэх, сэтгэл зүйн хувьд тогтвортой байлгах, хувь хүнийг төлөвшүүлэхэд туслалцаа дэмжлэг үзүүлэх, мэдээллийн сан бүрдүүлэх, нийгмийн ажилтны өдөр тутмын үйл ажиллагааг зохицуулах зорилготой байна.

Хорих ял эдлүүлэх албаны Сургалт, нийгэм, сэтгэл зүйн хэлтэс болон хорих ангийн нийгэмшүүлэх ажлын мэргэшсэн нэгжийн чиг үүргийг тусгаж өгчээ. Энэ чиг үүрэгт хоригдлыг дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх хөтөлбөр, нийгэмшүүлэх ажлын арга, аргачлал байхгүй байгаа нь дутагдалтай байна. Тухайлбал, хоригдлын хувийн онцлог, аливаа зүйлд хандах хандлага, ар гэрийн харилцаа холбоо, орчны өөрчлөлтөөс шалтгаалан сэтгэл зүйд өөрчлөлт байгаа эсэхэд дүгнэлт хийж ангийн удирдлагад танилцуулна гэснээс өөрөөр хоригдолд чиглэсэн нэг бүрчилсэн нийгэмшүүлэх ажлын арга зүй байхгүй байна.

Мөн гэмт хэргийн хор уршгийг таниулах, нийгэмд учруулсан хохирлоо нөхөн төлөх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, сургалт хөдөлмөрт хамрагдахын ач холбогдол, хуулиар олгогдсон эрх зүйн боломжийн талаар яриа таниулга хийнэ, уулзалт хийсэн, зөвлөгөө өгсөн талаарх нууцыг хадгалах ба амиа хорлох, гэмт хэрэг, зөрчил гаргах, хорих ангийн хэвийн үйл ажиллагааг алдагдуулах талаар яриа гаргасан тохиолдолд холбогдох албан тушаалтанд танилцуулна гэснээс өөр нөлөөллийн ямар арга хэмжээ авах гэмт санаа бодлоос татгалзуулах чиглэлийн хөтөлбөр байхгүй.

6. Сэтгэл зүйн ажлын заавар[2].

Уг заавар нь хоригдол, хоригдогсдын сэтгэл зүйн тогтвортой байдлыг хангах, сэтгэл зүйн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэн мэргэжлийн үйл ажиллагааны дараалал, арга, хэлбэр, хэрэгжүүлэх аргачлалыг тодорхойлж, сэтгэл зүйчийн өдөр тутмын үйл ажиллагааг зохицуулах зорилготой.

Хорих ангийн сэтгэл зүйч нь хоригдлын сэтгэл зүйн байдлыг тодорхойлж, тулгамдсан асуудалтай тохиолдолд сэтгэл зүйн зөвлөгөө өгч, сэтгэлийн хөдөлгөөний тэнцвэрт байдлыг хангахад чиглэсэн үйлчилгээ үзүүлнэ гэж заасан боловч сэтгэл зүйн тулгамдсан асуудалтай хоригдлын сэтгэл зүйд эерэг нөлөөлөл

[1] www.cd.gov.mn

[2] ШШГЕГ. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагаанд дагаж мөрдөх хууль, тогтоомжийн эмхэтгэл. Уб., 2020. 352 дахь тал.

үзүүлэх зорилгоор гэмт хэрэг үйлдсэн сэдэлд нь тохирсон арга хэмжээ авч, өөрийн бие эрхтэндээ гэмтэл учруулах болон гэмт хэрэг үйлдэж болзошгүй, сэтгэцийн хувьд тулгамдсан асуудалтай хоригдлын талаар ангийн удирдлага болон гүйцэтгэх ажилтанд заавал танилцуулна гэсэн нь сайшаалтай байна.

Хорих ангийн сэтгэл зүйч нь хоригдлын сэтгэл зүйн байдлыг тодорхойлж, тулгамдсан асуудалтай тохиолдолд сэтгэл зүйн зөвлөгөө өгч, сэтгэлийн хөдөлгөөний тэнцвэрт байдлыг хангахад чиглэсэн үйлчилгээ үзүүлнэ гэж үргийг заасан боловч гэмт хэрэг үйлдэж болзошгүй хоригдолд ямар сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх талаар аргачлал байхгүй.

Хорих ял эдлүүлэх ажиллагааны үед хоригдлыг гэмт хэрэг, зөрчил үйлдэхээс урьдчилан сэргийлэх тусгай чиг үүргийн субъектүүдийн албан тушаалын тодорхойлолтод хэрхэн урьдчилан сэргийлэх болон хамтын ажиллагааны талаар тусгаж өгөөгүй байгаа нь учир дутагдалтай байна гэж үзлээ.

ДҮГНЭЛТ

1. Хорих ял эдлүүлэх ажиллагааг зохицуулж буй хууль, дүрэм, журмууд нь хүний эрх, түүн дотроо хорих ял эдлүүлэх ажиллагаанд хамаатуулан батлан гаргасан олон улсын эрх зүйн хэм хэмжээ (пакт, конвенц тунхаглал)-ний агуулга, хорих ял эдлүүлэх зарчимд нийцсэн, хоригдлыг дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, нийгэмшүүлэх үндсэн зорилготой уялдаж байгаа боловч хэрхэн нийгэмшүүлэх болоод гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар арга зүйг нарийвчлан тусгаж өгөөгүй байна.

2. Хоригдлын үйлдсэн гэмт хэрэг, сэтгэцийн онцлог, анх болон удаа дараагийн ял шийтгэл, боловсрол, нийгмийн гарал байдал зэрэг зүйлсийг харгалзан тухайн бүлэг хоригдолд чиглэсэн нийгэмшүүлэх тусгайлсан хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх хэрэгцээ үүссэн гэж үзлээ.

3. Хоригдлыг гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх чиглэлээрх тусгайлсан эрх зүйн зохицуулалт үгүй хэдий ч хорих ял эдлүүлэх ажиллагаанд холбогдох олон улсын болон үндэсний хууль тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан эрх зүйн актад аюулгүй байдлыг хангах, харуул хамгаалалтын зохион байгуулалт болон хоригдлын үйлдсэн зөрчлийг шийдвэрлэхтэй холбоотой зохицуулалт хэрэгжиж байна.

САНАЛ

1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн хорин гуравдугаар бүлэгт “хоригдлыг гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх ажил” гэсэн бүлэг шинээр нэмж оруулах. Энэхүү бүлэгт:

- хоригдлын үйлсэн гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг тодорхойлох;
- хоригдлын үйлдэх гэмт хэргийн эрсдэлийг үнэлэх;

- хоригдлыг гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөлт;

- хоригдлыг гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх ажлын арга зүй;

- хоригдлын үйлдэж болзошгүй гэмт хэргээс урьдчилан сэргийлэх албан тушаалтны чиг үүрэг зэрэг зохицуулалтыг багтаасан байх.

2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 218 дугаар зүйлийн 218.2 дахь хэсэгт “хорих анги нь нийгэмшүүлэх ажлын мэргэшсэн нэгжтэй байх бөгөөд хоригдлыг хорих ангид хүлээн авмагц нийгэмшүүлэх мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх хэрэгцээ, шаардлагыг тодорхойлж, түүнд үндэслэн нийгэмшүүлэх үйлчилгээ үзүүлэх төлөвлөгөө, **хувь хүнд тохирсон хөтөлбөр** боловсруулж ажиллана” гэж нэмж оруулах;

3. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.5-д “гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлсэн этгээдийн зан байдалд нөлөөлөх, хуулийг чандлан сахих дадал төлөвшүүлэх, хорих байгууллагад байх хугацаанд **дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх**, боловсрол, ажил хөдөлмөр эрхлэх дадал, туршлага олгох, суллагдсаны дараа нийгэмд дасан зохицох шаардлагатай мэдлэг, ур чадвар олгох” гэж нэмж оруулах;

4. Хоригдлыг гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх ажлын арга, аргачлалыг боловсруулж, үйл ажиллагаанд нэвтрүүлэх;

5. Хоригдлын үйлдсэн гэмт хэрэг, сэтгэцийн онцлог, анх болон удаа дараагийн ял шийтгэл, боловсролын зэрэг, нийгмийн гарал байдал зэрэг зүйлсийг харгалзан тухайн бүлэг хоригдолд чиглэсэн нийгэмшүүлэх тусгайлсан хөтөлбөрүүдийг шинээр боловсруулж, үйл ажиллагаанд нэвтрүүлэх зэрэг болно.

БАГШИЙН ЁС ЗҮЙН АСУУДАЛ БОЛОВСРОЛЫН СИСТЕМД НӨЛӨӨЛӨХ НЬ

IMPACT OF TEACHER ETHICS ON THE EDUCATION SYSTEM

Ц.Өнөболд

Дотоод хэргийн их сургуулийн Эрх зүй, нийгмийн ухааны сургуулийн Нийгмийн ухааны тэнхимийн багш, цагдаагийн ахлах дэслэгч

Хураангуй: Боловсролын салбарын тулгамдаж буй асуудлын нэг болох багшийн ёс зүйн тухай онолын мэдээлэл ба судалгааны ажилд тулгуурлан багшийн ёс зүйн асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар тайлбарлахад оршино.

Түлхүүр үг: Багш мэргэжил, ёс зүй, багшийн үүрэг, сурагчид, үлгэр дуурайлал

Удиртгал

Аливаа зүйлийг гүн гүнзгий ойлгож, бүхнээс илүү мэдлэг чадвараараа ялгарч, явсан газар бүхнээ шинэ мэдлэг, шинэ уур амьсгал, ажлын шинэ үүсгэл санаачилгыг өрнүүлж байдаг хүмүүс гэж багш хүнийг манай ард түмэн хүндэтгэн дээдэлдэг. Сургаж хөгжүүлэх ажлыг өдөр цаг тутам гардан зохион байгуулж байгаа багш хүн өөрийн ажилдаа ямагт дүн шинжилгээ хийж юу нь болж, юу нь болохгүй байгааг тунгаан бодож цаашид хийх ажил арга зүйгээ оюун ухаандаа төсөөлөн, бодож мөрддөг байх нь сайн багш болохын үндэс юм. Багш мэргэжил бол нийгмийг бүрдүүлэгч анги давхаргыг өөр хооронд холбох гүүр төдийгүй хувь хүн бүрийн ирээдүйн хөгшлийн замыг заагч хөтөч мөн. ЗХУ-ын нэрт сурган хүмүүжүүлэгч В.А Сухомлинский өөрөө өөртэйгээ ярьж, өөрийн мөс, чанарын тухай бодож үзэх гэдэг бол оюун санааны амьдралын дээд шат, хүн төрөлхтний ёс суртахууны баялаг дотор өөрийнхөө байр суурийг олж авах шат мөн хэмээжээ. Үнэхээр багш мэргэжил бол энэ нийгмийн сор болсон мэргэжил төдийгүй манай улсын ирээдүйн хөгжлийг тээгч цогц чадамж юм. Багш хүн ажилдаа эзэн болж, ажилдаа гаршиж дадлагажих ёстой, орчин үеийн багш нар байнга хөгжиж, мэдлэг чадвар, хандлагаа өөрчлөхгүй бол бүх зүйл маш хурдацтай хөгжиж байгаа. XXI зууны багш бол судлаач багш болж байгаа. Багш нар сурагчаа судална, өөрийнхөө хичээлийг судална, өөрийгөө, хөдөлмөрөө ч судлах ёстой. Мөн өнөө цаг үед багшийн ёс зүйн тухай асуудал боловсролын системд нэн чухлаар яригдах болсон билээ.

Зорилго

Боловсролын салбарын багш мэргэжилтний ёс зүй гэж юу болох, түүнд нөлөөлөх хүчин зүйлсийн талаар судлан шинжилж, багшийн ёс зүйн талаар үнэлгээ дүгнэлт гаргах

Зорилт

Багшийн хөгжлийн эхлэл суурь болох ёс зүйн талаар судлан шинжлэх

Багшийн ёс зүйд юу юу хамаарах талаар судалгааны ажлыг өрнүүлэх

Багшийн хөгжлийг илэрхийлэх гол хүчин зүйлүүд ба багш хэрхэн ёс зүйтэй байх талаар өөрийн үзэл бодлыг илэрхийлэх

Багшийн ёс зүй

Багш мэргэжлийн үнэ цэнэ бол хүнийг хараад таних улмаар хүүхэд, залуустай болон бусадтай зөв боловсон ёс зүйтэй харилцах явдал мөн. Өөрөөр хэлбэл багшийн үнэ цэнэ нь харилцаагаар илэрхийлэгддэг гэж ойлгож болно. Мундаг сайн мэдлэгтэй багш байлаа гээд харилцааны эв дүй муутай бол тэрбээр өөрийн эргэн тойрны хүмүүсийн итгэлийг дааж чадахгүй төдийгүй шавь нараа үнэлэгдэж чадахгүй юм. Бас багш хүн хүүхэд залуусын хамтрагч ба зөвлөгч байх ёстой гэсэн багш хүний үнэт хэм хэмжээг даган биелүүлж чадахгүй. Тиймээс багш хүн хамгаас түрүүн харилцааны ур чадвар дээр маш сайн анхаарах хэрэгтэй. Багш хүний үнэ цэнийн илэрхийлэгч гол хүчин зүйл бол харилцаа. Харилцааны мөн чанар бол бусдыг хүндэтгэх, нийгэмд эерэг байдал түгээх явдал хэмээн ойлгож болох бөгөөд боловсон ёс журам хүүхэд ахуйгаас гэр бүлийн дотор үүсэж бүрэлддэг. Хүмүүс бид хүүхэд байхаасаа «баярлалаа», «зүгээр», «уучлаарай» гэх зэрэг үгийг сонсож мэдээд амьдралынхаа туршид хэрэглэж ирдэг. Эдгээр үгс хүмүүсийн хоорондын харилцааг сайн сайхан болгон чимж тэднийг улам элдэг боловсон болгодог төдийгүй үүний ачаар нэг хүн баярласан талархсанаа илэрхийлж, нөгөө хүн чин сэтгэлийн энэхүү хөдөлгөөнийг ойлгон мэдэрдэг билээ.

Ёс зүй нь гүн ухааны нэгэн салбар бөгөөд ёс зүйн талаар асуултуудыг судлана. Ёс зүй хэмээх ойлголт нь эртний грекийн Ethos буюу хамтран амьдрах, оршин амьдрах газар гэдэг утгатайгаар илэрхийлэгддэг байсан. Хожим нь хөгжлийн явцад “ёс заншил, зан төлөв, зан араншин, сэтгэлгээний хэв маяг” гэсэн агуулгатай болж, тэдгээрийн шинж чанарыг илэрхийлэх болсон. Аристотель хүний зан төлөвийн өвөрмөц шинжийг илэрхийлэхийн тулд “Этос” гэх ойлголтыг анх хэрэглэсэн. Монголчуудийн хувьд ёс зүй буюу ёс суртахуун бол хүн нийгэмд хэрхэн биеэ авч явах, юуг яаж хийх бичигдээгүй дүрэм, журам юм. Ёс суртахууны үндсэн дөрвөн зарчим байдаг. Эдгээр нь бусдыг үл хорлон буяныг үйлдэх, бусдад хүч үл хэрэглэн эвийг хичээх, үл бузарлан сэтгэлийг ариусгах, аливаад үл булхайдан шударгыг эрхэмлэх юм.

Ёс зүй нь нийгэм хүмүүнлэгийн аль ч ухаанаас илүүтэйгээр нийгмийн амьдрал, хүний үйлдэл, үйл ажиллагаа, харилцаатай нягт холбогддог онцлогтой. Ёс суртахуун улс төрийн харилцаанд хүмүүнлэг ба хүмүүнлэг бус, эдийн засгийн харилцаанд шударга ба шударга бус, оюун санааны харилцаанд үнэнч ба үнэнч бус чанараар илэрч байдаг. Ёс суртахуун нь хүмүүсийн зайлшгүй баримталж хэрэгжүүлэх зарчим, дагаж мөрдөх зүй зохистой хэм хэмжээ юм. Ёс суртахуунлаг байна гэдэг нь зөвийг сурах, түүнийгээ өдөр тутмын амьдрал, үйл ажиллагаандаа байнга мөрдөж хэвшүүлнэ гэсэн үг. Харин хүний ёс журам, заншил сурталд нийцүүлж чадахгүй үйлийг “ёсгүй” хэмээн тодорхойлсон байдаг. Ёс суртахууны үйлдэл нь тодорхой зорилготой байхаас гадна ёс суртахууны алтан зарчмын дагуу хэрэглэнэ. Ёс зүй бол тухай орны ард түмний зан заншил,харилцаанд бичигдээгүй хууль маягтайгаар тогтсон хариуцлагын хэм хэмжээ юм. Өөрөөр хэлбэл тодорхой ажил үйлс эрхэлж байгаа хүний зүгээс нийгэмтэйгээ харилцах, хариуцлага хүлээх, олны дунд биеэ авч явах, хүнтэй харилцах соёл сайн сайхан зан үйлийн уламжлалт хэм хэмжээний нэгдмэл системийг хэлдэг гэж болох мэт.

Багш хүн хүний оюун сэтгэхүйтэй ажилладаг учраас шавь нарынхаа хэн болохыг харцнаас нь, сэтгэл санаанаас нь, мэдлэг чадвараас нь, харилцаа хандлагаас нь “уншиж” судалж, шинжилж, зөв оношилж, ажиллах арга эвээ өөрөөс нь олж авдаг. Багштай хэрхэн харилцах нь хүүхдэд багш яаж хандаж түүний сайн сайхны төлөө сэтгэлээ хэрхэн хандуулж анхаарал халамж тавьж байгаагаас хамаардаг. Хүүхдийг зэмлэх, буруушаах талыг өрөөсгөл барьж “Багш бол багш л байх ёстой” гэж хандаж харилцах нь сурган хүмүүжүүлэх харилцаа зөрчигдөхөд хүргэх нь олонтаа. Хүүхэдтэй харилцахад хэм хэмжээнээсээ хэтэрсэн аливаа хандлага тэдний зүгээс сөрөг хандлага, дургүйцэлтэй заавал тулгардаг болохыг эрдэмтэд тодорхойлсон нь буй.

Польшийн нэрт сурган хүмүүжүүлэгч Януш Корчакийн нэгэн тэмдэглэлд хүүхдийн оюуны ертөнцийг хүндэтгэх, харин тэгэхдээ хүлцэнгүй хандахгүй байх тухай дурдсан байдаг. Энэ бол тун нарийн утга санаа бөгөөд түүний мөн чанарт багш бид нар гүнзгий нэвтрэх хэрэгтэй. Хүүхдийг хөхүүлэн магтахгүйгээр, түүний ямар нэгэн содон чанарыг тодруулахгүйгээр, орчин тойрныхоо бодит байдалыг өвөрмөц хэлбэрээр ялгаж тодруулах хүүхдийн ухаарал, сэтгэл хөдлөлийн хариу үйлдэл тэдний хүртэхүйн ертөнцийг ойлгохгүйгээр жинхэнэ сурган хүмүүжүүлэгч болж чадахгүй. Хүүхдийн оюуны ертөнцийг хүндэтгэх гэдэг үзэл нь ертөнцийг зүрх ба ухаанаараа танин мэдэх явдал гэж ойлгох хэрэгтэй.

Оросын сэтгэл зүйч Д.Париган “Харилцах процесс нь хүмүүс хоорондоо харилцан үйлчлэлцэх, мэдээлэл дамжуулан солилцох, найз нөхдийн хувьд хүмүүс бие биендээ хандах, харилцан бие биедээ нөлөөлөх, хэн хэнийхээ сэтгэл санааны байдлыг мэдэрч хуваалцах, харилцан ойлголцох зэрэг олон асуудлыг нэгэн зэрэг

илэрхийлж байдаг” гэж тодорхойлсны зэрэгцээ шинжлэх ухааны үүднээс харилцааг олон янзаар тодорхойлсон байдаг. Жишээ нь :

-Харилцаа нь амьд ахуйн үндсэн нөхцөл юм.

-Харилцаа бол хүмүүсийн дотоод сэтгэлийн хэрэгцээ юм.

-Харилцаа нь хүмүүсийн сэтгэл хөдөлгөөний илэрхийлэл мөн.

-Харилцаан хүмүүсийн хоорондын энергийн харилцан солилцоо мөн.

-Харилцаа нь харилцан нөлөөлөл юм.

-Харилцаа бол харилцагч хүнээ таних, судлах арга болдог.

-Харилцаа нь бие хүнийг төлөвшүүлэх хэрэглүүр мөн.

-Харилцаа бол соёл юм гэх мэтээр харилцааг олон талаас тодорхойлж хүн төрөлхтний хөгжил дэвшилд харилцааны мөн чанарыг ойлгож ухаарах явдал нь нэн чухал боллхыг харуулж өгчээ.

Харилцааны бүтэц нь хэлхээ холбоо тогтоох буюу харилцагчдын хооронд мэдээлэл солилцох үйл явцыг багтаасан харилцааны явцуу утга, харилцагчдын хооронд мэдээлэл, үзэл санаагаа солилцохын зэрэгцээ үйлдэл солилцох, харилцан үйлчлэх, харилцаанд оролцогчид бие биенээ хүндлэн хүлээн авахдаа харилцан ойлголцлыг төрүүлэх мэдрэхүйн хэсгүүдээс бүрдэнэ. Өөрөөр хэлбэл харилцааны мөн чанар гэдэг бол асар их мэдрэмж шаардах үзэгдэл хэмээн ойлгож болно. Харилцааны мөн чанарыг ойлгож ухаарч түүнд суралцсанаар хүмүүсийн харилцааны доголдол ба сөрөг шинжүүдийг олж харан тэдгээрийн эерэг аргаар шийдвэрлэх арга замд ч суралцах юм. Харилцаа гэдэг бол хүний амьдралын бүхий л үйл явцын тасралтгүй үргэлжлэл бөгөөд нийгмийн аль ч хэсэгт зайлшгүй харилцааны идэвхтэй байдал нв хүнийг хөгжихөд, нийгэмшихэд гол нөлөөлөл болдог. Эсрэгээрээ харилцааны идэвхтэй байдал үгүй бол хөгжил гэж үгүй. Иймээс сурган хүмүүжүүлэгч багш хүн харилцааны олон зөв дадал хэвшлийг өөртөө төлөвшүүлж ямар ч нөхцөлд байдалд зөв харилцаагаараа нийгэмд үлгэрлэсэн ёс зүйтэй багш хүн байх ёстой.

Багшийн эцэг эхтэй хамтран ажиллах үйлийн сэтгэл зүйн үндэс: Гэр бүл бол хүүхэд, залуусын хөгжлийг тэтгэгч анхдагч орчин бөгөөд хүүхэд хамгийн чухал дэмжлэгийг гэр бүлээсээ л авч байдаг ба түүний хөгжилд эцэг эхийн оролцоо хэдийчинээ их байх тусам бие бялдар, оюун ухаан, нийгэмшихүйн хөгжлийн үзүүлэлт нь төдийчинээ дээшилдэг байна. Гэвч дийлэнх эцэг эхчүүдэд хүүхдийнхээ хөгжлийг дэмжих арга замаа олоход бэрхшээл тохиолддог тул тэдэнд сурган хүмүүжүүлэх ур чадвараа хөгжүүлэх хэрэгцээ байнга үүсч байдаг. Тиймээс багш хүн эцэг эхтэй ажиллах арга барилыг сайтар эзэмшиж, эцэг эх, хүүхэд, багшийн гурвалсан харилцааг үүсгэж сургалтын хэлбэрийг зохион байгуулж,

хичээлээс гадуурх үйл ажиллагааг идэвхтэй өрнүүлэх нь бие хүний хөгжил төлөвшил болон хүүхэд, залуусд нийгэмшлийг олоход маш чухал нөлөө үзүүлдэг.

Сэтгэл судлалын шинжлэх ухаан нь олон зууны туршид хөгжингүй болон боловсорсоор ирсэн бөгөөд энэ чиглэлээр судалгаа шинжилгээ хийж, санал бодлоо тусгасан эрдэмтэд ч олон билээ. Дэлхий нийтээр хүлээн зөвшөөрдөг ганц зүйл бол хүүхэд, залуусын хөгжил төлөвшилд нийгэм буюу хүрээлэн буй орчин хамгаас чухлаар нөлөөлдөг гэх үзэл санаа билээ. Хүрээлэн буй орчин гэдэгт хамгаас түрүүн гэр бүл ба сургуулийн орчин хамаарагдана. Гэр бүлийн бүхий л гишүүд мөн сургуулийн багш ажилчин бүр хүүхдийн хөгжлийн толь болж байдаг. Үүнийг багш хүн сайтар ухаарч эцэг эхтэй хамтран ажиллах тал дээр санал бодлоо тусган мөн туршлага бүхий бусад багш нараасаа туршлага солилцох нь хүүхдийн ирээдүйн хөгжилд болон багш хүний ажлын ахиц дэвшилд эерэг нөлөө үзүүлэх юм.

Мөн багш хүний хамгийн сайн анхаарах зүйлийн нэг бол сурагч нэг бүрийг судалж бас сурагч нэг бүрийн ар гэрийн байдлыг таньж мэдэх нь чухал. Өнөөгийн байдлаар эцэг эхчүүдийн хүүхэддээ анхаарал хяналт тавих хэлбэр харьцангуй өөр өөр билээ. Тиймээс сурагчаа сайтар мэдэж таньж, сурагч бүрт тулгарч байгаа асуудлыг хэн хүнээс илүү анги удирдсан багш хүн зайлшгүй мэдэж байх нь чухал юм. Тийм ч учир боловсролын тогтолцоонд заахдаа багш хүнийг хүүхдийн зөвлөгч, чиглүүлэгч бас сайн хамтрагч хэмээсэн байдаг. Сайн хамтрагч байхын тулд хүүхдийг сайтар судалж, түүнд илүү ойр дотно хандах хэрэгтэй. Ийнхүү өнөөгийн нийгэм багш хүнээс судлаач байх чадварыг зайлшгүй шаардаж байгаа. Хэн илүү хөдөлмөрлөнө тэр илүү ихийг хүртэнэ гэдэг шиг өнөөдөр аль багш шавь нарынхаа төлөө цаг зав гаргана тэр багш олон талаараа хөгжхөөс гадна бас олон хүний хайр хүндлэлийг даасан жинхэнэ мэргэжилтэн болж чадна.

Багш эцэг эхтэй байнгын холбоотой ажиллаж хүүхдийн сурч хүмүүжих ахуй нөхцөлийг хангахад анхаарч тэднийг зөв хүн болгон төлөвшүүлэх тал дээр санал, зорилго нэгдэж үйл ажиллагаагаа хамтран явуулж хүүхдийн хөгжил төлөвшилд чиглэсэн үйл ажиллагааг өргөнөөр явуулснаар эцэг эхтэй хамтран ажиллах багш хүний үүргээ биелүүлж чадна. Хүүхдийн төлөөх байгууллага, хувь хүмүүс бүгд хамтарч ажиллахгүй юмаа гэхэд багш эцэг эхчүүд өөрсдөө хүүхдээ төлөвшүүлэхийн тулд хамтын ажиллагаагаа илүү ур дүнтэй болгох аваас бусад хүүхдийн хөгжлийн төлөөх байгууллагуудад үлгэр жишээ үзүүлэгч болох юм. Зөв хөгжил төлөвшил зөв чиглүүлэгчээс эхлэнэ. Тиймээс шинэ эрин зуунд хөгжлийг түүчээлэгч багш хүн өөрөө хамгийн зөв мэргэжилтэн болж мэргэших нь зүйтэй. Нийгмийн орчин нөхцөл маань ирээдүйн багш биднээс дан ганц мэдлэг боловсрол биш ёс зүй, зан суртхуун, харилцааны ур чадвар гэх мэт багш хүнд байх бүхий л цогц чадварыг шаардаж байгаа болохыг багш хүн бүр ойлгох нь чухал болов уу.

Судалгааны хэсэг:

Багш мэргэжилтний ёс зүйн тухай судалгааг асуулга хэлбэрээр өрнүүлж багшийн ёс зүйн талаар үнэлэлт хийсэн билээ.

Судалгаанд оролцсон багш Б: Багш хүн мэргэжлийнхээ үнэ цэнийг ухаарч ажлын байран дээр багш мэргэжлийн ёс зүйг эрхэмлэн сахих ёстой. Ёс зүй гэдэг бол багшийн хөгжлийг илэрхийлэгч тулгуур хүчин зүйл. Ялангуяа өнөөгийн нийгэмд багшийн ёс зүйн тухай асуудлууд маш их хөндөгддөг болсон. Хүүхдийг өөрийн хүүхэд мэт хайрлаж, хамгаалж тэдэнд ухаалгаар аливааг ойлгуулах нь жинхэнэ багшийн хөгжих үйл явц хэмээн дүгнэдэг. Багш хүн мэргэжлийн чиглэлийн мэдлэгээ чадварлагаар ашиглах хэрэгтэй билээ.

Судалгаанд хамрагдсан багш С: Багшийн хөгжилд нөлөөлөх хүчин зүйл гэхээр хамгаас түрүүн харилцааны чадварын тухай санаанд бууж байна. Ер нь бүх зүйлийн хэм хэмжүүр нь харилцаа, ёс зүй байдаг. Тэр тусмаа амьд харилцаа гэгч зүйл хамгаас чухал. Багш хүн бусадтай эелдэг боловсон харилцаж бүх талаараа үлгэр жишээч байх ёстой.


Судалгаанд хамрагдсан багш Д: Багшийн хөгжилд сургалтын хөтөлбөрөөс гадна ёс зүй, харилцааны соёл, энэрэх хайрлах сэтгэл, ажилдаа хандах хандлага, багийн ажиллагааг эрхэмлэх явдал, судлаач байх чанар, эцэг эх-багш-хүүхдийн гурвалсан холбоог эрхэмлэн ажиллах гэх мэт олон хүчин зүйлсүүд хамаарч тэдгээрээр дамжин багш тасралтгүй хөгжиж байдаг. Багшийн ажлын гол цөм бол ёс зүйтэй байх явдал зайлшгүй мөн.


Судалгаанд хамрагдсан багш Г:Боловсролын салбарын багш мэргэжилтнүүд бид төрийн албан хаагчийн хувьд өөрийн мэргэжлийн үнэ цэнээ ухаарч боловсролын стандартын дагуу чанартай, хүртээмжтэй байдлаар хичээлийг зохион байгуулах ёстой. Сургуулийн насны хүүхдүүдэд түгээмэл тохиолддог зүйл бол танхимын сургалтын үеэр хүүхэд илүү их хөгжиж мөн нийгэмшдэг. Харин цахим сургалтаар хичээллэх болсноос хойш хүүхдүүдийг идэвх оролцоо эрс суларч өмнө нь сурч мэдсэн зүйлээ мартах тохиолдлууд олонтаа ажиглагдсан. Иймээс танхимын сургалтын үед сургалтын төлөвлөгөөг чухалчлан үзэж сургалтаа өрнүүлэх нь зохистой мэт санагдаж байгаа.


Судалгаанд хамрагдсан багш Ц: Багш байна гэдэг маш том үүрэг хариуцлага юм. Багшийн ажилдаа хандах хандлага, нийгэмд үлгэрлэх үлгэр дууриаллаар нийгмийн хөгжил, цаашлаад улс орны хөгжил тодорхойлогдоно. Иймээс багш мэргэжилтэн ёс зүй гэгч зүйлийн мөн чанарын талаар ойлгож ухаарч түүнийг өдөр тутмын амьдралдаа хэрэгжүүлэх учиртай. Дан ганц сургуулийн орчинд ёс зүйтэй байх биш эерэг харилцаа, нэгдмэл байдал, хүнлэг сэтгэл, хүн чанарыг чухалчилсан жинхэн багш байснаар ёс зүйтэй багш байж чадна гэж боддог.


Судалгаанд хамрагдсан багш Э: Багшийн ёс зүй гэдгийг нэг үгээр тодорхойлбол асар том соёл юм. Ёс зүйтэй хүнээс соёлтой үйлдлүүд гарна. Мөн

нийгэмд зөв соёлыг түгээж чадна. Багш мэргэжилтэн нь өөр өөрийн мэргэжлийнхээ дагуу сургалт хүмүүжлийн үйл ажиллагааг өрнүүлдэг хэдий ч ёс зүй гэгч чухал зүйл нь хүүхэд залуус зөв төлөвшил хүмүүжлийг олгоход нэн чухлаар нөлөөлдөг. Хэрвээ багш хүнээс ёс зүйтэй үйлдлүүд гарахгүй бол түмний хүүхдэд зөв үлгэр жишээ болж чадахгүй шүү дээ.









Судалгааны боловсруулалт: Багш бие хүний үндсэн шинж чанаруудыг эрдэмтэн судлаачид дараах байдлаар авч үзсэн байдаг. Тухайлбал: ажилдаа дур сонирхолтой, идэвхи санаачлагатай, шинийг хийж бутээх эрмэлзэлтэй, хариуцлагатай, уян хатан сэтгэдэг, ажилдаа сэтгэлээ зориулдаг, шударга, хүмүүнлэг, өөрийгөө эзэмддэг, хянадаг, хурдан сэтгэдэг, аливаад ухаалаг ханддаг, тэвчээртэй хүлээцтэй ханддаг, өөрийн сурган хүмүүжүүлэх үзэл бодол, зарчимтай, шавь нараа чин сэтгэлээсээ хайрладаг, хүндэлдэг, сурагчдад бүх талаараа үлгэр жишээ үзүүлдэг, өөрийгөө дайчилдаг, шаргуу, мэргэжлийнхээ нэр төрийг эрхэмлэдэг, урлаг, спорт гэх зэрэг олон талын мэдлэг чадвартай, хууль журмыг хүндлэн сахидаг, өөрийн эрх мэдлээ урвуулан ашигладаггүй байх зэрэг нийтлэг шаардлагууд тавигддаг. Эдгээр нь уг чанартаа багш хүнийг ёс зүйтэй байдал руу хөтлөх ажгуу.

Багшийн талаар технократ үзэлд багш дуулгавартай гүйцэтгэгч хүмүүсийг бэлтгэх явдал гэж үзээд багш шинжлэх ухаан техник, технологийн туршилтыг сургалтандаа өргөнөөр ашиглэхыг зөвлөдөг бол, хмүүнлэгийн онолд багш бол шударга ёсыг баримтлан тогтоох ёстой. Ингэснээр боловсролын тогтолцоо хүмүүнлэг энэрэнгүй болж үр өгөөж нь дээшилнэ гэж үздэг бол орчин үеийн манай нийгэмд дараах нийтлэг шаардлагуудыг биелүүлхийг багшаас шаардаж байна.

- Багш хүн мэргэжилдээ эзэн байхын хамт хөгжил, төлөвшлийн онол, орчин үеийн сэтгэл судлал, сурган хүмүүжүүлэх зүйн мэдлэг эзэмшсэн байх, эдгээр мэдлэгийг өдөр дутмын сургалтын үйл ажиллагаанд бүтээлчээр хэрэглэдэг байх, эдгээр мэдлэгийг өдөр дутмын сургалтын үйл ажиллагаандаа бүтээлчээр хэрэглэдэг байх
- Хүүхдэд хайртай түүний төлөвшил сайн сайхны төлөө чадах бүхнээ хийж чаддаг, хүүхдийн төлөө гэсэн сэтгэлтэй, хүүхдийн сурах чадвар, авъяас сонирхол, хэрэгцээнд хүндэтгэлтэй, өөдрөг ханддаг байх, харилцааны өндөр соёлтой, хүүхдийн санаа бодлыг анхааралтай сонсож чаддаг байх
- Багш өөрийнхөө нөөц боломжыг дайчилж, гадаад хэл, компьютер, мэргэжлийн мэдлэг ур чадварыг цаг үргэлж дээшлүүлэн сайжруулж өөрийгөө байнга хөгжүүлэх чадвартай судлаач хүн байх, өөрөө өөртөө шаардлага тавьдаг, өөртөө шүүмжлэлтэй ханддаг алдаа дутагдлаа олж засч чаддаг байх. Багш хүн ажил хэрэгч, нямбай, хариуцлагатай, төлөв даруу, шударга, хэлсэн үгэндээ эзэн болж үг ажил хоёр нь зөрдөггүй байх ёстой. Эдгээр нь жинхэнэ ёс зүйтэй багш байхын суурь чадамжууд юм.

Монгол улсын боловсролын системд шинэ залуу багш нар хүч түрэн орж ирж байгаа тэдгээр нь өмнөх багш нарынхаа алдаан дээр суралцаж дэлхийн жишигт хүрсэн мэрэгжилтэн болохыг хичээж буй. Манай боловсролын тогтолцоо багш төвтэй сургалтаас шавь төвтэй сургалтруу шилжин орж байгаа. Энэ шинэчлэлийн

нэн тэргүүнд багш нар явж, бид өөрсдийгөө хөгжүүлэх орчин үеийн хүүхдүүдийн хэрэгцээ, сонирхолыг харгалзан үзэж өөрсдийн хандлагаа өөрчлөхийг оролдож байна энэ нь маш үр дүнтэй болж байгаа билээ. Гэхдээ багш нь хүүхдэд ганцхан мэдлэг эзэмшүүлэх төдийгөөр хязгаарлагдахгүйгээс гадна бүтээлч хандлагат, ёс зүй, харилцааны соёл, хүүхдэд зөв үлгэр дууриалал болж чаддаг байх ёстой. Ийм ч учраас багш хүн гэдэг ирээдүйн эх ороны эзэдийг бэлтгэж өгдөгөөрөө нийгмийн өмнө онцгой үүрэг хариуцлагатай байдаг.

“Өсвөр залуу үеийг сурган хүмүүжүүлэх, тэднийг амьдралд бэлтгэх хариуцлагатай үүргийг эрт дээр үеэс эцэг эх, овгийн ахлагч, философичид, лам хуврага нар хэрэгжүүлж ирсэн ба сүүлийн нэг зуунд зориуд бэлтгэгдсэн мэргэжлийн багш хэмээх хүмүүс хийх болсон. Багш мэргэжлийг хүндэтгэж, багшын хөдөлмөрийг зөв үнэлэх, багш мэргэжлийн ёс зүйн шалгуур үзүүлэлтийг тодруулхын тулд мэргэжлийн онцлогийг мэдрэх шаардлагатай. Багш хүнд байх ёстой шинж чанрын талаар нэрт сурган хүмүүжүүлэгч эрдэмтэд эртнээс авхуулаад тодорхойлон бичсэн байдаг.

- И.Г.Пасталоццийн хувьд багш бол “Хүүхдийн цэцэрлэгч”
- Ж.Ж.Руссогийн хувьд “Муу нөлөөнөөс хүүхдийг хамгаалагч манаач”
- П.П.Блонскийн хувьд “Хүн судлалын инжинер байх ёстой”
- Я.А.Коменский “Өндөр боловсрол, ёс суртахуунтай, өөрийн үйлсэд үнэнч шударга, ажил хэрэгч, хүүхдэд эцэг ёсоор хайртай зөвхөн тийм л хүн багш байж болох юм” гэдгийг өөрийн бүтээлүүддээ тэмдэглэж байжээ.

Харин гол чиглэлийг удирдсан тодорхойлолт бол В.М.Ломоносов багш хүн бол зөвхөн үгээрээ сургаад зогсохгүй мөн “сайн сайхан үйлсээрээ үлгэр жишээ үзүүлэх ёстой” хэмээн үзсэнд оршино. Нөгөөтэйгүүр Ш.Ичинхорлоо “Өсвөр залуу үеийнхэнд амьдрал ахуйд нь хэрэгтэй мэдлэг, арга барил, чадвар, туршлага олж авхад нь туслах, тэднийг иргэн-бие хүн болон хөгжин төлөвших, нийгэмших ажлыг шинжлэх ухааны үндэстэй зохион явуулах ур чадвар бүхий бие хүн гэж үзэж болно” хэмээн зохиол бүтээлүүддээ тусгасан байна.

Боловсролтой хүмүүсийн хамгийн том төлөөлөл бол төрийн алба хаагч нар байдаг. Гэхдээ боловсролын олон төрөл зүйл дундаас хамгийн чухал нь зүрх сэттгэлийн боловсрол. Төрийн алба хаагч нь ямар ч үед төрийн албан хаагчийн ёс зүйг баримталж эерэг хандлагыг эрхэмлэх ёстой. Хандлага гэдэг нь нөхцөл байдал болон бусад хүмүүсийг тааламжтай ба тааламжгүй аль нэг байдлаар үнэлэх үнэлэлт юм. Харилцаа хандлага хоёр нягт холбоотой бөгөөд харилцааны явцад хандлага мэдрэгддэг. Хандлага үйлдэл болохдоо бодлоор дамжин илэрдэг. Ёс зүй нь хүний дотоод сэтгэлийн төгөлдөршилтэй нягт холбогддог бөгөөд энэ нь харилцаа хандлагын хэлбэрээр илэрнэ. Иймээс төрийн албан хаагчийн хувьд ажлын байр ба бусад ямар ч нөхцөлд эерэг хандлагыг чухалчилж, түүний талаар тодорхой хэмжээний ойлголттой байх нь чухал. Тэгж хэмээн зүрх сэтгэлийн боловсролд төлөвшсөн мэргэжилтэн байж чадах юм.

Хандлага оюун ухаанаас илүү чухал гэж зарим эрдэмтэн судлаачид үзсэн байдаг. Сэтгэл судлаач Карол Двек бүхий л хугацааг хандлага болоод гүйцэтгэлийн талаар судлахад зарцуулсан бөгөөд тэрээр судалгаагаараа хүний амжилтыг IQ биш хандлага тодорхойлдог гэдгийг баталсан нь буй. Хүний хандлагыг хэвшмэл сэтгэлгээ ба өсөлтөт сэтгэлгээ гэж үндсэн хоёр ангилалд хуваж үзсэн бөгөөд хэвшмэл сэтгэлгээтэй хүмүүс өөрийгөө өөрчлөгдөх боломжгүй гэж үнэлжээ. Ямар нэг сорилт бэрхшээл тулгарахад сэтгэлээр унаж цөхөрдөг бол өсөлтөт сэтгэлгээтэй хүмүүс өөрөө хичээвэл өсөж дэвжиж амжилтанд хүрнэ гэдэгт итгэдэг хэмээн дүгнэсэн аж. Хүмүүсийн амьдралдаа хандах хандлага, ёс заншил, уламжлал дэг жаяг, шашин шүтлэг зэргийг хэрхэн авч үзэх нь эцэг эх гэр бүлийн нөлөөлөл, нийгмийн хөгжлийн хандлагаас хамаарч байдаг билээ. Эерэг хандлага байхын адил сөрөг хандлагууд ч бас бий. Иймээс эерэг хандлагыг чухалчилж зүрх сэтгэлийн боловсролыг ямагт эрхэмлэх ёстой.

Дүгнэлт

Орчин үед сургалтын шинэ технилогид тавигдаж буй шаардлагын дагуу шавь төвтэй, хөгжүүлэх сургалтыг зохион байгуулах шаардлага тавигдаж байна. Хөгжүүлэх сургалтыг хэрэгжүүлэх нэг чухал хүчин зүйл нь багш хүн шавь нараа сайтар судлаж тэдгээрийн хувийн онцлогийг танин мэдэх явдал юм. Учир нь багш хүн, шавь нараа бүхий л талаас нь судалж чаддаг байхын хамт заасан хичээлдээ болон өдөр тутмынхаа үйл ажиллагаандаа олон талын дүн шинжилгээ хийж боловсронгуй болгох, өөрийнхөө мэдлэг, чадварыг өөрөө дээшлүүлэх зэрэг арга барил эзэмшсэн, ном зохиол уншиж судалдаг, ажиглалт судалгаа хийх чадвартай байх ёстой. Багш хүн хэдий чинээ хүүхдийнхээ талаар өргөн мэдлэгтэй тэдний хэрэгцээ сонирхол, хүсэл эрмэлзлийг олж харахыг хичээдэг, хэрэгцээг нь хангахад чиглэсэн үйл ажиллагаа явуулж чадвал багш бидний өнөөгийн болон ирээдүйн сайн сайхны төлөө оруулж буй хөрөнгө оруулалт юм.

Багш хүн урлаг, уран сайхан, улс төр, эдийн засаг, спорт гэх зэргийн олон талын өргөн мэдлэгтэй байх зэрэг юм. Орчин үеийн багш нь шавь төвтэй сургалт зохион байгуулж, сурах үйлд сургах нь багшын ажлын чиглэл болоод байна. Багшийн өдөр дутмын сурган хүмүүжүүлэх үйл ажиллагаанд байнга нөлөөлөл үзүүлдэг үндсэн объект бол өсөн хөгжиж буй шавь нар нь юм. Багш шавийн сурч хүмүүжих, хөгжин төлөвших үйл ажиллагааг зохион байгуулах, чиглүүлэх, шавийн сурч хөгжих үйл явцыг жолооддог менежер байх хэрэгцээ улам өсөн нэмэгдэж байна. Багшийн ажил нь олон хүүхдийг нэгэн зэрэг хамарч тэдний нүдэн дээр ил явагддаг учир байнга бусдын хараа хяналт дор хэрэгждэг онцлогтой. Багш тун олон янзын зан авиртай шавь нартай ажилладаг учир өөрийгөө байнга эзэмдэх, хэлж буй үг, хийж буй зан үйлээ сайтар хянах, аливаад хүлээцтэй, тэвчээртэй хандах нь мөн энэ мэргэжлийн чухал онцлог юм. Багш сурган хүмүүжүүлэх үйл ажиллагааны

явцад бүх шавь нарыг анхааралдаа багтааж ёс зүйн ур чадварыг гарган ажил үүргээ гүйцэлдүүлэх ёстой ажээ. Багшийн ёс зүй бол нэн түрүүнд тавигдах хамгийн чухал чадварын нэг мөн бөгөөд боловсролын системд хүчтэй нөлөөлөх хүчин зүйл юм.

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ БАЙГУУЛЛАГЫН ЭМЭГТЭЙ АХЛАГЧ БҮРЭЛДЭХҮҮНИЙ АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙГ ҮНЭЛЖ, ДҮГНЭХ АСУУДАЛ

ASSESSMENT AND CONCLUSION OF THE PERFORMANCE OF THE FEMALE SENIOR MEMBERS OF THE COURT EXECUTION ORGANIZATION

Х.Уянга

Эрх зүй нийгмийн ухааны сургуулийн нийтийн эрх зүйн тэнхимийн багш, цагдаагийн дэслэгч

Д.Энх-Амар

Эрх зүй нийгмийн ухааны сургуулийн Нийтийн эрх зүйн тэнхимийн ахлах багш, цагдаагийн ахмад

Товч агуулга: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын эмэгтэй ахлагч бүрэлдэхүүний ажлын гүйцэтгэлийг үнэлж, дүгнэж байгаа өнөөгийн журмын зохицуулалт нь бодит байдалтай нийцэж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийх, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, эмэгтэй ахлагч бүрэлдэхүүнээс авсан судалгаанд түшиглэн өнөөгийн байдлыг харьцуулан судаллаа.

Түлхүүр үг: Жендер, үнэлгээ, дүгнэлт, ажлын гүйцэтгэл, шинжилгээ

УДИРТГАЛ

Өнөө цагт төрийн байгууллагад ажиллаж буй алба хаагчдын дунд эмэгтэй алба хаагчдын тоо багагүй хувийг эзэлсээр байна. Алба хаагчдын ажлын гүйцэтгэлийг зөв үнэлж, дүгнэх, урамшуулах асуудал туйлын чухал юм. Тэр дундаа эмэгтэй алба хаагчдын ажлын гүйцэтгэлийг хэрхэн үнэлж, дүгнэх асуудал орхигдсон хэвээр байна. Учир нь өнөөдрийг хүртэл эмэгтэй алба хаагчдын ажлыг хэрхэн үнэлж, дүгнэх талаар тусгайлан гаргасан заавар, дүрэм, журам төрийн байгууллагад байхгүй байгаа талаар судлаачдын зүгээс ихээхэн шүүмжлэлтэй хандсаар ирсэн.

Миний бие Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын харьяа 407 дугаар нээлттэй, хаалттай хорих ангид 3 дахь жилдээ ажиллаж байна. Эмэгтэй ахлагч бүрэлдэхүүнийг үнэлж, дүгнэх ажил зохих журмын дагуу явагдаж байгаа боловч уг үнэлгээ, дүгнэлт өгөх ажилд тодорхой ач холбогдол өгч нарийвчлан авч үзэх шаардлагатай. Иймд миний бие энэ илтгэлийг боловсруулаа. Ажлыг үнэлж, дүгнэх асуудал багагүй хугацааны турш маргаантай, сонирхол татах хэмжээнд байсаар ирсэн. Олон улсад ажлын гүйцэтгэлийг хэрхэн үнэлж, дүгнэж байгааг бид сайтар судлах ёстой гэж үзэж байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын эмэгтэй алба хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлж, дүгнэх асуудлыг ярихын өмнө жендерийн тухай ойлголтыг та бүхэнд өгөх нь зүйтэй гэж бодож байна.

Жендер гэдэг үг нь англи хэлэнд “gender”, орос хэлэнд “гендер” буюу “ хүйс гэх” латин үгнээс гаралтай бөгөөд жендер судлал нь гэр бүл, нийгэм, улс төр нийгмийн бүхий л харилцаанд эрэгтэй, эмэгтэй хүний гүйцэтгэх үүрэг, хүлээх хариуцлага, тэдний нийгэмд эзлэх байр суурийн талаар уламжлагдан тогтсон, түүхэн явцад хувьсан өөрчлөгддөг ойлголт, үзэл, хандлагыг судалдаг шинжлэх ухаан юм.

Жендер судлал нь дэлхийд 1970-аад оны үеэс үүсэж, жендер ба хөгжил гэсэн хүн төрөлхтний нийгмийн дэвшлийн шинэ цогц үзэлтэй хамаатайгаар ихээхэн хурдацтай хөгжиж байна.

Монгол Улсад 1990 оны үеэс “Жендер”-ийн асуудал эрчимтэй яригдаж эхэлсэн ба “Монгол Улс эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах, тэдэнд тулгамдсан асуудал”-ын талаар зохион байгуулагдсан дэлхийн эмэгтэйчүүдийн 4 дүгээр бага хуралд оролцох зорилгоор анх удаа Монгол Улсын Засгийн газрын 1995 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн 68 дугаар тогтоолыг “Эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах, нийгэмд эзлэх байр суурийг хангах” чиглэлээр батлан гаргасан байна”[1].

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад өнөөдрийн байдлаар 1100 орчим эмэгтэй алба хаагч ажиллаж байгаагийн 430 орчим нь ахлагч бүрэлдэхүүн байна.

Эдгээр эмэгтэй ахлагч нарыг бэлтгэх, дадлагажуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах ажлын гүйцэтгэлийг сайжруулах үнэлж, дүгнэх асуудалд анхаарлаа хандуулж ажиллах нь чухал ач холбогдолтой асуудал юм.

ХОЁР. ҮНДСЭН ХЭСЭГ

Ажлын гүйцэтгэлийг үнэлж, дүгнэх асуудал эрдэмтэд, судлаачдын дунд одоог хүртэл маргааныг дагуулсаар ирсэн ба хэрхэн дүгнэх талаар нэгдсэн ойлголтод хүрч чадаагүй байна. Олон улсад судлаачид дараах байдлаар тодорхойлсон байдаг.

Мурфи (1989) ажлын гүйцэтгэлийг “Тухайн хүний ажиллаж байгаа байгууллагын зорилго эсвэл ажиллаж буй байгууллагын нэгжийнх нь зорилготой хамаарал бүхий багц зан төлөв” гэж тодорхойлж болно гэсэн байна.

Тиймээс хувь хүний ажлын гүйцэтгэл нь байгууллагын хөгжилд маш чухал үүрэг гүйцэтгэдэг бөгөөд энэ нь бүхэлдээ байгууллагын ажлын гүйцэтгэл, сэтгэл зүйд маш чухал нөлөөтэй байдгийг харуулж байна.

[1] Монгол Улсын засгийн газрын 68 дугаар тогтоол. УБ.,1995 он. 28 дахь тал

Майкл Ваде, Майкл Парэнт нар (2002) “Ажлын ур чадвар ба ажлын гүйцэтгэлийн хоорондын хамаарал” судалгааны ажлаараа мэргэжилтнүүдийн ажлаа үр дүнтэй гүйцэтгэхэд шаардагдах ур чадвар, мэдлэгийг судлан олон хүчин зүйлийн шинжилгээний үр дүнд мэргэжилтнүүдийн техникийн ур чадвар, хувийн зохион байгуулалт ба хувийн менежмент хамгийн оновчтой байхыг санал болгон загвар таамаглалаар баталсан.

Саянтера (2019) “Ажлын байрны орчин ажлын гүйцэтгэлийн хоорондын нөлөөлөл” судалгааны ажлаараа ажлын байрны орчны чухал хүчин зүйл болох нас, ажлын байрны зохион байгуулалт, цэвэрч байдал, ажлын байрны тохируулга, тоног төхөөрөмжийн хийц, чанар, орон зай, температур, агааржуулалт, гэрэлтүүлэг, дуу чимээ чичиргээ, агаарын чанар хамраана гэж үзсэн.

Энэ нь тэдний ажиллах чадварыг хөгжүүлэх, ажиллахад дэмжлэг үзүүлэхээс гадна ажлын сайн орчин нь ажиллах зохистой нөхцөлийг бүрдүүлж ажилчдын оролцоо, улмаар байгууллагын амжилтад голлох үүрэг гүйцэтгэдэг болохыг судалгааны ажлаараа баталсан[1].

Гүйцэтгэл нь хүний нөөцийн судалгаанд чухал байр суурь эзэлдэг учраас ажлын гүйцэтгэл нь тухайн байгууллагын хүний нөөцийн менежментийн үр ашигтай байдлыг илэрхийлэх хэмжүүр болж байна.

Ажлын гүйцэтгэлийн үнэлгээ гэдэг нь байгууллагын зүгээс ажилтан үүргээ хэрхэн биелүүлж, ямар үр дүнд хүрч байгаа түүний ур чадвар, мэргэшлийн бэлтгэл, ажлын ачаалал ямар байгааг дүгнэх үйл явц юм.

Аливаа байгууллагын зорилго нь ажлын гүйцэтгэлийг өндөр байлгаж алдаа дутагдалгүй ажиллахад оршдог бөгөөд хамгийн сайн гүйцэтгэл нь байгууллагад өндөр үр ашиг, амжилтыг авчрах үндсэн нөхцөл нь болж байдаг.

Ажлын гүйцэтгэл нь:

- Үүрэг даалгаврын биелэгдсэн түвшин.
- Аливаа үйл ажиллагааны үйл явц, арга хэлбэр.
- Гүйцэтгэл нь мэдлэг эзэмшсэнээр бус мэдлэгийг хэрэглэснээр аливаа ажлыг амжилттайгаар хийж гүйцэтгэх явц юм.

Дээрх тодорхойлолтуудаас үзэхэд ажлын гүйцэтгэл гэдэг нь мэдлэг, ур чадвараа ашиглан удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх үйл ажиллагаа, арга хэлбэр гэж тодорхойлж болохоор байна.

[1] Б.Золзаяа. “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын удирдах ажилтны ур чадвар ажлын гүйцэтгэлд нөлөөлөх нь” магистрын зэрэг горилсон судалгааны ажил УБ., 2023 он. 9 дэх тал

Байгууллага бүрт ажлын гүйцэтгэлийн үнэлгээг хийх заавар, журам байх учиртай. Энэ журамд ямар үзүүлэлтээр, хэн, ямар давтамжтай алба хаагчдын гүйцэтгэлийн үнэлгээг хийж байх талаар тодорхой тусгасан байдаг. Алба хаагч нартай өдөр бүр харьцаж, үүрэг даалгавар өгч байдаг доод шатны албан тушаалтууд ажлын үнэлгээг өгөх нь илүү үр дүнтэй гэж судлаачид үздэг.

Ажлын гүйцэтгэлийн үнэлгээний явц нь 3 үе шаттай.

1. ***Бэлтгэл үе шат.*** Алба хаагчид ажлаа бодитой үнэлүүлэхийн тулд хийсэн ажлаа эмхэлж, тайлан бичих.

Өөрөөр хэлбэл энэ үе шатанд албан тушаалын категори бүрээр үнэлгээний үзүүлэлтүүд болон шалгуурыг боловсруулах, шаардлагатай илтгэлийн ба үнэлгээний хуудас бэлтгэж олшруулж түүнийг бөглөх заавар гаргаж ажиллагчдад танилцуулах, явуулах хугацааг товлон батлуулах, шаардлагатай нөөцийг төлөвлөх, салбар нэгжийн удирдлагуудад зохион байгуулалт арга зүйн зөвлөгөө өгөх зэрэг арга хэмжээг хүний нөөцийн хэлтэс, мэргэжилтнүүд авч хэрэгжүүлнэ. Харин энэ хугацаанд ажиллагчид ажлаа бодитой үнэлүүлэхийн тулд өмнөх үнэлгээнээс хойших хугацаанд өөрсдийн хийж гүйцэтгэсэн ажлыг цэгцлэн эмхэлж, хийсэн ажлынхаа талаар тайлан бичиж, ирээдүйн ажлаа төлөвлөж, зорилгоо тодорхойлсон байвал зохино.

2. ***Үнэлгээний үе шат.*** Эрх бүхий хүмүүс алба хаагч нэг бүрийн ажлыг үзэж шалган, шаардлагатай бол шалгалт авах.

Өөрөөр хэлбэл үнэлгээ хийхээр албан ёсоор томилогдсон эрх бүхий хүмүүс ажилтан нэг бүрийн өнгөрсөн хугацаанд хийж гүйцэтгэсэн ажлыг нэг бүрчлэн үзэж шалган, шаардлагатай бол тэдний мэргэжил, мэргэшлийн бэлтгэлийн талаар шалгалт авна. Ажлын гүйцэтгэлийг үнэлэхдээ тухайн ажлын байрны шаардлагыг эсвэл тусгайлан бэлтгэсэн үзүүлэлт, шалгуурыг удирдамж болгоно. Мөн үнэлгээний явцад уг ажилтантай болон түүний шууд удирдлагатай ярилцаж, ажлын гүйцэтгэл болон мэргэжил, мэргэшлийн түвшингийн талаар харилцан ярилцаж санал бодлоо чөлөөтэй солилцож, үр дүнг зөвшилцөн гарын үсэг зурна.

Үнэлгээний явцад болсон бүх үйл явц болон ярилцлагын талаар илтгэх хуудсанд бичнэ. Үнэлгээ бүрэн дууссаны дараа үнэлэгч тухайн ажилтны ажлын гүйцэтгэлийн үнэлгээний дүнг гаргаж дараа шатны удирдлагад танилцуулж эсвэл хамт олны хурлаар хэлэлцүүлж, тэдний санал бодлыг тусган эцэслэн дүгнэлт гаргана.

3. ***Үнэлгээний дараах үе шат.*** Үнэлгээний эцсийн үр дүнд тулгуурлан тухайн ажилтныг шагнаж урамшуулах, сахилгын шийтгэл ногдуулах арга хэмжээг удирдлагын зүгээс авах.

Өөрөөр хэлбэл ажилтны ажлын гүйцэтгэлийн болон мэргэжлийн түвшингийн үнэлгээний эцсийн үр дүн, дүгнэлтэд тулгуурлан албан тушаал дэвшүүлэх , зэрэг дэв олгох, мэргэжлийн зэрэглэл нэмэгдэх эсвэл буурах, зохих шатны сургалтад хамруулах, цалин хөлсийг өөрчлөх зэрэг арга хэмжээг захиргааны зүгээс авна. Мөн нийтлэг алдаа дутагдлыг хэрхэн сайжруулах талаар зөвлөмж эсвэл холбогдох хүмүүст үүрэг даалгавар өгнө[1].

Үнэлгээний явц, үр дүнгийн талаар бодитой мэдээллийг алба хаагчдад албан ёсоор өгч байх нь зүйтэй.

Гүйцэтгэлийн үнэлгээний явцад гарч болзошгүй алдаа:

1. Тогтмол нэг маягийн үнэлгээ өгөх
2. Хэт зөөлөн хандах
3. Дундыг барих, төвийг сахих
4. Нэг шинж дээр тулгуурлах
5. Сүүлийн сэтгэгдлээр хандах
6. Хувийн үзэмжээр хандах
7. Анхны сэтгэгдлээр хандах зэрэг алдааг гаргаж болзошгүй гэж судлаачид үзсэн байдаг.

Өнөө үед ажлын гүйцэтгэлийг үнэлэхдээ дараах аргуудыг өргөн хэрэглэж байна.

1. Харьцуулж зэрэгцүүлэх аргууд
2. Зорилгод тулгуурласан аргууд
3. Тоон чанарын үнэлгээний аргууд[2]

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийг Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн 301 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам”-ын хүрээнд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын эмэгтэй алба хаагч нарын ажлын гүйцэтгэлийг жилд 2 удаа үнэлж, дүгнэж байна.

Судлаачийн зүгээс илтгэлдээ төрийн албан хаагч тэр дундаа Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын эмэгтэй ахлагч бүрэлдэхүүний ажлын гүйцэтгэлийг үнэлж буй “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам”-д судалгаа хийхэд дараах байдлаар тусгасан байна.

---

[1] https://mhri.mn/news/

[2] А.Тэмүүжин. “Ажлын гүйцэтгэлийн үнэлгээнд нөлөөлөх хүчин зүйлсийн шинжилгээ” УБ., 2023 он.

Шинэчлэн батлагдсан журмаар төлөвлөгөө, боловсруулах хугацааг тухайн жилийн 01 дүгээр сарын 10-ны дотор батлуулахаар заасан бөгөөд алба хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө нь гүйцэтгэлийн зорилт мэдлэг чадвараа дээшлүүлэх гэсэн хоёр хэсгээс бүрдэх талаар зааж өгсөн.

Төлөвлөгөөний биелэлтийг тайлагнах, баталгаажуулах талаар хугацааг хагас жилээр 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор, бүтэн жилээр 12 дугаар сарын 05-ны өдрийн дотор 2 удаа тайлагдах, тайлагнаагүй нь оноо хасах үндэслэл болох талаар тусгаж өгсөн.

Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлтийг тухайн албан хаагчийн төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээ болон нэмэлт ажлын үр дүнгээр тооцож 70 хүртэлх оноогоор, Мэдлэг чадварын үнэлгээ, мэдлэг ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлтийг 15 хүртэлх оноогоор, Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээг 15 хүртэлх оноогоор тус тус үнэлэхээр заасан.

“Маш сайн” үнэлгээний ангилалд хамрагдсан төрийн албан хаагчийн хувьд:

а). Төрийн дээд болон салбарын шагналд тодорхойлох;

б). Мөнгөн болон бусад хэлбэрийн шагнал, урамшуулал олгох;

в). Зэрэг дэвийг хугацаанаас өмнө ахиулах (тухайн жилийн 2 удаагийн үнэлгээгээр дараалан “Маш сайн” үнэлгээний ангилалд хамрагдвал);

г). Албан тушаалд дэвшүүлэх зорилгоор мэргэшүүлэх багц сургалт, гадаад, дотоодын богино, дунд хугацааны сургалтад хамруулах. (сүүлийн 3 удаагийн үнэлгээгээр “Хангалтгүй” үнэлгээний ангилалд хамрагдаагүй байх).

“Хэвийн” үнэлгээний ангилалд хамрагдсан төрийн албан хаагчийн хувьд:

а). Төрийн дээд болон салбарын шагналд тодорхойлох;

б). Зэрэг дэвийг ахиулах. (сүүлийн 3 удаагийн үнэлгээгээр “Хангалтгүй” үнэлгээний ангилалд хамрагдаагүй байх);

в). Албан тушаалд дэвшүүлэх зорилгоор мэргэшүүлэх багц сургалтад хамруулах (сүүлийн 3 удаагийн үнэлгээгээр “Хангалтгүй” үнэлгээний ангилалд хамрагдаагүй байх).

“Хангалтгүй” үнэлгээний ангилалд хамрагдсан төрийн албан хаагчийн хувьд:

а). Сургалтад хамруулах (албан хаагчийн өөрийн зардлаар);

б). Төрийн албаны тухай хуульд заасан сануулах арга хэмжээ авах;

в). Албан тушаалын цалинг 3 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах;

г).Албан тушаал бууруулах (2 удаа дараалан “Хангалтгүй” үнэлгээний ангилалд хамрагдсан);

д). Төрийн албанаас халах (сүүлийн 2 жилийн үнэлгээгээр 3 удаа “Хангалтгүй” үнэлгээний ангилалд хамрагдсан)[1].


Өнөөдрийн байдлаар эмэгтэй ахлагч бүрэлдэхүүний ажлыг гүйцэтгэлийг үнэлэхдээ тухайн алба хаагчийн шууд удирдах албан тушаалтны үнэлгээг харгалзан үзэхгүйгээр хэлтэс, тасгийн дарга нар бие даан үнэлж, дүгнэн үнэлгээний багт танилцуулан шийдвэрлүүлж байна.

Энэ нь тухайн алба хаагчийн талаар бусад этгээдийн зүгээс үнэлгээний анхан шатны дүн тавьж буй удирдах албан тушаалтныг буруу ташаа мэдээллээр хангах, үнэлгээний улиралд бус өмнө нь гаргасан алдаа дутагдлыг сөхөх, хувийн үзэмж, анхны болон сүүлийн сэтгэгдлээр хандах зэрэг асуудлыг үндэслэн дүгнэх нь эрсдэлийг дагуулж байдаг.

Иймд үнэлгээний шат дараалсан, хамт олны саналыг үндэслэсэн арга барилыг өргөнөөр ашиглан дүгнэвэл тухайн алба хаагчийн ажлын гүйцэтгэлийг бодитой, үнэн зөв үнэлж, дүгнэх үндэс болно гэж үзэж байна.

Энэхүү илтгэлийн хүрээнд шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын 407 дугаар нээлттэй, хаалттай хорих анги, дотоод хэргийн их сургуулийн эчнээ ангид суралцаж буй эмэгтэй 52 алба хаагчаас алба хаагчаас “Эмэгтэй ахлагч бүрэлдэхүүний ажлын гүйцэтгэлийг үнэлж, дүгнэх асуудал”-ын хүрээнд судалгааны асуулт боловсруулан судалгаа авсан.


ГУРАВ. САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДЛЫН СУДАЛГАА



[1] https://igovernment.mn/docs/


Таны ажлыг үнэлэхэдээ жендерийн тэгш бус байдал гаргадаг эсэх ?

52 хариулт




Таньд ажлаа үнэлж дүгнүүлэхэд хүндрэлтэй зүйл гардаг уу?

52 хариулт




Таны зан байдал, хандлагаас хамаарч таны ажлыг дүгнэх асуудал гардаг уу?

52 хариулт




Таньд ажлаа үнэлж дүгнүүлэхэд хүндрэлтэй зүйл гардаг уу?


52 хариулт



Та хэн нэгний буруутай үйлдэл, ойлголтоос болж удирдлагадаа дутуу үнэлэгдэж байсан уу?
52 хариулт



Танай байгууллагын үнэлгээний баг таны ажлыг шударгаар үнэлж чаддаг уу?
52 хариулт



Судалгаанаас үзэхэд эмэгтэй алба хаагчдын 55.8 хувь нь ажлын гүйцэтгэл үнэлж, дүгнэж байгаа удирдлага болон үнэлгээний багийн шийдвэрт сэтгэл дундуур, эргэлздэг гэж дүгнэж болохоор байна.

Эмэгтэй ахлагч бүрэлдэхүүний ажлын гүйцэтгэлийг үнэлж, дүгнэхдээ ажлын ачаалал, ажиллах орчин нөхцөл, гэр бүлийн байдал, удирдлагын дарамт шахалт зэргийг нэг бүрчлэн харгалзан үзэхгүйгээр дээрх журамд тусгасан нөхцөл, аргачлалын хүрээнд дүгнэлт гаргаж байгаа нь ажлаас халшрах, ажлын гүйцэтгэл буурах, ажилдаа сэтгэл дундуур байх нөхцөлийг бий болгож тэр нь аажимдаа бухимдал стресс-д оруулж ажлаас чөлөөлөгдөх, хаяж явах эрсдэлийг дагуулж байна.

Дүгнэлт

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын эмэгтэй алба хаагчийн ажлын гүйцэтгэлийг үнэлж, дүгнэх асуудал судалгааны ажлын хүрээнд дараах дүгнэлтийг гаргаж байна.Үүнд:

1. Эмэгтэй алба хаагчийн ажлын гүйцэтгэлийг бодитой, шударгаар үнэлж, дүгнэх асуудал нь тухайн алба хаагчийн ажлын үр дүнг нэмэгдүүлэх, цаашид тогтвортой суурьшилтай ажиллахад нэн чухал нөлөө үзүүлдэг.

2. Ажлын гүйцэтгэлийн үнэлж, дүгнэх журам, аргачлалаар хэрхэн үр дүнг тооцох талаар алба хаагчид бүрэн дүүрэн судлаагүй, мэддэггүй байдлаас шалтгаалж удирдлагын шийдвэр гаргалтыг хүлээн зөвшөөрөхгүй байх, үнэлгээнд сэтгэл дундуур байх явдал ихээхэн байдаг. Тэдний эрх ашгийг хамгаалах, дуу хоолой болох байгууллагын эмэгтэйчүүд болон ахлагчийн зөвлөлийн үйл ажиллаагаа, үүрэг, хариуцлага сул гэж үзэж болохоор байна.

3. Төрийн цэргийн байгууллагын эмэгтэй ахлагч бүрэлдэхүүн өөрсдийн мэдлэг, ур чадвар, хувийн зохион байгуулалт, ёс зүйг алхам бүртээ дээшлүүлж байгууллагын зорилго, зорилтод нийцүүлэн ажлын гүйцэтгэлээ сайжруулснаар бодитой байдалд үзүүлнэ.

4. Ажлаа үнэлж, дүгнүүлэх боломж улам бүр нэмэгдэнэ гэж дүгнэж байна.

5. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын эмэгтэй алба хаагчийг үнэлэх, дүгнэх журмыг боловсруулахдаа тэднээс санал авч, бодит хэлэлцүүлэг зохион байгуулах нь зөв гэж дүгнэж байна.

- Учир нь сүүлийн жилүүдэд ажил үнэлж, дүгнэх журам олон удаа шинэчлэгдсэн нь алба хаагчийн зүгээс ажлаа хэрхэн үнэлж, дүгнүүлэх талаар эргэлзээ үүсгэдэг.

6. Эмэгтэй ахлагч бүрэлдэхүүний ажлыг дүгнэхдээ Жендерийн мэдрэмжтэй, ажлын байрны онцлог болон гүйцэтгэх үүрэгтэй нь хамтатган дүгнэх нь хүний эрхийн суурь шаардлагад нийцнэ гэж үзэж байна.

7. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын эмэгтэй алба хаагчийг үнэлж, дүгнэх асуудлыг тусгайлан зохицуулсан хууль зүйн баримт бичиг, эрх зүйн акт байхгүй, төрийн жинхэнэ алба хаагчийг “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам”-ын хүрээнд үнэлж, дүгнэж байгаа хэдий ч эмэгтэй алба хаагчийн ажлын гүйцэтгэлийг хэрхэн, ямар шалгууруар үнэлж, дүгнэх нь тодорхой бус, тусгайлан авч үзээгүй байна.

8. Байгууллагын удирдлагын зүгээс алба хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлж, дүгнэхдээ өөрийн ур чадварыг тогтмол сайжруулж өнгөрсөнд дүгнэж байсан сайн туршлагыг улам боловсронгуй болгох, шинээр нэвтэрч буй алба хаагчийг үнэлж, дүгнэх онол, арга зүйг судлах, үйл ажиллагаандаа нэвтрүүлэх шаардлагатай байна.

Дэвшүүлж буй санал: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын эмэгтэй алба хаагчийн ажлын гүйцэтгэлийг үнэлж, дүгнэх асуудал судалгааны ажлын хүрээнд дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Эмэгтэй алба хаагчийн ажлын гүйцэтгэлийг үнэлж, дүгнэхдээ Жендерийн ажлыг хэсгийг тухай бүр түр байгуулж, эмэгтэй алба хаагчийн оролцоотой дүгнэж байх.

- Энэ нь хорих байгууллагын удирдах албан тушаал, ахлагч бүрэлдэхүүний ажлын гүйцэтгэлийн үнэлж буй багт ихэвчлэн эрэгтэй алба хаагч байдаг, хүйсийн харилцааг тэнцүүлэх шаардлагатай гэж үзэж байна.

2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын эмэгтэй алба хаагч тэр дундаа ахлагч бүрэлдэхүүний ажлыг дүгнэхдээ хамт олны саналыг харгалзан үзэж дүгнэх талаар журамд тусгаж өгөх.

3. Эмэгтэй алба хаагчдын тэр дундаа ахлагч бүрэлдэхүүний ажлыг дүгнэхдээ албан тушаалын тодорхойлолт, ажлын байрт тохирсон бодит дүгнэлтийг хийх шаардлагатай. Үнэлгээний баг бодитой, үнэн зөв, шударгаар үнэлж, дүгнэсэн эсэх талаар алба хаагчаас сэтгэл ханамжийн асуулга авах, урамшууллын тогтолцоог бий болгох.

- Ингэснээр эмэгтэй алба хаагч хийж гүйцэтгэж буй ажилдаа сэтгэл хангалуун байх, үнэн зөв, шудрагаар, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл бүрдэнэ.

4. Эмэгтэй ахлагч бүрэлдэхүүний ажлын гүйцэтгэлийг хагас, бүтэн жилээр дүгнэхдээ дутагдалтай талыг олж илрүүлэн энэ чиглэлээр сургах, дадлагажуулах ажлыг тогтмол зохион байгуулах.

- Байгууллага амжилттай явах, зорилгодоо хүрэх чухал нэг алхам бол дунд болон бага бүрэлдэхүүний мэдлэг боловсрол, дадлага туршлага, хандлага, ёс зүй гэж үзэж байгаа учраас эмэгтэй алба хаагчийг сургах, дадлагажуулах асуудал чухал юм.

5. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хэмжээнд зөвхөн эмэгтэй ахлагч бүрэлдэхүүнд чиглэсэн мэргэжлийн сэтгэл зүйч нарыг ажиллуулах, ахлагч бүрэлдэхүүнийг сонгон шалгаруулахад сэтгэл зүйн чиглэлээр бодитой дүгнэлт гаргуулах, сургалтын хөтөлбөрт сэтгэл зүйн болон харилцааны чиглэлээр сургалтыг түлхүү оруулах.

6. Эмэгтэй ахлагч бүрэлдэхүүний ажлын гүйцэтгэлийг үнэлж, дүгнэх тусгай аргачлал, хүснэгтийг бий болгож сар бүрийн ажлыг дотооддоо дүгнэн нийт дүгнэгдсэн сарын нийлбэр дүнгийн дунджаар дүгнэдэг механизмыг нэвтрүүлэх.

- Жилийн 11 сард ямар нэгэн зөрчил дутагдал гаргалгүй ажиллаад 12 дугаар сард алдаа гаргахад тухайн алдаанд тулгуурлан үнэлгээг бууруулдаг асуудал байгууллагын үйл ажиллагаатай давхардал хийдэл байхгүй гэж үзэж байна.

“АРБИТРЫН ШИЙДВЭРИЙН ГҮЙЦЭТГЭХ АЖИЛЛАГААГ САЙЖРУУЛАХАД АНХААРАХ АСУУДЛУУД

“MATTERS TO CONSIDER IN IMPROVING THE EXECUTION OF ARBITRATION DECISIONS”

С.Бямба-Эрдэнэ

Дотоод хэргийн их сургуулийн багш, Их засаг олон улсын их сургуулийн доктрант, ахмад

Товч утга: Аль улсад гаргасснаас үл хамааран арбитрын үндсэн шийдвэрийг талууд заавал биелүүлэх бөгөөд харьяалах буюу хариуцагчийн оршин суугаа газрын иргэний хэргийн анхан шатны шүүхэд нэхэмжлэгч арбитрын шийдвэрийг албадан гүйцэтгүүлэх хүсэлтийг гаргаж, шүүхээс арбитрын шийдвэрийг баталгаажуулна. Шүүхээс албадан гүйцэтгэх захирамж, гүйцэтгэх хуудас бичиж, нэхэмжлэгчид олгодог.

Арбитрын шийдвэрийг шүүхийн шийдвэрийн нэгэн адил албадан гүйцэтгэхэд тулгамдаж буй асуудлуудын талаар өгүүлнэ.

Түлхүүр үг: Арбитр, төлбөр төлөгч, төлбөр авагч, шийдвэр гүйцэтгэх ажиллагаа

Нэгэн судалгаа сонирхуулахад 2022 оны 10 дугаар сарын байдлаар Монгол Улсын хэмжээнд 42181 гүйцэтгэх баримт бичгийн 2.8 их наяд төгрөгийг биелүүлэхээс 19076 гүйцэтгэх баримт бичгийн 595.8 тэрбум төгрөгийг бодитой биелүүлж, улсын дундаж биелэлт 45.2 хувьтай [1] байснаас арбитрын хэргийн шийдвэртэй гүйцэтгэх баримт бичиг 10 хүрэхгүй хувийг эзэлж байсан.

Арбитр нь үндсэн 4 төрлийн ажиллагаа явуулдаг үүнд:

1. Арбитрын хэлэлцээр байгуулах үед уг хэлэлцээрийн талууд өөр өөр улсад үйл ажиллагаа явуулж байгаа тохиолдолд хийгдэх арбитрын ажиллагаа;

2. Арбитрын хэлэлцээрт заасан, эсхүл түүнд тодорхойлсон арбитрын ажиллагааны харьяалал нь талуудын үйл ажиллагаа явуулж байгаа газраас өөр тохиолдолд хийгдэх арбитрын ажиллагаа;

3. Арилжааны харилцаанаас үүсэх үүргийн ихэнхийг гүйцэтгэх газар, эсхүл маргааны зүйлтэй илүү холбоотой газар нь талуудын үйл ажиллагаа явуулж байгаа газраас өөр тохиолдолд хийгдэх арбитрын ажиллагаа;

[1] Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харъяа Шийдвэр гүйцэтгэх албаны 2022 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 03/2722 дугаар албан бичгээр өгсөн мэдэгдэл;

4. Арбитрын хэлэлцээрээс үүсэх харилцаа нэгээс олон улсад хамаарна гэдгийг талууд тодорхой тохиролцсон тохиолдолд хийгдэх арбитрын ажиллагаа зэргийг ордог.

Арбитрын тухай хуулийн 43 дугаар зүйлд зааснаар 43.1-т "...Арбитрын ажиллагааны явцад талууд эвлэрсэн бол арбитрын бүрэлдэхүүн ажиллагааг дуусгавар болгох ба талууд ийнхүү хүсэлт гаргасныг арбитрын бүрэлдэхүүн татгалзаагүй бол эвлэрлийн нөхцөлийг арбитрын үндсэн шийдвэрт тусгаж баталгаажуулна..." гэж,

Мөн хуулийн 43 дугаар зүйлийн 43.2-т зааснаар "...Талууд эвлэрсэн тухай арбитрын үндсэн шийдвэр энэ хуулийн 44 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангасан байх ба арбитрын үндсэн шийдвэр мөн болохыг уг шийдвэрт тусгайлан заана. Уг шийдвэр нь арбитрын үндсэн шийдвэрийн адил хүчин төгөлдөр хэрэгжинэ…" гэж заажээ.

Арбитрын хэрэг хянан шийдвэрлэх дүрэм-ийн 25 дугаар зүйлийн 25.3. "...Эвлэрлийн гэрээг баталгаажуулсан шийдвэр нь арбитрын бүрэлдэхүүний хэрэг хянан шийдвэрлэсэн тухай шийдвэрийн адил хүчинтэй...гэж заасан.

Мөн дүрмийн 25 дугаар зүйлийн 25.4 "...Арбитрын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад талууд эвлэрүүлэн зуучлалын журмаар эвлэрэн хэлэлцэх хүсэлт гаргавал арбитрын бүрэлдэхүүн мэргэшсэн эвлэрүүлэн зуучлагчид хандах боломжийг талуудад олгоно..." гэж зааж өгсөнөөс харахад Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн эвлэрүүлэн жуучлах ажиллагаатай төстэй байдаг. Тухайлбал, Арбитр талуудын хүсэлтээр эвлэрлийн журмаар хэрэг хянан шийдвэрлэж, талуудын эвлэрлийг баталж шийдвэр гаргадаг.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 183, 184 дүгээр зүйлийн 184.3 дүгээр зүйлд зааснаар хариуцагч төлбөрөө сайн дураар төлөөгүй тохиолдолд шүүх нэхэмжлэгчийн хүсэлтээр албадан гүйцэтгэх захирамж, гүйцэтгэх хуудсыг бичиж олгодог.

Нэхэмжлэгч иргэн, хуулийн этгээдээс Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад хандахдаа эвлэрлийг баталсан шийдвэр, албадан гүйцэтгэх захирамж, гүйцэтгэх хуудсыг эх хувиар нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 118 дугаар зүйлд зааснаар шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардлын гэрээг байгуулж, хүсэлт гарган өгсөнийг цахим бүртгэлд оруулсанаар албадан гүйцэтгэх ажиллагаа явуулах үндэслэл бүрддэг.

Хариуцсан нэгжийн ахлах шийдвэр гүйцэтгэгч нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 21 дүгээр зүйлийг үндэслэн хүлээн авсан гүйцэтгэх хуудас, захирамжинд шийдвэр гүйцэтгэх ажиллагааг явуулах талаар үүсгэх тогтоолыг ажлын 3 хоногийн дотор гаргаж, хариуцсан тойргийн шийдвэр

гүйцэтгэгчид гүйцэтгэх баримт бичгийг хуваарилж шийдвэр гүйцэтгэх ажиллагааг эхлүүлдэг.

Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад төлбөр төлөгч иргэн, хуулийн этгээдэд сайн дураар төлбөр төлөх боломжит хугацааг олгох бөгөөд арбитрын хэрэг дээр нэгэн адил төлбөр төлөх боломжит хугацаа олгож сайн дураар төлбөрийг төлөөгүй тохиолдолд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 44 дүгээр зүйлд зааснаар албад гүйцэтгэх ажиллагааг явуулдаг.

Би Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт 2022 онд ажиллаж байх хугацаандаа арбитрын шийдвэртэй нийт 940.428 мян.төгрөгийн үнийн дүнтэй 4 гүйцэтгэх баримт бичгийн 737.803 мян.төгрөгийн 2 гүйцэтгэх баримт бичгийг дуусгавар болгосон.

Ажиллагаанд байгаа үлдэгдэл 202.625 мян.төгрөгийн 2 гүйцэтгэх баримт бичигт төлбөр төлөгч арбитрын шийдвэр гарсаны дараа хөрөнгө бусдад шилжсэн байдаг. Анхан шатны шүүхээс албадан гүйцэтгэх захирамж, гүйцэтгэх хуудас бичүүлж Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт хандсан байгаа нь төлбөр гаргуулахад хүндрэлтэй нөхцлийг үүсгэсэн.

Арбитрын шийдвэртэй гүйцэтгэх хуудсанд шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулах үед эвлэрлийг баталсан шийдвэрт заасан барьцаа хөрөнгийг дурьдаагүй тохиолдол цөөнгүй байдаг.

Сайн дураар төлбөр төлөх хугацааг тодорхой бичсэн шийдвэрт барьцаа хөрөнгийн мэдээлэл нь албадан гүйцэтгэх захирамж, гүйцэтгэх хуудсанд бичигдээгүйгээс шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулах үед зөвхөн барьцаа хөрөнгө гэж үзэхгүйгээр төлбөр төлөх боломжит бүх аргаар шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулдаг. Тухайлбал,

Төлбөр төлөгч иргэн, хуулийн этгээдийн банк дахь дансыг битүүмжлэх, хасалт хийх, шинээр данс нээх, хаах, эзэмших эрхийг хориглох тухай тогтоолыг банкуудад хүргүүлэх, үнэт цаас, тээврийн хэрэгсэл, тусгай зөвшөөрлийн эрх, эзэмшил, өмчлөлийн газар, үл хөдлөх эд хөрөнгийн захиран зарцуулах эрхийг түдгэлзүүлэх, үзлэг нэгжлэгээр илэрсэн хөдлөх эд хөрөнгийг битүүмжилж, хураах, шаардах эрх, цалин хөлс, түүнтэй адилтгах бусад орлогоос суутгал хийх, хуулийн этгээдийн хувьцаа эзэмшигчийн хувьд ногдох хувьцааны хэмжээгээр улсын бүртгэлд өөрчлөлт оруулах эрхийг түдгэлзүүлэх зэрэг тодорхой ажиллагааг явуулдаг.

2. Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад хөрөнгийн үнэлгээ, шийдвэр гүйцэтгэх ажиллагаатай холбогдуулан талуудаас болон гуравдагч этгээд буюу хөрөнгийн өмчлөгч, эзэмшигчээс шүүхэд гаргаж байгаа гомдлын тоо их байдаг. Үүнээс шалтгаалан шүүх шийдвэр гүйцэтгэх ажиллагааг болон хөрөнгийн үнэлгээг хүчингүй болгох нь цөөнгүй байдаг. Шүүх, арбитраас шийдвэр гүйцэтгэх

ажиллагааг хянаж гомдлыг хянах хүртэл хүртэл гурван шатны шүүх хурлаар дамжин явсаар арбитрын шийдвэр, захирамж биелэгдэхгүй уддаг.

Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт талуудаас хөрөнгийн үнэлгээнд холбогдуулан гаргасан шүүхэд хянагдсан нэхэмжлэлийн тоо 2020 онд 111 байснаас нэхэмжлэлийг хангаж, үнэлгээг хүчингүй болгосон 21, нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгосон 85, нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан 5 тохиолдол байна.

Харин 2021 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн байдлаар 216 байснаас нэхэмжлэлийг хангаж, үнэлгээг хүчингүй болгосон 26, нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгосон 181, нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан 9 тохиолдол байна[1]. Монгол Улсын олон улсын гэрээнд заасан бол гадаад улсын шүүх, олон улсын шүүх, арбитрын шийдвэр, захирамжинд албадан гүйцэтгэх ажиллагаа явуулах явцад талуудаас хөрөнгийн үнэлгээ болон шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талаар гаргасан гомдлыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 122 дугаар зүйлийн 122.5-д заасны дагуу гүйцэтгэх хуудас олгосон шүүхэд гаргадаг.

Гүйцэтгэх хуудас олгосон шүүхийн шүүгч нь иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талаарх гомдлыг хүлээн авч, иргэний хэрэг үүсгэхээсээ өмнө шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хувийн хэрэг буюу гүйцэтгэх баримт бичгийг татаж хянах тогтолцоо байхгүй байгаа нь шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талаарх үндэслэлгүй гомдол гаргаж арбитрын шийдвэр биелэгдэхгүй байх нэг нөхцөл болдог.

3. Арбитраас эвлэрлийг баталсан шийдвэрийг биелүүлэхэд төлбөрийн шаардлага нь өндөр үнийн дүнтэй буюу 50 сая ба түүнээс дээш үнийн дүнтэй байх нь түгээмэл байдаг.

2002 онд батлагдсан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулинд 2014 оны 12 дугаар сард нэмэлт орж мөн хуулийн 133 дугаар зүйлийн 133.4.4-т зааснаар төлбөр төлөгчийн гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлж эхэлсэн байдаг.

Харин 2017 онд батлагдаж, одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулинд 2020 оны 01 дүгээр сард нэмэлт орж мөн хуулийн 59 дүгээр зүйлд зааснаар 50 сая төгрөгнөөс дээш хөрөнгийн шаардлага бүхий гүйцэтгэх баримт бичгийн шаардлагыг тогтоосон хугацаанд биелүүлээгүй эрэн сурвалжлагдаж байгаа, эсхүл төлбөр төлөхөөс санаатай зайлсхийсэн, хөрөнгөө нуун дарагдуулсан, төлбөр төлөхөөс зайлсхийх зорилгоор гадаад улсад оргон зайлж болзошгүй гэсэн үндэслэлээр гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэхээр

[1] Б.Даваасүрэн.”Шинжээчийн хөрөнгийн үнэлгээ тогтоох үйл явц, эрх зүйн зохицуулалтын шинэчлэл”, Иргэн захиргааны шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн шинэтгэл сэдэвт хурлын илтгэлийн эмхэтгэл.,УБ.,2021 он., 42 дахь тал;

хуульчилсан. Гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлж эхэлсэнээр төлбөр төлөгч төлбөрөө төлөх хөшүүрэг болсон. Тухайлбал,

Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын хэмжээнд 2020 онд 2732 гүйцэтгэх баримт бичигт холбогдох 2162 иргэн, хуулийн этгээдийн хувьцаа эзэмшигч гүйцэтгэх удирдлагын гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлснээс шүүхийн шийдвэрт заасан төлбөрөө бүрэн төлсөн 52 гүйцэтгэх баримт бичгийн 61 төлбөр төлөгч иргэн хуулийн этгээдийн хувьцаа эзэмшигчийн гадаадад зорчих эрхийг сэргээснээс 7 гүйцэтгэх баримт бичиг арбитрын шийдвэртэй, 9 төлбөр төлөгч иргэн-хуулийн этгээдийн хувьцаа эзэмшигч байсан[1].

Мөн НШШГГ-ын 2021 оны 5 дугаар сарын байдлаар 510 этгээдийн гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлсэнээс 94 этгээд төлбөрөө төлж эрхээ сэргээлгэж, төлбөрөө төлөөгүй 3 иргэн шүүхэд гомдол гаргаж гадаадад зорчих эрхээ сэргээлгэх шийдвэр гаргуулж 2 нь гадаадад гарч, одоог хүртэл хугацаанд Монгол Улсын хилээр нэвтрээгүй байна[2].

Мөн гүйцэтгэх баримт бичигт шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулах явцад төлбөр төлөгч, хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлага, хувьцаа эзэмшигчийн гадаадад зорчих эрхийг төлбөрийн шаардлагыг биелүүлэх хүртэл хугацаанд түдгэлзүүлдэг боловч төлбөр төлөгч иргэн-хуулийн этгээдийн хувьцаа эзэмшигчээс шүүхэд гомдол гаргах тохиолдол гардаг. Арбитрын эвлэрлийг баталсан шийдвэрт заасан хугацаандаа төлбөрөө хуваагаад төлөхгүй байгаа нь төлбөр төлөхөөс санаатай зайлсхийж байгаа үйлдэл гэж үзэхээр байхад шүүх нотлох баримт хангалтгүй, хуульд заасан үндэслэл бүрдээгүй, эсхүл мэдэгдэлгүй хилийн хориг тавьсан гэж үзээд гадаадад зорчих эрхийг сэргээх шийдвэр гаргах, үүнээс болоод Монгол улсын хилээр гарснаас болоод шийдвэр гүйцэтгэх ажиллагаа удааширч улмаар төлбөр төлөгч, иргэн, хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлага, хувьцаа эзэмшигчийг Монгол улсын хилээр нэвтрэх хүртэл шийдвэр гүйцэтгэх ажиллагааг зогсоож түдгэлзүүлэхэд хүрдэг нь харамсалтай.

4. Шүүхээс гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах үүднээс шүүгч, арбитрч нь хуульд заасны дагуу хөрөнгө хамгаалах, тодорхой үйлдэл хийхгүй байхыг даалгах, нотлох баримт хамгаалах буюу гаргуулах зэрэг тодорхой ажиллагаа явуулахыг даалгасан шийдвэр гарган Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт хүргүүлж болно.

Арбитрын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-т “...Арбитрын ажиллагаа эхлэхээс өмнө, эсхүл уг ажиллагааны явцад арбитраас гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах энэ хуулийн 19.2-т заасан арга хэмжээ авахуулахаар

[1] Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын Тоо бүртгэлийн хэлтсийн 2020 оны 12 дугаар сарын судалгаа;

[2] Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын Тоо бүртгэлийн хэлтсийн 2021 оны 5 дугаар сарын судалгаа;

шүүхэд хүсэлт гаргасан, шүүх уг хүсэлтийг хангасан шийдвэр гаргасан нь арбитрын хэлэлцээрийг зөрчсөнд тооцогдохгүй...” гэж заажээ.

Арбитраас гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах арга хэмжээ авч шийдвэрийг эх хувиар нь баталгаат шуудангаар эсхүл бичиг хүргэгчээр хүргүүлэхэд хугацаа алддаг тул цахим хэлбэрт шилжүүлж, нэн даруй ирүүлж, дараа нь эх хувийг нь хүргүүлдэг болох хэрэгцээ шаардлага бий болсон.

Ялангуяа арбитрын шийдвэрийг эх хувиар нь хүлээн авсаны дараа шийдвэр гүйцэтгэгч баталгаажуулах арга хэмжээг авах хооронд хөрөнгө үрэгдэх, устах, захиран зарцуулах эрх бусдад шилжиж хөрөнгийг хамгаалж чадахгүй байх нөхцөл байдал үүсэх эрсдэл өндөр байдаг. Мөн нотлох баримтыг хамгаалахад хугацаа алдсанаас болж хүндрэл үүсч болно.

ДҮГНЭЛТ

Арбитр шийдвэрийг албадан гүйцэтгэх ажиллагаа нь иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны нэг хэлбэр бөгөөд шүүх, арбитр болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын салшгүй уялдаа холбоонд хэрэгжиж байна.

Арбитрын шийдвэрт заасан тодорхой төрлийн барьцаа хөрөнгийн мэдээллийг гүйцэтгэх хуудас олгох шүүх нь дурьдаж бичдэг болох шаардлага бий.

Иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг боловсронгуй болгоход арбитрын шийдвэрт гүйцэтгэх хуудас олгосон шүүх хөрөнгийн үнэлгээг хүчингүй болгуулах болон иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талаарх гомдлыг хүлээн авахаасаа өмнө гүйцэтгэх баримт бичгийг татаж хянах, шийдвэрийн биелэлтэнд хяналт тавих тогтолцоог бүрдүүлж, хүлээн авах ёстой гомдол мөн эсэхийг шалгаж, шаардлагатай тохиолдолд нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалздаг болох хэрэгтэй.

Мөн гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх талаар мэдэгдлийг төлбөр төлөгч иргэн-хуулийн этгээдийн хувьцаа эзэмшигчид биечлэн гардуулах гэж төлбөр төлөгчийг хайж, олох асуудлыг зогсоож, цахим шуудангаар эсхүл гар утсаар нь мэдэгдэж нэн даруй түдгэлзүүлж болох эрх зүйн орчныг бүрдүүлж, гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлсэн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хүчингүй болгуулах нэхэмжлэлийг шүүх хүлээн аваад шүүх нотлох баримт хангалтгүй, хуульд заасан үндэслэл бүрдээгүй, эсхүл мэдэгдлийг биечлэн гардуулаагүй, оргон зайлах үндэслэл бүрдээгүй гэх үндэслэлээр шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хүчингүй болгох явдлыг зогсоож, эвлэрлийг баталсан шийдвэрт заасан хугацаанд төлбөрийг хувааж төлөөгүй явдлыг төлбөр төлөхөөс санаатай зайлсхийж байгаа үйлдэлд тооцож төлбөр төлөгчийг оргон зайлахаас урьдчилан сэргийлэх хэрэгтэй юм.

Мөн Арбитраас гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах арга хэмжээг боловсронгуй болгож шийдвэрийг цахим хэлбэрээр шүүхийн шийдвэр

гүйцэтгэх байгууллагад хүргүүлэхээс гадна гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх арга хэмжээг шаардлагатай тохиолдолд шийдвэр гарахаас өмнө хэрэгжүүлдэг болох эрх зүйн орчныг бүрдүүлж чадвал хариуцагч, төлбөр төлөгч нь гадаад улс руу оргон зайлахаас урьдчилан сэргийлэх боломж бүрдэх болно.

САНАЛ

1. Арбитрын шийдвэрт заасан тодорхой төрлийн барьцаа хөрөнгийн мэдээллийг албадан гүйцэтгэх захирамж, гүйцэтгэх хуудсанд тодорхой зааж бичих,

2. Арбитр гаргасан шийдвэрийн биелэлтэд хяналт тавих

3. Шүүх хөрөнгийн үнэлгээг хүчингүй болгуулах болон иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талаарх гомдлыг хүлээн авахаасаа өмнө гүйцэтгэх баримт бичгийг татаж хянах, шийдвэрийн биелэлтэд хяналт тавих тогтолцоог бүрдүүлэх,

4. Арбитраас гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах арга хэмжээ авахыг даалгасан шийдвэрийг цахим хэлбэрээр хүргүүлэх нөхцөлийг бүрдүүлэх,

5. Гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх албадлагын арга хэмжээг арбитраас гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах арга хэмжээний нэг төрөл болгон авч үзэх, биечлэн мэдэгдэх шаардлагагүйгээр гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх

Судлаач сонсогч, оюутан, суралцагч

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ЭМЭГТЭЙ ХҮМҮҮЖИГЧ НАРТ ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ, ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМ

PROBLEMS AND SOLUTIONS FOR WOMEN WITH DISABILITIES

Н.Удвалцэцэг

Дотоод хэргийн их сургуулийн докторант, хошууч

Товч агуулга: Аливаа судалгааны ажил нь нийгэмд тулгамдаад буй тухайлсан асуудалд чиглэж, тодорхой шийдэл, чиг баримжаа гаргахыг зорьж байдаг. Энэхүү илтгэлээр хорих ял шийтгүүлсэн хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэй хүмүүжигч нарын эрх зүйн байдалд бодит дүн шинжилгээ хийж, тэдэнд тулгамдаж буй асуудлыг нээн илрүүлж, шийдвэрлэх арга замыг эрэлхийлэхийг зорьлоо.

Түлхүүр үг: Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх зүйн байдал, нийгмийн хамгаалал, боловсролын асуудал, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах асуудал, хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн амьдралд нийгмийн амьдралд тэгш хүртээмжтэй оролцох боломж.

Удиртгал:

Мэдээлэл, технологийн 21 дүгээр зуунд нийгмийн бүхий л салбарт хүний эрхийг хуулиар хангах асуудалд анхаарал хандуулж, судалгаа, шинжилгээний бүтээлийг олон эрдэмтэн, судлаачид бүтээл туурьвиж, нийтийн анхааралд хүрэхийн хирээр төр засгийн болон төрийн бус байгууллагад олон шинэ санаачилгат төсөл, хөтөлбөрүүд зохих төвшинд хийгдэж, энэ чиглэлийн салбар эрчимтэй хөгжиж байна .

Засгийн газар, хариуцсан чиг үүргийн байгууллагын зүгээс хүний эрхийг хангах чиглэлээр олон төрлийн ажил, арга хэмжээг зохион байгуулж, нийгэм олон нийтэд хүрч байгаа хэдий ч хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах, тэдэнд тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх ажил цаг үеэсээ хоцрогдсон, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр "...ярианы хэлийг дохионы хэлмэрч тайлбарлах, төрийн байгууллага, аж ахуй нэгжийн үүдний хэсэгт налуу шат байрлуулахаас өөр төвшинд хүрээгүй, бодлогын хэмжээнд анхаарал хандуулж, шинжлэх ухааны төвшинд судалж, цаашдын чиг баримжааг тодорхойлох зайлшгүй шаардлагатай..." гэж судлаачийн зүгээс үздэг.

Энэ ч утгаараа хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг бүх төвшинд хангах, тэр дундаа "...хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэй хүмүүжигч нарын эрхийг хамгаалах, нийгмийн баталгааг хангах, тэднийг сурч боловсрох, нөхцөл бололцоогоор хангах, эрх зүйн шинэтгэлийн хүрээнд тулгарч буй асуудлыг шийдвэрлэх...." цаг үеийн шаардлага байна гэж үзсэн бөгөөд "...Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэй хүмүүжигч

нарт тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга зам...” ерөнхий сэдвийг дараах 3 асуудлын хүрээнд тоймлон авч үзсэн.Үүнд:

1.Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэй хүмүүжигч нарын нийгмийн асуудлыг шийдвэрлэх чиглэлээр зохион байгуулсан ажил, арга хэмжээ, өнөөгийн нөхцөл байдал.;

2.Хөгжлийн бэрхээлтэй эмэгтэй хүмүүжигч нараас авсан судалгааны дүн,

3.Дүгнэлт, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ.

Нэг. Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэй хүмүүжигч нарын нийгмийн асуудлыг шийдвэрлэх чиглэлээр зохион байгуулсан ажил, арга хэмжээ, өнөөгийн нөхцөл байдал.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь мэргэжлийн олон төрлийн албадыг багтаасан, үйл ажиллагааны чиглэл тус бүр өөрийн өвөрмөц онцлог шинжтэй, 100 гаруй жилийн баялаг түүхтэй байгууллага бөгөөд хуулиар хүлээсэн чиг үүргийн хүрээнд шүүхийн хүчин төгөлдөр шийдвэр, тогтоолын дагуу “эрүү, иргэн, захиргаа”-ний хэргийн шийдвэрийг хэрэгжүүлэн ажиллаж ирсэн .

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харъяа 407 дугаар нээлттэй хаалттай хорих анги нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай Монгол Улсын хуульд зааснаар хорих ялыг биечлэн эдлүүлэхээс гадна “...хорих ял шийтгүүлсэн эмэгтэй хүмүүжигч нарын гэмт санаа бодлыг арилгах, засан төлөвшүүлэх, ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, их дээд сургуульд элсэн суралцуулах...” боловсролын байгууллагын чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Тус хорих анги нь хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэй хүмүүжигчийг “...ажлыг байраар хангах, мэргэжил эзэмшүүлэх, нийгмийн баталгааг хангах...” чиглэлээр шат дараатай ажил эхлүүлж, тэдэнд чиглэсэн зорилтот хөтөлбөрийг дэвшүүлж, хорих ангид хуваарилагдаж ирсэний дараа 50-60 хувьд нь “...тогооч, оёдолчин, оёдолын мастер...” зэрэг мэргэжлийг эзэмшүүлж, 80-90 % ажлын байраар хангасан байна.

Хүснэгт 1. Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэй хоригдлын эзлэх хувь.

Хүснэгт 2. Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэй хоригдлын гэмт хэрэг үйлдсэн тоо, давтамж

Энд дурдсанчлан тус ангийн удирдлагын зүгээс хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэй хүмүүжигч нарын “...ажил хөдөлмөр эрхлэх, сурч боловсрох эрхийг хангах, нийгмийн баталгааг хангах...” хүрээнд “...хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэй хүмүүжигч нарт хорих ангид ирсэний дараа мэргэжил эзэмшүүлж, ажлын байраар хангаж байгаа ч тэдэнд тохирсон ажлын байр хомс, хөдөлмөр чадвар алдалтын хувь

өндөр, ар гэрийн эргэлт, холбоо байхгүй, суллагдсаны дараа хүлээн авах орчин байхгүй...” зэргээс давтан гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлэх асуудал буурахгүй байгаа нь судлаач миний анхаарлыг ихээхэн татаж байгаа юм.

Хүснэгт 3. Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэй хүмүүжигч нарын хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ.

Тус байгууллагад хорих ял эдэлж буй хөдөлмөрийн бэрхшээлтэй хүмүүжигчдийн – 23% нь хөдөлмөрийн чадвараа 50 – 60 алдсан, – 32 % 61 – 70 алдсан, – 45% орчим хувь нь 71 – 80 хувийн алдагдалтай байгаа нь байгууллагын зүгээр ажлын байраар хангасан хэдий ч хөдөлмөрийн алдагдалын хувь хэмжээ их байгаагаас шалтгаалж, ажлын бүтээмж муу байхын зэрэгцээ болзошгүй ажлын осол, эрсдэл гарах магадлал их болохыг илтгэн харуулж байна.

Хоёр. Хөгжлийн бэрхээлтэй эмэгтэй хүмүүжигч нараас авсан судалгааны дүнгийн талаар.

407 дугаар нээлттэй хаалттай хорих ангийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүжигч нарт тулгамдаж буй асуудал болон сургалт, нөлөөллийн үйл ажиллагаанд ашиглагдаж буй техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн хүртээмж, хэвийн ажиллагааны талаар судалгаа авсан. Үүнд:

Хорих ял эдэлж буй хөдөлмөрийн бэрхшээлтэй эмэгтэй хүмүүжигчдийн – 23% нь 20-30 настай, – 32% орчим хувь нь 31 – 40 настай, 46% нь 51 –ээс дээш настай, – 45% нь 41 – 50 настай хоригдлууд байгаа болон дундаас дээш хувийг 51-ээс дээш насныхан эзэлж байгаа нь цаашид насны онцлогоос хамаарч хөдөлмөр алдалтын хувь хэмжээг нэмэгдэж боломжтой байгааг харуулж байна.

Хүснэгт 4. Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэй хүмүүжигч нарын насны хэмжээ

Танд хуульд заасан эрхээ эдэлж, үүргээ хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудлыг нэрлэнэ үү? Гэсэн асуултад суллагдсаны дараа нийгэмд хүлээн авах орчин байхгүй –50%, өөрт тохирсон ажил байхгүй –40%, бусадтай ойлголцоход хүндрэлтэй байдаг –10% гэсэн хариултыг тус тус сонгосон байна.

Хүснэгт 5. Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэй хүмүүжигч нарт тулгамдаж буй асуудлуудын дараалал.

Сургалт, нөлөөллийн үйл ажиллагаанд ашиглагдаж буй техник хэрэгслийн хүртээмж хангалттай түвшинд байдаг уу? гэсэн асуултад хүртээмж муутай, нэмэгдүүлэх шаардлагатай – 80 хувь, хэвийн хүрэлцээтэй байдаг – 10, үлдсэн 10 хувь нь тодорхой хариулж мэдэхгүй байна гэсэн байна.

Байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж буй техник хэрэгсэл, тоног төхөөрөмжууд нь чанарын шаардлагад нийцэж байгаа эсэх? Гэсэн асуултад 70.0

хувь нь чанарын шаардалагад нийцдэггүй, үзүүлэлт муутай, 18.0 хувь нь техник, хэрэгсэл, тоног төхөөрөмжийн чанар, үзүүлэлт муу, 12.0 хувь тодорхой үнэлгээ өгөх боломжгүй гэсэн хариултыг тус тус сонгосон байна.

Хүснэгт 6. Сургалт, нөлөөллийн ажилд ашиглаж буй техник хэрэгслийн чанар, хүртээмжид хийсэн сэтгэл ханамжийн судалгаа.

Сургалт, нөлөөллийн үйл ажиллагаанд ашиглагдаж буй техник, хэрэгслийн ажиллагаанд сэтгэл ханамж ямар түвшинд байдаг вэ? гэсэн асуултад 81 хувь нь сэтгэл ханамж муу, хоцрогдсон, шинэчлэх шаардлагатай 10 хувь нь хэвийн ажиллагаатай, техникийн шаардагад нийцсэн гэсэн бол үлдсэн 9.0 хувь нь тус байгууллагын техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн үйл ажиллагаанд тодорхой үнэлгээ өгөөгүй гэсэн дүн судалгаа гарсан байна.

Гурав. Дүгнэлт

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага тэр дундаа 407 дугаар нээлттэй, хаалттай хорих анги нь “...анх хуваарилагдан ирэхдээ эзэмшсэн мэргэжилгүй байсан хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэй хүмүүжигч нарыг 50-60 хувьд мэргэжил эзэмшүүлсэн, 100 хувь ажлыг байраар хангаж, тогтоосон хэмжээгээр цалин олгож, санхүүгийн асуудлыг шийдвэрлэж байгаа...” зэргээс Монгол Улсын Үндсэн хуульд заасан “...сурч боловсрох, ажиллах, хөдөлмөрлөх...”-ийг бүрэн хангаж, хуулиар хүлээсэн үүргээ бүрэн хэрэгжүүлсэн гэж үзэж болохоор байна.

Гагцхүү хорих ял эдлүүлэх байгууллагад хангагдаж буй хүний хуулиар хязгаарлаагүй “...сурч боловсрох, ажил хөдөлмөр эрхлэх, ялгаварлан гадуурхахгүй байх...” зарим эрхүүд эрх чөлөөт нийгмийн амьралд бүрэн хангагдаж чадахгүй байгаа нь “...хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэй хүмүүжигч нар суллагдсаны дараа дахин гэмт хэрэг үйлдэх тохиолдол буурахгүй байгаа, нийгэмд тохирсон ажлыг байр олдохгүй байх, бусадтай ойлголцоход хүндрэлтэй байдаг...” зэргээс тодорхой харагдаж байна.

Монгол улсын эдийн засгийн тогтворгүй байдал, сүүлийн жилүүдэд хурдацтай өссөөр байгаа инфляцийн төвшин, төсвийн таналт, батлагдсан төсөв хүрэлцдэггүй зэрэг санхүүгийн хүчин зүйлээс хамаарсан “хүндрэл, бэрхшээл” бүхий л төрийн байгууллагын үйл ажиллагаанд тулгамдаж байгаатай адил 407 дугаар нээлттэй, хаалттай хорих ангид ч мөн тулгамдаж байна.

Дээр дурдсан санхүүгийн хүчин зүйлээс үүсэн асуудал болон “...эмэгтэй хүмүүжигч нарын сурч боловсрох, хөдөлмөрлөх, ар гэртэйгээ байнгын цахимаар харилцаа, холбоотой байх, хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэй хоригдогч нарын сургалт, боловсролын үйл ажиллагаанд ашиглах техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн “...хүрэлцээг нэмэгдүүлэх, чанарыг сайжруулах...” цаг үеийн шаардлага байгаа бөгөөд энэ ажилд төрийн болон төрийн бус байгууллагуудын дэмжлэг, туслалцаа нэн чухал шаардлагатай болоод байна.

Дөрөв. Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ, санал

- Хэвлэл, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах чиглэлээр мэдээ, мэдээллийг тогтмол хүргэх, энэ чиглэлийн ажлыг олон нийтэд хүргэх, сурталчилах;

- Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэй хүмүүжигчийн сулагдсаны дараа нийгэмд дасгах, ажил олгогчид зуучлах, ажлын байраар хангах асуудлыг Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн газартай хамтран шийдвэрлэх;

- Хөгжлийн бэрхшээлтэй хорих ял шийтгүүлсэн хүмүүжигчийг сурч боловсрох эрхийг хангах хүрээнд сургалтын үйл ажиллагаанл ашиглаж буй тоног төхөөрөмжийг хүрэлцээг сайжруулах арга хэмжээг шат дараатай авч хэрэгжүүлэх;

- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар болон Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн газар хооронд хамтран ажиллах санамж бичиг боловсруулах, хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэй хүмүүжигчийн эрхийг хангах бодлогын баримт бичиг боловсруулах, төсөл, хөтөлбөрүүдэд энэ талаар тусгах.

ЦАГ ҮЕ, ҮЙЛ ЯВДАЛ

1. Дотоод хэргийн их сургуулийн баг тамирчид гардан тулааны Ази тивийн аварга шалгаруулах тэмцээнд амжилттай оролцлоо

Бүгд найрамдах Киргиз улсын Бишкек хотод Гардан тулааны Ази тивийн аварга шалгаруулах тэмцээн 2024 оны 09 дүгээр сарын 12-16-ны өдрүүдэд зохион байгуулагдлаа. Энэхүү тэмцээнд Ази тивийн 16 улсын 300 гаруй тамирчин эрэгтэй 19 жин, эмэгтэй 12 жинд хурд хүч, авхаалж самбаа, техник ур чадвараа сорин өрсөлдсөн юм.

Тэмцээний өөрийгөө хамгаалах төрөлд 18-37 насны ангилалд Дотоод хэргийн их сургуулийн Цагдаагийн сургуулийн 338 дугаар дамжааны сонсогч Ө.Өлзийбат +90 кг-ийн жинд алтан медаль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн 542 дугаар дамжааны дэд түрүүч Б.Урангоо 70 кг-ийн жинд, Цагдаагийн сургуулийн 338 дугаар дамжааны сонсогч О.Арман 70 кг-ийн жинд мөнгөн медаль, мөн дамжааны сонсогч Э.Лхагва-Очир 90 кг, П.Мөнхжин 80 кг-ийн жинд тус тус хүрэл медаль хүртсэн юм.

Их сургуулийнхаа 90 жилийн ойн босгон дээр Гардан тулааны Ази тивийн аварга шалгаруулах тэмцээнээс Их сургуулийн баг тамирчид 7 медаль хүртэж, Биеийн тамир, албаны бэлтгэлийн институтийн ахлах багш, хошууч Х.Оналбек, Цагдаагийн сургуулийн 338 дугаар дамжааны сонсогч Ө.Өлзийбат нар Их сургуулиас төрөн гаргасан анхны Ази тивийн аваргууд болж, Бүгд Найрамдах Киргиз Улсын Бишкек хотноо эх орныхоо төрийн дууллыг эгшиглүүлсэнд баяр хүргэж, спортын их амжилт хүсье.



2. ДОКТОРЫН ДИПЛОМ ГАРДУУЛЛАА

Докторын судалгааны ажлаа амжилттай хамгаалсан Удирдлагын академийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн удирдлага, стратегийн тэнхимийн ахлах багш, дэд хурандаа Ч.Батболд, Цагдаагийн сургуулийн Эрүүгийн процессын эрх зүйн тэнхимийн ахлах багш, цагдаагийн хошууч Н.Сайнбаяр, Сургалт, судалгааны 403 дугаар анги-Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн Ял эдлүүлэх эрх зүйн тэнхимийн ахлах багш, хошууч Д.Буяннэмэх нарт Дотоод хэргийн их сургуулийн захирал, доктор (Ph.D), профессор, цагдаагийн хурандаа П.Батбаатар хууль зүйн докторын зэргийн дипломыг өнөөдөр (2024.09.27) гардууллаа.

Дотоод хэргийн их сургуулийнхаа түүхт 90 жилийн ойн босгон дээр докторын зэргийн дипломоо гардаж авсан докторуудаа халуун баяр хүргэж, цаашдын судалгаа шинжилгээний ажилд нь өндөр амжилт хүсье.





3. БАГШ, АЛБАН ХААГЧДАД ХУГАЦААНЫ ЦОЛ ОЛГОЛОО

Дэлхийн багш нарын 30 дахь, Монголын багш нарын 58 дахь өдөр болон Дотоод хэргийн их сургуулийн түүхт 90 жилийн ойг тохиолдуулан эрхэлсэн ажилдаа идэвх зүтгэл, үр бүтээл гарган хамт олноо манлайлан идэвх санаачилгатай ажиллаж байгаа Дотоод хэргийн их сургуулийн албан хаагчдад өнөөдөр (2024.09.27) цол гардууллаа.

📌”Хошууч” цолоор:

- Сургалт, судалгааны 403 дугаар анги-Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн Иргэний шийдвэр гүйцэтгэлийн тэнхимийн ахлах багш, ахмад Б.Замбага

- Сургалт, судалгааны 403 дугаар анги-Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн Аюулгүй байдлын тэнхимийн ахлах багш, ахмад З.Түвшинжаргал

📌”Ахлах дэслэгч” цолоор:

- Сургалт, судалгааны 403 дугаар анги-Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн Иргэний шийдвэр гүйцэтгэлийн тэнхимийн багш, дэслэгч Б.Дэнсмаа

Эрхэлсэн ажилдаа амжилт гарган цол шагнагдсан багш, албан хаагчдадаа халуун баяр хүргэе.





4. ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛИЙН ТҮҮХТ 90 ЖИЛИЙН ОЙН БАЯРЫН ХУРАЛ БОЛЖ БАЙНА

Дотоод хэргийн их сургуулийн түүхт 90 жилийн ойн баярын хурал Соёлын төв ордонд эхэллээ.

Түүхт 90 жилийн ойн баярын хуралд Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч У.Хүрэлсүх, Монгол Улсын Их Хурал, Засгийн Газрын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэл, Монгол Улсын Их хурал, Засгийн Газрын гишүүн, Боловсролын сайд П.Наранбаяр, УИХ-ын гишүүн, Хууль зүйн байнгын хорооны дарга Д.Цогтбаатар, УИХ-ын гишүүн Э.Бат-Амгалан, УИХ-ын гишүүн Б.Энхбаяр, Дотоод хэргийн их сургуулийн захирал, доктор, профессор, бригадын генерал П.Батбаатар, Захирлын зөвлөлийн гишүүд, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга А.Бямбажаргал, Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Л.Энхбилэг, Улсын Их Хурлын дарга, Хууль зүй, дотоод хэргийн сайдын албан тушаал хашиж байсан Ц.Нямдорж, Монгол Улсын Их Хурлын даргын хуулийн зөвлөх Н.Отгончимэг, Монгол Улсын Ерөнхий сайдын зөвлөх Л.Төр-Од болон Хууль зүй, дотоод хэргийн яам, Батлан хамгаалах яам, Боловсролын яам, Сангийн яамны удирдлага, Монгол Улсын төрийн цэргийн болон хууль сахиулах салбарын агентлаг, байгууллагын удирдлага, төлөөлөл, хамтын ажиллагаатай Монголын их, дээд сургууль, сургалт, эрдэм шинжилгээний байгууллагын удирдлага, Гадаад улсуудын төрөл мэргэжлийн их, дээд сургуулийн удирдлага, зочид, төлөөлөгчид, Монгол Улсад суугаа гадаад улсын Элчин сайдын яамд, олон улсын байгууллагын удирдлагууд, Дотоод хэргийн их сургуулийн ахмад ажилтан, эрдэмтэн багш, албан хаагч, сонсогч суралцагчид оролцож байна.

Дотоод хэргийн их сургуулийн эрхэм бахархал болсон ахмад ажилтан, эрдэмтэн багш, албан хаагч, сонсогч, суралцагчид, үе үеийн төгсөгчид та бүхэндээ түүхт ойн баярын мэнд хүргэе.





5. ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛИЙН 90 ДЭХ ХИЧЭЭЛИЙН ШИНЭ ЖИЛИЙН НЭЭЛТ БОЛЛОО

Хууль зүй, дотоод хэрэг, аюулгүй байдлыг хангах салбарын хүний нөөцийг 90 жилийн турш тасралтгүй бэлтгэж ирсэн Сүхбаатарын одон, Байлдааны гавьяаны болон Цэргийн гавьяаны улаан тугийн одонт Дотоод хэргийн их сургуулийн 2024-2025 оны хичээлийн шинэ жилийн нээлт Их сургуулийн жагсаалын талбайд өнөөдөр (2024.10.07) ёслол төгөлдөр боллоо.

Нээлтийн ажиллагаанд Дотоод хэргийн их сургуулийн захирал, доктор, профессор, бригадын генерал П.Батбаатар, Тэргүүн дэд захирал, доктор, профессор, цагдаагийн хурандаа Д.Эрдэнэбаатар, Дэд захирал, доктор, цагдаагийн хурандаа Б.Эрдэнэбат, Дэд захирал бөгөөд штабын дарга, цагдаагийн хурандаа Г.Буянхишиг болон Захирлын зөвлөлийн гишүүд, эрдэмтэн багш, албан хаагч, сонсогч, суралцагч, сурагчид оролцов.

Сүхбаатарын одон, Байлдааны гавьяаны болон Цэргийн гавьяаны улаан тугийн одонт Дотоод хэргийн их сургуулийн туг, Монгол Улсын Баатар, ахмад С.Лхагвадоржийн нэрэмжит Хилийн албаны сургууль, Хилийн цэргийн 0345 дугаар ангийн байлдааны тугийг хүндэтгэн залснаар нээлтийн ажиллагаа эхэллээ.

Энэ үеэр Дотоод хэргийн их сургуулийн захирал, доктор, профессор, бригадын генерал П.Батбаатар:

“Их сургуулийн түүхт 90 жилийн ойг тэмдэглэх хүрээнд бүтэн 2 жил үргэлжилсэн 90 бүтээлч ажлыг амжилттай зохион байгуулахад сэтгэл зүтгэл гарган ажилласан нийт эрдэмтэн багш, албан хаагч, сонсогч, суралцагчид та бүхэндээ Их сургуулийн эрдмийн хамт олны нэрийн өмнөөс болон хувиасаа чин сэтгэлийн талархал илэрхийлье.

Их сургууль үүсэн байгуулагдсаны түүхт 90 жилийн ойг тохиолдуулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2024 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн 148 дугаар зарлигаар Дотоод хэргийн их сургууль маань Төрийн дээд шагнал “Сүхбаатарын одон”-гоор шагнагдаж, төрийн гурвалсан чандмань одонг тугандаа мөнхөллөө.

Мөн Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар Дотоод хэргийн их сургуулийн 90 жилийн түүхэнд тус Их сургуулийн захирал албан тушаалтнаас анх удаа генерал цолтон төрж, түүхийн шаргал хуудаснаа нэрээ мөнхөлсөндөө туйлын их баяртай байна.

Энэхүү төрийн дээд шагнал болон цэргийн дээд генерал цол бол та бүхний нөр их хүч хөдөлмөр, хичээл зүтгэл, хамтын бүтээл, амжилт юм шүү гэдгийг онцлон тэмдэглэхэд таатай байна.

Дотоод хэргийн их сургуулийн түүхт 90 жилийн ой тохиож буй энэ хичээлийн жилд тус Их сургуулийн Удирдлагын академид 28, Ахисан түвшний боловсролын сургуульд 7, Цагдаагийн сургуульд 438, Хилийн албаны сургуульд 160, Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуульд 122, Онцгой байдлын сургуульд 121, Эрх зүй, нийгмийн ухааны сургуульд 61, Шинжлэн магадлахуйн институтэд 21, Ахлагчийн мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвд 140, Ахлах сургуульд 96 сурагч элсэн орж, эрдмийн их өргөөнд мөр зэрэгцэн суралцахаар жигдрэн жагсаад байна. Та бүхэндээ сурлага, урлаг, спортын өндөр амжилт хүсье” гэлээ.

Дотоод хэргийн их сургуулийн бие бүрэлдэхүүн ёслолын жагсаалаар алхаж, багш, сонсогч, суралцагч, сурагчид шинэ хичээлийн жилийн хичээлдээ орлоо.

Дотоод хэргийн их сургуулийнхаа нийт бие бүрэлдэхүүнд хичээлийн шинэ жилийн баярын мэндийг хүргэж, сонсогч, суралцагч, сурагчдадаа сурлагын өндөр амжилт хүсье.





6. ТЭРГҮҮНИЙ БАГШ НАРТ ДХИС-ИЙН ТЭРГҮҮН ДЭЭД “ЭРДЭМ” ШАГНАЛ ГАРДУУЛЛАА

Дэлхийн багш нарын 30, Монголын багш нарын 58 дахь өдрийн баярыг тохиолдуулан Дотоод хэргийн их сургуулийн 2023-2024 оны хичээлийн жилийн тэргүүний багш нарт Их сургуулийн тэргүүн дээд “Эрдэм” шагнал гардуулах ёслол хүндэтгэлийн ажиллагаа өнөөдөр(2024.10.08) боллоо.

Шагналыг Дотоод хэргийн их сургуулийн захирал, доктор, профессор, бригадын генерал П.Батбаатар гардуулан өгөв.

Дотоод хэргийн их сургуулийн 2023-2024 оны хичээлийн жилийн “Тэргүүний багш”-аар Шинжлэн магадлахуйн институтийн Криминалистикийн шинжилгээний тэнхимийн профессор, доктор, цагдаагийн дэд хурандаа З.Сүлд, “Тэргүүний заах арга зүйч багш”-аар Цагдаагийн сургуулийн Мөрдөх арга зүйн тэнхимийн ахлах багш, доктор, цагдаагийн хошууч Ш.Номин-Эрдэнэ, “Тэргүүний анги даасан багш”-аар Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн Иргэний шийдвэр гүйцэтгэлийн тэнхимийн багш, хошууч Э.Цэрэнханд нар шалгарч Их сургуулийн Тэргүүн дээд “Эрдэм” шагналын эзэд боллоо.

Их сургуулийн Тэргүүн дээд “Эрдэм” шагналыг Дотоод хэргийн их сургуулийн хөгжил цэцэглэлтэд үнэтэй хувь нэмэр оруулсан эрдэмтэн багш, судлаач, албан хаагчдад олгож байхаар баталж, эрхэм хүндтэй энэхүү шагналын дээжийг өнгөрсөн хичээлийн жилд мэдлэг, ур чадвараараа бусдыгаа манлайлан ажилласан тэргүүний багш нарт анх олгосон түүхтэй.

Дотоод хэргийн их сургуулийн эрдэмтэн багш нараас 2023-2024 оны хичээлийн жилд ажил хөдөлмөр, хичээл зүтгэлээрээ онцгойрч Тэргүүн дээд “Эрдэм” шагналыг хүртсэн эрхэм багш нартаа халуун баяр хүргэж, сурган хүмүүжүүлэх их үйлсэд нь өндөр амжилтыг хүсье.



7. ДОКТОРЫН ЗЭРЭГ АМЖИЛТТАЙ ХАМГААЛЛАА

Дотоод хэргийн их сургуулийн Хууль сахиулахуй, дотоод хэргийн докторын зэрэг хамгаалуулах дэд зөвлөлийн хуралдаан өнөөдөр (2024.10.15) боллоо.

Тус хуралдаанаар Дотоод хэргийн их сургуулийн докторант, хурандаа Д.Одсэр “Өсвөр насны хүнд оногдуулсан хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаа”, хурандаа Д.Чинзориг “Баривчлах шийтгэл гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн зохицуулалт”, хурандаа А.Намсаманд “Хүнийг алах гэмт хэрэг үйлдсэн хүнд оногдуулсан хорих ял эдлүүлэх ажиллагаа” сэдвээр докторын зэрэг тус тус амжилттай хамгаалав.

Шинэхэн доктор, хурандаа Д.Одсэр, Д.Чинзориг, А.Намсаманд нарт халуун баяр хүргэж, цаашдын эрдэм судлалын ажилд нь өндөр амжилт хүсье.



8. ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХАРЬЯА ХОРИХ АНГИ, САЛБАР НЭГЖИЙН УДИРДАХ АЛБАН ТУШААЛТНЫ МЭРГЭШҮҮЛЭХ СУРГАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

Дотоод хэргийн их сургууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын 2024 оны хамтран ажиллах төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, захиалагч байгууллагын удирдах албан тушаалтныг үе шаттайгаар мэргэшүүлэх сургалтыг хамтран зохион байгуулах санамж бичгийн дагуу Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа хорих анги, салбар нэгжийн удирдах албан тушаалтны мэргэшүүлэх сургалтыг өнөөдөр (2024.10.18) Дотоод хэргийн их сургуулийн Удирдлагын академийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн удирдлага, стратегийн тэнхим, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Захиргааны удирдлагын газрын Соён гэгээрүүлэх хэлтэстэй хамтран зохион байгууллаа.

Тус мэргэшүүлэх сургалтыг нээж Дэд дарга бөгөөд Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх газрын дарга, хурандаа П.Оростогоо, Захиргааны удирдлагын газрын дарга, хурандаа Ч.Нэргүй, Дотоод хэргийн их сургуулийн Удирдлагын академийн захирал, цагдаагийн хурандаа Ц.Азбаяр нар үг хэлэв.

ДХИС-ийн Удирдлагын академийн захирал, цагдаагийн хурандаа Ц.Азбаяр, Хүний эрхийн үндэсний комиссын гишүүн, доктор (Ph.D), дэд профессор Б.Энхболд, Монгол Улсын гавьяат багш, МУИС-ийн Улс төр судлал, олон улсын харилцаа, нийтийн удирдлагын сургуулийн Нийтийн удирдлагын тэнхимийн профессор, доктор (Ph.D), профессор Н.Бурмаа, Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн Удирдлагын академийн профессор, бригадын генерал Х.Даваацэрэн, Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлал профессорын судалгааны багийн тэргүүлэх профессор, доктор (Ph.D), профессор Б.Алтангэрэл, ДХИС-ийн Сургалт, судалгааны 403 дугаар анги – Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн Ял эдлүүлэх эрх зүйн тэнхимийн профессор, доктор (Ph.D), дэд профессор, хурандаа Э.Батбаяр, Рояал академийн эрдэм шинжилгээ эрхэлсэн захирал, доктор (Ph.D), дэд профессор Ц.Баясгалан нарын салбартаа хүлээн зөвшөөрөгдсөн эрдэмтэн судлаачдыг урьж хичээл, сургалтыг явуулав.

Энэхүү сургалтад Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа хорих анги, салбар нэгжийн удирдах албан тушаалтан, Удирдлагын академийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн удирдлага, стратегийн тэнхимийн профессор, багш, суралцагсдын хамт оролцлоо.

Уг сургалт нь XXI зууны VUCA орчин (Volatility-Хувьсамтгай, Uncertainty-Тодорхойгүй, Complexity-Төвөгтэй, Ambiguity-Эргэлзээтэй)-д төрийн тусгай чиг үүргийг хэрэгжүүлэгч байгууллагыг үр дүнтэй удирдах, удирдлагын шийдвэр гаргах, асуудалд хүний эрхийн мэдрэмжтэй хандах зэрэг бусад шаардлагатай ур чадвар, мэдлэг, үнэт зүйлсийг хангасан сэдвийн хүрээнд явагдсан нь онцлог байв.





9. “ШИЛДЭГ ИЛТГЭЛ, УРАН ИЛТГЭГЧ” ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭН ЗОХИОН БАЙГУУЛЛАА

Дотоод хэргийн их сургуулийн Сургалт судалгааны 403 дугаар анги, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны сургуулиас “Шилдэг илтгэл, Уран илтгэгч” шалгаруулах тэмцээнийг Их сургуулийн соёлын төвд зохион байгууллаа.

Тус тэмцээн нь сонсогч, суралцагчдад эрдэм шинжилгээ, судалгааны ажил бичих сэдэл, сонирхлыг төрүүлэх зорилгоор 2012 оноос эхлэн жил бүр зохион байгуулагддагаараа онцлогтой юм. “Шилдэг илтгэл” шалгаруулах тэмцээнд нэгдүгээр шатанд шалгарсан 6 илтгэлийг хурлаар хэлэлцүүлж, тэргүүн байранд Сургалт судалгааны 403 дугаар анги-Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн 541 дүгээр дамжааны дэд түрүүч Б.Өсөхбаярын “Хоригдлын шашны зан үйл үйлдэх, өрөөний стандарт” сэдэвт илтгэл, дэд байранд Сургалт судалгааны 403 дугаар анги-Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн 5331 дүгээр дамжааны суралцагч Н.Азжаргалын “Шийдвэр гүйцэтгэлийн бүртгэл, хяналтын системийн аюулгүй байдалд нөлөөлөх зарим асуудал” сэдэвт илтгэл, гутгаар байранд Сургалт судалгааны 403 дугаар анги-Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн 532 дугаар дамжааны сонсогч Г.Хулан “Жендерт суурилсан хүчирхийлэл, эрх зүйн зохицуулалтын асуудал” сэдэвт илтгэлээр тус тус шалгарав.

“Уран илтгэгч” шалгаруулах тэмцээнийн тэргүүн байранд “Ахлагч” мэргэжлийн боловсролын сургуулийн 1401 дүгээр дамжааны сонсогч Ж.Соёл-Эрдэнэ, дэд байранд Эрх зүй нийгмийн ухааны сургуулийн 211 дамжааны суралцагч М.Алтжин, гутгаар байранд Шинжлэн магадлахуйн ухааны сургуулийн 921 дамжааны суралцагч Э.Ариунзаяа нар тус тус шалгарсан юм.

Тэмцээнд амжилттай оролцсон сонсогч, суралцагчдынхаа эрдэм судлалын ажилд нь амжилт хүсье.



10. СУРГАЛТ, СУДАЛГААНЫ 403 ДУГААР АНГИ-ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭЛИЙН АЛБАНЫ СУРГУУЛИЙН АВАРГА ШАЛГАРУУЛАХ 3 ТӨРӨЛТ СПОРТЫН ТЭМЦЭЭН ЗОХИОН БАЙГУУЛЛАА

Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн аварга шалгаруулах спортын 3 төрөлт тэмцээн Их сургуулийн спорт зааланд 2024 оны 11 дүгээр сарын 16, 17-ны өдрүүдэд боллоо. Тус тэмцээнд Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн багш, алба хаагчид бакалаврын өдрийн ангийн сонсогчид, эчнээ дамжааны суралцагчид хурд хүч, авхаалж самбаагаа сорин өрсөлдлөө.

Сагсан бөмбөгийн төрөлд эрэгтэй багийн "Тэргүүн" байранд Иргэний шийдвэр гүйцэтгэлийн тэнхимийн профессор, доктор (Ph.D), дэд хурандаа Я.Батгэрэл багштай 521 дүгээр дамжаа, "Дэд" байранд Иргэний шийдвэр гүйцэтгэлийн тэнхимийн багш, хошууч Б.Замбага багштай 541 дүгээр дамжаа, "Гутгаар" байранд Иргэний шийдвэр гүйцэтгэлийн тэнхимийн багш, хошууч Э.Цэрэнханд багштай 531 дүгээр дамжаа, эмэгтэй багийн "Тэргүүн" байранд Нийгмийн ажил, сэтгэл зүйн тэнхимийн багш, ахлах дэслэгч О.Төртүшиг багштай 542 дугаар дамжаа, "Дэд" байранд Иргэний шийдвэр гүйцэтгэлийн тэнхимийн багш, хошууч Б.Замбага багштай 541 дүгээр дамжаа, “Үнэ цэнэтэй тоглогч”-оор 541 дүгээр дамжааны түрүүч Э.Тэргэл, 542 дугаар дамжааны дэд түрүүч С.Сайнтуяа нар тодорчээ.

Волейболын төрөлд эрэгтэй багийн "Тэргүүн" байранд Аюулгүй байдлын тэнхимийн ахлах багш, хошууч Э.Өнөболд багштай 5512 дугаар дамжаа, "Дэд" байранд Ял эдлүүлэх эрх зүйн тэнхимийн профессор, доктор (Ph.D), дэд профессор, хурандаа Э.Батбаяр багштай 5531 дүгээр дамжаа, "Гутгаар" байранд Иргэний шийдвэр гүйцэтгэлийн тэнхимийн багш, хошууч Б.Замбага багштай 541 дүгээр дамжаа, эмэгтэй багийн "Тэргүүн" байранд Ял эдлүүлэх эрх зүйн тэнхимийн ахлах багш, хошууч Г.Балжмаа багштай 5521 дүгээр дамжаа, "Дэд" байранд Ял эдлүүлэх эрх зүйн тэнхимийн багш, дэслэгч Б.Уянга багштай 5331 дүгээр дамжаа, "Гутгаар" байранд Нийгмийн ажил, сэтгэлзүйн тэнхимийн ахлах багш, хошууч Г.Батжаргал багштай 522 дугаар дамжаа, “Үнэ цэнтэй тоглогч”-оор 521 дүгээр дамжааны сонсогч Б.Дашзэвгэ, 522 дугаар дамжааны дэд түрүүч Г.Цэдэн нар тодорсон байна.

Дартсын багийн төрөлд “Тэргүүн" байранд Аюулгүй байдлын тэнхимийн багш, хошууч И.Санчиргарав, лаборант, дэд ахлагч А.Цэрэнпил, "Дэд" байранд 541 дүгээр дамжааны түрүүч Э.Тэргэл, төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн, цагдаагийн хошууч Д.Баясгалан, "Гутгаар" байранд 531 дүгээр дамжааны сонсогч А.Энх-Амгалан, Х.Энхзул нар тус тус шалгарсан байна.

Тэмцээнд амжилттай оролцсон баг тамирчдад баяр хүргэж спортын өндөр амжилт хүсье.



11.ТЭРГҮҮНИЙ СУДЛААЧДАД ИХ СУРГУУЛИЙН ТЭРГҮҮН ДЭЭД “ЭРДЭМ” ШАГНАЛ ГАРДУУЛЛАА

Монгол Улсад орчин цагийн шинжлэх ухааны байгууллага үүсэж хөгжсөний 103 жилийн ой, “Шинжлэх ухааны ажилтны өдөр”-ийн баярын өдрийг тохиолдуулан Их сургуулийн эрдэм шинжилгээ, судалгааны ажлын үр дүнг тайлагнах, үнэлж, дүгнэх, 2024 онд эрдмийн бүтээл туурвилаараа хамт олноо тэргүүлсэн эрдэмтэн, багш, судлаачдаа шалгаруулан урамшуулах ёслолын ажиллагаа өнөөдөр (2024.11.22) боллоо.

Их сургуулийн ректор, доктор, профессор, бригадын генерал П.Батбаатар ёслолын ажиллагааг нээж хэлсэн үгэндээ:

“Цаашид эрдэм шинжилгээ, судалгаа, инновацын чадавхыг сайжруулах хүрээнд хүний нөөцийг чадваржуулж, багш, эрдэм шинжилгээний ажилтнууд олон улсын хянан магадалгаа бүхий сэтгүүлд өгүүлэл нийтлүүлэх, эрх зүйн баримт бичгүүдийг шинэчлэн боловсруулж, урамшуулахтай холбоотой эрх зүйн таатай орчныг бүрдүүлэхэд бодлого, үйл ажиллагаагаа чиглүүлэх болно” гэдгээ онцоллоо.

Энэ үеэр Дотоод хэргийн их сургуулийн сургалт, эрдэм шинжилгээ эрхэлсэн проректор, доктор, профессор, цагдаагийн хурандаа Д.Эрдэнэбаатар 2023-2024 оны хичээлийн жилийн Их сургуулийн эрдэм шинжилгээ, судалгааны ажлын талаар танилцуулга хийсэн юм.

Эрдэм шинжилгээ, судалгааны ажлын үзүүлэлтээр бусдыгаа манлайлан 2024 оны “Тэргүүний судалгааны профессорын баг”-аар Шүүхийн шийдвэр гүйцэтгэл

судлалын профессорын судалгааны баг тус тус шалгарч Их сургуулийн тэргүүн дээд “Эрдэм” шагналын эзэд боллоо.

Эрдмийн ажлын үр дүн, амжилтаараа бусдыгаа манлайлсан судлаач багш, албан хаагчдадаа халуун баяр хүргэж, эрдэм судлалын үйлсэд нь өндөр амжилт хүсье.





12. ДОКТОРЫН ЗЭРГИЙН ДИПЛОМ ГАРДУУЛЛАА

Дотоод хэргийн их сургуульд “Хууль сахиулахуй”, “Гэмт явдал судлал”, “Хууль зүй”, “Хил судлал”, “Шинжлэн магадлахуй”, “Гамшиг судлал” хөтөлбөрөөр докторын зэрэг амжилттай хамгаалсан судлаачдад докторын зэргийн диплом гардуулах ёслолын ажиллагаа өнөөдөр (2024.11.22) боллоо.

Дотоод хэргийн их сургуулийн ректорын тушаалаар:

🔷 “Хоригдлыг нийгэмшүүлэх үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалт” сэдэвт диссертац амжилттай хамгаалсан хошууч П.Баярбаатар,

🔷“Шүүхийн шийдвэр биелүүлээгүй этгээдэд хүлээлгэх хууль зүйн хариуцлага” сэдэвт диссертац амжилттай хамгаалсан дэд хурандаа Я.Батгэрэл,

🔷“Өсвөр насны хүнд оногдуулсан хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаа” сэдэвт диссертац амжилттай хамгаалсан хурандаа Д.Одсэр,

🔷“Баривчлах шийтгэл гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн зохицуулалт” сэдэвт диссертац амжилттай хамгаалсан хурандаа Д.Чинзориг,

🔷“Хүнийг алах гэмт хэрэг үйлдсэн хүнд оногдуулсан хорих ял эдлүүлэх ажиллагаа” сэдэвт диссертац амжилттай хамгаалсан хурандаа А.Намсаманд нарт “Хууль сахиулахуй”-н,

✅ Докторын зэргийн дипломоо гардан авсан докторууддаа халуун баяр хүргэж, цаашдын эрдэм судлалын ажилд нь өндөр амжилт хүсье.






13. ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛИЙН “ЭМЕРИТ ПРОФЕССОР”, МОНГОЛ УЛСЫН ГАВЬЯАТ ХУУЛЬЧ, ХУУЛЬ ЗҮЙН ДОКТОР, ПРОФЕССОР А.ЛХАГВАА АГСНЫ НЭРЭМЖИТ “ОЮУНЫ ИНДЭР-2024” ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА

Дотоод хэргийн их сургуулийн “Эмерит профессор”, Монгол Улсын гавьяат хуульч, хууль зүйн доктор, профессор А.Лхагваа агсны нэрэмжит “Оюуны индэр-2024” эрдэм шинжилгээний хурлыг “Хорих байгууллагад явуулах нийгмийн ажил” сэдвээр 2024 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр зохион байгуулагдлаа.

Эрдэм шинжилгээний хурлыг нээж, А.Лхагваа багшийн охин Л.Цэвэл, хурлын үйл ажиллагаанд амжилт хүсэж Нийгмийн ажил, сэтгэл зүйн тэнхимийн профессор, доктор (Ph.D), дэд профессор, дэд хурандаа Б.Галбадрах нар үг хэллээ. Л.Цэвэл ““Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын төдийгүй хууль сахиулах салбарын хүний нөөцийг бэлтгэх, хууль зүйн шинжлэх ухааны үйлсэд арилшгүй ул мөрөө үлдээсэн аавын маань нэрэмжит эрдэм шинжилгээний хурал зохион байгуулагдаж байгаад үр хүүхдүүдийнх нь зүгээс талархаж байна”. Б.Галбадрах “А.Лхагваа багш маань шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлалын салбарын төдийгүй, Монгол Улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн эрдэмтэн багш, эрдмийн эх хүн байв. Засан хүмүүжүүлэх байгууллагаас ажлын гараагаа эхэлж, улс орны хэмжээнд танигдсан эрдэмт хүнтэй хамтран ажиллаж байсан профессорын судалгааны багийн хувьд багшийнхаа үйл хэргийг залгамжлах нь бидний хүндтэй үүрэг юм. А.Лхагваа багшийнхаа ар гэр, үр хүүхдүүдэд багшийн маань гавьяа, сургаалыг түгээн дэлгэрүүлж байгаад талархаж байна, та бүгдэд шинэ ололт амжилтыг хүсье” гэж тэмдэглэн хэлсэн юм.

Хуралд Дотоод хэргийн их сургууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Монгол Улсын Боловсролын их сургууль, Шинжлэх ухаан, технологийн их сургууль, Олон Улсын Улаанбаатар их сургуулийн 100 гаруй эрдэмтэн судлаач, судлаач-оюутан, суралцагчид оролцлоо.

Тус хурал нь доктор, профессор А.Лхагваа агсны эрдэм шинжилгээ, судалгаа ажлын үр дүн, бүтээлүүдийг олон нийтэд таниулах, судлаач сонсогч, оюутнуудыг дэмжсэн, хоригдлыг нийгэмшүүлэх, гэмт хэрэг үйлдсэн хүнийг нийгэмшүүлэх, дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, суллагдсаны дараа хяналт тавих, нийгэмд дасан зохицоход дэмжлэг үзүүлэхэд тулгамдаж буй асуудлуудыг залуу судлаач сонсогч, оюутнуудын шинэлэг сэтгэлгээ, шинэ өнцгөөс харах, тухайн асуудлуудыг орчин үеийн техник, сэтгэлгээний онцлогт нийцүүлэн шийдвэрлэх чухал саналуудыг дэвшүүлсэн, эрдэм шинжилгээний мэтгэлцээн өрнүүлэхэд чиглэгдсэн.

Эрдэм шинжилгээний хуралд хууль зүйн их, дээд сургуулиудын оюутан, суралцагчдаас 30 гаруй илтгэл ирүүлснээс 6 илтгэлийг хоёрдугаар шатанд шалгаруулан хэлэлцүүлж шилдгүүдийг тодруулжээ.

Хэлэлцүүлсэн илтгэлээс тэргүүн байрт Сургалт, судалгааны 403 дугаар анги-Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн 532 дугаар дамжааны сонсогч Г.Хулангийн “Хоригдлыг урамшуулах эрх зүйн зохицуулалт, тулгамдаж буй асуудал” сэдэвт илтгэл, дэд байрт Олон Улсын Улаанбаатар их сургуулийн Хууль зүйн сургуулийн 4 дүгээр дамжааны оюутан У.Сарнай, А.Төгс-Эрдэнэ нарын “Сэтгэцийн өөрчлөлттэй хоригдолд үзүүлэх нийгмийн ажлын үйлчилгээ”, гуравдугаар байрт Сургалт, судалгааны 403 дугаар анги-Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн 542 дугаар дамжааны сонсогч Х.Жаргалтуяагийн “Суллагдах дөхсөн хоригдолд үзүүлэх нийгмийн ажил, үйлчилгээ” сэдэвт илтгэл тус тус шалгарсан байна.

Хуралд илтгэл хэлэлцүүлж байр эзэлсэн судлаач-оюутнуудад А.Лхагваа багшийн охин Л.Цэдэв өргөмжлөл, үнэ бүхий зүйлийг гардуулан урамшуулав.

Эрдэм шинжилгээний хурлын хүрээнд судлаач-оюутнууд маань суллагдах дөхсөн хоригдолд үзүүлэх нийгмийн ажил, хоригдлын хөдөлмөрийг Эх орны бүтээн байгуулалтад ашиглах боломж, хорих байгууллагын сэтгэл зүйчийн үйл ажиллагаа, сэтгэцийн өөрчлөлттэй хоригдолд үзүүлэх нийгмийн ажил, хоригдлыг урамшуулах эрх зүйн зохицуулалт зэрэг олон тулгамдсан асуудлаар илтгэл хэлэлцүүлж, хэлэлцүүлэг өрнүүлэв.







14. ДЭЭД БОЛОВСРОЛТОЙ ИРГЭДЭД ЗОРИУЛСАН ХОЁР ЖИЛИЙН МЭРГЭШҮҮЛЭХ БАКАЛАВРЫН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРҮҮДИЙГ СУРТАЛЧЛАХ ӨДӨРЛӨГИЙГ ШУТИС-Д ЗОХИОН БАЙГУУЛЛАА

Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэлийн санаачилгаар дээд боловсролтой иргэдэд зориулсан хоёр жилийн мэргэшүүлэх бакалаврын хөтөлбөрийг сурталчлах уулзалт, өдөрлөгийг 2024 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр ШУТИС-д зохион байгууллаа.

Өдөрлөгийн үеэр тус их сургуулийн төгсөх курсийн суралцагчдад “Дотоод хэргийн их сургуулийн хэрэгжүүлдэг 2 жилийн мэргэшүүлэх бакалаврын сургалтын хөтөлбөрийг танилцуулсан юм. Мөн сургалтын хөтөлбөр, салбарын мэргэжлийн онцлогийг танилцуулсан үзэсгэлэнг дэлгэж сонирхууллаа.

Дотоод хэргийн их сургуулийн хэрэгжүүлдэг сургалтын хөтөлбөр, салбарын мэргэжлийн онцлог танилцуулах уулзалт, өдөрлөг ийнхүү төрийн өмчит АШУҮИС, ХААИС, МУИС, МУБИС, ШУТИС-ийн байрлалд амжилттай зохион байгуулагдаж дууслаа.



15. ДЭД ТҮРҮҮЧ Б.ӨСӨХБАЯР: ХОРИГДЛУУДААС АВСАН БОДИТ СУДАЛГАА МААНЬ ИЛТГЭЛИЙГ ИЛҮҮ ҮР ДҮНТЭЙ, АЧ ХОЛБОГДОЛТОЙ БОЛГОЛОО

Энэ удаагийн Хууль зүй, дотоод хэргийн сайдын нэрэмжит “Шилдэг илтгэл”-ийн тэмцээнд ШШГАС-ийн Иргэний шийдвэр гүйцэтгэлийн тэнхимийн багш, хошууч Э.Цэрэнханд багшаараа удирдуулан “Хоригдлын шашин шүтэх, эс шүтэх

эрхийн хэрэгжилт, анхаарах асуудал” сэдэвтэй илтгэлээ амжилттай хэлэлцүүлж III байр эзэлсэндээ маш их баяртай байна. Илтгэлээр хүний шашин шүтэх, эс шүтэх эрхийн мөн чанар, ач холбогдлыг тайлбарлан хорих ял эдлүүлэх ажиллагаан дахь хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх хэрэгцээ, шаардлагыг тодорхойлж, хоригдлын шашны зан үйл үйлдэх, өөр өөр шашны итгэл үнэмшил бүхий хоригдлын хэрэгцээг тэнцвэртэй хангахад чиглэсэн шийдлийг санаачлахыг зорьсон. Илтгэлийн сэдвийн хүрээнд хоригдлуудаас авсан бодит судалгаа маань илтгэлийг илүү үр дүнтэй, ач холбогдолтой болголоо. Энэхүү амжилтийг үзүүлэхэд хамгийн их хувь нэмэр оруулсан хүн бол удирдагч багш маань байсан. Туслаж, дэмжиж, гар нийлэн хамтран ажилласан багшдаа баярлалаа.

Энэхүү уралдаанд 90 жилийн баялаг түүхт ДХИС-ийнхаа нэрийн өмнөөс оролцож, шилдэг оролцогчдын нэг болон зогсож байгаа минь сонсогч насны минь хамгийн дурсамжтай, бахархалтай үйл явдлуудын нэг болж байна. Энэхүү уралдаанд амжилттай оролцсон, бүтээлээ ирүүлсэн, илтгэлээ хэлэлцүүлсэн нийт оролцогч та бүхэндээ халуун баярыг хүргэж, цаашдын эрдэм шинжилгээ, судалгааны ажилд нь амжилтын дээдийг хүсье!



16. “ХҮНИЙ ЭРХИЙГ ДЭЭДЭЛЬЕ” СЭДЭВТ ПАРЛАМЕНТЫН МЭТГЭЛЦЭЭНИЙГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

Дотоод хэргийн их сургуулийн Эрх зүй, нийгмийн ухааны сургууль, Сонсогч, оюутны холбооноос санаачлан Хүний эрхийн үндэсни комисстой хамтран "Хүний эрхийг дээдэлье" сэдэвт парламентын мэтгэлцээнийг өнөөдөр /2024.12.10/ Их сургуулийн хурлын танхимд зохион байгууллаа.

Энэхүү мэтгэлцээн нь сонсогч, суралцагчдад хүний эрх, жендэрийн тэгш байдлын тухай ойлголтыг өгөх, хүний эрхийг дээдлэх, хүндлэх, багаар ажиллах, үзэл бодлоо илэрхийлэх, мэдээлэл солилцох зорилготой юм.

Тус тэмцээнд Цагдаагийн сургууль, Хилийн албаны сургууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны сургууль, Онцгой байдлын сургууль, Эрх зүй, нийгмийн ухааны сургууль, Шинжлэн магадлахуйн ухааны сургуулийн 6 баг "Хэвлэл мэдээллийг зүйтэй", "Хүний эрх гэж хэт туйлшрах нь буруу", "Эмэгтэйчүүдийн улс төр дахь харьцааг эрэгтэйчүүдтэй тэнцүү болгох нь зүйтэй ", "Төрийн үйлчилгээг сайжруулах хамгийн гол арга нь төрийн албан хаагчдад хүний эрхийн боловсрол олгох явдал юм" гэсэн шийдлүүдээр мэтгэлцлээ.

Тэмцээний тэргүүн байранд ЭЗНУС-ийн 222-р дамжааны суралцагч Ш.Халиун, 211-р дамжааны суралцагч Г. Хулан, дэд байранд ШМУС-ийн 921-р дамжааны сонсогч Б. Энхбат, 911-р дамжааны сонсогч С. Баттогтох, гутгаар байранд ШШГАС-ийн 541-р дамжааны дэд түрүүч Б.Өсөхбаяр нар тус тус шалгарлаа.



17. ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛИЙН СОНСОГЧ, СУРАЛЦАГЧДЫН ДУНД "СПОРТЫН ДӨРВӨН ТӨРӨЛ"-Т ТЭМЦЭЭНИЙ АВАРГУУД ШАЛГАРЛАА

Дотоод хэргийн их сургуулийн сонсогч, суралцагчдын дунд жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “Спортын дөрвөн төрөл”-т тэмцээнийг 2024 оны 12 дугаар сарын 06-15-ны өдрүүдэд зохион байгууллаа.

Энэхүү тэмцээнд бүрэлдэхүүн сургуулийн 400 гаруй сонсогч, оюутан, суралцагчид оролцож аваргуудаа тодруулж алт, мөнгө, хүрэл медаль, өргөмжлөл, мөнгөн шагналын эзэд болсон юм.

“Волейбол”-ын эмэгтэй төрөлд:

Тэргүүн байранд хурандаа Д.Чинзориг захиралтай, хошууч З.Түвшинжаргал дасгалжуулагчтай, дэд түрүүч Б.Өсөхбаяр ахлагчтай Шүүхийн шийдвэр, гүйцэтгэлийн албаны сургууль,

Эмэгтэй “Үнэ цэнэтэй тоглогч”-оор Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн 541-р дамжааны дэд түрүүч Б.Өсөхбаяр, “Шилдэг тоглогч”-оор Эрх зүй, нийгмийн ухааны сургуулийн 245-р дамжааны оюутан Ж.Лхагвасүрэн нар шалгарлаа.

“Сагсан бөмбөг”-ийн эмэгтэй төрөлд:

Тэргүүн байранд цагдаагийн хурандаа Г.Ганбаатар захиралтай, хошууч С.Ууганбаатар дасгалжуулагчтай, сонсогч Ц.Тэмүүлэн ахлагчтай “Ахлагч” мэргэжлийн боловсролын сургууль,

Эмэгтэй “Үнэ цэнэтэй тоглогч”-оор “Ахлагч” мэргэжлийн боловсролын сургуулийн 1306-р дамжааны сонсогч Б.Оюунтогос, “Шилдэг тоглогч”-оор Эрх зүй, нийгмийн ухааны сургуулийн 211-р дамжааны оюутан У.Ууганцэцэг нар шалгарсан юм.

“Сагсан бөмбөг”-ийн эрэгтэй төрөлд:

Дэд байранд хурандаа Д.Чинзориг захиралтай, хошууч Ж.Мягмардорж дасгалжуулагчтай, түрүүч Э.Тэргэл ахлагчтай шүүхийн шийдвэр, гүйцэтгэлийн албаны сургууль,

Эрэгтэй “Үнэ цэнэтэй тоглогч”-оор “Ахлагч” мэргэжлийн боловсролын сургуулийн 1205-р дамжааны сонсогч А.Мянганбаяр, “Шилдэг тоглогч”-оор Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн 541-р дамжааны түрүүч Э.Тэргэл шалгарсан юм.

“Шатар”-ын эмэгтэй төрөлд:

Гутгаар байранд хурандаа Д.Чинзориг захиралтай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн 522-р дамжааны сонсогч О.Азжаргал нар шалгарлаа.

“Шатар”-ын эрэгтэй төрөлд:

Дэд байранд хурандаа Д.Чинзориг захиралтай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургуулийн 542-р дамжааны сонсогч Б.Лувсандорж

“Ширээний теннис”-ний эмэгтэй төрөлд:

Дэд байранд цагдаагийн хурандаа Б.Хишигтогтох захиралтай, Цагдаагийн сургуулийн 343-р дамжааны дэд түрүүч Б.Сүхбат

Гутгаар байранд хурандаа М.Батсайхан захиралтай, Онцгой байдлын сургуулийн 621-р дамжааны сонсогч Б.Дэмүүл нар шалгарлаа.

“Спортын дөрвөн төрөл”-т тэмцээний “Багийн нийлбэр дүн”

Дэд байранд 11 оноогоор Шүүхийн шийдвэр, гүйцэтгэлийн албаны сургууль тус тус байр эзэлсэн юм.

Дотоод хэргийн их сургуулийн сонсогч, суралцагчдын дунд жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “Спортын дөрвөн төрөл”-т тэмцээнд амжилттай оролцсон баг, тамирчидадаа спортын өндөр амжилт хүсье.



